




ТЭРГҮҮН ДЭВТЭР

МОНГОЛ ТУУРГАТНЫ



ҮАЛТЭР

Монгол туургатны үлгэр

/тэргүүн дэвтэр/



Мир
еже ртнѹ
домогъ ѹгѣр





Хүн урт наслах болсон нь

Эрт урьд цагт хүн тийм ч урт насалж чаддаггүй байж гэнэ. Тэгээд хүн урт насалж, удаан жаргахын төлөө дээд тэнгэрээс насан хутаг гуйхаар явжээ. Нохой, илжиг, сармагчин гурвын хамт сансар бурханыд хүрч гэнэ. Тэр дөрөв тэнгэрт хүрч очсонд сансар бурхан:

- За, та дөрөв ямар учиртай ирэв гэж асуусанд. Тэд:

- Бид урт насалж, удаан жаргахын тулд багш танаас насан хутаг гуйхаар ирлээ гэв. Сансар бурхан:

- Өө, тийм үү? Болно, болно гээд тэр дөрвийг суулгаж, тус бүр гучин нас өгөөд:

- Та нар гучин жил амьдарцгаа, болно биз дээ гэж асуув. Хүн энэ үгийг сонсоод “Би тийм их холоос ирчихээд, гучхан жилийн нас авна гэдэг чинь” гэж чамлав. Илжиг бурханы хэлснийг сонсоод “Бид чинь хүнд зарагддаг амьтан шүү. Энэ хар толгойт хүний зарц болж, тэднээр 30 жил унуулж, тээрэм татаж, усыг нь ачиж зүдрэхийн оронд арван таван жил амьд явбал болно” гэж бодоод:

- Би таны хайрласан гучин насыг хүлээж дийлэхгүй юм байна. Энэ насныхаа хагасыг хайрлавал ямар вэ? гэж гуйв. Бурхан багш сонсоод:

- Болно, болно гэж зөвшөөрөв. Хүн үүнийг сонсоод, бурханд:

- Бурхан багш аа, та тэр илжигний үлдээсэн арван таван насыг надад нэмээд хайрлаж болох уу? гэж гуйв. Бурхан багш их дуртайгаар:

- За, за бололгүй яахав гэж зөвшөөрөв. Хүн илжигний аваагүй арван таван насыг авчихаад: “Одоо дөчин таван настай боллоо, бас л бага байна” гэж дотроо бодож суув. Нохой бурханы өгсөн насыг сонсоод: “бид бас хүний зарц шүү. Гучин жил хар толгойт хүний гэрийг сахиж, тогооны угаадас долоож өнгөрөөхийн оронд арван таван жил амьд явсан нь дээр” гэж бодоод, бурхан багшид:

- Бурхан багш аа, би таны хайрласан гучин жилийн насыг хүлээж чадахгүй. Та тэр насны хагасыг хайрлаж болох уу? гэж гуйв. Бурхан багш:

- Болно, болно гэж зөвшөөрөв. Хүн хажуугаас нь:

- Хүүе, бурхан багш аа, та тэр нохойны үлдээсэн арван таван насыг надад нэмээд хайрлачих, болох уу? гэхэд бас л дуртай зөвшөөрөв. Хүн нийт жаран насыг олоод авчихлаа. Тэгээд дотроо: “жаран нас болох нь болно, бас л бага юм шиг байна” гэж бодож суув. Хамгийн сүүлд сармагчин: “Надад тийм сайн мэдэх эрдэм гэж үгүй. Өдөртөө уул, модонд мацаж, зэрлэг үр жимс олж гэдсээ тэжээнэ. Заримдаа идэх юм ч сайн олдохгүй өлсөж явах удаа цөөнүй. Ингэж гучин жил зовж явахын оронд арван таван жил амьд явбал болох биш үү?” гэж бодоод:

- Бурхан багш аа, таны хайрласан насны хагасыг нь хүлээж чадвал ямар вэ? гэж гуйв. Бурхан багш:

- За, за бололгүй яахав гэлээ. Хүн бас л баярлаж:

- Бурхан багш аа, та сармагчны үлдээсэн арван таван насыг надад нэмээд хайрлачих гэж хэлэхэд бас л дуртай зөвшөөрөв.

Ингээд хүн бурханаас далан таван нас гуйж аваад баяртай харьж ирсэн гэнэ.

Хүн хэдийгээр далан таван жил амьд явах насыг олсон ч энэ далан таван жилийг адилгүй өнгөрөөдөг юм байна.

Түрүүчийн гучин жилийн нас бол бурхан багшаас хүнд өгсөн жинхэнэ нас болохоор тэр насанд хүн хамгийн чадал тэнхээтэй, гоо ганган, өвчин эмгэггүй, ямар ч ажлыг бүтээдэг чадвартай байдаг гэнэ.

Гучин наснаас дөчин тав хүрэх насыг хүн илжигнээс авсан тул энэ насандаа гэр бүлтэй болж, үр хүүхдээ өсгөж, өдөр шөнөгүй ажиллаж тээрмийн илжиг шиг зүтгэдэг ба дөчин таван наснаас жар хүрэх нас нь нохойноос авсан тул хүн энэ насандаа хүүдээ эхнэр авч өгч, охиноо мордуулж, хойч үеэ хардаг тул нохой шиг гэрээ сахиж суудаг нь тийм учиртай гэнэ. Харин жаран наснаас далан таван насыг хүн сармагчнаас авсан тул энэ насандаа ач, гучаа айл гэр болгож, үлдсэн жаахан хөрөнгөө үр хүүхэддээ өмчилж өгдөг тул гэрт нь дорвитой эд юмгүй, амьдрал нь сармагчин шиг хүчир болдог нь тийм учиртай гэнэ.

Хөгшин хүнийг ачлах (нэг)

Эрт урьд цагт хөгшин хүнийг ачилдаг заншилтай байжээ. Хөгшин хүний жил ирэхээр гурав хоносон тугал хөөлгөөд, гүйцвэл ачилдаггүй, гүйцэхгүй бол ачилдаг гэнэ.

Хөгшин хүнийг ачлахад бас их хурим найр хийдэг байв. Гэхдээ заавал ач хүү нь авга эхээ ачилдаг ёстой. Ачилдаг хүн болон, ачлуулах хүн бүр сайхан шинэ тэрлэгээ өмсөж гоёод, найрын ширээний голд суудаг.

Тэгээд нэлээд найрлаж байгаад ач хүү нь хонины ууцыг зүсээд шаант чөмгийг нь авч, нарийн толгойгоор нь хонины сүүлэн дээрээс дугариг хэрчсэн сүүлийг авч авга эхийнхээ амруу гударч оруулаад хахааж алдаг.

Одоо болтол Алша монголчууд ууц зүсэхээс өмнө сүүлнийх нь дээрээс дугариг хэрчээд ууцан дээр тавьдаг нь эртний хөгшин хүнийг ачлах ёсноос үлдсэн уламжлал юм гэнэ.

Хөгшин хүнийг ачлах (хоёр)

Эрт урьд цагт хөгшин хүнийг ачилдаг заншилтай байжээ. Хөгшин хүний жил нь ирэхэд залуу үе нь гурван алд нүх малтаад хөгшин ээж, ааваа дотор нь хоёр хөлийг нь жийлгэж суулгаад аманд нь хонины сүүлийг хэрчин шаант чөмгөөр чихэж оруулаад амьдаар нь булж тавьдаг байжээ. Одоо болтол Алшагийн зарим ууланд дугуй, дугуй чулуун хүрээ байдаг ба зарим хүн түүнийг хөгшин хүнийг ачилж тавьсан ор гэж хэлдэг. Дараа нь яагаад хөгшин хүн ачлахаа больсон бэ гэвэл бас түүхтэй юм гэнэ.

Нэг жил нэгэн хүүхний ээж нь ачлах насанд хүрчээ. Хүүхэн ээждээ хайртай тул ачлах тун дургүй. Тэгээд тэр нэг арга сэдэж, газар доор гүн нүх малтаад ээжийгээ дотор нь нуугаад явжээ. Нэг өдөр тэнгэрээс нэгэн сүрхий бүлтгэр нүдтэй, урт хоёр эвэртэй амьтан бууж ирсэнд хэн ч түүнийг таньсангүй гэнэ. Үүнд хаан:

- Хэн энэ амьтныг танина, түүнийг ихээр шагнана гэж зар тараав. Тэгээд олон өдөр болсон боловч түүнийг таньсан хүн гарсангүй. Үүнийг өнөөх хүүхэн ээждээ очиж хэлсэнд ээж нь тэр амьтны байдлыг сонсоод:

- Өө, хүү минь, чи тэр амьтанд нэг дээл аваачаад дэвсэж өгөөд, сайн ажигла гэж хэлэв. Хүүхэн ээжийнхээ хэлсэн ёсоор тэр амьтанд нэг дээл дэлгэж өгсөнд дээлэн дээр хэвтэж өнхрөөд баярлаж байна гэнэ. Хүүхэн үүнийг ээждээ хэлсэнд ээж нь:

- За чи очиж хаанд “Энэ амьтан бол хүний бөөс мөн” гэж хэл гэв. Хүүхэн хаанд очиж хэлсэнд хаан баярлаж:

- Чи яаж таньсан юм? гэж асуухад:

- За, би хэлж болно, гэвч та миний хүслийг заавал зөвшөөрөх хэрэгтэй гэв. Хаан:

- Тэгье, тэгье гэж ам алдав. Хүүхэн:

- Энэ амьтныг манай ээж таньсан юм. Ээж маань ачлах насанд хүрсэн хүн, би ээждээ хайртай тул ачилсангүй, гүн нүхэнд нууж байгаа. Би танд үнэн үгийг хэллээ. Хаан та хэлсэндээ хүрч, ээжийн минь амийг өршөө гэв.

Хаан үүнийг сонсоод: “Хөгшин хүнийг үлдээж байвал бас хэрэгтэй юм байна” гэж бодоод түүнээс хойш хөгшин хүнийг ачлахаа больсон гэнэ.

Төө биетэй тоодгор өвгөн догшин хар лусын хааныг дарсан нь

Эрт урьд цагт энэ орчлонг уул хангай, говь цөл газар гэж хоёр хэсэг хувааж байсан гэнэ. Энэ үед төө биетэй, хоёр төө сахалтай хувилгаан өвгөн байжээ. Тэр орчлон дэлхийг эргүүлж үзэх нүдтэй, урваж хувирах увдистай, ухаж мэдэх шидтэй юм гэнэ.

Тэр өвгөнд бас тэмээн хүзүүний арьсыг матигар чигээр нь өвчиж хийсэн тулам байдаг бөгөөд бугын эвэр зорж хийсэн халбага байжээ. Тэр үед тэнгэрт догшин хар лусын хаан гэдэг харгис амьтан амьдарч, орчлонгийн хүний мал сүрэг, эд хөрөнгө, уул хангай, ой модыг “цөм минийх, би авна” гэж зар буулгав. Тэгсэнд орчлонгийн хүн түүнд юу ч өгсөнгүй гэнэ. Үүнд догшин хар лусын хаан уурлаж:

- Надад газар нутаг, эд баялгаа өгөхгүй бол та нарт үргэлж гай гамшиг буулгана гэв.

Төө биетэй тоодгор өвгөн түүнийг сонсоод уул, хангай, талын оронд очоод тэндхийн хүмүүст:

- Та нар одоо болгоомжтой байхгүй бол болохгүй, догшин хар лусын хаан та бүхэнд зовлон буулгах гэж байна гэж хэлэв.

Тэр газрын хүмүүсийн дунд Чөмөг гэдэг нэртэй олиггүй өвгөн байжээ. Тэр, төө биетэй тоодгор өвгөний хэлсэн үгийг сонсоод догшин хар лусын хаанд очиж ховлов. Догшин хар лусын хаан уурлаж, сүрхий аянга буулгаж, төө биетэй тоодгор өвгөнийг алчихав гэнэ. Төө биетэй тоодгор өвгөнийг алсны дараа догшин хар лусын хаан Чөмөг өвгөнийг тэнгэрт “бурхан” болгож:

- За, чи бас газар дээр очиж гавьяа байгуул, надад орчлонгийн хүний мал хөрөнгийг авчирч өгч бай гэж хэлээд явуулав. Чөмөг өвгөн орчлондоо буцаж ирээд айл амьтан хэсэж, мал хөрөнгө авах учраа хэлсэнд, нэг ч айл юм өгсөнгүй гэнэ. Чөмөг өвгөн тэр дор нь лусын хаанд хэлсэнд буцааж явуулаад тэнгэрээс халуун зуны үдэд мөндөр буулгав. Өнөө муу Чөмөг өвгөн “Төө биетэй тоодгор өвгөнийг аянга буулгаж алаагүй бол энэ мөндөрийг лавгай чадах юмаа” гэж бодохтой зэрэг өвгөний толгой дээр том мөндөр бууж толгойг нь хага цохиж, тархи нь цацагдаж үхэв. Араас нь догшин хар лусын хаан гурван тохой цас буулгаж гунан үхрийн эвэр хөлдөж, орчлон дэлхийн уул хангай тал нутгийн айл амьтнаас юу ч үлдсэнгүй гэнэ.

Харин төө биетэй тоодгор өвгөн түрүүчийн аянганд үхээгүй байжээ. Өвгөн уул, хангай, тал нутгийн хүн амьтан үхэж барагдсаныг мэдээд говь, цөл газрын айлуудад хүрч:

- Би танай эндхийн гайг арилгая гэж хэлэхэд говь, цөлийн лусын хаан:

- Чи догшин хар лусын хаантай хамтарч уул, хангайн айл амьтныг идэж бараад ирсэн биз. Үгүй бол яагаад ганцаараа үлдээд ирж байдаг юм гээд өвгөний хэлсэн үгэнд итгэсэнгүй.

Өвгөн аргагүйдэж, айлуудаас зайдуу очиж өөрийн хувцсаараа нэг хас эрдэнийн монгол гэр хувилган барьж “Яаж эндхийн хүмүүсийн итгэлийг олох вэ” хэмээн бодож суув. Тэндхийн ард өвгөнийг “золбин, сахалт, муу тоодгор” гэж аль муугаар хэлж, ад үзэж байлаа. Нэг өдөр

догшин хар лусын хаан говь, цөлд усан гамшиг учруулах гэж байгааг төө өвгөн мэдээд нэг арга гаргаж:

- За, энэ жилийн хур бороо их элбэг болмоор янзтай байна. Усан гамшиг амаргүй шүү! Та нар усан аюулаас эртхэн сэргийлэх хэрэгтэй гэж хэлэв. Улс амьтан түүний үгийг тоож сонссонгүй. Удсангүй тэр газар учиргүй их хур бороо орж усан аюул болов. Төө биетэй тоодгор өвгөн шид увдисаа гаргаж их усыг өөр газар уруу урсгаж явуулав. Борооны дараа хүмүүс бүр ч тоосонгүй.

- Муу худалч, чиний их бороо бууж, усан аюул болно гэсэн чинь хаана байна? гэж басамжлан асуудаг болов.

Догшин хар лусын хаан бороо буулгаад усан аюул болгож чадаагүйдээ лав учиртай гэдгийг мэдээд энэ удаа ган гамшиг тавьж хүмүүсийг чадья гэж орчлон дэлхийг гандуулав.

Төө биетэй тоодгор өвгөн учрыг хэлсэнд тэд мөн л итгэсэнгүй. Говь, цөлийн нутагт ган гачиг болж, өвс мод хатаж, ус худаг ширгэж, улаан шороо босоод орчлонгийн амьтан амьдрах аргагүй болов. Өвгөн тэнгэрт нүүж байгаа үүлийг санамсаргүй хараад “Энэ нүүж байгаа үүлсийг цуглуулж, тулмандаа хийж байгаад бороо буулгая” гэж бодоод орчлонгийн үүлсийг цуглуулж байгаад их устай хур буулгав. Тэгээд ган гансарга тайлагдаж өвс мод ургаж, ус булаг оргилов. Говь газрын ард төө биетэй тоодгор өвгөнийг:

- Муу худалч аа, чи ган гачиг болно гэсэн биш үү? Яагаад ийм их бороо бууж, өнтэй болов? гэж дооглов.

Говь, цөл газарт ган гачиг болсонгүй, харин улам сайхан өншсөнд догшин хар лусын хаан гайхаж “Миний хийсэн хэрэг бүхэн бүтэхгүй, үүнд лавтай нэг сүрхий амьтан аргалаад байна” гэж бодоод нэг элчээ тэнгэрээс буулгаж үзүүлсэнд, төө биетэй тоодгор өвгөн үхээгүй, эдгээр явдлыг аргалаад байгааг олж мэдэв.

Догшин хар лусын хаан бас нэг элчээ явуулж:

- Таныг тэнгэрт залж, тэнгэрийн ноён болгоё гэж байна төө биетэй тоодгор өвгөнийг залав.

Төө биетэй тоодгор өвгөн энэ ч догшин хар лусын хааны мэх гэдгийг мэдээд “За яахав, би очъё. Энэ завшаанаар догшин хар лусын хааны залиг сансар бурханд заалдыя” гэж элчтэй хамт тэнгэрт гарав. Төө биетэй тоодгор өвгөн тэнгэрт гарсанд догшин хар лусын хаан түүнтэй ёс булаалдаад дийлсэнгүй, элчээ дуудаж өвгөнийг буцааж газарт нь хүргүүлэв.

Элч нь төө биетэй тоодгор өвгөнийг түмэн жингийн том хар чулуугаар дарж алчихаад харив. Догшин хар лусын хаан төө биетэй тоодгор өвгөнийг дарчихлаа хэмээн санаа амар сууж байтал, төө биетэй тоодгор өвгөн түүний хорт санааг сансар бурханд дуулгаж амжив. Сансар бурхан догшин хар лусын хааныг мөн газарт буулгав. Догшин хар лусын хаан хуурай газар дээр ирээд муу зангаа хаясангүй улам догширч, орчлонгийн хүн амьтныг дураараа зарж иддэг болов. Төө биетэй тоодгор өвгөн үүнийг мэдээд түүнийг даралгүй болохгүй нь гээд түмэн жингийн хар чулууг ганц нясалж хаячихаад догшин хар лусын хааныг дарахаар тэмээн хүзүүн

туламаа үүрээд, бугын эврэн халбагаа бариад явж байтал замд нь их тэнгис далай таарав. Тэнгис далай:

- Чи юу хийхээр явж байна? гэж асуув. Өвгөн:

- Би догшин хар лусын хааныг дарахаар явж байна гэхэд:

- Чам шиг төө биетэй тоодгор өвгөн түүнийг дарж чадах уу? гэж тохуурхахад, өвгөн уурлаж, өнөөх бугын эврэн халбагаараа далайг ганц утгаж аваад тэмээн хүзүүн тулмандаа савлаж хийгээд цааш явав. Ард нь өнөө далай дусал ч усгүй хуурай хотгор болж хоцров.

Төө биетэй тоодгор цааш явж байтал замд нь нэг үнэг тааралдаж:

- Чи хаашаа явж байна? гэж асуусанд өвгөн:

- Би догшин хар лусын хааныг дарахаар явж байна гэв. Үнэг сонсоод:

- Чам шиг төө биетэй тоодгор өвгөн түүнийг яаж дарах юм? гэж шоолж хэлсэнд өвгөний уур хүрч, барьж явсан бугын эврэн халбагаараа өнөө үнэгийг утгаж, туламруугаа чулуудчихаад цааш явав.

Төө биетэй тоодгор цааш явж байтал замд нь нэг чоно таарч:

- Хөөе, Чи хаашаа явж байна? гэж асуусанд өвгөн:

- Би догшин хар лусын хааныг дарахаар явж байна гэв. Чоно сонсоод:

- Чам шиг төө биетэй тоодгор өвгөн түүнийг яаж дарах юм? гэж шоолж хэлсэнд өвгөний уур хүрч, барьж явсан бугын эврэн халбагаараа өнөө чоныг утгаж, туламруугаа шидчихээд цааш явав. Төө биетэй тоодгор өвгөн цааш явж догшин хар лусын хааны байгуулсан орд, харшийн хажууд ирж, араас нь нуугдаж явсаар далан хотын орой дээр нь гараад:

- Би бол төө биетэй тоодгор өвгөн байна! Хүний орчлонгийн заналт дайсан догшин хар лусын хааныг дарахаар ирлээ, хурдан гараад ир! гэж тэнгэр газрыг доргитол хашгирсанд догшин хар лусын хаан уурсаж:

- Чам шиг төө биетэй тоодгор өвгөн бас намайг дарна гэнэ ээ? Би чамайг яаж чадахыг үз гэж хэлээд наанаас нь түмэн хонио бэлчээж тоосонд нь хахааж алах гэв. Төө биетэй тоодгор өвгөн газар бүрхэн ирж яваа хонийг үзээд туламын амаа тайлаад хүлээж байв. Олон хонь хажууд нь ирэхэд чоноо гаргаж тавьсанд түмэн хонь нь чонын бараанаар үргэж бутран алга болов.

Догшин хар лусын хаан үүнийг үзээд “Энэ муу тоодгор өвгөн ямар саваагүй юм, одоо юу ч үгүй болгоод хаячихъя” гэж наанаас нь асар, басар хоёр нохойгоо тавьж явуулав. Хоёр нохой нь төө биетэй тоодгор өвгөнрүү хуцан дайрч ирэхэд, туламын амаа нээж, үнэгээ тавьж явуулсанд хоёр нохой өвгөнийг орхиод үнэгийг хөөж алга болов. Үүнийг үзсэн догшин хар лусын хаан “Түмэн цэргээ дайчилж, бүсэлж байгаад алья” гэж шийдээд түмэн цэргээ

дагуулан наанаас нь хүрч очив.

Төө биетэй тоодгор өвгөн хүлээж байгаад догшин хар лусын хааныг түмэн цэрэгтэйгээ бүсэлж иртэл тулмын амаа нээж тавьсанд далайн ус нь догшин хар лусын хааныг түмэн цэрэгтэй нь хамт хөлгүй туугаад алга болгов. Догшин хар лусын хаан далайд амьдардаг болохоор өөрөө амьд үлдэв. Үүнийг мэдсэн төө биетэй тоодгор өвгөн “Энэ муу амьтныг оргүй устгахгүй бол эрт орой хэзээ нэгэн цагт гарч ирээд олонд дахиад гамшиг тарина” гэж бодоод говь, цөлийн улстай хэлэлцээд далайг шүүрдэхээр болов.

Төө биетэй тоодгор өвгөн говь, цөлийн залуу эрэгтэйчүүдийг томилж, далайг гурван өдөр шүүрдсэнд юу ч олдсонгүй. Дараа нь эмэгтэйчүүдийг томилж гурван өдөр шүүрдсэнд бас юу ч олдсонгүй. Хамгийн сүүлд хөгшин настайчууд, нялхас багачуудыг явуулж гурван өдөр шүүрдүүлсэнд догшин хар лусын хаан нэгэн загасанд хувирсан байсныг шүүрдэж олоод ирэв. Тэгээд өвгөн догшин хар лусын хааныг тэр дор нь дэвсэж алаад хүүрээр нь нохой шувуу тэжээв.

Төө биетэй тоодгор өвгөн догшин хар лусын хааныг дарснаас хойш дахин муу амьтан гарч орчлонгийн хүн малыг зовоохоо больсон бөгөөд энэ үед говь цөлийн айлууд төө биетэй тоодгор өвгөн бол хувилгаан эрдэмтэй хүн гэдгийг мэдэж хаан болгон шүтсэн гэнэ.

Нар, сар хиртэх болсон нь

Эрт балар цагт бурхан багш хүнийг зохиохдоо цэцгээс гаргадаг байж гэнэ. Тэгээд хүний өсч бойжиж, идэх уух болон амьдралын бүх хэрэгцээ нь цэцгээс бүрддэг байжээ. Тийм учраас тэр үеийн хүн үхэхгүй мөнх, үгүйрэхгүй баян, өнө үүрд жаргалантай амьдардаг бөгөөд гэгээ гэрлээ ч биеэсээ гаргадаг байв.

Хойно нь “Хүн буянаа даахгүй”-дээ хорон санаа нь ихдэж зарим нь хүн алж зарим нь хулгай хийж элдэв бусын муу ажлыг хийсээр байгаад өөрийн бие дэх гэгээ гэрлээ барж харанхуй балар ертөнцөд орсон гэнэ.

Тэр үед орчлон ертөнцөд нар сар гэдэг юм байсангүй. Хүн төрөлхтөн гэгээ гэрлээ алга болгосноос зарим нь ус мөрөнд унаж үхэж, зарим нь уул хадруу нисч үхээд амьдрах аргагүй болж гэнэ. Ингээд эцэс сүүлдээ хүн төрөлхтөн нэгэн элч томилж бурхан багшаас аврал гуйлгахаар явуулжээ.

Элч бурхан багшид учраа хэлж, яаж гэгээ гэрэл гаргах тухай асуусанд, бурхан багш:

- Хүн гэдэг амьтан бол цэцэгнээс төрсөн цэвэр ариун амьтан байлаа. Өөрсдийн буруу үйлээс болж, үнээ барж, өнгөө гээжээ. Үүнээс хойш цэцэг шиг цэвэрхэн, гэрэл шиг гэгээтэй амьдарч чадахгүй гэж хэлжээ. Хүний элч үүнийг сонсоод:

- Тэгээд одоо яах билээ? Ингээд харанхуй орчлонд амьдарч болохгүй биз ээ? гэхэд бурхан багш юм дуугарсангүй. Элч:

- Хүмүүс бид тун буруу зүйл хийжээ. Буруугаа хүлээе. Та заавал нэг гэгээ гэрэл гаргах арга хайрла, үгүй бол хүн бүр үхэж барагдах нь хэмээн бүхий л аргаар гуйж эхэллээ. Бурхан багш аргагүйдэж:

- За яахав. Та нар буруугаа мэдсэн бол болжээ. Би нэг арга гаргая гэж хэлээд, өнөө элчид нэг эрдэнийн бүлүүр өгч:

- За, чи энэ бүлүүрийг аваад яв, гадаад далайн хөвөөнд хүрээд, далайг хоёр бүлчихээд ир, илүү бүлж огт болохгүй шүү гэж захижээ. Өнөө элч тэр бүлүүрийг аваад гадаад далайн хөвөөнд хүрээд нэг бүлсэнд сайхан гэгээтэй сар гарч ирж гэнэ. Бас нэг бүлсэнд улам сайхан гэгээтэй нар гарч ирж гэнэ. Хүний элч түүнийг үзээд улам баярлаж “Хүүе, энэ чинь яасан сайхан эд вэ? Нэг бүлэхэд нэг нь нэгээсээ сайхан гэрэл гэгээтэй юм гарч ирдэг. Би одоо хүн төрөлхтөнд гэгээ гэрэл авч ирсэн гавьяатан боллоо. Дахиад нэг бүлчихвэл улам сайхан гэрэлтэй юм гарчихаж магадгүй” гэж бодоод бурхан багшийн хэлснээс зөрөөд өнөө бүлүүрээрээ гадаад далайг бас нэг бүлсэнд, харин нар сарыг барьж иддэг Раах гараад ирж гэнэ. Раах элчид:

- За, чи намайг гаргаж ирсэн чинь сайн боллоо. Бурхан багш намайг дараад их удлаа. Чи надад ямар алба өгөх гэж байна даа? гэж асуухад, айж сандарсан элч сая л ухаан орсон юм шиг:

- Өө, өгөх албагүй, өгөх албагүй гэж хэлэв. Раах үүнийг сонсоод ууртайгаар:
- Өгөх албагүй гэдэг чинь юу гэсэн үг вэ? Тэгээд чи намайг яах гэж гаргаж ирсэн юм бэ? хэмээн зандран асуув. Элч улам сүрдэж:
- Би бурхан багшийн үгэнд орсонгүй, ийм юм боллоо гэж үнэнээ хэлсэнд Раах улам уурлаж:
- Хн, чи бас л муу ажил хийлээ дээ гэж хэлчихээд нар, сар хоёрыг нь хөөгөөд алга болов. Элч уруу царайлан бурхан багшид хүрч очиход бурхан багш:
- За, юу болов? Нар, сар гарч дэлхий гэгээрэв үү? гэж асуусанд, элч:
- Гарлаа, гарлаа гэж хэлээд урамгүйхэн толгойгоо унжуулж зогсов. Бурхан багш:
- За, болж болж. Чи одоо харь гэсэнд элч уруу царайлан зогссоор байв. Бурхан багш гайхаж:
- Үгүй, чи чинь яасан бэ? Хүн төрөлхтөнд нар, сар гаргаж гэрэл гэгээтэй болгосондоо баярлах ёстой шүү дээ гэхэд элч үг хэлж чадсангүй. Хэрэг муу болсныг бурхан багш мэджээ. Тэгтэл гэнэт тэнгэр харанхуйлж эхэллээ. Бурхан багш түүнийг үзээд элчээс:
- Чи бүлүүрийг илүү бүлсэн биз? Раах яасан? гэж асуухад элч үнэнээ хэллээ. Бурхан багш:
- Раах гэдэг амьтан бол туйлын хорчин амьтан юм. Түүнийг одоо дарахгүй бол нар, сарыг идэж, тэнгэр газар дахин харанхуйлна гэж хэлээд гарч явав.
- Бурхан багшийг явсны дараа Раах сэм гэрт нь орж ирээд ширээн дээр нь байсан эрдэнийн бумбыг авч мөнхийн рашааныг нь залгилчихаад, мөнх амь орж, эрдэнийн бумбанд шээж орхиод дутаав гэнэ. Бурхан багш Раахыг хайж хайж олсонгүй буцаж ирэхэд ширээн дээр нь байсан эрдэнийн бумбыг амьтан хөдөлгөсөн янзтай байна гэнэ. “Үүнийг хэн хөдөлгөдөг билээ” хэмээн авч үзсэнд бумбатай мөнхийн рашаан нь эрт үгүй болж, оронд нь үмхий шээс хийсэн байлаа. Бурхан багш маш ихээр уурлаж:
- Энэ муу Раах хэтэрч байна. Тэр миний эрдэнийн бумбатай мөнхийн рашааныг хулгайлж уугаад мөнх амьтай болсноор барахгүй, бурханыг бузарлаж эрдэнийн бумбанд минь шээсэн байна. Одоо энэ муу амьтныг хурдан барьж устгахгүй бол орчлонгийн амьтан тэсэхгүй гээд мөрөөр нь мөшгин хайлаа. Замдаа сартай таарч Раах хаашаа явсныг заалган араас нь хөөсөн боловч Раах гүйцэгдсэнгүй хол явсан байлаа. Замдаа мөн нартай тааралдаж Раахын барааг нарны гэрэлд олж хараад барихаар хөөлөө. Раах мөнхийн рашаан ууж хүчтэй болсон тул бурхан багш эс гүйцэв. Бурхан багш гартаа барьж явсан очроо Раахын араас шидэхэд очир Раахыг дундуур нь тас цохиж гэнэ. Тасарсан Раахын доод хагас бие нь гадаад далайд унаж алга болов. Дээд хагас бие нь цааш дутаасанд бурхан багш түүнийг үзээд “бөгсгүй цээж ч хэдийхэн хэрэг гаргаж чадах аж” гэж бодоод дахиж Раахыг хөөсөнгүй, буцаж гэнэ. Бурхан багшийн буцсаны дараа Раах эрэмдэг болсноо мэдэхгүй нар, сар хоёроос хариугаа авах гэжээ. Явсаар сарны дэргэд ирээд:
- Чи муу гайхал намайг бурхан багшид зааж өгч, би ийм боллоо. Чамайг би гурван сард нэг

барьж иднэ гэж сүрдүүлсэнд, сар түүнийг тоосонгүй, гурван сар болоход нэг удаа үүдээ хааж, Раах гаднаа хорьдог болсон гэнэ. Раах нарыг хөөж очоод:

- Чи муу гайхал намайг бурхан багшид зааж өгснөөс би ийм боллоо. Би чамайг гурван жилд нэг барьж иднэ гэж сүрдүүлсэнд сар түүнийг тоосонгүй гурван жилд нэг удаа үүдээ хааж, Раахыг гаднаа хорьдог болсон гэнэ.

Түүнээс хойш, нар гурван жилд нэг хиртдэг, сар гурван сард нэг хиртдэг болсон гэнэ. Нар, сар хиртдэг нь Раах хэлсэн цагтаа ирж, барьж идэх гэхлээр үүдээ хааж байгаа нь тэр гэнэ.

Үүрийн харанхуй яагаад буй болсон бэ?

Эрт урьд цагт нэгэн залуухан эхнэр нөхөр хоёр хоол хийж идэх тогоо ч үгүй туйлын ядуу зүдүү амьдардаг байж гэнэ. Эхнэр нь:

- Бид нэг тогоо олж авах юмсан, тогоотой болчихвол жаахан идэх юм олсон ч түүнийгээ чанаж иддэг болно шүү дээ гэж үглэдэг байв.

Нөхөр нь тогоо олох гэж хэчнээн бодсон боловч арга олсонгүй. Тэгээд нэг үдэш эхнэрээ унтсаны дараа хажуу айлынхаа тогоог хулгайлж ирэв. Нөхрөө орж ирэхэд эхнэр нь:

- Чи хаашаа яваад ирэв? гэхэд нөхөр нь айлаас тогоо хулгайлж ирснээ хэлэхэд:




- Чи яасан мулгуу хүн бэ? Айлын хоёр, тогоогүй болохоор хоолоо чанаж идэж чадахгүй сандрах биш үү? Хурдан буцааж өг гэв.

Нөхөр нь буцаж айлын тогоог хүргэж өгөх гэсэн боловч үүр цайчихав. Хүнд харагдахаас айж хүргэж өгөхөөс татгалзахад эхнэр нь:



- Болохгүй ээ, чи аргалж байгаад хурдан хүргэж өг, одоо жаахан л удвал тэнгэр гэгээрч, айлын улс босч тогоогоо хайвал чиний хулгай баригдана гэж ятгаж явуулав.

Нөхөр нь аргагүйн эрхэнд гэрээсээ гарч айлд ойртож очиход гэгээ ороод өглөө болж гэнэ. Залуу “Одоо өглөө болчихсон болохоор тогоог яаж гэрт оруулж тавьдаг билээ?” хэмээн бодсоор айлын үүдэнд иртэл гэнэт харанхуйлж юу ч үзэгдэхгүй болж гэнэ. Залуу энэ завшаанд айлын гэрт сэм орж тогоог нь тавьчихаад буцаж ирэв.

Тэр цагаас хойш үүр цайхаас өмнө үүрийн харанхуй гэж буй болсон гэнэ.



ЗАН ЗАНШИЛЫН
ДОМООГ ҮЛГЭР





Охин хүүхдийг хүнд өгдөг болсны учир

Эрт урьд цагт охин хүүхдийг харьд мордуулдаггүй байв. Нэг авгай гурван охинтой байж. Охид нь том болоход ээж нь хүүхдүүдээ яаж амьдрах бол? гэж санаа зовж суудаг болов. Нэг өдөр авгайнд мэргэн хүн иржээ. Авгай мэргэн хүнээс:

- Охидууд томрохоор яавал дээр вэ? гэж асуухад мэргэн хүн мэдэхгүйдээ:

- Зараа гэж нэг мэргэн амьтан байдаг юм. Та түүнээс л асуувал мэднэ дээ гэж хэлжээ.

Нэлээд олон хоногийн дараа тэр айл малаа оторлуулаад нүүж явгал зам дээр нь зараа таарав. Охидын ээж зарааг угтаж очоод:

- Зараа гуай, танаас нэг зүйл асуух гэсэн юм гэхэд, зараа:

- Юун тухай асуух юм? гэв. Авгай:

- Манайх урагшаа их хол явахгүй. Ойрхон бууна. Та орой манайд морилж саатаж болохсон болов уу? гэхэд зараа зөвшөөрчээ.

Тэгээд цаашаа холгүй яваад ачаагаа буулгаж, гэрээ бариад:

- Орой манайд зараа гэдэг сүрхий мэргэн амьтан ирнэ. Би тэр амьтнаас та гурвын хувь заяаг мэргэлүүлнэ. Та гурав огт дуугарч, инээлдэж болохгүй шүү гэж хэлэв.

Орой болоход зараа айлд хүрч ирээд үүдээр нь орох гэсэнд гэрийн босго өндөр, зарааны хөл богино тул бүдэрч унаад дугариглан өнхөрч орж ирэв гэнэ. Гурван охин зарааны энэ байдлыг үзээд “Энэ муу амьтан бас мэргэн гэнэ шүү, өөрийнхөө дүрийг үз” гээд писхийтэл инээлдчихэв.

Зараа гурван хүүхэн өөрийг нь шоолж байгааг мэдээд уур нь туйлын ихээр хүрч, охидыг муухай харснаа, айлын баруун талд нь олбог дээр очиж суугаад хийж өгсөн цайг нь зөв буруу харан ууж дуусчихаад:

- Хар үсийг нь хагалж, хамбан дээлийг нь өмсгөж, хар элэгтэнд барьж өг! гэж хэлчихээд гараад явчихаж гэнэ. Түүнээс хойш охин хүүхдийг насанд хүрэхээр нь толгойтой үсийг нь хагалж самнаад, хувцас хунараар гоёж гангалаад харийн нутагт төрөл садан бус хүнд өгдөг болсон юм гэнэ.

Хүн тариа тарих болсон нь

рт цагт хүн тариа тарьж бор хоол иддэггүй, зөвхөн мах иддэг байжээ. Усны шувууд намар болоход усан дотор үр өндгөө үлдээж дулаан орондоо өвөлжөөд хавар болохоор түүнээ үзэхээр баяр хөөртэй буцаж ирдэг юм гэнэ.

Ийнхүү усны шувууд намар үр өндгөө орхихдоо гунигтай болдог тул хүмүүс намрын шувуу билэггүй, хаврын шудууд билэгтэй гэж ярьдаг байв.

Нэгэн хавар нэг эмэгтэй малаа хариулаад явж байтал дулаан орноос ирж яваа сүрэг усны шувуутай таарч, ихэд билэгшээн гэртээ харьж өөдөөс нь сүүн цацал өргөсөнд усны шувууд баярлан ганганалдаж, удтал гэрийнх нь дээгүүр эргэлдэж байгаад явав.

Удалгүй намар болж сүрэг шувуу дулаан газартаа буцахаар явж байхад нь өнөө эмэгтэй мөн л хонио хариулж яваад таарчээ. Шувууд хоньчин бүсгүйг таньж баярлалдан толгой дээгүүр нь хэчнээн нисэлдсэн боловч бүсгүй: “Намрын шувуу билиггүй” гэж бодоод хаврых шигээ баярлаж, сүүгээр цацал өргөсөнгүй. Сүрэг шувууд хэсэг эргэлдэж байснаа нэг юм цацчихаад нисэж одов.

Эмэгтэй шувуудын цацсан зүйлийг юу болохыг мэдсэнгүй дараа жилийн хавартай золгож, шувууд ирдгээрээ ирж, бүсгүй сүүгээ өргөн намар болоход мөн л шувууд буцдагаараа буцав.

Намрын налгар сайхан өдөр хонио хариулж яваад урд жил усны шувуудын юм цацсан газарт нэг их тариа ургачихсан халиурч байхыг олж үзжээ. Бүсгүй баярлан хөөрч, тариаг хураан авч гурил будаа гарган авчээ.

Үүнээс хойш хүн тариа тарьдаг болсон бөгөөд тарианы үрийг анх усны шувуу хүнд өгсөн юм гэдэг.

Орчлонгийн эзэн, шувуу буйлласан нь

Эрт урьд цагт төр гүрэн сайн тогтоогүй үед, шувуу хэнд ч захирагддаггүй эрх дураараа газар бүхэнд хэсүүчлэн нисдэг хэвээр байжээ. Нэг өдөр орчлонгийн эзэн “Энэ шувуу гэдэг амьтан ямар эрх дураараа амьтан бэ? Үүнээс хойш би энэ амьтдыг эрхэндээ оруулж, захирах болно” гэж шийдээд:

- Дэлхийн олон шувуудыг цөм тогтсон нэг цагт миний дэргэд цуглар гэж зарлиг буулгажээ.

Тэгтэл шувууд цөм тогтсон нэг цагт цугларч чадсангүй. Ар араасаа суварч ирцгээхэд орчлонгийн эзэн уурлаж, шувуудыг захаас нь барьж аван буйллан уяад, сүүлчийн шувууг хүлээж суув. Хамгийн сүүлд Эдэн шувуу ирэв. Орчлонгийн хаан ууртай ширүүнээр:

- Чи яагаад тогтсон цагтаа ирэлгүй, олон хоног хоцорч ирэв? гэж асуухад Эдэн шувуу:

- Эзэн минь, уураа тат! Би гуйван гуйван гэж гуч хоног ниссээр, дайван дайван гэж дал хоног ниссээр ирж байгаа нь энэ билээ гэв. Орчлонгийн эзэн:

- Хаана тийм гуч, дал хоног нисэх хол газар байдаг юм бэ? Энэ хэд хоногийн учраа бүгдийг тайлбарлаж хэл гэв. Эдэн шувуу:

- Би бүрэнхий өдрийг шөнөөр бодоод, бүрэг эрийг эмээр тооцоод ийм олон хоног саатлаа гэж хэлжээ.

Орчлонгийн эзэн түүний хэлэхийг сонсоод: “Эдэн шувууны хэлдэг үнэн болж таарлаа. Нээрэн бүрэнхий өдрийг шөнөд бодож таарна. Би ер нь их буруу юм хийж байгаа юм байна” гэж гэмшин, хамгийн сүүлд ирсэн Эдэн шувууг буйлласангүй, бусад шувуудыг ч тавьж явуулав.

Түүнээс хойш шувуу хамар дээрээ буйлны ором шиг нүхтэй болсон юм гэнэ.

Чоно өмч хувааж авсан нь

Эрт урьд цагт бурхан багш түмэн амьтанд идэх юм хувааж өгчээ. Тэр үед чоно зээр барьж идэх гэж элдэж байгаад хоцорчихжээ. Үнэг бурхан багшаас өмчөө аваад буцаж явах замдаа чонотой таарч:

- Хөөе, чи энд юу хийж яваа юм бэ? Цаана чинь бурхан багш түмэн амьтанд өмч хувааж байна гэж хэлэв.

Чоно үнэгний хэлэхийг сонсоод хөөж байсан зээрээ орхиж, бурхан багшаас өмч авахаар очжээ. Гэвч чоныг хүрч очиход бурхан багш өмчөө хуваагаад дуусчихсан байв. Чоно:

- Надад өмч хувааж өгөөч гэхэд бурхан багш:

- Чи хоцорч ирсэн тул өмч дууссан гэж хэлэв. Чоно дургүй нь хүрч:

- Бусад амьтанд бүгдэд нь өмч хуваачихаад надад яагаад үлдээдэггүй юм гэж гомдоллоход бурхан багш:

- За тэгвэл чи хойшид өөрийн эр чадлаараа хоолоо олж ид. Гэхдээ мянгаас нэгийг идэж байгаарай гэж захижээ.

Чоно түрүүхэн хөөж байсан зээрээ холдоод явчихвий гэж санаа нь зовж яарч сандарч байсан болохоор бурхан багшийн хэлснийг буруу сонсож “Мянгаас нэгийг үлдээж бай” гэж ойлгоод:

- За за, болно гэж хэлчихээд зээрээ хөөж барихаар буцаж давхижээ.

Түүнээс хойш чоно айлын хоттой мал таарвал заавал бүгдийг нь хороодог болсон ба үүнийг бурхан багш сонсоод үнэн худлыг нь шалгаж үзэхээр шийджээ.

Тэгээд бурхан багш нэг өдөр айлын хоттой малан дунд ороод хонины нэхий нөмрөөд өвс идсэн дүр үзүүлээд сууж байтал чоно сүрэг хонь уруу дайран ирж яваа харагдав. Эр чадалдаа бардаж, олз омогтоо улайрсан чоно сүрэг хонийг захаас нь эхлэн гэдсийг нь хүүлж хядсаны дараа бурхан багшийг барьж идэхээр дайрчээ.

Бурхан багш өмнөөс нь гэнэт босоод зогстол чоно бурхан багшийг таниад айн цочихдоо нүүр уруу нь харж чадалгүй буруулан зугтжээ.

Үүнээс хойш чоно хүний улаан нүүрийг харж чадахаа больсон юм гэнэ.

Ёл шувуу халзан болсон нь

Эрт урьд цагт хүн төрөлхтөнд гал олддоггүй байжээ. Тэр цагт тэнгис далайн цаад хөвөөнд өтгөн шигүү ой мод байдаг байв.

Нэг жил тэр их өтгөн ой шугуйн салаа мөчир нь хоорондоо үрэлдсэнээс гал гарч түймэр асчээ. Далайн наад хөвөөнд амьдардаг хүмүүс галын цогийг авах гэж тун их хичээгээд авч чадсангүй. Олон амьтан галын цогийг авах гэж тэнгис далай гаталсан боловч авчирч чадахгүй байлаа. Хамгийн сүүлд Ёл шувуу:

- Би очиж тэр цогийг аваад ирье гэж хэлээд тэнгис далайн дээгүүр нисэн одов гэнэ.

Ёл шувуу тэнгис далайн цаад хөвөөнд хүрээд галыг авч явах гэсэнд хийх сав олдсонгүй тул толгой дээрээ тавиад буцаж нисэв. Галын цог халан халсаар Ёлын толгойны өдийг хуйхалж түлжээ.

Ийнхүү Ёл шувуу хүн төрөлхтөнд гал авчирч өгсөн гавьяатай бөгөөд галын цогонд өдөө хуйхлуулснаас толгой нь халзан болсон түүхтэй юм гэдэг.

Тангудууд тогоогоо хагалахаа больсон нь

Эрт урьд цагт Тангудууд хоолоо хийж идчихээд бүх тогоо шанага, аяга тавгаа хагалж хаядаг заншилтай байжээ. Учир нь тэд маргааш өглөө амьд сэрүүн босч ирэх юм уу? Үгүй ч юм уу? Хэн мэдэх вэ? гээд тэгдэг байжээ. Тэгээд маргааш нь амьд босч ирвэл дахиж тогоо шанага, аяга таваг худалдаж авдаг байж гэнэ.

Нэг удаа хэсэг Тангуд Монголд иржээ. Тэд Монголчуудыг орой унтахынхаа өмнө хоолоо хийж идчихээд тогоо шанага, аяга тавгаа бүгдий нь сайхан угааж цэвэрлээд, үлдсэн хоолоо маргааш өглөө иднэ гэж тавьж хонохыг үзээд:

- Энэ Монголчууд чинь яасан мэргэн улс вэ? Маргааш амьд сэрүүн босч ирэхээ мэддэг ухаантай улс байна гэж хэлэлцээд:

- Бид ч бас ингэж байвал болох юм байна гээд түүнээс хойш хоолоо хийж идчихээд тогоогоо хагалахаа больсон юм гэдэг.

Ар халхад яагаад бөх олон байдаг вэ?

Эрт урьд цагт Зул вангийн хошуунд Ширмэнхоовон гэдэг нэртэй сүрхий бөх хүн байжээ.

Тэр хэнтэй ч барилдаад шороодож үзээгүй бөгөөд нутаг хошуу дамжин баяд ноёдын адуу малыг хулгайлж, ядуу зүдүү ард олонд өгдөг зартай хулгайч хүн байжээ.

Ширмэнхоовон өтөлж, нас дээр гараад, Зул ванд:

- За, миний амьд явах хоногийн тоо гүйцэж байх шиг байна. Намайг өнгөрөхөөр та нар миний хүүрээр овоо босгож тахиарай гэж захижээ.

Удалгүй Ширмэнхоовон бөх насан өөд болоход Зул ван:

- Энэ муу амьтан нэг насандаа хулгай хийж явсан байж хүүрээрээ овоо босгуулж, биднээр тахиулах санаатай гэж санаад цогцсыг нь чирч, хол аваачиж хаяжээ.

Дараа нь амьтан хүн мал адуу эрж хайж яваад Ширмэнхоовонгийн хүүрнээс чоно гарч явахыг харжээ.

Энэ тухай хүмүүс амаас ам дамжин гайхан ярилцдаг болсон бөгөөд энэ яриаг Ар халхын нэг хүн сонсоод хэргийг сонирхож, зориуд хүрч очсонд хүүрийн цээжинд чоно гөлөглөсөн байжээ. Мань хүн ихэд сонирхон “Энэ ямар учиртай юм бол?” гэж бодоод татаж үзсэн чинь цээж нь яс биш ширмэн төмөр байжээ.

Тэгээд тэр хүн: “Зул вангийн хошууны Ширмэнхоовон гэгч бөх амьдаа хэнд ч дийлддэггүй байсан нь ийм учиртай байж. Зул вангийн хошуу тахихгүй юм бол бид тахья” гэж хэлээд Ширмэнхоовонгийн хэнхдэгийг нь ачин Ар халхдаа аваачиж овоо босгож тахисан гэдэг.

Түүнээс хойш Зул вангийн хошуунд бөх ховордож, Ар халхад бөх олон төрөх болсон гэнэ.

Нанжин поодой бээжин явсан нь

Эрт урьд цагт Нанжин поодой гэдэг хүн Бээжин орохоор явжээ. Замд нь нэг их урт гээгтэй хүн таарсанд харилцан амар мэндээ мэдэлцээд:

- Та хаашаа явж байна? гэж асуусанд Нанжин Поодой:

- Бээжин орохоор явж байна гэж хариулаад хариу:

- Та харин хаашаа явж байна вэ? гэхэд

- Би бас Бээжин явж байна гэв.

Тэгээд хоёулаа зам нийлж хамт явав.

Тэр урт гээгтэй хүн өглөө болгон түрүүлж босоод цай чанаж тавьдаг байв. Хоёул явсаар Бээжинд ойртжээ. Нэг өглөө урт хар гээгтэй хүн босч цай чанасангүйд Нанжинпоодой гайхаж очиж үзсэн чинь, том чоно орон дотор нь хэвтэж байв. Нанжинпоодой: “Энэ чоно урт хар гээгтийг идчихэж, одоо бас намайг ч идэх байх” гэж айгаад хөнжлөө толгой дээгүүрээ нөмрөөд хэвтчихэв. Нэлээд хэвтэж байгаад хөнжлөө сөхөөд хартал урт гээгт босчихсон цайгаа чанаж суув. Нанжинпоодой гайхаж:

- Би түрүүн нэг сонин юм харлаа гэхэд урт хар гээгт ажиг ч үгүй

- Юу хараав? гэж асуув. Нанжинпоодой:

- Би чамайг босоогүй болохоор орыг чинь сөхөж үзсэн чинь чиний орон дотор том саарал чоно хэвтэж байсан. Би чамайг идчихээд намайг бас идэх байх гэж айгаад орондоо хэвтсээр өдий хүрлээ гэж хэлэхэд, урт гээгт:

- За, та хөөрхий байна. Тэр хол газраас ирж байхыг бодоход чухал хэрэгтэй л яваа байлгүй. Одоо хурдан Бээжинд очиж юм хумаа ав. Би бол хүн биш. Эрлэгийн элч байна. Манай эрлэгийн элч бол гурав байдаг. Нэг нь морин толгойтой. Нэг нь үхэр толгойтой. Нэг нь чонон толгойтой байдаг юм гэж хэлэв.

Тэгээд тэр хоёр салж Бээжин хотод оржээ. Энэ үед хаан таалал төгсч эрлэгийн элч авахаар явж байсан нь тэр байж. Нанжинпоодой Бээжин хотоос авах юмаа аваад буцаж явтал өнөө эрлэгийн элч тааралдав. Эрлэгийн элч Нанжинпоодойд:

- Би чамд нэг сонин юм үзүүлье гэж хэлээд бүх хүний нэр, насны хэмжлийг бичсэн данс гаргаж үзүүлэв. Нанжинпоодойн нас нь ч гүйцээд байна гэнэ. Тэгээд эрлэгийн элч:

- Би чиний нэрийг данснаас хасчихъя. Харин чи хүнд нэр, насаа огт хэлж болохгүй шүү гэж хэлээд яваад өгчээ.

Нанжинпоодой түүнээс хойш нэр, насаа хүнд хэлэлгүй байсаар 108 нас хүрчээ. Энэ хооронд арван найман авгай авч, арван найман хүүтэй болж гэнэ. Нэг өдөр гэрийнх нь ойр байдаг

усан дээр нэг үхэр бөгсөөрөө ус ууж байхыг Нанжинпоодой хараад:

- Хөөе, энэ чинь ямар сонин юм бэ? Нанжинпоодой би зуун найм наслахдаа ийм юм үзсэнгүй гэж нэр, насаа хэлчихэв.

Тэгтэл бөгсөөрөө ус ууж байсан үхэр эрлэгийн элч байжээ. Эрлэгийн элч Нанжинпоодойн нэр, насыг сонсоод тэр дороо авч явжээ.

Тиймээс хуучны хөгшид нэр, насаа танихгүй хүнд хэлэхийг цээрлэдэг байжээ.

Эцгийн яс дэрэн дотор

Эрт урьд цагт өвгөн, эмгэн хоёр, ганц хүүтэйгээ амар тайван аж төрөн суудаг байжээ.

Гэнэт нэг өдөр өвгөн нь бие өнгөрөөд, удаагүй байтал эмгэн нь хүнд өвчин тусч хэвтэрт орж өдрөөс өдөрт муудсаар байлаа. Хүү яах учраа олохгүй сандарч байтал, ээж нь:

- Халхын наймаачид, Хөх хот орохдоо үүгээр өнгөрдөг юм. Тэдний дунд мэргэн хүн явж магадгүй. Миний хүү хоттой хониноосоо нэгийг гаргаж, цайлгасан далыг нь бариад наймаачдын замыг тос. Дал шинжээч таарвал үгийг нь сайн тогтоогоод ир гэж хэлэв.

Хүү хонь гаргаж, далны ясыг нь чанаж мөлжөөд, наймаачдын замыг тосохоор явав. Наймаачдын ачаатай тэмээ ч хүрээд ирлээ. Тэмээний цуваа өнгөрөөд л байлаа. Дуугарах хүн олдсонгүй. Аяны цуваа барагдахын үед нэг өвгөн хүүгийн барьсан далыг авч эргүүлж тойруулж харснаа:

- Эцгийн яс дэрэн дотроо гэж хэлчихээд яваад өгөв. Хүү учир тоймыг ойлгосонгүй буцаж ирэхэд, эх нь

- Халхын аянчид юу гэж байна гэж асуув. Хүү:

- “Эцгийн яс дэрэн дотроо” гэж учир нь олдохгүй ганц юм хэлчихээд явчихлаа гэлээ.

Эмгэн үүнийг сонсоод “Өвгөний минь эдэлж байсан юм байж л байг” гээд баруун хойд авдартаа хадгалж байсан өвгөнийхөө хуучин дэрийг гаргаж, ханзалж эхлэв. Хүү учрыг олохгүй гайхан зогсож байтал дэрэн дотроос аавынх нь араа шүд унаж ирэв. Эмгэн:

- Ээ дээ, ийм учиртай байж. Аав чинь өөд болохдоо өөхөнд боогоод нохойд хаяж өг гэхээр нь би өгөөгүй юм. Өнгөрсөн хойно нь сүнс нь үүнд хоргодсон байх нь гэж хэлээд тэр ганц арааг хүүр чандарласан газарт нь хүргүүлжээ.

Удалгүй эмгэний бие илааршиж эдгэсэн бөгөөд түүнээс хойш Монголчууд өөд болсон хүний яс шүд болон хэрэглэж байсан эдлэл юмыг нь гэртээ байлгахгүй заавал хамтад нь шатаадаг заншилтай болжээ.

Эр хүний нөхөр яс

Эрт цагт гэнэ. Хүн амьтан арилжаа наймаа хийж явахдаа заавал дайрч өнгөрдөг бөгөөд ойр хавьд айл хунар огт байдаггүй, буйд бөглүү газар байдаг байв. Наймаачид үүгээр өнгөрөхдөө заавал нэг хонодог байж.

Энэ замаар наймаачид өнгөрдөг гэдгийг хулгайч дээрэмчид олж мэдээд, шөнийн харанхуйг ашиглаж, дээрэм хийдэг болж гэнэ.

Нэг сэргэлэн залуу түүнийг олж сонсоод, тэнд хонохдоо уран арга гаргахаар шийджээ. Залуу унтахынхаа өмнө майханыхаа үүдэнд нэг богт чөмөг босгож хатгаад, өмнө нь нэг хавирганы яс хөндлөн хавчуулж тавьчихаад унтав.

Шөнө дунд хулгайчид наймаачдын ачаа барааг хулгайлахаар майхны хажууд иртэл үүдэнд нь буу барьсан хүн зогсож байв. Үүнийг харсан хулгайчид ухаан жолоогүй зугтаж алга болжээ.

Учир нь богт чөмөг, хавирганы яс хоёр шөнийн харанхуйд буу барьсан хүн шиг харагдсан юм байж.

Түүнээс хойш бусад наймаачид ч тэр аргыг хэрэглэж, хулгайчдад эд бараагаа алдалгүй авч хоцордог болжээ.

Ийм учраас хуучны хүмүүс богт чөмгийг эр хүний нөхөр хэмээн ташиж идэхийг цээрлэдэг байжээ.

Хоноцын толгойг эргүүлдэггүй

Эрт урьд цагт олон хүүхэдтэй эмгэн байжээ. Нэг орой хоолоо идчихээд хүүхдүүдтэйгээ хөөрөлдөж суутал галын хөвөөнд нэг хоноц (Зуухны хөө хөлрөх) суусан байж гэнэ. Түүнийг хүүхэд нь олж үзээд:

- Ээж ээ, хоноц суучихаж, одоо манайд хүн ирэх юм байна гэхэд, ээж нь:

- Дуугүй бай. Хүн ирвэл хоолны гарз. Хоноц суусан байвал хол аваачиж толгойг нь эргүүлж хая гэв.

Тэгээд нэг хүүхэд нь “Хоноцын толгойг эргүүлж байна” гээд эргүүлж эргүүлж доош нь харуулаад аягатай усанд хийгээд хаячихаж гэнэ.

Маргааш нь эмгэн малаа услахаар иртэл худаг дотор нь нэг хүн унаж үхсэн байв. Эмгэн “Юун хүн байдаг билээ” гээд өнөө хүнийг худгаас татаж гаргасанд өөрийнх нь ойрын төрлийн хүн тэднийд очихоор явж байгаад “билиг”-ээр болж, толгой нь эргэж, зам төөрөн худагт унаж үхсэн байжээ.

Түүнээс хойш Монголчууд хоноц суувал төөрүүлж болохгүй, цай уу, хоол ид гээд дээрээс нь үнс асгаж галд хийдэг заншилтай болсон гэнэ.

Монгол хүн цуварч явдаггүйн учир

Урьд цагт өргөн уудам Монгол нутагт Манжийн хааны дарлалыг эсэргүүцэж нэг сайн эр гарч гэнэ.

Сайн эр өргөн олон Монгол ах дүүгээ дайчилж бослого гаргахаар бэлтгэж байв. Манжийн хаан жил бүр түшмэл цэргээ дагуулж ан ав хийдэг байв. Сайн эр тэр цагийг ашиглаж хааныг дарахаар шийдэж амдаж байгаад хааны цэргүүдэд баригдаад зугтаж гарчээ.

Энэ хэргийг Манжийн хаан мэдээд:

- Миний өөдөөс тэрслэх санаатай тэр муу Монгол залууг амьдаар нь барьж ирсэн хүнд их алт мөнгө өгнө гэж зар тараав.

Хааны зарыг гурван хүүтэй нэг хүн олж сонсоод “Тэр залууг би барьж өгч хааны их шан харамжийг авъя” гэж бодоод, хаанд гурван хүүгээ дагуулан очиж, ам тангараг өгчээ.

Тэр хүн гурван хүүдээ ижил зүсмийн хар морьд унуулаад сайн эрийн мөрөөр мөшгиж явав. Явсаар нэгэн малчин эмгэнийд хүрч учир явдлаа хэлж асуусанд эмгэн дотроо “Энэ муусайн тэнэг малууд, Монголчуудын дундаас нэг ч гэсэн сайн эр гарч Манжийн хааныг эсэргүүцэж байхад, Монголын төлөө зүтгэхгүй Манжийн хааныг дэмжиж монголоо барьж өгнө” гэнээ гэж бодоод:

- Мэдэхгүй, мэдэхгүй гэж хэлээд цай чанаж эхэлтэл гурван хүү яарч:

- Бид яарч явна. Цай уухгүй гэж хэлээд гарч явцгаав.

Эмгэн араас нь гарч “Болсон идээнээс амсаж мэддэггүй улс уу?” гэж хэлээд халуун цайгаа араас нь цацчихаад гэртээ оров.

Тэр үед мөнөөх сайн эр эмгэний гэрийн ойролцоо овооны ард нуугдаж байжээ. Гурван хүү ар араасаа цуварч овоон дээр гарч ирэхэд сайн эр өөдөөс нь буугаа онилж, онилж:

- Хааны амталсангүй суманд та гурав торчихлоо гэж хэлээд ах дүү гурвыг зэрэг буудаж алжээ.

Түүнээс хойш Монгол хүн унаатай явахдаа ар араасаа цуварч явахыг цээрлэж “Амгай зуузай холбож, гөлөм тохош харшилж байна” гээд зэрэгцэж явдаг болжээ.

Ууль шувуу хавар дуугардгийн учир

Хөдөө газар Ууль гэгч нэгэн зүйлийн шувуу байдаг. Тэр шувуу хавар болохоор учиргүй орилж бархирдаг гэнэ.

Ууль бол өөрийн хүчээр төрж, өндгөө гаргаж чаддаггүй зовлон ихтэй шувуу юм. Тэр шувуу хаврын улиралд өндөглөхдөө заавал шинэ зандан модны замбага үнэрлэж байж төрдөг. Тэгээд эр Ууль нь зандан модны замбага олохоор явсан хойгуур эм Ууль нь:

- Би өндөглөх гэж байна. Хурдан зандан модны замбага олж ир! хэмээн орилж бархирч байгаа нь тэр юм гэнэ.

Тэмээ үнсэн дээр хөрвөөдөг болсны учир

Эрт урьд цагт тэмээ хулгана хоёр тааралдаж, нар аль зүгээс манддаг тухай маргаж гэнэ. Тэмээ:

- Нар яахын аргагүй өмнө зүгээс манддаг гэхэд хулгана:

- Юу гэсэн үг вэ? Нар хойд зүгээс манддаг гэж маргалдав.

Тэгээд тэмээ, хулгана хоёр хэн хэн нь бууж өгсөнгүй тул маргааш өглөөний нар гарахыг харъя гэж хэлэлцэж тохиров. Тэмээ өмнө зүгрүү харан хивж хэвтгэл хулгана тэмээний бөхөн дээр үсрэн гараад хойд зүгрүү харж нар гарахыг хүлээж суув. Өглөөний нар гарахын алдад тэмээний бөхөн дээр хойшоо харж суусан хулгана хойд уулын орой дээр туссан нарны гэрлийг түрүүлж хараад:

- Нар гарчихлаа. Тэр хойд зүгээс гарч байна гэж хашгирсанд тэмээ эргэж харсанд үнэхээр хойд уулын оройд нарны гэрэл туссан харагдав.

Тэмээ хулганад чадуулсандаа уурлаж биеэ шилгээсэнд хулгана үсэрч буугаад хажууд нь байсан үнсрүү гүйгээд орчихож гэнэ.

Түүнээс хойш тэмээ хулганд уурлаж үнсэн дээр хөрвөөдөг болсон юм гэнэ.

Хар ус хүнд өгдөггүйн учир

Монголчууд эрт дээр үеэс гаднаас ирсэн зочин гийчиндээ хар ус хийж өгдөггүй заншилтай. Юунаас ийм заншил тогтсон нь түүхтэй юм гэнэ.

Эрт урьд цаг, нэгэн баян айлд хавчиг үүрсэн бадарчин ирж гэнэ. Тэр айлын эзэгтэй дуртай дургүй бадарчинд цай хийж өгөх гэсэнд, өнөө бадарчин:

- Хэрэггүй, хэрэггүй. Би яаруу явж байна. Та харин надад андуутай хүйтэн уснаасаа нэг шанагыг хийгээд өгчих гэж гэнэ.

Айлын хүнд харин ч сайн юм болж, хурдан гэгч гантай хар уснаасаа гутгаж өгөв. Бадарчин шанагатай түүхий усыг авч залгилчихаад цааш явж байтал замдаа гэдэс нь өвдөөд болохоо байж, бие зассанд мөнгөөр хүндэрч гэнэ.

Түүнээс хойш тэр бадарчингийн амьдрал өдрөөс өдөрт сайжирч, үеийн үедээ баяжсан бөгөөд харин бадарчинд хар ус хийж өгсөн баян айл өдрөөс өдөрт муудаж, үеийн үедээ ядуу зүдүү амьдарсан гэдэг.

Тэр бадарчин жирийн хүн биш байсан учраас зориуд баян айлын буяныг авахаар очсон байжээ.

Тийм учраас Монгол хүн хүн ирэхээр хүндэтгэж халуун хоол унд хийж өгч, хар ус өгөхийг ихэд цээрлэдэг болжээ.

Буруудвал барагдана

Урьд цагт нэгэн баян айл хоёр охинтой байжээ. Мал сүрэг олонтой болохоор ааруул, ээзгийгээ гэрийнхээ гадаа хадан овоолж хатаадаг байж гэнэ.

Хоёр охин нь өдөржин өнөө овоолгоотой ээзгий, ааруулаараа “Энэ хатаж уу? Тэр хатаж уу?” гэж бие биерүүгээ шидэж тоглодог байжээ.

Нэг өдөр баяны хоёр охин мөн л идээ цагаага хаялцаж наадаж байтал нэг ядуу айлын охин мал тэмээ эрж яваад өлсөж харангадаад тэр айлд иржээ. Баян айлын хоёр охин үзээгүй юм шиг янз гаргаж, нааддагаараа наадаж, ядуу охинд цай хоол хийж өгөх байтугай, өрөм ааруулнаасаа ч ганцыг авч өгсөнгүй явуулчихжээ.

Орой аав ээж нь харьж ирэхэд хоёр охин нь өдрийн учраа хэлжээ. Аав ээж нь түүнийг сонсоод:

- Тэгж болдог юм уу? Хүн амьтан ирэхээр та нар цай хоол хийж өгөөд, өрөм ааруулнаасаа идүүлж бай! Буян болно гэж хэлэхэд, хоёр охин нь:

- Юуг буян гэдэг юм? гэж асуужээ. Аав, ээж нь:

- Буян хийнэ гэдэг бол хүн амьтанд тус хүргэхийг хэлдэг юм. Жишээлбэл: Бид өрөм ааруулаа улам арвитгая гэвэл ядуу зүдүү хүмүүст өгч байх хэрэгтэй. Тэгвэл бид улам баян явна гэж захиж сургасанд, охид нь учрыг ойлгосонгүй:

- Бидний хоол унд ийм арвин байхад юунд барагдах юм? гэж хэлээд өнгөрчээ.

Түүнээс хойш удалгүй баян айлын буян барагдаж, хоосорсон гэдэг.

Ийм учраас Монголчууд будаа хоолоо хамаагүй асгаж хаявал буян барагдана хэмээн ихэд цээрлэж, хүн амьтан ирэхэд заавал ч үгүй цай хоол хийж өгдөг болсон гэнэ.

Замын голоор явдаггүйн учир

Эрт урьд цагт Агваандандар хэмээх хүн зууд очиж ном эрдэм сураад, их эрдэм сурч, алдар нэр олоод нутагтаа буцахад багш нь:

- Чи нутагтаа харих замдаа замын дундуур битгий яв гэж захижээ.

Агваандандар замдаа “Багш юунд ингэж хэлсэн юм бол?” гэж бодоод учрыг олоогүй боловч багшийнхаа хэлсэн ёсоор замын хөвөөгөөр явж байв.

Нэг өдөр, ядарч явсан Агваандандар замын хөвөөнд амарч үдлэхдээ барьж явсан таягаа санамсаргүй замын гол дунд хатгачихаад, замын хажууд цай чанаж суутал гэнэт хүчтэй хуй салхи ирээд түүний замын голд хатгаж тавьсан таягийг нь хугалж хаяжээ.

Агваандандар түүнийг үзээд ардын дунд “Хуй салхи бол үхсэн хүний сүнс байдаг” гэдэг яриаг санаж, чөтгөр замын дундуур явдаг юм байна гэдгийг мэдээд багшийнхаа захиасны учрыг сая ойлгожээ.

Тиймээс монгол хүн замын дундуур явахыг цээрлэдэг болсон гэнэ.

Хулгана, арван хоёр жилийн эхэнд орсон нь

Эрт урьд цагт, хулгана арга мэхээр хэнийг ч дийлдэг сүрхий зальтай амьтан байжээ.

Хүн анх удаа цаг хугацааг арван хоёр жилээр үечилж амьтны нэрээр нэрлэх болжээ.

Тэгээд орчлонгийн амьтдаас арван хоёр төрлийн амьтныг сонгож, дэс дарааллыг тогтоохоор болсонд бүгд хамгийн эхэнд орно гэж булаалдаж, үймээн шуугиан болов гэнэ. Тэгэхээр нь хүн арга бодож:

- Та нарыг уралдуулаад, түрүүлж ирсэн дэс дарааллаар нь тогтооё гэж зарлиг гаргаад, хурсан олон амьтдыг уралдуулахаар болов.

Олон амьтан арван хоёр жилийн эхэнд орохын тулд чинээ мэдэн, бүх хүчээ шавхан уралдаж эхлэхэд хулгана аль хэзээний үхрийн эвэр дээр үсэрч гараад суучихаж гэнэ. Тэгээд амьтан бүр давхисаар зорьсон газартаа цувралдан хүрч ирэхэд, зальт хулгана үхрийн эвэр дээрээс ганц үсэрч буугаад хамгийн түрүүнд орж, арван хоёр жилийн эхэнд орсон гэнэ.

Эрвээхэй гал уруу ордог болсны учир

Эрт урьд цагт эрвээхэй чөтгөрийн хүргэн болохыг хүсдэг байжээ. Нэг өдөр, эрвээхэй чөтгөрийнд нисэн ирж хүүхнийг нь гуйсанд, чөтгөр тун дургүйцэж, хүүхнээ өгөхгүй арга бодож олоод:

За, яахав би чамд хүүхнээ өгч болно. Гэхдээ чи миний нэг хүслийг заавал биелүүлэх хэрэгтэй. Биелүүлж чадвал миний хүүхнийг аваарай гэж хэлэхэд, эрвээхэй:

- Болно, болно. Тэгье гэж хэлэв. Чөтгөр:

- Чи явж шөнө миний гэрийг гэрэлтүүлэх асаасан гал авчирч өгөх хэрэгтэй байна. Тэгвэл би чамд хүүхнээ өгнө гэв. Эрвээхэй чөтгөрийн хүргэн болохын тулд түүний гэрийг гэрэлтүүлэх асаасан гал аваачиж өгөхөөр яваад эргэж ирээгүй гэнэ. Түүнээс хойш эрвээхэй гал үзвэл орж, түлэгдэж үхдэг болсон юм гэнэ.

Муур баасаа булдгийн учир

Эрт урьд цагт муур хулганы багш байжээ. Тэр өдөр бүр хичээлээ заачихаад хулганыг жагсааж явуулаад тоог нь авдаг байв. Өдрөөс өдөрт хулганууд цөөрөөд байхаар нь тэд:

- Муур багш биднийг өдөр бүр тоолоод байхад яагаад өдрийн нэг цөөрөөд байгаа юм бол? Арай муур багш барьж байгаа юм биш биз? гэж ярилцаад, муур багшийн баасыг шалгаж үзэхээр болж тохиров. Тэгээд муурын баасыг шалгаж үзсэнд дотор нь хулганы ноос, үс байна гэнэ. Хулганууд муур багш өөрсдийг нь барьж идээд байгааг мэдээд, дахиж идүүлэхгүйн тулд нэг арга бодож олоод муур багшид нэг хонх бэлэглэхэд тэр баярлан хонхыг авч хүзүүндээ зүүжээ. Маргааш нь муур урьдын ёсоороо хулгануудыг жагсаагаад нэг нэгээр нь тоолж гаргаж байгаад хамгийн сүүлчийн хулганыг барьж авгал хонх нь дуугарав. Олон хулгана эргэж харсанд муур багш нэг хулганыг барьж аваад идэх гэж байв. бүгдээрээ буцаж ирээд:

- Багш, юу хийж байна вэ? гэж асуухад, муур сандарсандаа:

- Би хулганыг сургаж байна гэж хариулжээ. Хулганууд:

- Тэгвэл таны баасан дотор яагаад бидний ноос, үс байдаг юм бэ? Яагаад бид өдөр бүр нэг нэгээр цөөрөөд байдаг юм? гэж асуусанд муур хэлэх үггүй болсон бөгөөд үүнээс хойш муур хулганад баригдахгүй гэхдээ баасаа булдаг болжээ.

Үхсэн хүнийг мууранд үзүүлдэггүйн учир

Эрт урьд цагт нэг эмгэн ганц хүүтэй байсан ба хүү нь цэрэгт яваад гурван жил болов. Дараа нь хажуу хавийн айл нь “Энэ эмгэн ганцаараа юу хийж байгаа бол” гээд очиж үзсэн чинь эмгэн аль эрт өнгөрөөд муур нь түүнийг идээд хоёр муур болчихсон байжээ. айлын хүн түүнийг үзээд айж “Муур эмгэнийг идчихээд чөтгөр болчихжээ” гэж хүүд нь хэл дуулгав.

Хүү нь харьж ирээд ээжийгээ оршуулах гэсэнд хүний мах идэж чөтгөр болсон муур нь дийлдсэнгүй гэнэ. Тэгээд аргаа бараад лам залж:

- Муур, ээжийн минь цогцосыг идээд заримдаа нэг, заримдаа хоёр болчихоод байх юм. Энэ ямар учиртай бол? Танд арга чарга байна уу? гэж асуухад лам үзэж байснаа:

- За, үүнийг дарахад амаргүй юм байна. Би дарж үзье. Хэрвээ би дарж дийлэхгүй бол муур чинь гурав болно. Тэгвэл их хэцүү юм болно. Та нар түлээ бэлдэж гэрийн гаднаас хүрээлж босго. Би хонх, дамраа бариад орёе. Хэрвээ хонх дуугарч байвал би хүчирч байна гэсэн үг. Харин хонхны дуу тасарч, дамар дуугарах юм бол би дийлэгдэж байна гэсэн үг. Тэр үед түлээрүү гал хийж асаагаарай гэж хэлээд оров.

Залуу хэдэн хүн цуглуулж, түлээ түүж, гэрээ тойруулж босгоод чагнаж суутал хонхны дуу дуу гарч дараа нь муур бархирч байгаад чимээ тасрав. Төд удалгүй хонхны дуу ч үгүй болж, дамарны дуу гарахад залуу түлээндээ гал өгч шатааж гэнэ.

Тэгээд залуу ээжийнхээ цогцос болон муур, лам гурвыг гэртэйгээ хамт шатааж чөтгөрийг дарсан бөгөөд түүнээс хойш хүний хүүрийг мууранд үзүүлэхгүй хэмээн ихэд цээрлэж иржээ.

Хэрээ айлын үнсэн дээр суудаг болсон нь

Эрт урьд цагт Шарай гол гэдэг газарт ах дүү гурван сайн эр байж гэнэ. Дараа нь ах, дүү гурвуулаа хаан суув. Их ах нь сайхан цагаан эсгий гэртэй, дунд ах нь шар эсгий гэртэй, бага дүү нь хар эсгий гэртэй юм гэнэ.

Нэг өдөр, их ахынх нь хатнаас хүү төрж гэнэ. Хүү нь том болж, ах дүү гурван хаан түүнд хатан залахаар болж, бүх цэрэг, морь, унаа хөсгөө хөдөлгөж орчлонгийн хамгийн гуа сайхан эмэгтэйчүүд бүсгүйчүүдийг булаан авахаар болов.

Тэгээд нэгэн мэргэн хүнээс асуусанд маш олон цэрэг морио алдах учраас өөр аргаар хайж олохыг зөвлөжээ. Ах дүү гурван хаан мэргэний хэлэхийг сонсоод яаж зарлага багатайгаар хүүдээ хатан олж өгөхийг ярьж хэлэлцсэний дараа хар хэрээг дуудаж ирүүлээд:

- Чи явж, энэ дэлхийн хаана, ямар гоо хатад буйг мэдэж ир! гэж явуулав.

Хар хэрээ, хааны зарлигаар Төвдийн өндөрлөг, Шинжааны элс, Ар халхын говиор явж хайсан боловч гуа сайхан хатан олсонгүй гэнэ. Явж явж гурван жилийн дараа эргэж иржээ. Хэрээ:

- Шарай голын гурван хаан аа, алс хол явсан гавьяатай хэрээ үүргээ биелүүлээд ирлээ гэж дуугараад нисч байв.

Ах дүү гурван хаан хар хэрээний хэлэхийг сонсоод аргагүй биз дээ. Тийм хол газар удаан явж ирсэн амьтан юм чинь гэж хонь алаад бүтэн ууц тавиад:

- За, гавьяатай хэрээ минь, та энэ шүүсэн дээр бууж суугаад үгээ хэл гэж залав.

Хар хэрээ хонины ууцан дээр буусангүй.

- Гавьяатай хэрээ ирлээ, Гавьяатай хэрээ ирлээ гэж хашгираад нисээд байжээ.

Ах дүү гурван хаан түүнийг үзээд “Энэ хар хэрээ хонины ууц чамлаж байна, аргагүй биз” гэж бяруу алж тавиад:

- Гавьяатай хар хэрээ энд буугаад үгээ хэл гэсэнд бас бууж ирсэнгүй.

- Гавьяатай хэрээ ирлээ, гавьяатай хэрээ ирлээ гээд нисээд байв.

Ах дүү гурван хаан яаж буулгаж ирэх аргаа олохгүй сандарч байтал хэрээ тэнгэрт эргэж эргэж байгаад:

- Гурван хаантаан, энэ хурмаст тэнгэрт гурван сайхан дагина байна. Нэгийг нь гуйвал авч болох юм. Нэгийг нь хулгайлвал авч болох юм. Бас нэгийг нь булаавал авч болох юм байна гэж хэлээд нисч байна гэнэ.

Ах дүү гурав хэрээний хэлэхийг сонсоод “Энэ ч сайхан үг байна. Хар хэрээ үнэхээр үүргээ сайн биелүүлж иржээ” гээд ах хаан өөрийнхөө мөнгөн дугараа гаргаж тавиад, хэрээг:

- За, гавьяатай элч минь, та мөнгөн дугар дээр залран сууж үгээ хэл гэж залсанд хэрээ мөн л бууж ирсэнгүй. Тэрээр:

- Энэ газар доор лусын хааны зургаан сайхан охин байна. Гэвч та нар түүнийг авахад туйлын хэцүү гэж хэлчихээд нисээд байв. Ах дүү гурван хаан түүнийг сонсоод:

- Гавьяатай элчин хар хэрээ минь, тэнгэрийн дагина, газрын лусын хүүхнүүдийг бид авчирч чадахгүй. Энэ Төвдийн өндөрлөг, Шинжааны элс, Ар халхад сайхан хүүхнүүд байхгүй юм уу? Та энэ дээр бууж суугаад үгээ хэл хэмээн их хаан алтан дугараа гаргаж хар хэрээг залав. Хар хэрээ мөн буулгүйгээр:

- Энэ Төвдийн өндөрлөгт Рогма гуа гэдэг нэртэй, нар сар шиг гэрэлтэй, навч цэцэг шиг өнгөтэй, дэлхийд олдомгүй сайхан хатан байна. Гэвч та нар түүнийг авахын тулд их дайн дажин болно гэж хэлээд нисээд байжээ.

Ах дүү гурван хаан хар хэрээг “Бууж ирээд үгээ хэл” гээд орчлонгийн бүх үнэ хүндтэй ёсоор залсан ч огт бууж ирсэнгүй гэнэ. Тэгэхээр нь гурван хаан уурлаж, энэ лав бидний явуулсан хэрээ биш байх, хаанаас ийм хэрээ гарч ирээд биднийг дооглоод байгаа юм бол? буудаад алчихья гэж хэлээд буудах гэсэнд хэрээ айж сандрахдаа гэрийн гаднах үнсэн дээр шургаж унаад:

- Гурван хаантаан, амийг минь өршөө, би гурван жил явсан боловч юу ч олсонгүй, сая миний хэлсэн бүхэн худлаа гэж хэлээд буруугаа хүлээж, амь гуйж гэнэ.

Түүнээс хойш хар хэрээ айлын гаднах үнс, хогон дээр суудаг болсон юм гэдэг.




Тэмээний засаа ардаа байдгийн учир

Эрт урьд цагт, бурхан багш орчлонгийн амьтанд засаа хувааж гэнэ. Тэмээ замдаа уужуу тайвуу идээшилж явсаар цагаасаа хоцорсон тул засаа дуусчихсан байжээ. Тэгээд засаа нэхээд байхлаар нь бурхан багш аргагүйдэж энд тэндээс эвлүүлж байгаад жаахан засаа олж өгчээ. Тэгсэн чинь тэмээ уурлаж:



- Би ийм том биетэй байж, тийм жаахан засаагаар яах юм гэж хэлээд бурхан багшийн өгсөн засааг авалгүй цаашаа эргэж явсанд бурхан багш араас нь:

- Чи цагаасаа хоцорч ирчихээд бас том засаа авна гэнэ ээ? Яасан их санаатай амьтан бэ? Авсан ч энэ байна. Аваагүй ч энэ байна гэж хэлээд араас нь шиджээ.

Тэр шидсэн засаа нь цаашаа явж байсан тэмээний ар гуяны завсарт нь наалдаж тогтсон гэнэ. Тэгээд тэмээний засаа жаахан мөртөө ар гуяных нь хооронд хавчуулаатай байдаг нь тийм учиртай юм гэнэ.



ТҮҮХЭН
ДӨМӨГ ҮЛГЭР





Хавт Хасар хараалч Тангудыг дарсан нь

Эрт цагт Чингис хаан Тангудыг дайлахаар явж байтал замд нь нэг Ооль шувуу бархирч гэнэ. Чингис хаан түүнийг сонсоод:

- Муу ёрын шувуу бархирч байна. Хурдан харваж ал! гэж тушаав.

Чингис хааны дүү хавт Хасар нумаа сааж байгаад харвасанд сум нь Оолийг харвасангүй цаана нь байсан шаазгай шувууг харваж алав.

Тэр үед, Чингис хааны хажууд Хавт Хасарт тун дургүй, санаа муутай түшмэл байжээ. Тэр өнөөх завшааныг ашиглаж хавт Хасарыг хорлоё гэж бодоод, Чингис хаанд:

- Хаантаан, энэ хавт Хасар сахилга батыг эвдэж, архи дарс ууж, эхнэр эмс эргүүлж, элдэв муу ажлыг хийгээд таны үгийг сонсохоо больжээ. Та уг нь Оолийг ал гэж байхад шаазгайг алчихлаа гэж ховлож гэнэ. Чингис хаан энэ үгийг сонсоод уур нь хүрч:

- Тэр тийм бүтэхгүй юм бол хурдан барьж, дөрвөн мөчийг нь хүлээд, худгийн ёроолд хая гэж зарлигдав. Муу санаат түшмэлийн бах тав нь ханаж, Хавт Хасарыг барьж хүлээд худгийн ёроолд хаяж оруулав. Чингис хаан цааш явж, Тангудын нутагт ирэхэд дайн хийхийн аргагүй улаан шороо нүдэж байв. Аргагүйдэж мэргэн хүнээр төлөг буулгуулж асуухад:

- Ноднин жил манай энд хараалч хар Тангуд ирсэн юм.

Тэр эхнэртэйгээ нийлж хараал тавьснаас хойш улаан шороо нүдээд зогсохоо болив гэж хэлэв. Чингис хаан түүнийг сонсоод хараалч Тангудыг, эхнэртэй нь хамт ал гэж тушаав. Цэргүүд нь хэчнээн харвасан боловч хоёр хараалч дийлдсэнгүй гэнэ. Эцэст нь дахин нэг мэргэнээс асуухад, мэргэн хүн:

- Таны цэргүүд энэ хоёр шулмыг дийлэхгүй юм байна. Харин нэг л хүн дийлнэ. Тэр хүн одоо муу хүнд хорлогдон, далан харын нэг худаг дотор хүлээтэй хэвтэж байна гэж хэлжээ. Чингис хаан муу хүний мэхэнд орсноо мэдэж, муу түшмэлийг алж, элч томилж:

- Та нар хурдан буцаж, хавт Хасарыг гаргаж, зуун хар хонь гаргаж, биеийг нь тэнхрүүлээд, Хэрээ шорогт суугаа хараалч эр, эм хоёрыг дар гэж явуулав.

Хавт Хасар гарч ирээд, зуун хар хонины шөлөөр биеээ тэнхрүүлж, хүч чадалтай болоод, нум сумаа гаргаж, Хэрээ шорог гэдэг газар уруу нар гарахад онилж, нар жаргахад харваж тавьсан гэнэ. Сум нь явсаар шулам эмийг онож гаталсанд өнөө шулам Улаан мөрөнрүү унаж үхэв.

Шуламын цуснаас болж Улаан мөрний ус одоо болтол улаан байдаг нь тийм учиртай гэнэ. Тэр сум эм шулмыг нэвт гаталж, хараалч хар Тангудын хөлийг нь хугалж шархдуулжээ. Шархадсан хараалч Тангуд унахдаа хажуудаа байсан том хамхагаас шүүрч босох гэтэл өнөө хамхаг нь үндсээрээ булга татагдан унаж гэнэ. Уурласан Тангуд:

- Ургахаараа урга, үндсээрээ эргэ гэж хараажээ. Түүнээс хойш хамхаг одоо болтол үндэсгүй болсон гэнэ. Тангудын хажуугаар нэг луус явж өнгөрөхөд түүний ноосноос татаад босох

гэтэл луус үргээд цааш зугтаажээ. Тангуд мөн уурлаж:

- Төрөхөөрөө төр, төрсөн нь төрөлгүй бол гэж хараав. Тийм учраас луус одоо болтол үргүй байдаг нь тийм учиртай гэнэ. Тангуд улам уурлаж “Энэ муу хавт Хасар яагаад ийм сүрхий харвадаг юм” гэж төлгөө татаад үзсэнд, зуун хар хонины шөл ууснаас тийм их хүчтэй болсон юм байжээ. Тэгээд хараалч Тангуд:

- Муусайн хар хонинууд өсөхөөрөө өс, нэг сүрэгт зуу битгий хүр гэж хараагаад үхжээ.

Тийм учраас нэг айлын хотонд хар хонь цөөхөн болсон гэнэ.

Онъ гарт баатар

Эрт урьд цагт халхчууд Алшад Онъ гарт баатар гэдэг цуутай дархан хулгайч явуулж гэнэ. Тэр хулгайч Алшад ирээд хүн амьтны эд хөрөнгө, адуу малыг хулгайлаад ер болохгүй болохоор нь Алша ноён хэдэн хүнээр түүнийг бариулахаар явуулжээ. Онъ гарт баатар үүнийг сонсоод Алшагаас дутааж, Ма Цүнд* очиж нэг уулын агуйд нуугдаж суув.

Алша ноёны томилсон хүмүүс Онъ гарт баатрыг мөрдөж хүрээд, түүнтэй тэнхээ мэдэн тэмцэлдэж байж, арайхийж барьж хүлэв. Онъ гарт баатар:

- Би энэ насандаа та нарын адуу малыг хулгайлж байгаад баригдлаа. Хожим миний бие адуу малыг чинь үлдээхгүй иднэ гэж андгай тавьжээ. Түүнээс хойш Ма Цүнд чоно тасардаггүй болсон гэнэ.

Тоорой банди

Эрт урьд цагт Ордосоос Алшад Тоорой банди гэдэг сайн эр ирж гэнэ. Тэр хулгайч хүн амьтны адуу мал, эд хөрөнгийг тонож дээрэмдээд болохгүй болохоор нь Алша ноён олон цэрэг томилж явуулсан боловч ер барьж чаддаггүй байж гэнэ.

Нэг өдөр хэдэн цэрэг санаандгүй явж байгаад айлын гадаа Тоорой бандитай халз тулгарч барьж авч гэнэ.

Тоорой банди арга гаргаж, тэдний гараас мултрахыг бодож их номхон царайлж:

- За, би та нарт нэгэнт баригдсан хүн, одоо хаашаа дутаах билээ? Миний энэ морь олон жил надад хань болж их тус хүргэсэн юм. Одоо би морио тавьж явуулчихаад та нартай явья гэж хэлээд морио тавихдаа:

Морь минь ээ, одоо би ч үхэх юм байна. Энэ насандаа би үзээгүй бүхнийг үзэв. Бээжин хотыг ч үзлээ. Гэтэл харамсалтай нь ногоон хурганы арьс үзээгүй, цагаан хилэн үзээгүй, эвэртэй туулай үзээгүй, соёотой тугал үзээгүй гэж олон юм хэлэв.

Цэргүүд Тоорой бандийн элдэв сонин яриаг сонсоод туйлын их сонирхож, түүний мэхэнд бага багаар орж байгааг мэдээд дотроо баярлаж, морио тавьж байгаа хүн болж мориныхоо эмээлийг авч газарт тавиад морио илээд:

- За, чиний энэ туг сүүлийг түмний нохой барсан юмаа, тохох нурууг нь Тоорой банди барсан юмаа гэж хэлээд нэг хурганы арьсан дээлийг гартаа барьж:

- Арал тайжийн хүүхэн хуруутай хэмээн оёж өгсөн юмаа, Тоорой банди ч хувьтай хэмээн өмсч элээсэн юмаа гэж хэлээд эмээл, хазааргүй морин дээрээ хаяад:

- За, үхэх хүн гурван амьсгаа авдаг юмаа, алагдах хүн гурван үгээ хэлдэг юмаа гэж өнөө цэргүүдэд олон үгээ дэлгэж хэлэхэд, тэдгээр цэргүүд ч Тоорой бандийн үгэнд уярч, сэрэмжээ алдан, буу зэвсгээ газарт тавьж, түшин зогсоход, Тоорой банди мориндоо үсрэн мордож, мориныхоо баруун талруу нэг сайн алгадсанд морь нь нисэх мэт хурдан давхиж одов. Энэ үед тэр хэдэн цэрэг сая ухаан орж, буугаа авбал, Тоорой банди аль хэдийн товцог давж алга болсон байв. Ингээд Тоорой банди урьдын адил бас нэг удаа баригдсангүй мултарч гарсан тул цэргүүд хоосон буцаж Алша ноёнд мэдэгдэв. Алша ноён дотроо “Энэ Тоорой банди ерийн хүн биш байх, тэгээд амар баригдахгүй байна” гэж бодоод:

Хэн Тоорой бандийг барьж чадвал түүнд арвин алт, мөнгөөр шагнана гэж зар тараав. Энэ зар дамжигдсаар ганц бие эмгэний чихэнд хүрэв.

Нэг өдөр Тоорой банди тэнүүчилж яваад өнөөх эмгэнийд хүрч ирэв гэнэ. Эмгэн Тоорой бандийг таниад, ихэд сайхан загнаж, амттай хоол ундаар дайлж, торгон хөнжил засч унтуулав. Тоорой банди “Ганц хөгшин эмгэн намайг яаж ч чадахгүй” гэж бодоод сэрэмж алдаж ажиггүй унтав. Шөнө, Тоорой бандийг унтсаны дараа өнөө эмгэн сэм босч, нэг гадас улайсгаж байгаад Тоорой бандийн амаар нь цоргиулж алав.

Тоорой бандийг үхсэний дараа эхнэр нь нөхрөө санаж:

Арван наймтай Тоорой минь

Албан яаманд баригдаагүй шүү

Хорь хүрээгүй Тоорой минь

Хуулийн яаманд баригдаагүй шүү гэж дуулдаг байсан ба сүүлдээ амьдрал нь доройтож ирэхэд эр нөхрөө дурсаж:

Тоорой банди минь байхад

Торгоны сайныг өмсдөг байлаа

Тоорой бандиа алдсанаас хойш

Тостой торго ч олдохгүй болжээ гэж гансран дуулдаг байсан гэнэ.

Зүүн гарын дайн

Эрт урьд цагт нэг сүмд их сүрхий урвалга гарсан гэнэ. Манжийн хаан Алшагаас цэрэг татаж, урвалгыг дарсан гэдэг. Тэр дайныг зүүнгарын дайн гэдэг.

Тэр урвалга гарсан сүмийн лам нар нэг ёрч өвгөн, нэг ёрч ингэ, нэг ёрч тахиа бэлтгээд дайн дажин гарах эсэхийг урьдчилан мэддэг байжээ.

Тэр гурван ёрч туйлын мэргэн тул ямар нэгэн газраас цэрэг хөдөлгөхийг мэдээд ингэ нь буйлж, тахиа нь донгодож, өвгөн нь “Дайн ирлээ” гэж хашгирдаг байв.

Урвалга гаргасан лам нар ч дайнаас сэргийлж, сүмийнхээ хүрээний хавиар дүүрэн ган, харуул зогсоосон тул өөр бусад цэрэг тийм амар ойртож чадахааргүй байв.

Ингэж нэлээд удсаны дараа Зүүнгарын улс нэг арга гаргаж, цэрэг морио цуглуулж аваад, тараачихаад, дахин цуглуулж аваад тараачихаад байв.

Зүүнгар, цэрэг морио цуглуулж эхлэхэд ёрч ингэ буйлж, тахиа донгодож, өвгөн нь хашгирдаг байв.

Ингэж олон удаа худал ёролж, дан ирэхгүй болохоор нь сүмийн лам нар уурлаж, ёрч амьтдаа бүгдийг сүмээсээ хөөгөөд гаргачихаж гэнэ.

Урвалга гаргасан лам нар зүүнгарын мэхэнд орж, төд удалгүй тэдний цэрэгт олзлогдов. Зүүнгарын дайн ялалт олсны дараа олзлогдсон урвагч лам нарыг Манжийн хаан өөрийн биеэр шүүхээр болж, хамгийн түрүүнд толгойлогч ламыг шүүж эхлэв. Манжийн хаан ламаас:

- Чамайг хэн авчирсан бэ? гэсэнд лам:

- Тэр хамгийн сүүлд бүргэдийн суудлаар сууж буй залуу гэв. Хаан:

- Тэр урвагч ламыг барьсан Зүүнгарын толгойлогч залуу нааш ир гэж дуудав. Залуу хааны дэргэд ирж мөргөхөд, хаан:

- За, би чамайг гүн жинсээр шагнаж гэж хэлэхэд, залуугийн нагац ах их сүрхий хүн бөгөөд ард нь зогсож байснаа залуугийн хормой дээр гишгээд босгосонгүй. Тэгснээ:

- Хөөе, хаан чамайг гүнжээрээ шагнаж гэж байхад, хурдан мөргө! гэж дахин мөргүүлэв. Хаан гайхаж:

- Чи андуу сонсоно гэж ямар сонин юм бэ? Гэхдээ яахав, чи өөрөө миний догшин гүнжийг таньж чадвал хатнаа болгож ав л даа гэж ам алдав.

Залуу Манжийн хааны догшин гүнжийг хатнаа болгож авахаар болсон боловч, асрагч эхтэй нь нийлээд 108 хүүхэн бий гэж сонссон тул тэдний дундаас хааны догшин гүнжийг олж авна гэдэг туйлын бэрх явдал байв.

Залуу, нагац ахтайгаа нийлж, нэлээд судалж явсны эцэст гүнжүүдийг харгалзагч нэгэн эмгэн байдгийг олж мэдэв. Тэр хоёр харгалзагч эмгэнтэй уулзаж, учир байдлаа ярьж, ихээхэн мөнгө зоос төлсний эцэст туслахыг гуйхад эмгэн:

- Би ч хэлэх нь хэлж болно л доо. Гэхдээ та хоёр эхлээд гурван алд нүх малтаж, гурван төмөр гадас шааж, нэг цуу тогоон дээр нэрж, намайг дотор нь суулгаад, дээрээс шигшүүрээр бүрхэж, нэг урт гуулин гуурс шургуулаад тавьчих. Тэгвэл би хэлж өгье. Учир нь хааны зурхайч намайг хэлж өгснийг мэдчихвэл би алуулна гэв.

Залуугийн нагац ах эмгэний хэлснээр бүгдийг бэлэн болгож, ёсоор болгов. Эмгэн:

- Хааны догшин гүнж бол баруун нүд нь даруу, баруун эгэм дээрээ сувдаар зөв эргүүлж зөгий оёсон, зүүн эгэм дээрээ сувдаар буруу эргүүлж, зөгий ороосон өндөр биетэй хүүхэн бий гэж хэлж өгөв.

Алша залуу нагацтайгаа хааны догшин гүнжийн өмсгөл засал, дүр байдлыг ойлгож мэдээд гүнжийг авах бэлтгэл ажлаа хийв.

Тэгж байтал удалгүй, Манжийн хаан Алша залууд гүнжээ таниулах цаг нь болж, 108 гүнжээ дуудан ирүүлж, дотроос нь таньж ав гэв. Алша залуу нагацтайгаа хадгаа дэлгэж, тэр олон хүүхнийг ажиглаж үзсэнд, бүгд өндөр биетэй, ижилхэн өмсгөл засалтай байжээ. Аль нь догшин болохыг таньж мэдэхийн аргагүй болж, горьдлого тасрахын үед, хамгийн сүүлийн эгнээний гуравдугаарт эмгэний хэлсэн баруун нүд нь даруу, баруун эгэм дээрээ сувдаар зөв эргүүлж, зөгий ороосон, зүүн эгэм дээрээ сувдаар буруу эргүүлж, зөгий оёсон өндөр биетэй хүүхэн зогсож байв. Залуу:

- Ажиглаж харвал адил сохор, шинжиж харвал шинэ сохор гээд хүүхний хүзүүн дээр хадгаа тохов. Хаан цочиж, дотроо дургүй нь хүрч, улаан зурхайчаа дуудан асуухад:

- Доод тивээс гурван төмөр хөлтэй, цуу бөгстэй, түмэн нүдтэй, гуулин хошуутай эм шулам хэлж өгсөн байна гэж буув.

Хаан уурлаж “Дэлхий дээр тийм амьтан хаана байдаг юм” гэж зурхайчаа хөөж явуулав.

Тэгээд хаан Алша залууд жинс зүүлгэж, догшин гүнжийг хатан болгон өгөөд Алша нутгаа ачилж суу гэж явуулсан гэнэ.

Түүнээс хойш Алша хошуу байгуулагдсан бөгөөд хожим нь хүмүүс Алша ноён, догшин гүнжийг хатнаа болгож авснаас болж, Манжийн хаан улаан зурхайчаа хөөж явуулсан тул ноёны хатныг улаан хатан гэж дууддаг болсон гэдэг.

Бөхсэлэм

Эрт урьд цагт Алша хошуунд Бөхсэлэм нэртэй бөх хүн байжээ.

Нэг жил халхад их найр наадам болов. Бөхсэлэм тэр найранд орохоор явж байхад нь замд нь нэг хүүхэн чулуун онгоцонд тэмээ услаад зогсож байв. Бөхсэлэм хүүхнээс:

- Танай халхын их найр хаана болж байна ? гэж асуухад, хүүхэн Бөхсэлэмрүү нэг харснаа, ус ууж байсан нэг бүдүүн атыг ар хоёр борвиноос нь шүүрч аваад:

- Тэнд байдаг юм гэж зааж өгөв. Бөхсэлэм энэ хүүхэн ч нэлээд тэнхээтэй юм байна гэж бодоод өмнөх чулуун онгоцыг шүүрч аваад:

- Тэнд гэнэ үү? гэж хүүхний заасан зүгрүү хаячихаад явчихав.

Бөхсэлэм цааш явж байтал замд нь нэг монгол гэр таарч орсонд хөгшин настай өвгөн, эмгэн хоёр сууж байв. Хоёр хөгшин: Та хаанаас хаа хүрэхээр явж байна? гэж асуусанд Бөхсэлэм:

- Би Алша хошуунаас ирлээ. Танай энд их найр наадам болж байна гэж сонсоод үзэхээр явж байна гэв.

Өвгөн, эмгэн хоёр Бөхсэлэмд цай унд хийж өгөхөөр болж, эмгэн нь нэг бүдүүн хожуулыг хуруугаараа бяц хагалан, тулгандаа хийж, дээрээс нь хэтээ цахиж галаа асаав. Бөхсэлэм дотроо “Ийм хөгшин хүн байж яасан сүрхий тэнхээтэй юм” гэж бодож суув. Цай ууж суух зуураа нүд алдуулж байгаад өнөөх хожуулыг авч хуруугаараа эмтэлж үзсэн чинь огт дийлсэнгүй.

Тэгээд цааш явж найрын газар хүрч очиход халхын хүчит бөхчүүд ид барилдаж байв. Тэдний дунд Янжиндулам нэртэй, их тэнхээтэй бөх, учраа бөхчүүдээ нуга нуга дарж, алж байгаа харагдав. Сайн ажиглаад байсан чинь өнөөх бөх чинь замд чулуун онгоцонд тэмээ услаад зогсож байсан хүүхэн мөн байна гэнэ. Бөхсэлэм ‘Энэ охин хэдий их хүчтэй юм бол, бөхчүүдийг алаад дуусах нь, нэг барилдаад үзье’ гэж шийдээд бөхийн даамалд нэрээ бичүүлээд барилдаж эхлэв.

Бөхсэлэм, Янжиндулам хоёр таарсан бөхчүүдээ унагаж давсаар, хамгийн сүүлд барилдахаар тунаж үлдэв.

Тэр хоёр барилдсаар бүтэн өдөр болж, орой болсон хойно Бөхсэлэм Янжиндуламыг арайхийн дийлж, толгойгоор нь газарт тохой шааж алав. Халхын ноён өөрийн бөхийг нь алсанд уурлаж:

- Алшагийн бөхийг хурдан барьж, шийтгэ! гэж тушаав.

Бөхсэлэм олон хүн үймэлдэж эхлэхэд, сиймхийг ашиглан дутаан гарч, амь мултран, давхисаар өнөөх эмгэн, өвгөн хоёрын дунд хүрч ирэв. Хоёр хөгшин баярлан, өлсөж ядарсан Бөхсэлэмд цай унд хийж, үхрийн мах чанаж өгөв.

Бөхсэлэм үхрийн мах идэж, чөмгийг нь хуруугаараа имирч хугалаад сорж идэхийг өвгөн

хараад “Жирийн хүн үхрийн чөмгийг юмаар цохиж иддэг, энэ хүн имэрч балбаад идэж байхыг бодоход их хүчтэй хүн байна” гэж бодож суутал, гадаа хүмүүс үйлмэлдэж:

- Хүүе, та минь ээ! Алшагаас ирсэн бөх Янжиндуламыг дийлж алаад зугтаасан гэнэ хэмээн шуугилдаж гарав. Өвгөн:

- Энэ хүү, үхрийн чөмгийг хуруугаараа имэрч хугалаад идэж байсан. Тэр Алша бөх чинь энэ биш биз дээ? гэж хэлэхэд эмгэн нь хаалгаа дарж зогсов.

Бөхсэлэм “Одоо ч хэрэг биш боллоо” гэж бодоод ухасхийн босоод, нэг гараараа айлын гэрийг хананаас нь өргөж хаячихаад зугтааж гарав.

Ингээд Бөхсэлэм халхын бөхчүүдийг алдаг цуутай эмийг дарчихаад аав, ээжид нь баригдалгүй нутагтаа ирж, дархан цолоо мандуулсан гэнэ.

Орос улс Алша ноёнд бэлэг хүргэсэн нь

Эрт цагт Оросын хаан бэлэг хүргэх нэрээр Алша ноёныг чадах санаатай элчээ илгээжээ. Алшагийн элч заавал Орос улсад очиж бэлгээ авах ёстой гэж болзол тавив. Алша ноён итгэж, өөрийн элчээ томилж явуулав.

Алша ноёны элч явсаар Орос улсад ирэхэд, Оросын хаан өмнөөс нь ав адилхан хоёр адуу авч ирээд:

- За, чи энэ хоёр адууны аль нь эх, аль нь унага болохыг ялгаж чадвал аваад яв! Үгүй бол толгойг чинь авна гэж эрс тэс хэлэв.

- Элч хоёр адууг хэчнээн шинжиж үзсэн боловч аль нь эх, аль нь унага гэдгийг таньж эс чадсан тул тэр дороо толгойгоо цавчуулав.

Алша ноён элчээ эргэж ирэхгүй болохоор нь араас нь дахиад нэг элч томилж явуулсан боловч бас л хоёр адууг таньж чадалгүй толгойгоо авахуулсан байжээ. Тэгээд Алша ноён хэчнээн олон элчээ Орос улсруу явуулсан боловч бүгд толгойгоо авахуулжээ. Сүүлдээ аргаа бараад Оросын бэлгийг явал авчирч чадах бол гэж нэг хашир хөгшинд хүрч үзүүлэв. Тэр хөгшин мэргэчин мэргэлж үзээд:

- Өө, энэ их амархан. Та нар зөөлөн өвсийг хатуу өвстэй холиод хоёр адууны өмнө тавиад өг. Тэгвэл нэг морь нь зөөлөн өвсийг нь нөгөө адуундаа дөхүүлж өгчихөөд өөрөө хатуу өвсийг нь идэж байх буй. Тэгвэл тэр нь унага, нөгөө нь эх нь болно гэж хэлж өгөв.

Алша ноён бас нэг элчийг томилоод, хөгшний хэлснийг захиж явуулав. Тэр элч Орос улсад очоод хатуу, зөөлөн өвсийг хольж аваачаад хоёр адууны өмнө тавьж өгсөнд үнэхээр нэг адуу нь зөөлөн өвсийг нөгөө адуундаа түлхэж өгөөд, өөрөө хатуу өвсийг идэж байв. Элч тэр дор нь хатуу өвс идэж байгаа адууг унага гэж таниад, нөгөө адууг нь эх гэж нотолж, морины хүнд бэлгийг Алшадаа авчирч чадав.

Алшагийн элч унага, эх хоёрыг авч явсны дараа зориг нь мохсонгүй, бас толгой үндэс нь танигдахгүй бөв бөөрөнхий мод гаргаж тавьчихаад толгой үндсийг ялгаж чадвал авч яв! гэж хатуу шалгалт тавьжээ. Энэ хэргийг Алшагийн хаан сонсоод, өнөө хөгшинд очиж мэргэлүүлсэнд:

- За, бөөрөнхий модны үндэс, толгойг таньж ядах юухан байхав. Нэг том усан ган аваачиж, ус хийгээд модыг дотор нь хийж живүүлбэл толгой тал нь дээшээ хөвж, үндэс тал нь доошоо живэх болно гэж хэлж өгөв.

Алша ноён бас нэг элчийг томилоод, хөгшний хэлснийг захиж явуулав.

Элч Орос улсад очоод том усан ганд ус дүүргэж, дотор нь өнөө модыг хийсэнд, үнэхээр нэг тал нь дээшээ хөвж, нөгөө тал нь доошоо живж ордог юм байна. Элч тэр дор нь хөвж ил гарсан хэсгийг модны толгой гэж таниад, живсэн хэсгийг үндэс гэж нотлоод Оросын бэлгийг авав. Үүний дараа Оросын хаан Алша ноёнд бас нэг хүнд бэлэг өгнө гэж элч дуудуулав.

Алшагийн элчийг хүрч очиход Оросын хаан том биетэй, урт соёотой, шингэн сахалтай, бүлтгэр нүдтэй луус шиг амьтныг зааж:

- Энэ ямар амьтан бэ? Таньж чадвал аваад яв. Эс чадвал толгойгий чинь авна гэв. Тэр хүн огт таньж чадсангүй толгойгоо авахуулав.

Алша ноён энэ учрыг мэдээд бас л нөгөө хөгшнийд очиж, яах учрыг асуухад хөгшин мэргэлж үзээд:

- Тэр амьтан бараг хулгана байх янзтай. Та нар есөн жингийн муур аваад очвол таньж чадаж магадгүй. Хуучны үгэнд “Есөн жингийн муур зуун жингийн хулганыг дардаг” гэсэн үг байдаг юм гэв.

Алша ноён луусын чинээ том хулгана гэж юу байдаг юм? гэж бодоод ордондоо ирээд нэг том муур олж жигнэж үзсэнд найман жин байв. Тэгээд Орос улсад хүн томилж, өнөө муураа, нэг жин махтай өгч, учир байдлыг тайлбарлаж явуулав.

Элч Орос улсад очоод хааны ордонд ороход өмнө нь том биетэй, хулгана гэхээргүй, луус шиг амьтан хэвтэж байв. Нэг жингийн махаа гаргаж, муурандаа идүүлээд жигнэж үзсэн чинь яг есөн жин болсон тул өнөөх том амьтны наанаас тавьтал муур нь үсэрч багалзуураас нь хазаж алав. Тэгээд Алша ноёны элч мэргэн хөгшний ачаар Оросын хааны хүнд хэцүү гурван бэлгийг авч чаджээ.

Хожим нь “Хайрлавал хариутай” гэдгээр Алша ноён ч Оросын хаанд буцааж бэлэг барьсан гэдэг. Хамгийн түрүүнд дэрсээр чиг хийгээд улаан хонины ноосыг эв хавгүй зулж, усаар норгож дэвтээгээд Оросын хаанд аваачиж бариад:

- Энэ ямар амьтны ноос вэ? Яаж хийсэн эд вэ? Эх толгой нь аль вэ? гэж асуув. Оросууд энэ шалбайсан эх толгойгүй улаан юмыг үзээд гайхаж, толгойг нь хайсан чинь цөм адил, эсгийн гэхээр модтой, устай огт биш гэлцээд таньж чадсангүй Алша ноён дийлж гарав.

Дараа нь Алша ноён нэг сүрхий мэргэн даамлаа арван цэрэгтэй Оросууд тэмцээнд оруулахаар явуулав. Оросын хаан:

- За, та нар хэр зэргийн чадалтай улс вэ? гэхэд, мэргэн даамал:

- Адгийн би ч арван хүндээ зөв гэж хариулав. Оросын хаан:

- Та нарын зэвсэг аль зэрэг хурц юм? гэхэд, мэргэн даамал:

- Гоёухай модыг гурав цавчсан ч хотойхгүй гэв. Оросын хаан:

- Та нарын морь чинь хэр тэнхээтэй юм? гэхэд мэргэн даамал:

- Зараа гөрөөсийг гурав эргүүлэхэд тамирддаггүй юм гэж хэлэв.

Оросын хаан тэдний хэлснийг үнэн эсэхийг шалгахаар мэргэлж үзэхэд гоёухай гэдэг нь уул

хадыг нэвт шувт ургадаг маш хагуу мод гэж байна. Тийм сүрхий модыг гурав цавчаад ир нь мохдоггүй байхыг бодоход “Эдэнтэй зэвсгийн уралдаан хийх аргагүй” гэв.

Мөн зараа гэдэг гөрөөсийг зурхай татаж үзсэн чинь: биедээ үй түмэн жадтай, урт араа соёотой сүрхий хурдан амьтан байв. Морь нь бас шөрмөстэй юм байна. Эдэнтэй морины уралдаан хийх аргагүй гэв.

Тэгээд Алшагийн мэргэн даамал Оросын хааныг айлгаж, мөрийгөө аваад буцаж явав. Тэднийг буцсаны дараа Оросын хаан “Алшагийн даамал арван хүний чадалтай юм гэсэн, би арван нэгэн цэрэг явуулбал тэр даамлыг дарчихна” гэж бодоод арван нэгэн цэрэг араас нь явуулав.

Алшагийн даамал буцаж явж байтал замд нь нэг уулын хавцал таарав. Тэр даамал “Оросын хаан биднийг тийм амархан тавьж явуулахгүй” гэж бодоод уулын хавцалд бууж морио чөдөрлөж тавиад бусад цэрэгтээ:

- Та нар хурдан яв! Талд гараад мориныхоо эрчээр давхиж яваарай гэж захиад хоцров. Арван цэрэг нь даамлынхаа хэлснээр уулнаас гарангуутаа морио ташуурдаж сум мэт шуугиулан одов. Хэсэг давхиад эргэж харсанд араас нь Оросын арван нэгэн морьт цэрэг нэхэж айсуу. Оросын цэргүүд уулын хавцалд нуугдаж хоцорсон даамлыг үзсэнгүй. Даамал араас нь даган давхив. Оросын цэргүүд Алшагийн цэргүүдийн араас хөөсөөр морь нь сульдаж, цуварч эхлэв. Мэргэн даамал араас нь :

- Хурдан давхиарай, морио удаашруулж болохгүй шүү! гэж хашгирахад, тэд өөрийн хүнээ хэлэв гэж итгээд морио ташуурдан байдаг чадлаар нь давхиулав.

Энэ үед мэргэн даамал ард нь гүйцэж ирээд нэг нэгээр нь толгойг нь цавчиж унагасаар, хамгийн түрүүний цэргийг гүйцэж:

- Хөөе, танай хүмүүс үхээд дуусч байхад, чи юунд ингэтлээ давхиж байна вэ? Хурдан буцаж хэл хүргэ! гэсэнд өнөөх цэрэг цочин эргэж хараад ард нь Алшагийн даамалаас өөр хүн байхгүй, ганцаараа давхиж байсандаа айн сандарч, хэл хүргэхээр буцаж одов.

Алшагийн мэргэн даамал ингэж Орос цэргийг дарчихаад, эсэн мэнд нутагтаа иржээ.

Түүнээс хойш Оросын хаан дахиж Алша Монголыг басамжлахаа больсон гэдэг.

Манжийн хаан зууд явсан нь

Манжийн төр тогтсоны дараа, Манжийн хаан төрөө улам мандуулахын төлөө зууд хүрч, далай ламтай золгохоор Алшагаар дайрч явжээ. Тэр хаан ертөнцийн хүнд танигдахгүйн тул зуны зургаан сард ямаан дах өмсч, өвсөн малгай зүүн, хар азарган илжиг унаад явж байжээ.

Нэг өдөр зуны халуунд хаан харангадаж, цангаад туйлдаа хүрч явтал нэг айл таарав. Тэр айлд эмгэн, өвгөн хоёр байх ба мал нь ч гаднаа байв. Эмгэн нь хаанд хуурсан будаатай унд хийж өгөв. Хоол унд идэж ууж, нэлээд ярьж хөөрч суусны дараа унтаж амрахаар хэвтэцгээв.

Өвгөн орон дээрээ хажуулдан хэвтэх гэтэл тонон дээр нь Манжийн хааны од шиг од харагдахад гайхаж дэрэн доороосоо боолттой хувилгаан чулуугаа авч төлөг буулгасан чинь Манжийн хааны од мөн байв. Өвгөн чулуундаа итгэж ядан “Яагаад өнөөдөр манайд Манжийн хаан байна гэж буугаад байгаа юм бол, сонин юм даа” гэж бодоод чулуугаа далд хийгээд унтав.

Манжийн хаан үүнийг мэдээд сэм гарч илжигээ унан давхиж одов. Явсаар, явсаар хэдэн арван өдрийн дараа зууд ирээд, нэг монгол гэрийн гадна хүрч, илжгээ морь уядаг шонгоос нь уячихаад гэрт орох гэтэл айлын хүн:

- Орж болохгүй, юун хүн яах гэж яваа юм? гээд оруулсангүй. Бас нэг хүн хүрч ирээд:

- Чи яагаад марал илжгээ морины шонгоос уяж байгаа юм? Хурдан зайлуулж уя! гэв. Манжийн хаан уурлаж:

- Хүн ордоггүй юм бол гэр байсны хэрэг юу юм? Унаа уядаггүй юм бол уяа байсны хэрэг юу юм? гэж хэлээд илжгээ авч нэгэн зандан модноос уячихаад далай ламтай уулзахаар явав.

Манжийн хаан далай ламд мөргөл хийгээд гарч ирэх хооронд илжиг нь зандан модруу шээчихсэн байв. Дараа нь зандан мод илжигний шээсэнд хордоод үхчихэж гэнэ.

Манжийн хаан далай ламд мөргөөд буцахдаа өнөө мэргэн өвгөнөөс сэрэмжилж, замаа өөрчлөөд явж байтал хул морь унасан торгон дээлтэй лам хүн таарав. Тэр лам биш чөтгөр байсныг Манжийн хаан таниад ойртож очоод:

- Хаанаасаа хаа хүрэхээр явж байна? гэхэд чөтгөр ч Манжийн хааныг таньж:

- Энүүхэнд нэг айл хурим найр хийж, залуу хос гэр бүл болох гэж байна. Түүнд очихоор явж байна. Харин та хаа хүрэхээр явна вэ? гэж асуухад, хаан:

- Аан, би ч бас тэр хуримд оролцохоор явж байна даа гэхэд чөтгөр Манжийн хаанаас айж цааш зугтан одов.

Хаан явсаар өнөө хурим хийж буй айлд хүрч ирэхэд олон хүн бужигнаж, хөл ихтэй найр болж байлаа. Айлын улс хааныг гэрт ороход их л билэгшээж:

- Манай талд нэг ахмад дутаад байсан юм. Та манай хуримын ахмад бол гэж гуйхад аргагүй

зөвшөөрч, тэнд нэг хоноод маргааш нь мордов.

Цааш явж байтал замд нь хонь хариулсан лам таарч, хаашаа явж байгааг нь асуухад хурим найранд оролцоод явж байгаагаа хэлэв. Тэгээд хаан:

- Энэ айл их сонин юм. Ийм муу өдөр хурим хийж байдаг. Би ирээгүй бол энэ айлд чөтгөр ирж, залуу хосыг хорлох байж гэхэд, өнөө лам:

- Тийм, тийм. Би энэ өдрийг үзэж өгсөн юм. Залуу хосыг хурим хийхэд таарамжтай сайн өдөр тун олдохүй байсан юм. Харин энэ өдөр нэг сүрхий том хүн ирж, чөтгөрийг дарах юм байна гэдгийг үзэж мэдээд сонгож өгсөн юм. Одоо чөтгөрийг дарж, хурим сайхан болсон бол болжээ, болж гээд цааш явав.

Манжийн хаан саяын өвгөнийг жирийн хүн биш байна гэж мэдээд хурдан замдаа орж, Бээжиндээ ирэв.

Ингээд манжийн хаан далай ламд мөргөөд буцахдаа айлын хуримд ахмадаар сууж, мөн чөтгөрийг дарсан бөгөөд илжиг нь зандан модруу шээж хордуулсан тул тун билэггүй юм болж, удалгүй Манжийн төр унасан юм гэнэ.

Тоорой бандийн арга заль

Эрт урьд цагт, Алшад халхын сайн эр Тоорой банди хүрч иржээ. Нэг өдөр Алша ноён, Тоорой бандийг барьж ирүүлэхээр цэргүүдээ явуулж гэнэ. Алшагийн цэргүүд Тоорой бандийн мөрөөр мөшгиж явсаар морио уяд унтаж байхад нь гэнэдүүлэн бүсэлж авчээ. Тоорой банди цочин сэрээд ажиг ч үгүй:

- За, би ч одоо хаашаа зугтах билээ? Та нарын бууны сумаас хэрхэн зайлж чадах вэ? Хуучны үгэнд “Алах малын цусыг нь ав. Үхэх хүний үгийг сонс” гэдэг юм. Би үгээ хэлж болно биз дээ гэхэд, цэргүүд:

- Тэг, тэг гэж зөвшөөрөв. Тоорой банди:

- Би энэ насандаа наймаа хийж явсан тухай намтар цадигаа ярьж өгье гээд олон цэрэг рүү харсанд цэргүүд байсан байрандаа хөдөлгөөнгүй зогсож байв. Тоорой банди цааш үргэлжлүүлэн:

- Урьд би Да хүрээ явж даавуу майханд сууж, далан тэмээ ачиж, таатай сайхан наргиж явлаа гэж хэлээд харахад тэд урьдын адил зогссоор байв. Тоорой банди “За, одоо ч энэ муусайн намайг барихаасаа өнгөрч байна” гэж бодоод улам молиго үмхүүлж:

- Миний майханд юу байсан бэ? гэвэл: даавуу хөвөн, даалимба янбуу, энтэй торго, эр хар, да хар, морин домбо, модон аяга, шавар лонх, шаазан аяга, үйлийн хайч, үсний хавчаар цөм байдаг байлаа гэж хэлээд цэргүүдрүү харсанд түүний уран үгэнд автчихсан байв гэнэ. Тоорой банди дотроо улам баярлан:

- Тэгээд миний майханд юу юу дутаж байв? гэвэл: туулайн эвэр, тугалын соёо, ногоон хурганы арьс, цагаан хилэн дутаж байлаа.

Наймаа хийж хийж, хойтон жилийнх нь найман сард дансаа бодсон чинь таван зуун тавин таван лан, таван цэн алт дутаж байна. За, наймаа юунаас алдав гэвэл: дээд хүүхэнд дээлийн торго, тэнзэн мөнгө, дундын хүүхэнд дурдан алчуур, дугуй мөнгө, адгийн хүүхэнд амаар торго, атгаар чихэр өгсөөр дутсан байлаа. Тэгээд урамгүйхэн гэртээ харьж явтал морин туурайд “хангир жингэр” гэж дуугарав.

Тэгэхээр нь би “Енбүү бол би авна, чулуу бол хүүхэд наадна биз” гэж бодоод, аваад гэртээ хариад өглөө сэрсэн чинь хүүхдүүд “Наана чинь енбүү, цаана чинь енбүү” гэгцгээж байлаа. Босоод үзсэн чинь нээрээ енбүү байв.

Гэдэс өлсөөд идэх хоол хайсанд юу ч олдсонгүй, арга ядаж элсэн говьд өлсөөд хоол олдохгүй, өндрийн цагаан чулууг өөх гэж санаж үмхэх гээд, өглөөний гарсан нарыг өрөм гэж самардах гээд, талын цагаан дэрсийг хонь гэж хөөх гээд, өвөртөө байсан алчуурыг гүзээ гэж зулгаах гээд, зам дээр байсан могойг гургалдай гэж шувтрах гээд юу ч үгүй хоцорчээ.

- Тэгээд цааш яваад могой цоохор морио молон гүйлгээд, мордсон хойноо шувт гүйлгээд, сэхийн шилээр сэт гүйлгээд, шивэр хурд илж гүйлгээд, дэвж дэвсээр, явж явсаар Замбал

залан гуай гэгч айлд ирлээ.

- Замбал залан гуайнд ороод үзсэн чинь дэнхэр гэдэг дэрийн өмнө, хүнхэр гэдэг гүний өмнө хамаг хүүхнийг нь хүй хүн өвөрлөөд хэвтчихсэн надад юу ч байсангүй.

- За, тэгээд цааш яваад дэрсэн модны Дэрен чавганцынд хүрлээ. Тэгээд муу хоохор цоохор морио тугалын голд тавьчихаад, дэрсэн модны Дэрен чавганцыг дэмий нэг дэрлэж хоночихоод, маргаашийн өглөө хоохор цоохор морио барьж аваад явсан чинь морь минь Хонголын гол өнгөрөөд хоохир доохир, хоохир доохир гээд явж байтал хоёр нохой гонирлоод, хорин шувуу цоёглоод эгээтэй буудай хийгээд хаячихлаа.

- Тэгээд зууд хүрлээ. Гүзээтэй билээ гэж налан сууж нэг наргилаа, гүйдэг билээ гэж цэх сууж нэг наргилаа, дуутай билээ гэж дунд нь сууж дугариг хэнгэргийг нь оргилтол цохиж, луу шиг нижигнэж, баруун дээврийг нь оволзуулж, навгалзуулж нэг наргилаа.

- Тэгээд цааш нь “Дархан сайн, дархан сайн” гэж далай ламын дэргэд хүрч, дарх хийж, эр хүний бэл ташаа, эхнэр хүний ээмэг сүйх хийж, дархан Аранчимбо цолыг авч нэг наргилаа.

- Тэгээд цааш нь бөх сайн вангийн хошуунд очиж “Бөх сайн, бөх сайн” гэж хий бууж, хий гарч, хий торгон жолоог нь атгаж газар алгадуулж бас нэг наргив гэж олон үг нуршиж, олон цэргийн гараас хурдан гарахаа бодож, их морио тавьсан хүн болж мориныхоо эмээлийг авч, хазаарыг нь мулталчихаад:

- За, миний энэ морь өвсний соргогийг идэж, усны тунгалгийг ууж явтугай. Энэ морийг би залуу цагт нь унаад явахад хамбан торгон хүрэмний хойд хормой дээвэр аятай дэрвэж, хоргой торгон бүч нь утаа аятай гозойж, шагийн цоохор товч нь лимбэ аятай исгэрэлдүүлж явсан сайн морь билээ гэж хэлээд мориныхоо нурууг илбэж:

- Муу мориныхоо тохох нурууг би барсан, туг сүүлийг нь түмний нохой барсан, онгод дэлийг нь огторгуйн салхи барсан, дөрвөн туурайг нь алтан дэлхий барсан юм. Ийм учраас энэ морио муугийн бараа үзүүлэхгүй юмсан гэж хэлээд дээлээ авч:

- Би дээлээ нэг өмсөх юмсан гэж дээлийнхээ элс тоосыг гүвж байгаа хүн болж:

- Миний энэ дээл бол урьд нь Сайн ноён хан аймгийн сайхан Жамбад холимог шиг холилдож, хошног шиг залгалдаж, сүүж шиг ухлалдаж байсан дээл юм билээ! гэж хэлэнгүүтээ мориндоо ухасхийн мордож нурууруу нь нэг алгадаад сум шуугиад морь ч үгүй, хүн ч үгүй болж гэнэ.

Тэгээд цэргүүд Тоорой бандийг мөн л барьж чадалгүй алдаж явуулсан гэнэ.

Дээрхийн гэгээн Алшад ирсэн нь

Эрт урьд цагт, дээдийн гэгээн анх Алшад ирж нэг баян айлд мал хариулж суужээ. Баяны эмгэн их зан муутай хүн тул дээдийн гэгээнээс хоолоо харамлаж хэмжиж өгдөг байжээ. Энэ янзаар дээдийн гэгээн нэлээд хэдэн жил зарц хийж суув.

Нэг өдөр баяны зожиг ямааг нь хээрийн амьтан(чоно) бариад идчихжээ. Дээдийн гэгээн баян айлд ирж хэлсэнд эмгэн ихэд уурлаж:

- Юу гэнэ ээ? Хэтэрсэн туучий байна. Тэр ямаа чинь уг сайтай олон ишиг гаргасан сайн ямаа байсан юм. Чи мал сайн хариулсангүй, малын захад унтаж байсан биз? Чамд энэ шөнө хоол өгөхгүй, хурдан явж мал хотлуул гэж зандран цай ч өгөлгүй хөөж гаргав.

Дээдийн гэгээн үг дуугүй гарч, баяны малыг хотонд нь оруулчихаад уурандаа бүсээ тайлж аваад цааш явж, зожиг ямааг идсэн чоныг барьж оосорлож ирээд, баян айлын эмгэнд:

- За, эзэнтээн, таны зожиг ямааг зооглосон амьтныг би бариад ирлээ, одоо та нар яаж яллахаа өөрсдөө мэд гэж хэлжээ. Баяны эмгэн чоныг үзээд:

- Нүгэл гэм! Чи чинь ямар эргүү илжиг вэ? Хээрийн чоныг гэрт авчирч үүдээр шагайлгана гэгч ямар ёр вэ? Хурдан тавьж явуул гэж хашгирав. Дээдийн гэгээн:

- За за, та тавьж хөө гэж хэлсэн шүү гэж хэлээд чоныг тавьж хөөв.

Тэр жилийн хавар улаан ган болж байлаа. Өвс бэлчээргүйгээс хонь мал нь тогтохоо больж, яаж ч хариулсан тогтоож дийлэхгүй болов. Баяны эмгэн мөн л уурлаж:

- Хөөе, Бадарчин аа? Чи хонь сайн хариулахгүй байна. Юу хийгээд савируулаад байдаг юм. Хамаг хүч тамир нь барагдаж дууслаа гэж хараав.

Маргааш орой нь мал нь хотондоо орж ирэхдээ бүгд улаан туруутай доголлон болчихсон ирж гэнэ. Эмгэн үзээд их гайхаж, энэ малнуудын хөл нь яачихсан юм бэ? гэж асуухад дээдийн гэгээн ажиг ч үгүй:

- Энэ малнууд савираад, хүч тэнхээгээ бараад, тогтоож дийлдэхгүй болохоор хатуу турууг нь аваад хаячихсан юм. Одоо савирахаасаа өнгөрсөн гэж хэлжээ.

Баяныхан хатуу туруугүй болоод гишгэж чадахгүй байгаа малаа хараад уур нь ч хүрч гэнэ, айдас нь ч хүрч гэнэ. Тэд: “Нэг хот малын турууг нэг дор бүгдийг авна гэдэг тийм амар юм биш. Энэ бадарчин ямар учиртай хүн юм бол?” гэж сэжиглээд, орой нь түүнд сайхан хоол хийж идүүлээд, өвгөн зовсон сэтгэлээ хэлжээ. Түүнд дээдийн гэгээн:

- За гэмгүй. Муусайн мал савираад тогтохгүй болохоор нь би жаахан арга хэрэглэсэн юм. Маргааш өглөө зүгээр болчихно гэж хэлээд унтаад өгөв.

Маргааш өглөө нь баяны эмгэн эртлэн босч, хотондоо гүйж ороод үзсэнд, хоттой мал нь бүгд туруу нь зүгээр болчихсон хивж хэвтэнэ гэнэ. Баян айлынхан үүнийг үзээд бүр гайхжээ.

Дээдийн гэгээн өглөө босч, хоол ундаа идэж уугаад малдаа явах гэсэнд, айлын өвгөн:

- За, чи үүнээс хойш малын турууг битгий аваарай! Харин түүрүүг нь жаахан дараад явбал болно гэж сайхан загнаж явуулж гэнэ. Тэр өдөр өвгөн нь эмгэндээ:

- Энэ бадарчин лав зүгээр хүн биш байх. Ер нь хаанаас ирсэн хэн гэгч юм бол? Бид энэнийг өглөө болгон нэг аяга шингэн цай өгчихөөд бүтэн өдөр малд явуулаад байдаг нь арай хэтэрч байна. Тэр өлсөж цангаж байдаг байлгүй. Чи өнөөдөр түүнд хоол цай аваачиж өг гэв.

Эмгэн дуртай дургүй хоол хийгээд дээдийн гэгээнд хүргэж өгөхөд ядарч зүдэрч явсан дээдийн гэгээн их л баярлаж:

- Юун сайн юм. Хар халуун үдийн наранд цангаж харангадаад явж байлаа. Хишигт залбирч зооглоё гэж хэлээд хоол ундыг нь авч ухаангүй ховдоглон идэв.

Тэгээд хэдхэн үмхэж идчихээд савыг нь долооход баяны эмгэн дургүйцэж:

- Хөөе, бадарчин аа? Хонь холдоод явчихлаа. Хурдан явж тогтоо. Энэ муу савыг долоогоод яах юм гэхэд, дээдийн гэгээн:

- Харин яасан сайхан амттай юм бэ? Энэ насандаа ийм амттай хоол идэж байсангүй гээд гүзээ эргүүлж байгаа юм шиг савыг нь эргүүлж долоосноо буцааж хуучин хэвэнд оруулчихаад эмгэнд өгөв.

Баяны эмгэн санд мэнд хоолныхоо савыг шүүрч аваад хагалж, гэмтээсэн байх вий гэж санан эргүүлж тойруулж үзсэнд ямар ч гав оромгүй байв гэнэ. Эмгэн юу ч дуугарсангүй гэртээ хариад өвгөнөө дуудаж:

- Өнөөдөр би бас сонин юм олж мэдлээ. Өнөө бадарчин чинь миний хүргэж өгсөн хоолыг цөмийг нь идэж барчихаад, савыг нь гүзээ шиг эргүүлж байгаад долоодог байна шүү гэхэд, өвгөн сандран:

- Тэр тэгээд ганц муу хоолны савыг маань хагалаад хаячихсан уу? гэхэд

- Юу гэсэн үг вэ? Дуугүй миний хэлэхийг сонс! Бадарчин дахиж эргүүлж, хуучин хэвэнд нь оруулаад надад өгөхөд нь би ч бас хоолны савыг минь хагалчихаж уу? Үгүй юу? гээд сайн шалгаж үзсэн чинь ямар ч гав ором алга гээд хоолны саваа өвгөнд өгч харуулав. Өвгөн хэсэг дуугүй сууснаа гэнэт босон харайж:

- Чи хурдан явж, адуунаас миний гурван жил нуруунд нь гар хүрээгүй зандан хүрэн морийг минь бариад ир! Энэ бадарчин лавтай зүгээр хүн биш байна. Энэ тухай хошуу яаманд мэдэгдэлгүй болохгүй гэж шавдуулав.

Эмгэн нь ч өвгөнийхөө хэлсэн ёсоор адуундаа очиж, зандан хүрэн морийг нь барьж авчирч өгсөнд баян тэр дороо хошуу яаманд хүрч мэдэгдэв. Догшин гүнж баяны хэлэхийг сонсоод:

- Тийм бол түүнийг хурдан дуудаж ирүүл! Би өөрөө шалгаж мэдье хэмээн зарлиг буулгаж,

зарц цэргээ явуулав. Ноёны цэрэг баяныд хүрч:

- Саваагүй бадарчин чи мөн үү? Ноён чамайг дуудаж байна гэхэд бадарчин ажиг ч үгүй:

- Саваа наваагүй нь ч надад байхгүй. Би бол хөлсөө гаргаж, ходоодоо борлуулж яваа тэнүүлч бадарчин байна. Ноён намайг залж байгаа бол явья гэж хэлээд ноёны цэргийг дагаж Алша хошуунд иржээ.

Ноёны цэргүүд дээдийн гэгээнийг Алша ноёны ордонд оруулахад догшин гүнж нь торгон бүтээлэгтэй савлуур орон дээр цаашаа хараад хэвтэж байв. Тэгээд нааш эргэж харсан ч үгүй:

- За, муу бадарчин чи яасан, яасан гэнэ ээ? Айлын гэрт чоно барьж ирж шагайлгаж байна гэв үү? Айлын хоттой малын хар турууг мулталж байна гэв үү? Айлын хоолны савыг эргүүлж долоосон гэв үү? гэж асуусанд дээдийн гэгээн:

- Тиймээ тийм. Цөм үнэн хэрэг гэж хариулав. Догшин гүнж:

- Үнэнээ мэдвэл болж байна. Ингэхэд чи хаанаас ирсэн? Хэн гэгч вэ? гэхэд нь:

- Өө, би зуугаас ирсэн. Хөлсөө гаргаж амиа тэжээж яваа амьтан гэж үнэнээ хэлэв. Догшин гүнж нааш эргэж орноосоо босоод, дээдийн гэгээний өмнө сандал, ширээ тавьж өгөөд:

- За, тийм байж, чи тийм их шидтэй юм бол шидээ үзүүл гээд бөв бөөрөнхий өндөг шиг, ёроолгүй шилэн аяганд жаахан замбага хийж, дээрээс нь буцлам халуун цай хийгээд дээдийн гэгээнд гардуулав. Дээдийн гэгээн үг дуугүй аягатай халуун цайг тосч аваад, гурван хурууныхаа өндгөн дээр хөндий тавьчихаад, хэсэг эргүүлж үзэж байснаа өврөөсөө эрихээ гаргаж ирээд хатны ордны таазруу шидэж, араас нь аягатай цайгаа шидэж явуулав. Эрих нь агаарт хэд эргэж байснаа аяганы ёроол шиг цагариг болж ширээн дээр буув. Түүний араас аягатай цай нь ч эрихэн дээр онож буув. Дээдийн гэгээн өмнөх аягатай цайгаа авч оочихын хамт догшин гүнжээс:

- За, гүнж ээ? Намайг юунд дуудаж ирсэн юм бэ? гэж хариу асуухад гүнж хариу хэлэхийн оронд:

- Та ер нь ямар учиртай хүн юм бэ? гэж асуув.

- Дээдийн гэгээн инээмсэглэн гүнжийн асуултад мөн л хариулсангүй дуугүй суув.

Энэ байдлыг үзээд догшин гүнж дотроо “Манай Алшад шашин дэлгэрэх цаг иржээ. Энэ бадарчин манай Алшагийн их гэгээнтэн хүн юм байна” гэж сэжиг аваад:

- За, багшган минь, та их эрдэм номтой хүн байна. Манай нутагт одоо шашин дэлгэрэх цаг нь болсон шиг байна. Та шашнаа яаж дэлгэрүүлэх гэж байна? гэж асуужээ. Дээдийн гэгээн “Энэ гүнж бас сүрхий хүн байна” гэж бодоод:

- Надад тийм их ном эрдэм гэх юм байхгүй, тэгээд ч юугаараа сүм дуган байгуулж, шашин ном дэлгэрүүлэх билээ? гэв. Гүнж:

- Та хэрвээ шашин дэлгэрүүлэх ном чадалтай гэвэл сүм дуган байгуулах мөнгө хөрөнгийг би гаргая, эс чадах бол хурдан нутагтаа буц гэв.

Маргааш өглөө нь дээдийн гэгээн догшин гүнжид:

- Гүнж таны санаа байна, учирсан бидний ерөөл байна. Би танай энэ цэнхэр униартай, өндөр хөх уулын хамгийн хойд үзүүр дээр нэг сан тавьчихаад, говь элсээр буцъя гэж хэлжээ. Гүнж түүнийг сонсоод:

- Багш аа, та манай улсад тэнүүчилж ирчихээд манай нутгийг “хоосон юм байна, харгис хэрцгий юм байна” гэж доромжилж буй юм биз дээ, ингэж болохгүй гэж хэлээд суудал доороосоо олбогоо суга татаж аваад:

- Одоо би энэ олбогыг шиднэ. Та хэрвээ жинхэнэ гэгээнтэн юм бол миний энэ олбог үүдээр гарч, шашин дэлгэрэх газарт бууна. Үгүй юм бол үүдээр гарч чадахгүй, дороо унана гэж хэлэв. Дээдийн гэгээн:

- Гүнж та тааллаараа бол. Хатан таны зарлиг байна. Төрийн ёсонд хааны зарлиг харилтгүй юм гэнэ лээ, хишигт мөргөө гээд догшин гүнжид мөргөсөнд, гүнж түүнийг анзаарсангүй, олбогоо шидэв.

Олбог үүдээр гарч жигүүртэй юм шиг нисч Алша уулыг чиглээд явчихжээ. Гүнж цэргүүдээрээ хоёр морь бариулж өөрөө нэгийг нь унаж нөгөөг нь дээдийн гэгээнд унуулаад олбогны араас хөөж явав. Олбог нь нисч явсаар Алша уулын дээгүүр өнгөрч, Баянсүмбэрийн оройд гарч, одоогийн баруун хийд байдаг голын эрэг дэх булагтай хадан дээр унаж тогтов. Догшин гүнж:

- Та бол жинхэнэ гэгээн хүн мөн байна. Манай нутагт шашин дэлгэрүүлж, олон түмэнд амар түвшнийг авч ирэх хүн мөн байна. Одоо та энэ газарт сүм дуганаа байгуулж, шашин номоо дэлгэрүүлж суу гэж хэлээд буцжээ.

Ингээд баруун хийдийг энэ газарт байгуулж, Алшад шашин анх дэлгэрсэн юм гэнэ.

Дандар Лхарамба

Эрт урьд цагт, Алшад Дандар Лхарамба гэж нэртэй сүрхий эрдэм чадалтай хүү мэндэлжээ. Тэр анх Алшагийн зүүн хийдэд шавилж сууж байжээ. Тэр үед хүү тийм ч онцгой сайн эрдэмгүй, багш нь ч сонин юм зааж чадахгүй болохоор Гүмбүмд ном сурахаар явжээ. Багш нь түүнд унах морь, хоёр дан ном өгч явуулжээ. Дандар Лхарамба Гүмбүмд хүрээд их ламд учир байдлаа хэлэхэд, их лам:

- Чиний багш сүмийн лам нар дотор байгаа. Өөрөө хайж ол гэж хэлжээ. Дандар Лхарамба багшаа хайж нэлээд удсаны эцэст нэгэн мэргэн хүнтэй таарч асуухад:

- Чи сайн хүлээ. Одоо сүмийн хурал тарахад тэдний дунд нэг сүүдэргүй лам байгаа. Тэр бол чиний багш мөн гэж хэлэв.

Дандар Лхарамба мэргэн хүний хэлсэн ёсоор сүмийн хурал тарах үеэр сүүдэргүй хүнийг хүлээж зогстол үд дунд болж гэнэ. Хурлын лам нар ч яваад бараг дуусч байхад хамгийн сүүлд сүмийн гол үүдээр нэлээн хөгшин лам гарч ирэв. Үдийн нар голлосон тул өнөөх лам сүүдэргүй харагджээ. Дандар Лхарамба баярлан гүйж хүрээд ламд мөргөж, багш шавийн барилдлага гуйв. Гэтэл өнөө лам нь сүмийн гонир (дуганд зул хүж өргөдөг лам) байжээ. Хурал тарж лам нарыг явсны дараа сүмд сан тавьж, зул цөгцийг цэвэрлээд гарч яваа нь тэр байж. Гонир ихэд гайхаж:

- Юу гэсэн үг вэ? Хүү минь! Болохгүй. Би чамд багш болж чадахгүй гэж хэлэв. Гэсэн ч хүү ламаас огт салахгүй багшаа болохыг гуйсаар гурав хоног салахгүй дагаж явав. Аргаа барахдаа лам хүүг шавиа болохыг зөвшөөрчээ.

Тэгээд Дандар Лхарамба тэр ламыг дагаж гурван жил болж гэнэ. Энэ хугацаанд багш лам заасан ном ч үгүй, хэлсэн олигтой үг ч үгүй, өдөртөө түлээ аргалаа ингэж хий, тэгж хий гэж ажлаа хийлгэдэг байжээ. Ийм янзаар Дандар Лхарамба лам багшийндаа есөн жил болов. Нэг өдөр багш нь Дандар Лхарамбыг дуудаж:

- За Дандар Лхарамба аа, тусгүй, тусгүй. Чи ч ном сурах хүн биш байж, би ч ном заах хүн биш байж. Чи одоо нутагтаа буцаж, авгай хүүхэн авч, амьдралаа босго гэж хэлжээ. Дандар Лхарамба сандарч:

- Багш аа, яаж болох билээ? Надад сурсан эрдэм алга. Ийм байдалтай нутагтаа яаж очих вэ? Гэхэд, багш нь:

- Танай Алшагийнхан чамайг хүлээж байгаа. Энд одоо чамд заагаад байх юм ч байхгүй болсон. Хурдан нутагтаа очиж, хар гэртээ хаан, бор гэртээ богд болсон нь дээр гэж хэлээд хөөжээ.

Ингээд Дандар Лхарамба аргагүй Алша нутагтаа буцсан гэнэ.

Дандар Лхарамба нутагтаа ирээд одоогийн зүүн хийдийн орчим нэг самархай гэр барьж, дотор нь хэдэн уранхай зээрийн арьс дэвсэж, гаднаа хэдэн чулуу хаяжээ. Мөн хэдэн хар

ямаатай, нэг цагаан толгойтой эмгэнтэй, тамхины урт гаанстай, нус нулимсаа гоожуулсан мэргэн болж суужээ.

Дандар Лхарамбыг нутагтаа ирээд нэлээд удсаны дараа багш нь Гүмбүмээс хоёр банди томилж:

Та хоёр Дандар Лхарамбаас ном сурч ир! Тэр их эрдэм чадалтай хүн гэж хэлээд явуулжээ. Гүмбүмийн хоёр банди Дандар Лхарамбыг тийм их эрдэм номтой юм чинь сүм дуган нь сүртэй том байх гэж бодоод хүрч ирсэнд гаднаа хэдэн чулуу хаячихсан, сиймхий гэртэй, дэвсгэр ч үгүй, баруун талдаа элсэнд дарагдсан хоёр зээрийн арьс дэвсчихсэн их л ядруу айл байсан ба Дандар Лхарамба эрүү өвдөг нь нийлэх шахсан, нус нулимсандаа холилдсон, нэг бөгцгөр цагаан толгойтой эмгэн асарчихсан сууж байв. Хоёр банди энэ байдлыг үзээд итгэж ядан:

- За багш аа, багш лам маань бид хоёрыг танаар ном эрдэм заалгаад ир гэж явууллаа. Тэгээд бид хоёр таныг зорьж ирлээ гэж хэлсэнд Дандар Лхарамба гаансаа татангаа:

- За даа тэр ч юу л бол. Би хүнд ном заах байтугай, хэдэн ямаагаа хүчрэхгүй сууж байна гэж хэлээд хэд ханиалгаж цэр нусаа хаячихаад, хоёр бандид цай хийж өгчээ. Хоёр банди багшид шавь оръё гэж гуйгаад байхаар нь Дандар Лхарамба:

- Хуучны хэлдгээр “Залуу хүн ирвэл зарга нэмнэ. Хөгшин хүн ирвэл хөг нэмнэ” гэгчээр та хоёрын ирдэг сайн боллоо. Маргаашнаас эхлээд хэдэн ямааг минь хариулж өгөөрэй гэв. Хоёр банди маргааш өглөө нь хэдэн ямааг нь туугаад ууланд гарсанд үдийн хойно болоход ямаанууд нь нэг нэгээрээ хаданд тараад гүйцэгдэхгүй болов. Орой болоход хоёр гуравхан ямаатай харьж иржээ. Энэ янзаар нэлээд хэдэн өдөр болж гэнэ. Түүнийг Дандар Лхарамба мэдээд:

- Та хоёр хэзээ манай ямааг гүйцэд тууж ирнэ, тэр үед би ном зааж өгнө гэж хэлжээ. Хоёр банди өдөртөө яаж багшийнхаа ямаануудыг цөмийг нь цуглуулах вэ хэмээн чармайсаар өдрөөс өдөрт илүүг тууж ирдэг болов. Ингээд хоёр жил гаруй боллоо. Нэг банди нь ямаа хариулахаас цөхөрч, нөгөөдөө:

- Бид Алшад ирээд нэгэнт хоёр жил болжээ. Энэ багш өдөртөө хэдэн хар ямаагаа хариулуулахаас өөр юм заасангүй. Энэ янзаараа бид хоёрт ном заахгүй юм байна.

Би явна гэж хэлээд явчихжээ. Үлдсэн нь ямаагаа хариулсаар л байв. Тэгсээр гурван жил нь дөхөөд ирсэнд банди:

- Багш аа, миний ном сурах хугацаа дуусч байна. Та надад жаахан ном зааж өгөөч гэж гуйхад, Дандар Лхарамба:

- Чи үдийн хойно цайгаа ууж байхдаа ямаагаа тоолоод үз. Ямаа чинь хорь болчихсон бол би чамд нэг ном хэлж өгье гэжээ. Тэр өдөр үдийн хойно банди ямаагаа тоолж үзсэнд нэг дутаж гэнэ. Ямаагаа хорь хүргэчих санаатай чармайн зүтгэсээр нэлээд хонож, гурван жил нь гүйцэж гэнэ. Нэг өдөр Дандар Лхарамба бандийг дуудаж:

- За, чиний гурван жил чинь гүйцэж байна. Одоо Гүмбүмдээ буц. Их багш намайг асуувал “Дандар Лхарамба ном заасангүй, хэдэн хар ямаагаа хариулуулж байгаад буцаалаа” гэж хэлээрэй гэж захив.

Шөнө банди сайн унтаж чадсангүй, судар ном уншиж байна гэж зүүдлээд хонов. Өглөө боссон чинь толгой цээжинд нь дүүрэн ном эрдэм харагдаад болохгүй байв. Банди ном эрдэм сурчихлаа хэмээн баярлаж, багшдаа:

- А үсгийг ингэж бичдэг үү? На үсгийг ингэж бичдэг үү? гэж хоргоогоод салахаа байчихав. Дандар Лхарамба их дургүйцсэн янз гаргаж:

- Юугий нь асуугаад байдаг юм? Одоо нар халах нь эртхэн яв гэж хэлээд чи явахдаа заавал Баянсүмбэрийн орой дээр гарч сан тавиад яваарай гэв.

Банди багшийнхаа хэлсэн ёсоор сан тавиад Гүмбүмдээ очив. Тэгтэл түүний Алшагаас түрүүлж явсан ах лам нь Гүмбүмд нэрд гараад, зууд ном уншиж суудаг болсон байв. Харин их багш нь нэлээд хөгширч өтөлсөн байх ба бандийг хүрч очиход ихэд баярлаж:

- Чи минь ном сураад ирсэн бол болжээ. Би чамайг л хүлээж байлаа. Гарынхаа шар судрыг чамд хадгалуулья. Тэгвэл би маргааш үүрд буцна гэж хэлээд шар судраа шавьдаа гардуулаад:

- Зууд том дугана баригдаж дуусч байгаа. Тэр дуганыг аравнайлах хурал хийж олон лам гэгээн залах байх. Түүнд Алшагийн Дандар Лхарамба заавал оролцох ёстой юм шүү гэж захижээ.

Хэд хоногийн хойно зууд том дугана баригдаж дуусаад, дуган аравнайлах хуралд олон лам гэгээн уригдан ирж гэнэ. Банди багшийнхаа захиасыг биелүүлж, шар судрыг нь зууд тавьж, захиаг нь их ламд гардуулав. Их лам захиаг уншиж үзээд, Алшаруу хэдэн гэгээн томилж, Дандар Лхарамбыг залахаар явуулав. Дандар Лхарамбыг залах гэгээнтэн шар торгон орхимж өмсөж, унах морио ч гоёж аваад явжээ. Тэд Дандар Лхарамбынд хүрч ирээд байдлыг үзэж ихэд гайхаж, манай багш яахлаараа ийм амьтныг хуралд залдаг байна? гэж бодсоноо аргагүй зарлигийг бодож уранхай гэрт орж, амар мэндийг нь асуугаад:

- Зууд дуган аравнайлах их хуралд залах гэж ирснээ хэлж, гэрт суух олигтой дэвсгэргүй байсан тул үүдэнд зогсов. Дандар Лхарамба:

- Өө бололгүй яахав. Очно очно гэж хэлэв. Зуугаас ирсэн лам нар өвгөнийг залчихаад явах гэхэд, өвгөн:

- Тийм холоос ирчихээд ийм хурдан явж яаж болох вэ? Тэнгэр харанхуйлж байна. Хоноод яв гэв.

Ирсэн гэгээн аргагүйдэж хэдэн шавьтайгаа хонохоор болоход дагаж ирсэн хэдэн лам нь бид яарч байна гэж хэлээд явчихаж гэнэ. Гэгээн олигтой унтаж чадалгүй, шөнөжин ном судар зүүдлээд хоножээ. Маргааш өглөө нь өвгөн:

- Та нар урьдаар явж бай. Би араас чинь гүйцээд очье гэж хэлээд үлджээ.

Гэгээн шавь нартайгаа давхисаар эргэж харвал Дандар Лхарамбынх нөгөө уранхай ноорхой гэр биш, харин алтан дээвэртэй дуган гэрэл цацарч харагдав гэнэ. Гэгээн түүнийг үзээд “Ийм учиртай байх нь ээ. Энэ Дандар Лхарамба гэгч чинь ер жирийн хүн байх ёсгүй. Түүний үнэн дүр нь жирийн хүний нүдэнд үзэгдэх ёсгүй” гэж амаа барьж:

- Одоо ч аргагүй боллоо. Дахин төрөхдөө Дандар Лхарамбын шавь болж заяа гэж тангараглаад, мориноосоо бууж Дандар Лхарамбын дуганы зүг гурав мөргөөд нэг шавийгаа дуудаж:

- Чи буцаж Дандар Лхарамбын дуганд очоод ир. Дотор нь юу юу байна? Сайн үзээд ир гэж явуулав. Шавь нь дуганд хүрэхэд өвгөний салбархай гэр нь алтан дээвэртэй гэрэл цацарсан дуган байжээ. Гаднаа хаясан хэдэн чулуу нь маанийн үсэг байжээ. Хорин нэгэн хар ямаа нь хорин нэгэн боть ном байжээ. Хар шаа нь бумба байжээ. Эрүү өвдөг нийлсэн эмгэн нь цар байжээ. Салалгүй татдаг гаанс тамхи нь сан байжээ. Галын тулга нь шанлуу байжээ. Газар дэвссэн зээрийн арьс нь сүмийн олбого байжээ. Шавь түүнийг үзээд багшдаа очиж хэлэв. Гэгээн үүнийг сонсоод:

Бидний хэрэг сайхан бүтлээ. Дандар Лхарамбын үнэн дүрийг үзсэн хүн энэ орчлонд байхгүй. Тийм болохоор чи өөрийн биеэр зуугийн их багшид хэлээрэй. Харин би өөрийн биеэр үзэлгүй сүсэг алдсанаас нэг дэс буурлаа. Иймээс би зөвхөн Гүмбүмд суух заяатай байжээ гэж хэлээд буцжээ.

Гэгээний шавь өөрийн үзсэн, багшийн хэлснийг зуугийн их багшид очиж хэлжээ.

Хурлын өдөр Дандар Лхарамба гэгч тийм нэг урт гаанс татсан, шүлс нусаа хамаа намбагүй хаясан, хөл толгой нь нийлэх шахсан өвгөн хүрч иржээ. Зуугийн лам нар Дандар Лхарамбыг үзээд:

- Энэ чинь тэгээд Дандар Лхарамба гэгч нь мөн юм уу? Зээлийн гуйранч биш үү? хэмээн гайхацгааж байв.

Дандар Лхарамба зууд ирээд тамхиа татаж, амандаа хахир дуу аялж, дуганын энэ тэрүүгээр хамаагүй явж байв гэнэ. Хурлын дундуур мөн л нөгөө янзаараа ширээндээ ч тогтож суухгүй нааш цааш явж, тамхиныхаа үнсийг бурханы өмнө хаяж, дахин дахин тамхи татаад байжээ. Түүнийг хурлын их лам үзээд уур нь хүрч:

- За, үдийн хойно хурал хийхгүй, ингэж хурал хийх юм бол дуганыг бузарлах юм болно гэж хэлээд хурлаа тараажээ.

Дандар Лхарамба түүнийг сонсоод ойшоосонгүй, тамхиа татаад “Арван цагаан буян”, “Ханчир хаан” гэдэг дуугаа дуулаад, гарч явахдаа:

- За, одоо та нар хурлаа хур, би яарч байна, өнөөдөр энд хонож болохгүй, эртхэн буцаж явна гэж хэлжээ. Үдийн хойно чухам хурал хурахгүй болохоор Дандар Лхарамба:

- Та нар үдийн хойно хурал хийхгүй гэв үү? Хүнийг тийм холоос залж ирчихээд хурлаа

хийхгүй чинь ямар учиртай юм? Явахаасаа өмнө хурлыг чинь хурааж өгье гэж хэлээд хоёр дунг нь авч, хоёр завжиндаа нэг нэг үлээж хурлыг хурааж гэнэ.

Хурлын дунд манз барисанд Дандар Лхарамба сайн манз ч зоолсонгүй, тамхиа татаад тамхины гаансаар энэ тэр бандийн толгойруу нь нэг хоёр тогшиж явжээ. Зуугийн лам нар Дандар Лхарамба гэгч самуун этгээд ирээд дуганыг аравнайлуулсангүй дахиж хурал хурья гээд дахин олон лам багш нар залж иржээ. Зууд ирсэн олон багш лам нар дуганд орж үзэхэд ёстой сайхан аравнайлсан байв. Тэгээд:

- Танай энэ дуганыг Дандар Лхарамба учиргүй сайн аравнайлсан байна гэж хэлсэнд, зуугийн лам нар:

- Юу гэсэн үг вэ? Дандар Лхарамба ирээд зуу дотор тамхи татаж, энд тэнд нус цэрээ хаяж байгаад явсан. Худлаа гэвэл энд тамхины үнс нь байгаа гээд: багш лам нарыг дагуулж тамхины үнс хаясан бурханы өмнө очиж үзүүлсэнд юуны тамхины үнс байх билээ, цөм алтан цэц байж гэнэ.

Тэр хэргээс зуугийн лам нар Дандар Лхарамба гэгч жирийн хүн биш юм гэдгийг нүдээр харж үнэмшжээ.

Үнэндээ Дандар Лхарамба жирийн хүн биш байжээ. Түүний хийж байгаа хэрэг нь жирийн хүний нүдэнд үзэгддэггүй байв. Зууд ирээд тамхи татаж байсан нь сан тавьж байжээ.

Дандар Лхарамба буцах замдаа Гүмбүмээр дайрч явахад нэг лам түүнийг таниад сүмдээ залахад:

- Би их яарч явна. Манай багш түрүүлээд тэнд морилж байна. Нөгөөдөр би бас араас нь хүрнэ гэж хэлсэнд нөгөө лам заасан зүгрүү нь харсанд юу ч үзэгдсэнгүй. Өнөө лам:

- Таны багш хаана байгаа юм бэ? гэж асуухад Дандар Лхарамба:

- Миний гарын завсраар хар. Тэр явж байна гэж хэлэв.

Лам Дандар Лхарамбын гарын салаагаар харсанд түүний багш нь үүл хөлөглөн дээгүүр нь гараад шанбалын оронд явж байжээ.

Дандар Лхарамба Алшадаа хүрч нэг өдөр ном уншиж байгаад бурхан болжээ. Алшад ийм нэгэн эрдэм чадалтай, их увдистай хүн байсан бөгөөд түүнээс хойш дахиж Дандар Лхарамба төрөөгүй юм гэнэ.

Хүүхэн хутагт

Эрт урьд цагт, Хүүхэн хутагт гэгч сүрхий хувилгаан хүн байжээ. Тэр нэг насандаа ноёдтой тэмцэлдэж, эд хөрөнгийг нь хулгайлж, ядуу зүдүү ардад туслан дэмжиж явдаг тул баяд ноёд түүнд хорсож, үгээгүй ядуучууд хайрлан хүрээлдэг байжээ.

Хүүхэн хутагт хэдийгээр хулгайч дээрэмчин гэдэг нэртэй боловч авах гэсэн юмаа урьдаар эзэнд нь хэлж авдаг байв. Гэвч тэр хэзээ ирж авах, ямар үед явах нь туйлын нууц далд байдаг учраас баяд ноёд түүнийг барьж чаддаггүй гэнэ.

Нэг өдөр хүүхэн хутагт баяны адууг хулгайлахаар явж байхдаа:

Бор бор бялзуухай, босол үгүй суугаад жиргэнэ

Болзоогүй Хүүхэн хутагт баруухан биеэр нутаглана

Баяд ноёдын адуу баруухан хойшоо бэлчинэ

Баян Баргын адуунаас баахныг туугаад явна гэж дуулан баян Баргын адуунаас таслан тууж гэнэ. Хулгайлсан адуугаа хумин тууж явахдаа:

Нохой муутын гадуур нь пижигнэтэл хөөгөөд

Нойр сайтын гадуур нь найрланхан дуулаад хөөж явна даа гэж дуулан явсаар үүр цайж байхад нутгийн бараа харж:

Гурван марал нь гудайлаа

Гургалдайн даваагаар давлаа

Долоон бурхан томбойлоо

Долон нуураар давлаа гэж дуулан хойшоо эргэж харахад адууны эзэн хөөгөөд ирж байжээ.

Хүүхэн хутагт түүнийг үзээд ажиг ч үгүй:

Унасан морь минь эрдэнийн хүлэг билээ

Хазаарласан хазаар минь хаж мөнгөн билээ

Эмээллэсэн эмээл минь эрдэнэ зуугийн хос билээ

Барьсан ташуур минь Барай голын зандан билээ

Чирсэн уурга минь Чираа голын бургас билээ

Дөрөөлсөн дөрөө минь туж мөнгөн билээ

Туусан адуу минь гучин гурваас бусад нь усан тэлмэн жороо гэж дуулан хөөж явахад, адууны эзэн гүйцээд ирлээ. Хүүхэн хутагт туусан адуугаа уулруу шахаж:

Таны заяа байвал талын дундаас гүйц!

Миний заяа байвал манан будан тат! гэж хэлсэнд тэнгэр газарт тэр дороо улаан будан татаж, зүг чиг нь олдохгүй болчихож гэнэ.

Тэгээд хөөж явсан хүмүүс мананд төөрч буцсан гэдэг.

Хүүхэн хутагт ч амар тайван адуугаа хөөж нутагтаа ирээд, ард олондоо хувааж өгсөн гэнэ.

Мэргэн Тавнан

Эрт урьд цагт ойт мэргэн Тавнан гэж их элдэвтэй хүн байжээ.

Тэр хааны гүнжийг аваад Алшад буцах замд нь гүнж ойт мэргэн Тавнангаас:

- Алша ноён гэгч ямархуу хүн байдаг вэ? гэж асуухад мэргэн Тавнангийн саваагүй зан нь хөдөлж:

- Манай ноён сайн ч хүн, сайхан ч хүн. Ганцхан үмхий гэж авахын аргагүй гэж хэлжээ. Ойт мэргэн Тавнан, хааны гүнжийг Алшад залж ирээд шууд ноёны ордонд очсонгүй өөрийнхөө гэрт оруулаад:

- За, гүнж та энд сууж бай. Би ноёнд мэдэгдээд ирье гэж хэлээд явжээ. Ойт мэргэн Тавнан, ноёныд яваад орсонд, ноён:

- За, гүнж хаана байна? Ямархуу гүнж байна? гэж асуусанд, мэргэн Тавнан:

- Залаад ирлээ залаад ирлээ. Манайд жаахан амсхийж байгаа. Гүнж сайн ч хүн байна. Сайхан ч хүн байна. Бага ч хүн байна. Барамхан /хөөрхөн/ ч хүн байна. Ганцхан хамаргүй юм байна гэж хэлжээ. Ноён, гүнжийг хамаргүй гэж сонсоод “Би хамаргүй хүүхнээр яах билээ” гэж бодон:

- Өө, тийм үү, тэгвэл гүнжийг гэртээ долоо хонуулаад цэцэрлэгт оруулж надтай уулзуул гэв.

Мэргэн Тавнан гүнжийг гэртээ долоо хонуулаад цэцэрлэгт дагуулж ирж ноёнттой нүүр учруулжээ. Гүнж ноёныг үмхий гэж бодоод хамраа дараад орж иржээ. Ноён түүнийг үзээд “Энэ хүүхэн хамраа нуугаад дарж байна” гэж бодоод бусад биеий нь ажигласанд мэргэн Тавнангийн хэлснээр сайхан ч хүүхэн, хөөрхөн ч хүүхэн байв гэнэ.

Тэгээд ноён гүнжийг тоож уулздаг байжээ. Гүнж, ноён хоёр нэлээд хэдэн өдөр ийм байдалтай уулзжээ.

Нэг өдөр гүнж цэцэрлэгт явж байтал хуй салхи гарч, хамрын даруулгыг нь хийсгэж унагасанд хамар нь ил гарч иржээ. Ноён түүнийг үзээд:

- Чи чинь хамартай л юм байна ш дээ. Чамайг хамаргүй гэсэн биш билүү? гэж асуусанд, гүнж цочиж:

- Хаан таныг авахын аргагүй үмхий гэсэн биш билүү? гэж гайхан асуув.

Хаан үүнийг сонсоод “Энэ лав мэргэн Тавнангийн хийсэн мэх биз” гэж бодоод:

- Мэргэн Тавнанг барьж ир! гэж зарлиг буулгав.

Мэргэн Тавнан, ноёнд үнэнээ хэлсэнд ноён уур нь ч хүрч гэнэ. Инээд нь ч хүрч гэнэ. Тэгээд мэргэн Тавнан урьд нь ноёнд олон удаа тус хүргэж байсан тул толгойг нь авсангүй шийтгээд

өнгөрчээ.

Мэргэн Тавнан нэг тэнэг хүүтэй байжээ. Хүү нь өсч том болоод эрийн цээнд хүрч эхнэр авах цаг нь болжээ. Гэвч хүүг тэнэг болохоор эхнэр олддоггүй байж гэнэ. Мэргэн Тавнан хүүдээ заавал эхнэр олж өгнө гэж бодоод хүүдээ гурван хуц барьж өгөөд:

- За, чи энэ гурван хуцыг туугаад Бээжин ор. Гэхдээ гурван хуцаа зарж болохгүй. Харин гурван хуцандаа мөнгө ачиж ирээрэй. Үгүй бол толгойг чинь авна гэж хэлээд явуулжээ.

Ойт мэргэн Тавнангийн тэнэг хүү гурван хуцаа хөтөлж Бээжинд хүрээд “Аав минь намайг хуц худалдаж болохгүй гэсэн мөртөө гурван хуцандаа мөнгө ачиж ир гэсэн юмсан. Энэ их мөнгийг яаж олох билээ?” гэж санаа зовон зээл дээр уйлж суув. Хааны гүнж зээлийн хажуугаар өнгөрч яваад, тэнэг хүүг уйлж суухыг хараад гайхаж:

- Чи юун хүн бэ? Хаанаас ирсэн юм? Юунд уйлж суугаа юм бэ? гэж асуухад, тэнэг хүү учраа хэлэв.

Хааны гүнж тэнэг хүүгийн хөтөлж яваа гурван хуцыг хэсэг харж зогссоноо:

- Чи яасан унхиагүй хүн бэ? Энэ гурван хуцныхаа эврийг тайраад манай аавд худалдвал гурван хуц мөнгөтэй болж чадна. Энэ аргыг намайг хэлсэн гэж хэнд ч хэлж болохгүй шүү гэж хэлчихээд яваад өгөв.

Тэнэг хүү гүнжийн хэлсэн ёсоор гурван хуцныхаа эврийг тайрч хаанд худалдаад гурван хуцандаа дүүрэн мөнгө ачаад харьж ирэв. Мэргэн Тавнан хүүгээсээ:

- Энэ их мөнгийг яаж олов? гэж асуухад, тэнэг хүү нь:

- Гурван хуцныхаа эврийг худалдаж олсон гэв. Мэргэн Тавнан:

- Чамд энэ аргыг хэн зааж өгөв? гэж асуухад хүү нь:

- Хааны гүнж хэлж өгсөн гэв. Мэргэн Тавнан үүнийг сонсоод:

- За, тэгвэл тэр хааны гүнж чинь миний бэр байна. Би бэрээ залж ирнэ гэж хэлээд хүүгээ дагуулаад хааныд хүрч очив.

Мэргэн Тавнан хааныд хүрч гүнжийг нь тэнэг хүүдээ гуйсанд, хаан:

- За, яахав. Зуун хүн гуйдаг. Зөвтэй хүндээ өгдөг ёс бий. Гэвч чиний хүү миний гурван мөрийг авч чадвал би гүнжээ хүүд чинь өгье. Нэгд үнсээр дээс томж ир!

Хоёрт эр үхрийн сүүгээр элгэн тараг бүрж ир

Гуравт хоёр толгойтой морь авч ир гэж хэлэв.

Ойт мэргэн Тавнан хэдийвээр мэргэн хүн боловч энэ гурван мөрийг гүйцэж чадахгүйдээ

санаа зовж суутал, хааны гүнж тэнэг хүүд:

- Тэр гурван мөрийг би хэлж өгье. Гэвч намайг хэлсэн гэж аавд хэлж болохгүй. Үнсэн дээс гэж өвсөөр дээс томж галд шатаагаад аваад оч. Хоёр толгойтой адуу гэж унагалж байгаа гүү аваад оч. Эр үхрийн таргийг “Аав төрөх гээд бүрж чадсангүй” гэж хэл. Тэгвэл аав “Эр хүн төрөх гэж юу байдаг юм?” гэж асуух байх. Өөдөөс нь “Эр үхэр тугална гэж юу байдаг юм?” гэж асуугаарай. Тэгвэл аавд хэлэх үг олдохгүй гэж хэлж өгчээ.

Мэргэн Тавнан хааны гүнжийн аргыг сонсоод ухаантай охин байна гэж улам тоож, түүний хэлсэн аргаар хийсэнд хааны гурван мөрийг бүгдийг авч гэнэ. Тэгээд хаан хэлсэн үгэндээ хүрч гүнжээ өгч явуулжээ.

Хаан гүнжийнхээ араас харуусан “Энэ ойт мэргэн Тавнан яаж миний мөрийг мэдсэн юм бол?” гэж бодоод зурхайгаа татаад үзсэн чинь өөрийн охин нь хэлж өгсөн байжээ. Хаан уурлаж олон цэрэг томилж:

- Тэднийг хурдан барьж авчир гэж тушаав.

Ойт мэргэн Тавнан хүү бэр хоёроо дагуулан нутагтаа дөхөж явтал хааны цэргүүд хөөж ирэв. Мэргэн Тавнан хэрэг биш боллоо гэж санаа зовж явтал бэр нь эр нөхрийнхөө өмнө байгаа том хар чулууг зааж:

- Чи тэр хар чулууг түлхэж холдуулаад доош нь гурван алд малт. Тэгвэл доороос нь цагаан, хар хоёр судал гарч ирнэ. Хар судлыг нь тасалж хая гэж хэлэв.

Нөхөр нь хатныхаа хэлсэн ёсоор том хар чулууг булга татаж холдуулаад, доош нь гурван алд газар малтаж, хар цагаан судал гарч ирэхэд хар судлыг сэт татсанд, өнөө хар судал далайн хүйс байсан тул тэр дороо ус цоргин гарч нуур болж, хааны цэргүүдийн замыг хаав.

Тэгээд ойт мэргэн Тавнан, хүү бэр хоёртойгоо харьж ирэв.

Хааны цэргүүд тэднийг барьж чадалгүй буцаж ирэхэд хаан зурхайгаа татаж үзвэл далайн хүйсийг тавьсан нь бас өөрийн охиных нь арга болохыг мэдээд, улам уурлаж:

- Харьд мордсон охин хар элгээ өгдөг гэж хараагаад зурхайгаа хаяжээ.

Хожим тэр нуурыг Хөх нуур гэж нэрлэжээ.



ЯВГАН ҮЛГЭР





Газрын лус

Эрт урьд цагт туйлын ядуу зүдүү амьдралтай нэгэн залуу байжээ. Тэр хөөргөний үр түүж бор ходоодоо тэжээдэг байв.

Нэг өдөр нутгийн баян хүн малаа усалж байтал худаг дотроос могой гарч ирээд нэг ямааных нь уруулыг хатгачихаж гэнэ. Баян эр уурлаж могойг цохиж алахаар мод чулуу барьж хөөв. Энэ үед ядуу залуу худгаас ус авахаар ирж яваад баян эртэй таарч:

- Та юу хөөж байгаа юм бэ? гэж асуухад баян эр:

- Энэ муу могой миний ямааг хатгачихлаа. Тэгээд би түүнийг алахаар хөөж байна гэхэд, ядуу залуу:

- Та битгий ал! Газрын лусыг алж болдоггүй юм гэж хэлээд болиулсанд баян эр:

- Тэгвэл чиний хөөргөний үрээр ямааныхаа уруулыг цорлоё гэж хэлээд залуугийн түүж бэлтгэсэн хөөргөний үрийг бүгдийг аваад явчихжээ.

Залуу овоохойдоо буцаж ирээд идэх юмгүй хоосон хонох болсон тул унтахаар хэвтэв. Гэнэт нойронд нь нэг хүн:

- Хүүе, хурдан бос! Явья гэж дуудав. Залуу би зүүдэлж байна уу? гээд гараад хартал овоохойных нь үүдэнд хөтөлгөө морьтой танихгүй хүн зогсож байв. Ядуу залуу “Энэ чинь юун хүн билээ?” гэж гайхаж зогстол, өнөөх хүн:

- Би чамд идэх юм өгье. Энэ морийг унаад намайг дагаад яв. Харин нүдээ тас аниад яваарай. Намайг хар гэхээр хараарай гэж хэлэв. Ядуу залуу өнөө хүний хэлсэн ёсоор нэг морийг нь унаад, нүдээ тас аниад дагаж явав. Яван явсаар нэг газар ирээд:

- Одоо нүдээ нээгээд хар гэв. Залуу нүдээ нээгээд хартал нэг том цагаан гэрийн үүдэнд зогсож байв. Тэр хүн ядуу залууд:

- За, чи одоо энэ гэрт ор. Дотор нь миний аав, ээж хоёр биеэрээ дүүрэн могой ороочихсон сууж байгаа. Чи түүнээс айж болохгүй шүү. Гэр дотор элдэв зүйлийн алт, мөнгө, эрдэнэс бий. Аав, ээж хоёр чамаас:

- Чи миний хүүгийн амийг аварсан болохоор юу дуртайгаа ав гэж хэлнэ. Тэгэхээр нь чи “Аав ээж надад алтан хайрцгаа өгөөч” гэж гуй. Аав ээж чамд алтан хайрцгаа өгөхдөө гурван нөхцөл хэлнэ. Чи түүнийг сайн тогтоож аваад ир гэв.

Ядуу залуу гэрт орсонд үнэхээр биеэрээ дүүрэн могой ороосон, буурал үстэй өвгөн эмгэн хоёр сууж байв. Зарим могой биеэс нь бугаад нааш, цааш явж байна. Хоёр хөгшин залууг орж очиход:

- Чи миний хүүгийн амийг аварсан хүн. Одоо авдраар алт авна уу? Азаргаар адуу авна уу? Өөрөө сонгож ав гэв. Залуу:

- Аав ээж надад алтан хайрцгаа өгчих гэв. Өвгөн эмгэн хоёр аргагүйн эрхэнд алтан хайрцгаа залууд өгөөд:

- Чи гурван жил энэ хайрцгийн тагийг авч нээж болохгүй! Хэрэв нээвэл барцад ирнэ. Гурван нөхцөл тавина. Эхний жил зөвхөн хөөргөний үрээ түүж ид. Хоёр дахь жилд “Би өнөөдөр тийм хоол идмээр байна” гэж бодоод ажлаа хий. Хүрч ирэхэд чинь хүссэн хоол чинь бэлэн болсон байна. Гурав дахь жилд хайрцагны тагийг өөрөө нээж үз. Тэр үед чиний жаргал ирнэ гэв.

Ядуу залуу хоёр хөгшний хэлсэн нөхцлийг бүгдийг тогтоож аваад гарч ирэхэд өнөө хүн мориндоо мордуулж, нүдий нь аниулаад түрүүчийн адил гэрт нь хүргэж ирэв. Тэгээд:

- За, чи аав, ээж хоёрын хэлсэн ёсоор явах ёстой шүү. Хэрэв зөрчвөл барцад ирнэ гэж хэлээд буцаж явав.

Залуу эхний жилдээ урьдын адил хөөргөний үрээ түүж идэв. Хоёрдахь жил нь ажилдаа явахдаа “Би өнөөдөр тийм хоол идэх юмсан, ийм хоол идэх юмсан” гэж бодоод буцаж ирэхэд үнэхээр хүссэн хоол нь байж байдаг байв. Нэг өдөр ядуу залуу “Чухам ямар амьтан надад хоол бэлдэж өгөөд байгаа юм бол? Танадаж үзье” гэж бодоод ажлаасаа эрт харьж, гэрийнхээ ойролцоо гэтэж байгаад харсан чинь цав цагаан царайтай үзэсгэлэн төгөлдөр бүсгүй гэрт нь ирээд хоол хийж байв гэнэ. Залуу тэр гоо бүсгүйг хараад баярлан гэртээ гүйж орсонд бүсгүй уйлчихав. Тэгээд тэр бүсгүй юу ч хэлэлгүй уйлаад байхаар нь залуу сандарч:

- Яагаад уйлаад байгааг асуусанд, бүсгүй:

- Чи миний аав, ээжийн хэлснээр явсангүй. Одоо буцаад алтан хайрцгандаа орж чадахгүй гээд уйлаад байв.

Энэ өдрөөс хойш залуу бүсгүйн дэргэдээс холдож чадахгүй байнга хажууд нь дагаж явдаг болов. Бүсгүй:

- Чи явж ажлаа хий. Ингээд байвал бидний барцад удаж арилна гэж хэлдэг байв. Залуу нэг өдөр ажилдаа явах гэтэл хөл нь урагш алхахгүй буцаж гишгээд байв. Бүсгүй үүнийг үзээд залууд зургаа зурж өгөөд:

- Чи миний зургийг модны мөчрөөс өлгөөд санах үедээ харж ажлаа хий гэж хэлээд явуулав.

Тэгж байтал нэг өдөр хуй салхи ирээд бүсгүйн зургийг хийсгэж ноёны хашаанд унагажээ. Ноёны түшмэл өнөө зургийг олоод ноёндоо авчирч өгчээ. Ноён зургийг үзээд:

- Энэ чинь ямар сайхан хүүхэн бэ? Энэ хүүхэн лав ойрхон суудаг байх. Та нар хурдан явж энэ хүүхнийг олж ир! Би энэ хүүхнийг хатнаа болгож авмаар байна гэж зарлиг буулгав.

Ноёны түшмэл, зарц, хуягууд үймэлдэж, зурган дээрх бүсгүйг хайж эхлэв. Хайж явсаар ядуу залуугийн нэг уранхай овоохойгоос олоод авч явахад бүсгүй нөхөртөө:

- Чи богширго шувууны арьсаар малгай хийж, хулганы арьсаар дээл хийж өмсөөд гурван

жилийн дараа ноёны өргөөнд хүрч очоорой гэж хэлээд явав.

Ядуу залуу буцаад хэвийн амьдралдаа орж, өдөртөө хөөргөний үрээ түүж идэн, богширго алж арьсыг нь өвчин малгай хийх гэж, хулгана алж арьсыг нь өвчин дээл хийх гэж чармайж байв. Гэвч богширгоны арьсаар малгай хийх, хулганы арьсаар дээл хийх гэдэг тэнгэрт гарахаас хэцүү зүйл байлаа.

Ингэж байтал гурван жил болж залуу малгай, дээл хоёроо хийж чадсангүй. Гэнэт хүсэл биелүүлдэг алтан хайрцгаа санаж, унтахдаа “Энэ шөнө миний малгай, дээлийг бүтээж өгөх болтугай” гэж бодоод унтав. Маргааш өглөө нь сэрээд харсан чинь богширгоны арьсан малгай, хулганы арьсан дээл нь бэлэн болчихсон байв. Тэгээд залуу малгай, дээлээ өмсөөд ноёныд хүрч очив. Ноёны хатан залууг хараад учиргүй ихээр шоолон инээв. Ноён хатнаа ингэж ханатлаа инээж байхыг урьд хараагүй болохоор:

- Чи надтай суусан гурван жилд ингэж инээж байсангүй. Яасан сайхан инээдэг юм бэ? гэж сонирхон хэлэхэд:

- Та бодоод үз дээ. Орчлон дээр богширгоны арьсан малгай, хулганы арьсан дээл өмссөн хүн байна уу? Би анх удаа үзэж байна. Хэрэв ноён та энэ малгай дээлийг өмсөөд хотыг гурав тойроод ирвэл би дахиад инээж өгнө шүү гэв.

Ноён, ядуу залууг дуудан:

- Чи надад дээлээ өг. Би түр өмсчихөөд өгье гэв.

Ядуу залуу өмсөж байсан дээл, малгайгаа ноёнд тайлж өгөв. Ноён түүнийг өмсөөд их л додигор хотыг тойрохоор явав. Ноёныг гарсны дараа хатан ядуу залууд ноёны хувцсыг өмсгөж, зарц нартаа:

- Богширгоны арьсан малгай өмссөн, хулганы арьсан дээл өмссөн луйварчин хот тойрч байна. Түүнийг хурдан барьж ал! гэж зарлиг гаргав.

Олон цэрэг тэр дороо богширгоны арьсан малгайтай, хулганы арьсан дээлтэй ноёныг барьж алав.

Тэгээд лусын охин нөхрөө ноёны сууринд суулгаж, өөрөө хатан нь болж амар тайван амьдарчээ.

Анчин залуу есөн хэл сурсан нь

Эрт урьд цагт нэг анчин залуу эхнэртэйгээ ан гөрөө хийж амьдран суудаг байв.

Нэг өдөр, тэр залуу морио унан ан гөрөөгөө хийгээд явж байсан чинь нэг хадны өмнө олон могойнууд эрчлэн ороолдож байжээ. Анчин залуу тэдгээр могойнуудыг ажиглаж зогстол могойнууд нэг нэгээрээ нүхнийхээ хажууд байсан гозгор ногоон чулууг долоочихоод нүхэндээ орж байв. Залуу ногоон чулууг лав учиртай чулуу байх нь. Ямар эрдэнэ юм бол? гэж бодоод очиж авах гэтэл тун авагдсангүй.

Тэгж байтал нар шингэж орой болов. Залуу саваагүй зан нь хөдөлж “Могой долоосон чулууг долоогоод үзвэл яадаг бол? Хуучны хүмүүсийн хэлдгээр могой долоосон чулуу долоовол есөн хэл сурдаг юм гэсэн” гэж бодоод өнөө гозгор ногоон чулууг долоотол тэр дороо гулгаад могойны нүхэнд орчихов.

Нэг мэдэхэд түүний хажууд усан могой, гал могой хоёр цагариглан хэвтэж байв. Залуу айхдаа ухаан алдаж, гурван жил нүхэнд хэвтжээ. Энэ хойгуур эхнэр нь нөхрөө хайж хайж эмээлтэй морий нь олоод явжээ. Анчин нэг өдөр гэнэт ухаан орж үзвэл, хоёр могой мөн хэвээр хэвтэж байв. Хоёр могой анчны сэрэхийг хараад:

- Чи сэрчихсэн үү? Гадаа гармаар байна уу? гэж хэлээд миний сүүлнээс барь гээд нүхнээс чирч гаргав. Нүхний гадна бас л олон могой овооролдон, ногоон чулууг долоож байв. Тэгтэл:

- Чи гэртээ харьмаар байна уу? гэж усан могойн дуу гарав. Эргээд хартал юу ч харагдсангүй. Тэр:

- Би гэртээ харьмаар байна гэхэд:

- Чи ямар эрдэм авмаар байна гэж асуув. Залуу:

- Би есөн хэл сурмаар байна гэхэд могой:

- Тэгвэл чи миний хөлийг тоолж үз гэв. Залуу “Могойд юуны хөл байдаг юм гэж” бодоод эргэж харсанд усан могой хэвтэж байх нь үзэгдэв. Тэр нэг арга бодож:

- Чи миний толгойтой үсийг тоолж үз гэв. Усан могой:

- Чи сүрхий эр байна. Одоо чи миний хөлийг битгий тоол, би чиний үсийг ч тоолохгүй. Чи миний нүхэнд ухаангүй хэвтэж байхад чинь би чамд есөн хэл нэгэнт өгчихсөн. Харин чи гэртээ хариад нэг жилийн дотор есөн хэл сурснаа хэнд ч хэлж болохгүй.

Тэгж чадвал чамд тэр эрдэм тогтоно. Харин миний хэлснийг эс биелүүлвэл би чамайг хатгаж ална гэж хэлэв. Анчин залуу, могойноос салж, гэртээ харьж явгал замд нь баян, ядуу хоёр айл таарав. Баян айлд нь орж хоол идэх санаатай ойртож очтол нохой нь:

- Цаашаа яв, цаашаа яв. Манай эзэн хүнд хоол өгдөггүй юм гээд хуцаж байв. Залуу үүнийг сонсоод ядуу айлыг чиглээд очтол, нохой нь:

- Наашаа ир, наашаа ир. Манай эзэн ядуу ч хүнд хоол өгдөг юм, өгдөг юм гээд хуцаж байв.

Залуу, ядуу айлд ороход эзэн нь сайхан загнаж, хоол чанаж өгөв. Залуу хоол идээд унтахаар хэвтэж байтал баян айлын галын бурхан, ядуу айлын галын бурхан хоёр хүүхэн орж ирэв. Баян айлын галын бурхан хүүхэн:

- Чиний дээл чинь яагаад ийм муухай болчихсон юм бэ? гэж ядуу айлын галын бурхан хүүхнээс асуухад:

- Өө, манай эзэд хоол цайгаа хийж идэхдээ эхлээд надад өргөдөг юм. Би юм бүгдийг идсээр байгаад ийм болчихсон юм гээд:

- Харин чиний дээл яагаад ийм цэвэрхэн байдаг юм бэ? гэхэд, баян айлын галын бурхан:

- Манай эзэд юу ч идсэн надад өргөдөггүй мөртөө хэзээд миний дээрээс хар ус асгадаг юм. Тэгээд миний дээл ийм цэвэрхэн байдаг юм гэж хэлээд уйлж:

- Би танайд ирж амьдаръя. Манайхыг түлчихээд танай гэрийг өөд нь татаж явъя гэхэд ядуу айлын галын бурхан:

- Тэгж болохгүй. Танайд манай нэг аргалз байгаа. Тэрийг түлчихнэ гэхэд:

- Гэмгүй ээ. Би танай аргалзыг тогоон дотор хөмөрчихнө гэв. Ядуу айлын галын бурхан:

- Бас манай нэг борлон байгаа гэхэд баян айлын галын бурхан:

- Тэр бас гэмгүй ээ. Би танай борлонг хөдөө уячихъя хэмээн ярилцаж байна гэнэ.

Анчин залуу түүнийг сонсоод за энэ шөнө юу болдог бол? гэж бодож хэвтгэл гэнэт баян айлын нохой хуцаж, хүн хашгирч, хонь мал майлалдаж байгаад чимээ тасрав. Өглөө нь ядуу айлын эмгэн босч гараад:

- Хөөе, энэ зүүн айл юу болчихов? Шөнө бүгд шатчихаж. Ийм хэцүү юм байдаг аа хэмээн гасалж байснаа:

- Энэ айлд манай нэг аргалз байсан юмсан. Яасан бол? гээд шатсан бууцанд очиж аргалзаа хайв. Анчин залуу гэрээс гарч баян айлын буйрны хажууд хэвтээ тогоог зааж:

- Та нар энэ тогоог эргүүлээд үз. Танай аргалз дотор нь бий гэв. Айлын хүмүүс тогоог эргүүлээд үзтэл аргалз нь хөмрөөтэй байв. Тэд мөн:

- Бас манай нэг борлон эднийд байсан юмсан. Яагаа бол? гэхэд, залуу:

- Танай борлон шатаагүй. Хээр байгаа. Цаашаа яваад үз гэж хэлэв.

Айлын хүмүүс цааш явж үзсэнд борлон нь шүдээрээ биеэ шөргөөгөөд зогсож байжээ. Залуу цааш явж байтал замд нь бас нэг айл таарч ороход таньдаг айл нь байв. Айлын хүмүүс залуут

хараад:

- Хөөе, чи чинь энэ олон жил хаана байж байгаад ирэв? гэж гайхан асуухад, залуу:

- Аан, би хол газар явсангүй ээ гээд эг маг инээгээд өнгөрөөв.

Орой болсон тул залуу айлд хонов. Шөнө дунд салхи гарч, бороо ороход айлын хоттой мал:

- Бороо орж, салхи салхилаад даарч байна. Хурдхан өвөлжөөндөө очиж хоноё гээд хотноосоо цувраад явчихав. Ард нь нэг муу эцэнхий төлөг хоцорч:

- Та нар удаан яв. Би гүйцэхгүй байна. Би бол энэ айлын хамаг буян хишгийг авч яваа шүү. Хэрвээ та нар намайг орхиод явбал сайнаа үзэхгүй шүү гэж майлж байна гэнэ.

Шөнө айлын эзэн сэрээд хоттой малаа байхгүй болсон байсанд сандарч, тал тал тийш хайв. Тэгээд олсонгүй анчин залуугаас:

- Чи нэг төлөг татаж үз. Манай мал хаана байна? Хурдан олохгүй бол чоно нохойд орно гэв. Анчин залуу төлөг татаж буй хүн болж үзсэнээ:

- Төлөгт танай малыг өвөлжөөндөө байна гэж буулаа гэж хэлэв. Айлын улс шөнөөр явж өвөлжөөндөө хүртэл мал нь үнэхээр өвөлжөөндөө байв. Тэгээд малаа тууж ирээд, залууд:

- Төлөг тавьж, мал олж өгсөнд баярлалаа гэж хэлээд хотноосоо нэг бүдүүн хонь барьж өгөв. Залуу:

- Би ийм том хонь авахгүй. Харин тэр эцэнхий төлгөө л өгчихөд болно гээд төлгийг авч гэрийнх нь хажууд уячихаад цай ууж суутал нохой нь:

- Хамаг хишиг буянтай төлгийг минь аваад явах нь гэж хуцаад сүүлий нь тасдаад идчихэв. Залуу үүнийг хараад:

- Би сүүлгүй төлөг авахгүй. Харин нохойгий чинь авья гэхэд гэрийн эзэд:

- Та ямар сонин хүн бэ? Ирэг өгөхөөр төлөг авна гээд, төлөг өгөхөөр нохой авна гээд гэж гайхсан боловч нохойгоо өгөв. Анчин нохойгоо уячихаад гэрт орж юм хумаа аваад гарч иртэл нохой нь гэрийнхээ хаяаруу шээчихэв. Залуу:

- Одоо би энэ нохойгоор юу хийх билээ? Танай эндээс нэг бариул хайчилж авья гэж хэлээд нохой шээсэн газраас жаахан эсгий хайчилж аваад явав.

Анчин залуу гэртээ хариад өнөө бариулаа гэрийнхээ хананд хавчуулаад ортол, эхнэр нь уйлж:

- Чи чинь ийм олон жил сураг чимээгүй хаагуур явсан юм? гэж асуусанд:

- Аан, би сонин газраар яваагүй ээ гэж эг маг инээж эхнэрээ аргадаад өнгөрөв. Тэгээд эхнэртэйгээ эвтэй амьдарч хагас жил болж байтал, нэг өдөр гадаа нь нэг хулан жороо ирж

суугаад:

- Одоо салхи босох юм байна гэж дуугарав. Бас нэг богширго ирж:
- Танайд одоо нэг хүн ирэх юм байна гэж байв. Залуу үүнийг сонсоод инээд нь хүрч байн байн инээгээд байсанд, эхнэр нь гайхаж:
- Чи яагаад байсхийгээд л инээгээд байгаа юм бэ? Юу бодов? гэж асуухад:
- Харин зүгээр байж байхад инээд хүрээд байх юм гэж хэлжээ. Бас нэг өдөр нохой нь:
- Манай эзэгтэйн ханилдаг лам нь ирэх юм байна гээд хуцаж гэнэ. Залуу сонсоод инээд нь ч хүрч, уур нь ч хүрч байв. Тэр “Одоо манай эхнэрийн уулздаг лам нь ирэх юм байна. Ямархуу хүн байгаа бол?” гэж бодоод инээсэнд, эхнэр нь:
- Чи бас л инээгээд байх юм. Юу бодов? гэхэд залуу:
- Би есөн хэл мэддэг юм. Сая манай нохой чамтай уулздаг ламыг ирнэ гэж хуцаж байхыг сонсоод инээлээ гээд ам алдчихав.

Тэр өдрөөс хойш удаагүй байтал нэг өдөр эхнэр нь хананд хавчуулаатай байсан тогооныхоо алчуурыг авах гэтэл могой гарыг нь хатгаад алчихав. Эхнэр нь нэлээд болхи хүн байсан бөгөөд тогооныхоо алчуурыг дандаа эхний хананд хавчуулдаг байж. Залууд “Аав ээж тогооныхоо алчуурыг энд хавчуулж болдоггүй гэж хэлдэг байсан” гээд очоод авах гэтэл могой хатгаад алчихаж гэнэ.

Анчин залуу, хүн хар гөрөөс хоёрын үлгэр

Эрт урьд цагт нэг залуу эхнэр хүүхдээ орхичихоод ан гөрөө хийж явж байгаад алга болчихож гэнэ. Гэрийнхэн нь залууг хэчнээн хайгаад олоогүй тул үхчихэж гэж боджээ.

Харин залуу хадан ганд унаад хөлөө хугалчихаад явж чадахгүй мөлхсөөр нэгэн агуйд орж суусан байв. Анчин залуу агуйн хадыг түшээд сууж байтал шөнө дунд нэг амьтан ирэх чимээ гарав. Анчин буугаа авч хадны ард нуугдаж хэвтэв.

Удалгүй нэг том биетэй амьтан орж ирээд түс хийтэл газар хэвтээд хүржигнэтэл хурхирч гарав. Анчин босоод ирж магадгүй гэж бодоод хөдлөлгүй суусаар тэр дороо унтчихсан байв. Нэг сэрсэн агуйд гэгээ орж өглөө болсон байлаа.

Залуу сэм өндийж харвал өнөөх амьтан алга байлаа. Залуу мөлхөн гарч ойр тойрныг харвал бараа сураггүй болсон байсан тул түр амсхийгээд “Энэ агуйд удаан байвал аюултай юм байна. Араатан амьтны идэш болж магадгүй” гэж бодоод мөлхөж явсаар агуйгаас нэлээд холдоод нэг уулын бэлд жаахан амарч суух гэтэл уулын ард хоёр амьтан зодолдож байна гэнэ. Хартал хүн хар гөрөөс, баавгай хоёр зодолдож байв. Хэсэг харсанд баавгай дийлэх янзтай болж ирэхлээр нь “Хүн хар гөрөөст туслья. Хүн төрөлтөн юм даа” гэж бодоод буугаа онилж баавгайг буудаж унагалаа.

Тэгсэн чинь өнөө хүн хар гөрөөс баярлан алгаа ташиж анчин залуугийн дэргэд давхиж ирээд бууг нь хол шидчихээд залууг тэврэн давхив.

Залуу “За одоо ч тусыг цусаар гэгч болох нь дээ” гэж бодтол баавгайн хажууд ирээд баавгайн арьсыг хуу татан авч анчин залуугийн хугархай хөлийг чанга гэгч боочихоод цааш авч явав.

Тэгтэл өнөө агуйд хүрч ирлээ. Урьд шөнийн агуйд орж ирсэн амьтан нь хүн хар гөрөөс байжээ. Хүн хар гөрөөс залууг агуйд оруулаад агуйн амыг том чулуугаар дарчихаад яваад өгөв.

Удаж удаж хэсэг үхрийн мах авчраад хадан дээр хэд балбаад ид гэж залууд өгөв. Залуу их өлсөж байсан тул аргагүйн эрхэнд махыг авч иджээ.

Ингээд тэнд бараг жил болов. Тэр хүн хар гөрөөс эм гөрөөс байсан бөгөөд өглөө агуйн амыг чулуугаар дарж яваад, орой мах олж ирдэг байв. Залуугийн хөл ч эдгэж гэнэ.

Тэгээд хүн хар гөрөөстэй нөхцөж хүүхэд гаргажээ. Хүүхэд нь туйлын хөөрхөн бөгөөд цээжин бие нь хүнтэй адил, бөгсөн бие нь хүн хар гөрөөстэй адилхан болов. Хүүхэд нь ч том болж, хүн хар гөрөөс ч залууг явчихна гэж сэрэмжлэхээ больж агуйн амыг таглахгүй явдаг болов.

Анчин залуу гэр орондоо харихыг бодож, хүн хар гөрөөсийг эзгүй хойгуур хүүхдээ дагуулан уулын оройгоор явж газар үздэг болов.

Нэг өдөр гадуур явж байгаад зууд мөргөхөөр явж байсан лам нартай таарчээ. Залуу “Одоо л эндээс оргож явъя” гэж хүүхдээ санд мэнд агуйдаа оруулж тавьчихаад навгархай салбархай

хувцсаа өмсөөд лам нарыг амдан гүйв. Долоон лам түүнийг хараад:

- Чи юун хүн бэ? Хаанаас ирэв? гэж асуухад залуу үнэн учраа хэлж, аваад яваач гэж гуйв.

Лам нар залууг орхимжиндоо нуугаад цааш явав. Хэсэг яваад эргэж хартал хүн хар гөрөөс хөөгөөд ирж яваа харагдав. Анчин залуу түүнийг үзээд:

- Багш нар минь, намайг түүнд өгч огт болохгүй шүү гэж гуйсанд лам нар бүрээ бишгүүрээ үлээж хүн хар гөрөөсийг буцааж явуулав.

Цааш нэлээд явж байгаад эргээд харсанд хүн хар гөрөөс хүүхдээ тэврээд ирж явна гэнэ. Тэгээд хүүхдээ лам нарын араас өргөж үзүүлсэн боловч лам нар залууг аваад зогсолгүй явсанд хүн хар гөрөөс уурлаж хүүхдээ газар тавьж, толгой дээр нь гишгэж тас татаад талыг нь залуу руу шидэж, талыг нь өөрөө аваад буцаад явчихсан гэдэг.

Хүн хар гөрөөс айлын охиныг булаасан нь

Эрт урьд цагт Алшачууд жил болгон гэр бүлээрээ зууд мөргөл хийдэг заншилтай байжээ. Тэгээд зам холоос болж цаст уулын ёроолд буудаллаж байж гэнэ. Нэг жил, гэр бүлээрээ зууд мөргөхөөр явж байгаад цаст уулын ёроолд ирж морь тэмээгээ амрааж буудаллав.

Тэгээд явах болж арван дөрвөн настай охиноо тэмээгээ авчир гэж явуулжээ. Охин нь өндөр уулын бэлд хүрч, тэмээнийхээ дэргэд очтол цаанаас нь хүн хар гөрөөс гарч ирээд, барьж аваад явчихаж гэнэ. Ээж, аав нь охиноо хэчнээн хайгаад олсонгүй аргаа барж цааш явж зууд мөргөчихөөд харьжээ. Нэлээд хэдэн жил өнгөрч охиныхоо хойноос гашуудах нь багасч байх үест бас нэг айл зууд явж байгаад цаст уулын хажуугаар өнгөрч явтал бүх биеэрээ үстэй хүүхэн гүйж ирэв гэнэ. Айлын улс айж сандарч зогстол тэр ноостой хүүхэн:

- Та нар битгий ай. Би бол хүн байна. Олон жилийн өмнө миний ээж аав намайг дагуулж зууд явж байгаад энд үлдээсэн юм. Би тэмээгээ авахаар явж байхад хүн хар гөрөөс барьж аваад явсан юм. Өнөөдөр би арай гэж зугтааж ирлээ гэв. Угтаа айлын улс ч зэргэлдээ хошууны айл охиноо гэсэн талаар сонсож байсан болохоор түүний үгэнд арай гэж үнэмшив. Ноостой хүн:

- Одоо хүн хар гөрөөс араас хөөгөөд ирж яваа. Та нар миний амийг авар! гэж гуйжээ.

Тэд ноостой хүнийг ачаандаа хийж нуув. Төдөлгүй хүн хар гөрөөс хүүхний араас хөөж ирсэн боловч айлын хүмүүст ойртож чадахгүй, бас холдож чадахгүй ойр хавиар нь бараадан холхиж байснаа гэнэт буцаад ой модруу орчихов. Айлын хүмүүс “Одоо хүн хар гөрөөс явсан” гэж бодоод хүүхнийг ачаан дээрээ гаргаж суулгаад явж байтал өнөө хүн хар гөрөөс ой модноос хүүхдээ тэврэн гарч ирээд уулын хөвөөгөөр нааш цааш явж хүүхдээ эхэд нь харуулж байна гэнэ. Мөргөлчид ажиггүй цааш явсанд хүн хар гөрөөс хүүхдээ хоёр хөлөөс нь барьж хоёр тийш нь татаж тасдаад нэг хэсгийг нь ээжрүү нь шидэж, нэг хэсгийг нь өөрөө аваад ууландаа буцаад орчихсон гэдэг. Хүн хар гөрөөс гэгч амьтан их үнэнч сэтгэлтэй боловч хаягдаж үлдэхийг үл тэсвэрлэж, үр хүүхдээ золионд гаргадаг өрөвдөлтэй бөгөөд харгис хэрцгий амьтан байжээ.

Бурхан чөтгөр хоёр

Эрт урьд цагт хүний хоёр мөрөн дээр бурхан, чөтгөр хоёр нэг нэгээрээ сууж явдаг байжээ.

Тэр хоёр хэзээд сайн муу хоёрын талаар маргалдаж явдаг гэнэ.

Нэг удаа, бурхан чөтгөр хоёр хүн төрөлхтөн хэнийг түрүүлж шүтдэг тухай маргалдаж гарчээ.
Бурхан:

- Хүн төрөлхтөн намайг түрүүлж шүтдэг гэв. Чөтгөр:

- Үгүй, хүн төрөлхтөн намайг түрүүлж шүтдэг гэв.

Хоёулаа хэн нь ч хэнийгээ дийлсэнгүй тул мөрий тавьж үзэхээр болов. Тэгээд бурхан, чөтгөр хоёр нэгэн салаа замын эхэнд ирж, хүн ирэхийг хүлээж суув.

Гэтэл нэг үүргэвч үүрсэн бадарчин салаа замын эхэнд ирээд:

- Ёо, ёо. Ядарч үхэх нь. Яасан хол газар вэ? гэж үүргээ авч газар тавиад хөлсөө арчиж жаахан амарч аваад:

- Лам гончиг сүм минь! Ум ма ни бад ми хум. Яасан хол газар вэ? гэж үүргээ үүрээд босч явав.

Чөтгөр энэ үгийг сонсоод:

- За, ямар байна? Чи сонсов уу? Хэнийг түрүүлж хэлж байна? гэж асуухад бурхан хэлэх үггүй болсон гэдэг.

Учир нь “Ёо, ёо” гэж хэлэхэд чөтгөр баярладаг юм гэнэ.

“Ум ма ни бад ми хум” гэж хэлэхэд бурхан баярладаг юм гэнэ.

Бурхан чөтгөр хоёр, хүнд гэр хийж өгсөн нь

Эрт урьд цагт, бурхан багш хүнийг даарахаас нь хамгаалж монгол гэр хийж өгсөн юм гэнэ. Тэгээд бурхан:

- За, би хар толгойт хүнд хүйтэнд даарахгүй, халуунд халахгүй, салхи борооноос айхгүй монгол гэр хийж өглөө гэж хэлэв. Чөтгөр энэ үгийг сонсоод:

- Чиний тэр хар толгойт хүнд хийж өгсөн монгол гэр бол яршиг төвөгтэй, нүүж явахад амаргүй. Би бол түүнээс сайхан гэр зохионо гэж хэлсэнд, бурхан:

- Тийм юм бол чи нэг сайхан гэр хийгээтэх! Би харъя гэв. Чөтгөр:

- Тэр юухан байдаг юм. Чи харж бай! гээд хүнд майхан барьж өгсөн гэнэ.

Ийнхүү хүн төрөлхтөн бурханы хийж өгсөн гэрт өвөл даарахгүй, зун халахгүй, хавар намар салхи шорооноос айхгүй амар тайван амьдардаг ба чөтгөрийн хийж өгсөн майхныг аян замд авсаархан гэж авч явдаг болсон нь ийм түүхтэй юм гэнэ.

Шулам хүүхэд төрүүлсэн нь

Эрт урьд цагт нэг шулам “Би сайхан хүү төрүүлэх юмсан” гэж үргэлж боддог байж гэнэ.

Нэг өдөр, шулам анхны хүүхдээ төрүүлсэнд чоно төржээ. Шулам “Анхны хүүхэд ч тиймхэн л юм байна. Дахиж нэг хүү төрүүлье” гэж хоёрдахь хүүхдээ гаргасанд шилүүс байв.

Шулам дургүйцэж “Шилүүс чинь чоныг гүйцэхгүй амьтан. Одоо нэг сайхан хүү төрүүлье” гэж гуравдахь хүүхдээ төрүүлсэн чинь ирвэс байжээ. Шулам эс тоож дөрөвдэх хүүхдээ гаргатал ямаа байв.

Шулам эгдүүцэж “Энэ муу ямаагаар юу хийх юм. Одоо нэг хүү төрүүлье” гээд тавдахь хүүхдээ төрүүлтэл муур байв. Шулам үзээд “Энэ муур ч дэмий л амьтан даа” гэж сайхан хүү төрүүлэхээр зургаадахь хүүхдээ гаргасан чинь шар шувуу байв.

Шулам гайхаж “Энэ чинь одоо юу болж байна вэ?” гаргах тусам болохоо байлаа. Одоо лав нэг сайхан хүү төрөх байх гээд долоодахь хүүхдээ төрүүлсэнд ооль байв.

Шулам ихэд уурсаж “Дахиж энэ төрөлдөө хүүхэд гаргахгүй. Дараа төрөлдөө ч хүүхэдгүй явна” гэж амлав.

Үүнээс хойш үр төрүүлдэггүй амьтныг “Шуламын төрөлтэй амьтан” гэж хэлэлцдэг болжээ.

Гунан хар хүү, лусын охиныг аварсан нь

Эрт урьд цагт нэг ядуу айл Гунан хар гэдэг ганц хүүтэй байжээ. Ээж нь хүүдээ хэзээд сайн үйл хийж яв гэж захидаг байв. Нэг өдөр Гунан хар гадагш гарч яваад далайн эрэг дээр нэг өвгөн загасчилж байхтай таарав. Ойртоод очсон чинь өвгөн алтан загас барьчихсан гохноосоо салгаж чадахгүй ноцолдож байв. Гунан хар түүнийг үзээд ээжийнхээ сургаалыг санаж:

- Өвгөн та энэ загасаа надад худалдаж болох уу? гэж асуусанд, өвгөн:

- Зоос өгвөл болно гэв. Гунан хар алтан загасыг худалдаж авч далайд нь тавьчихаад цааш явж байтал далай дотроос цагаан морьтой гоо бүсгүй гарч ирээд:

- Ах аа, таныг миний аав дуудаж байна гэв. Гунан хар гайхаж:

- Чи юун хүн бэ? Аавыг чинь хэн гэдэг юм? гэж асуухад, бүсгүй:

- Би бол лусын хааны охин, та бол миний амийг аварсан болохоор би таны ачийг хариульа гэж бодсон юм. Та миний моринд сундлаад нүдээ аниад, чихээ бөглөөд яв гэж хэлэв.

Гунан хар гоо охины хэлснээр нүдээ аниад, чихээ бөглөөд моринд сундлаад лусын хааны гэрт хүрч очив. Гоо бүсгүй гэрийнхээ үүдэнд ирж зогсоод:

- Гэрт ороход олон могой бий. Түүнээс битгий айгаарай. Гэрийн баруун талд том эвэртэй могой байгаа. Тэр бол миний аав. Зүүн талд бас нэг могой байгаа. Тэр бол миний ээж. Та ороод баруун тийшээ харж аав сайн уу? Зүүн тийшээ харж ээж сайн уу? гэж мэндлээрэй. Тэгвэл тэр хоёр, хүн болж хувирна. Тэгээд танд охины минь амийг аварсан гэж их алт мөнгө өгөх байх. Түүнийг авч болохгүй. Оронд нь “Алтан амин гоогоо өгөөч” гэж гуйгаарай. Тэр дотор би байдаг бөгөөд хүсэл биелүүлдэг юм гэж захив.

Гунан хар, цагаан морьтой гоо бүсгүйн хэлсэн ёсоор гэрт нь ороход үнэхээр олон могой нааш цааш ороолдож байх ба гэрийн зүүн, баруун талд хоёр том могой сууж байв. Гунан хар баруун тийшээ харж:

- Аав сайн уу? гэж мэндлэхэд эвэртэй могой эр хүн болж хувирав. Зүүн тийшээ харж:

- Ээж сайн уу? гэж мэндлэхэд эм хүн болж хувирав. Хоёр могой хүн болж хувираад:

- За, чи манай охины амийг аварсан ачтай хүн байна. Бид таны ачийг хариульа. Чи юу авмаар байна? Түүнийгээ ав гэв. Гоо бүсгүйн захиснаар:

- Би танай алт мөнгө, шүр сувднаас авахгүй. Харин алтан амин гоогоо өгвөл болно гэв. Хаан, хатан хоёр цааш харж уйлж, нааш харж инээж байгаад алтан амин гоогоо өгөв.

Тэгээд Гунан хар алтан амин гоог нь авч өвөртлөөд, цагаан морьтой гоо бүсгүйн моринд сундлан далайгаас гарав. Гоо бүсгүй:

- Энэ алтан амин гоо бол эрдэнэ юм шүү. Одоо та энэ газар дээр гэрээ бариад суу. Тэгвэл та

үүнээс хойш дутагдах юмгүй сайхан амьдарна. Юу хиймээр байна? Юу олмоор байна? Түүнийгээ алтан гоод шивнэж хэлээд унтаж байгаарай. Сэрэхэд чинь бодсон зүйл чинь бүтсэн байх болно. Гэхдээ түүнийг нээж болохгүй. Цаг нь болохоор би өөрөө гарч ирнэ гэж захиад далайдаа буцаад орчихов.

Энэ өдрөөс хойш Гунан хар амттаны дээдийг идэж, хувцасны сайхныг өмсөн элбэг хангалуун амьдрах болов гэнэ. Үүнийг ойр хавийн улс хараад гайхаж:

- Чи хаанаас ийм сайхан юм аваад байгаа юм бэ? асуухад, Гунан хар:

- Надад нэг алтан амин гоо гэдэг хүсэл биелүүлдэг эрдэнэ байдаг юм гэж үнэнээ хэлжээ.

Энэ үг явсаар хааны чихэнд хүрэв. Хаан “Над шиг хаан хүнд л тэр эрдэнэ байх ёстой юм биш үү” гээд эмгэн шулмаа явуулж хулгайлж авав. Гунан хар идэж уух, өмсөж зүүхээр дутан, яах учраа олохгүй байж байтал нэг шөнө цагаан морьтой гоо бүсгүй зүүдэнд нь хүрч ирээд:

- Алтан амин гоог чинь Шар хаан хулгайлсан гэж хэлж өгөв. Гунан хар сэрээд:

- Алтан амин гоог минь Шар хаан хулгайлсан гэнэ. Яаж авах билээ? гэж амандаа үглэж суутал, нохой муур хоёр нь сонсоод:

- Би авч ирье.

- Би авч ирье гэж булаалдав.

Гунан хар үүнийг сонсоод баярлаж “Шар хаан гэгч өмнө далайн цаад талд суудаг юм. Миний нохой усч, муур мэргэн болохоор алтан амин гоог лавтай авчирч чадах байх” гэж бодоод нохой муур хоёроо Шар хааны ордонруу явуулжээ. Нохой муур хоёр өмнө далайг гаталж цаад хөвөөнд нь гарч гэнэ. Муур хулганы хааныг барьж:

- За, чи энэ шөнө миний биеийг багтах нүх ухаж хааны ордонд оруул. Үгүй бол чамайг барьж иднэ гэж сүрдүүлэв.

Хулганы хаан үнхэлцгээ хагартал айж, тэр шөнөдөө бүх хулганаа цуглуулж, нүх ухаад үүр цайхын үед хааны ордонд оруулав. Муур өнөө нүхээр орж хааны ордонд орж эзнийхээ алтан амин гоог хулгайлаад буцаж гарч иржээ. Энэ хооронд хааны ордонд үймээн болж алтан амин гоог хулгайлсан хулгайчийг эрж хайсан боловч хэн ч байсангүй.

Ингээд нохой муур хоёр алтан амин эрдэнийг эзэндээ буцааж авчирч өгчээ. Гунан хар хүү баярлаж, дахин амттаныг идэж, өнгөтэйг өмсөж суутал нэг шөнө цагаан морьтой, гоо бүсгүй зүүдэнд нь хүрч ирээд:

- Одоо далай дотор ордон барьж суу. Тэгэхгүй бол дахиад алтан амин гоог хулгайд алдана гэж хэлжээ.

Залуу маргааш орой нь алтан амин гоод “Далай дотор ордон босгож өг” гэж шивнээд унтав. Өглөө босоод далайн эрэгт хүрч очиход далайн дунд шил толин ордон сүндэрлэж харагдав.

Гунан хар далай доторх ордондоо, амин гоо эрдэнээ хулгайд алдах зовлонгүй амар тайван амьдрах болов.

Гурван жилийн дараа алтан амин эрдэнэд нуугдсан цагаан морьтой гоо бүсгүйтэй гэрлэж лусын хааны хүргэн болж насан туршдаа баян чинээлэг амьдарсан юм гэдэг.

Гунан хар ба мэргэн хэрээ

Гунан хар хүү нэг удаа гадуур гарч явтал хоёр хэрээ ингэж ярьж байна гэнэ.

- Өмнө айлын охин нь өвдчихсөн гэнэ гэж нэг нь хэлэхэд нөгөөх нь:

- Тэгээд өвчнийг нь эмчлэх аргагүй юу? гэж асуухад түрүүчийн хэрээ:

- Энэ худгийн дотор талын хананд мөөг ургасан байгаа. Тэрнийг аваад чанаж уулгавал хурдан эдгэнэ гэж бардам хэлж байв.

- Тэр нь тэгээд ямар өвчин юм бэ? гэхэд

- Өө, тэр айлын гадна нэг саглагар мод байдаг юм. Тэр модон дээр нэг хортой аалз байдаг юм. Шөнө болохоор аалз бууж хүүхний чихрүү шүлсээ хийж хордуулдаг юм гэв.

- Тэгвэл тэр аалз яавал дарагдах вэ? гэж нөгөө хэрээ нь асуухад:

- Тэр амархаан. Саглагар модыг огтлоод шатаачихвал аалз хамт шатаад үхчихнэ гэв.

- Үгүй, тэнд нэг дугана барихаар нурчихаад байдаг нь ямар учиртай юм бэ? гэж өнөө хэрээ дахин асуухад түрүүчийн хэрээ:

- Тэр дуганы нэг баганых нь доор үхсэн зааны сээр хүзүү хоёр байна. Тэрнийг малтаад хаячихвал дуган аяндаа нурахаа больчих юм гэв. Нөгөө хэрээ:

- Тэр дугана тэгээд босчихдог байж. Дуганын тэр олон лам гэгээний уух усыг хаанаас авах юм бол? гэж асуухад түрүүчийн хэрээ:

- Юу гэсэн үг вэ? Дуган барьдаг газраас тэрүүхэн өмнө бөөн дэрс байдаггүй юу? Тэр дэрсний хажууд нэг морин толгойн чинээ цагаан чулуу бий. Тэр чулууг ховхлоод авчихвал булгийн ус оргилон гарч ирэх юм гэж хэлэв.

Бас хэсэг байж байгаад хоёрдахь хэрээ нь:

- Үгүй, тэр баруун айлын таван охин яагаад хүнтэй суудаггүй юм бол? гэж асуухад нөгөө хэрээ нь:

- Тэр айлын том охины гэзгэн дотор алд хиртэй алтан шар үс байна. Тэр үсийг мэдэх хүн таслаад баруун үүдээр нь гарахад зүүн үүдээр нь цай хадаг барьсан хүн орж гуйх ёстой юм хэмээн хэлэлцэж байгаад нисээд явав гэнэ.

Гунан хар шалавхан очиж худагны амаар өнгийж үзсэн чинь хашлагны завсраас том цагаан мөөг ургасан байж гэнэ. Гунан хар баярлаж "Хоёр хэрээний хэлэлцсэн үг үнэн байж" гэж бодон мөөгийг тасдаж аваад өнөө бие муутай хүүхний гэррүү явав. Гунан хар явж тэр айлд ороход үнэхээр нэг бие муутай хүүхэн хэвтэж байв.

- Яасан юм бэ? гэж учрыг асуухад, хүүхний аав ээж:

- Манай хүүхэн гэнэт өвдчихлөө. Хэчнээн эмч домч залж эмчлүүлээд тус болохгүй юм гэж арга тасран хэлээд танд арга засал байвал хэлж өгч тус болооч гэж гуйв. Гунан хар:

- Би нэг мэргэлж үзье гэж хэлээд мэргэлсэн хүн болж хүүхнийг харж байснаа:

- Өнөөдрийн мэргэ тун муу байна. Маргааш үзье гэж хэлээд айлд хонохоор болов.

Шөнө дунд нэг том аалз модноос бууж ирээд хүүхний чихрүү шүлсээ хийчихээд гарав. Хүүхэн тэр аалзны шүлсэнд хордож ихэд өвдөж зовж байгаа болтой байв. Гунан хар “Хоёр хэрээний хэлсэн үнэн юм байна” гэж бодоод хэрээний хэлээр эмнэхээр болов.

Өглөө босч ирээд мэргэлсэн хүн болж үзээд:

- Таны хүүхэн нэг юманд хордсон юм байна. Хор нь танай гадаа байгаа саглагар модтой холбоотой. Одоохон тэр модыг огтолж шатаагаад миний өгсөн энэ эмийг чанаж уулгавал охин чинь удахгүй эдгэнэ гэж хэлэв.

Охины аав ээж Гунан харын хэлсэн ёсоор бүгдийг хийсэнд охин нь тун удалгүй зүгээр болж, өнгө зүс орж гэнэ. Өвгөн эмгэн хоёр баярлаж:

- Та манай охины амийг аварсан болохоор бид таны ачийг хариулж охиноо танд эхнэр болгон өгье гэж хэлэхэд, Гунан хар:

- Одоохондоо болохгүй. Би бас жаахан ажилтай. Буцаж ирээд авья гэж хэлээд цааш явав. Гунан хар нөгөө таван охин нь харьд очдоггүй айлд хүрч очиход, өвгөн эмгэн хоёр:

- Та их мэргэн хүн бололтой. Манай таван охин нас биед хүрсэн боловч хүн гуйж ирэхгүй юм. Та арга чарга хэлж өгөөч гэж гуйхад, Гунан хар эгээл мэргэч хүн болж мэргэлж үзээд, их охиныг нь дуудаж толгойтой үсийг нь илж үзэхэд дотор нь үнэхээр алд хэрийн шар үс байв. Охины аав ээж хоёрт:

- Танай охид харьд очдоггүйн учир энд байна гэж хэлээд урт шар үсийг тасдаж өвөртлөөд:

- Би одоо танай баруун үүдээр гарч явахад, зүүн үүдээр чинь хүн ирж охиныг чинь гуйна гэж хэлээд айлын баруун үүдээр нь гарч явав.

Удсангүй үнэхээр зүүн үүдээр нь цай хадаг барьсан хүн ирж охиныг гуйж гэнэ.

Гунан хар цааш явж байгаад, барихаар нурж унаад байдаг дуганын дэргэд хүрч очив. Олон лам гэгээн:

- Энэ газар ямар хатуу газар вэ? Дуган барихаар тэр дороо нурж унаад байх юм. Яавал нурахгүй болох бол? гэж асуув.

Гунан хар дуганы байдлыг нэлээд шинжиж харж байснаа нэг баганых нь доор очиж, зааны

хүзүү сээрийг малтаж гаргаад:

- Одоо та нар дуганаа санаа амар барь. Дахиж нурахгүй гэж хэлэв.

Олон лам гэгээн дуганаа барьж дуусгасанд дахиж нурсангүй боловч уух усгүй тул бас Гунан хараар мэргэлүүлэв.

Гунан хар дуганын ойр орчим газар шинжсэн хүн болж тойрч явж байгаад хэсэг бөөн дэрсний дэргэд хүрч:

- Энд газар малт. Доороос нь морин толгойн чинээ цагаан чулуу гарч ирнэ. Түүнийг булгалж гаргавал аягын чинээ булаг өөрөө оргилж гарна гэж хэлэв.

Лам нар Гунан харын заасан газар алд хэртэй ухаж хартал үнэхээр морин толгойн чинээ цагаан чулуу цухуйж байв. Тэр чулууг булгалж автал аягын чинээ булаг оргилж гарав.

Эдгээр байдлыг Гунан хар олж үзээд хэрээний хэлсэн үг чухам үнэн болохыг мэджээ.

Илжгэн чихтэй хаан

Эрт урьд цагт ерөөс эмэгтэй хаан байсангүй гэнэ. Тан улсын үед тэнгэрээс Эү Це гэдэг эмэгтэй хаан томилж ирүүлжээ. Эү Це даян хаан суусны дараа, ертөнцийн залуучууд түүний хүслийг хангаж чадахгүй болохоор нь нэг нэгээр нь барьж алаад байжээ.

Энэ хэргийг дээд тэнгэр олж мэдээд Эү Це даян хаанд илжгэн чихтэй эрэгтэй хааныг тэнгэрээс буулгаж өгч гэнэ. Илжгэн чихтэй хаан бууж ирээд Эү Це хааны хүслийг хангаж чадсан тул түүнээс хойш дахиж хүн алахаа байв.

Гэтэл илжгэн чихтэй хаан бас хүн алж эхлэв. Учир нь ертөнцийн хүмүүсийн чих нь хулгар, өөрийн хоёр чих нь урт тул ичихдээ хоёр чихээ малгайдаа хийж нуугаад явдаг ба үсээ авахуулсан хүнээ алдаг болов.

Нэг өдөр, илжгэн чихтэй хааны үсийг авах ээлж нэгэн залууд иржээ. Тэр залуу ээждээ:

- Өнөөдөр, би илжгэн чихт хааны үсийг авна. Лавтай амьд буцаж ирэхгүй байх гэж санаа алдан хэлэхэд, ээж нь:

- Ишц, хүү минь. Би чамд нэг арга зааж өгье гэж хэлээд хөхнийхөө сүүгээр замбага зуурч хүүдээ өгөөд:

- Чи хааны үсийг авч байхдаа үүнийг бага багаар холтолж идээрэй. Тэгвэл хаан “Чи юу идэж байгаа юм бэ?” гэж асуух байх. Тэхээр нь чи “Ээжийн өгсөн замбага идэж байна” гэж хэл хэмээн захиж явуулав.

Залуу хааны үсийг авч байхдаа ээжийнхээ зааснаар замбагыг бага багаар холтолж амандаа хийж тамшаалан идэхэд, илжгэн чихт хаан:

- Чи юу идэж байгаа юм бэ? гэж асуув. Залуу:

- Би ээжийнхээ өгсөн замбагыг идэж байна гэж хэлэв.

Хаан идэх дур нь хөдөлж:

- Замбаганаасаа надад жаахан өг. Би амсаж үзье гэж хэлэв.

Залуу идэж байсан замбаганаасаа хаанд өгөхөд хаан түүнийг амтархан идэж бараад:

- Аяа, яасан сайхан амттай замбага вэ? Юугаар хийсэн юм бэ? гэж асуухад, залуу:

- Миний ээж хөхнийхөө сүүгээр зуурч хийсэн юм гэж хэлэв.

Хаан үүнийг сонсоод:

- Тэгвэл чи бид хоёр нэг эхийн сүү идсэн тангарагийн ах дүүс болчихсон байна шүү дээ. Одоо би чамайг яаж алах билээ! Харин чи миний илжгэн чихтэй гэдгийг хүнд хэлж болохгүй

шүү гэж хэлээд явуулав.

Дараа нь залуу, хааны их элч болсон бөгөөд хааныг илжгэн чихтэй гэж хүнд хэлж болохгүй гэсэн болохоор тэсгэл алдахдаа хулганы нүхэн дээр ирж:

- Манай хаан илжгэн чихтэй, манай хаан илжгэн чихтэй гэж хашгираад хаандаа очиж:

- Хаантаан, та хулганы нүхэнд очиж сонс гэж хэлээд дагуулан явж хулганы нүхэн дээр очиход, хулганууд нүхэн дотроо:

- Манай хаан илжгэн чихтэй, манай хаан илжгэн чихтэй гэж шуугилдаж байв.

Хаан үүнийг сонсоод миний илжгэн чихтэйг хулгана хүртэл мэдэж байхад хүмүүс ярих нь аргагүй юм байна гэж бодоод түүнээс хойш дахиж үс авч өгсөн хүнээ алахаа больсон гэдэг.

“Баян Барга” ноёны хүргэн болсон нь

Эрт урьд цагт нэг нүд нь сохор, ядуу залуу байж гэнэ. Тэр орох оронгүй, оочих аягагүй туйлын ядуу тул өдөртөө гуйлга гуйж амьдардаг байжээ. Нэг өдөр, залуу гуйлга хийгээд явж байтал үнэг таарч:

- Хөөе, чи өдөр бүр гуйлга гуйж амьдраад юу хийнэ. Би чамайг ноёны хүргэн болгоё гэж хэлэв. Залуу үүнийг сонсоод:

- Чи битгий тоглоом хий. Над шиг сохор мөртөө, гуйранч хүн яаж ноёны хүргэн болдог юм бэ? гэсэнд, үнэг:

- Тэр хамаагүй ээ. Надад арга байна. Чи сурснаараа гуйран хийгээд явж бай. Харин чамд энэ өдрөөс эхлэн хог дээрээс алт мөнгө олдох болно гэж хэлээд явчихав.

Тэгээд сохор залуу мөн ёсоор айл амьтан хэсч, хог шавар эргүүлж явсан чинь үнэхээр нэг жаахан мөнгө олдож гэнэ. Залуу баярлаж, мөнгөө аваад явж байтал үнэг тааралдаж:

- За, Яав? Мөнгө олдов уу? гэж асуухад, залуу:

- Олдлоо, олдлоо гээд их л баяртай олсон мөнгөө гаргаж үзүүлэв. Үнэг түүнийг аваад:

- Чи энэ мөнгөнийхөө хагасыг надад өг. Би ноёнд аваачиж өгнө. Хагасыг нь чи өөрөө аваад хадгалаарай гэж хэлээд залуугийн мөнгөний хагасыг аваад явчихав.

Түүнээс хойш сохор залуу өдөр бүр хог дээрээс мөнгө олж, үнэг ч өдөр бүр ирж мөнгөний хагасыг “Ноёнд өгнө” гэж хэлээд авч явдаг болов. Залуу “Энэ үнэгний хэлсэн үнэн болов уу?” гэж боддог байв. Үнэндээ сохор залуугийн олдог мөнгийг үнэг хог дээр тавьдаг байжээ. Залуу өдөр бүр мөнгө олсоор нэлээд мөнгөтэй ч болов. Үнэг сохор залуугаас авсан мөнгөө ноёнд аваачиж:

- Баян Барга танд мөнгө өгч байна гэж хэлээд өгдөг байв. Ноён нэг өдөр:

- Тэр Баян Барга гэдэг хүн чинь ямар хүн байдаг юм бэ? гэж асуухад үнэг гайхсан янз гаргаж:

- Та чинь Баян Баргыг таньдаггүй юм уу? Тэр хүн бол туйлын баян чинээлэг, зүс царай ч сайхантай хүн байдаг юм гэхэд ноён:

- Тэр Баян Барга надад өдөр бүр мөнгө өгөөд байдаг нь ямар ухаантай юм бол? гэж асуухад үнэг:

- Харин таны хүргэн болох санаатай юм гэнэлээ. Та хэрвээ Баян Баргыг хүргэнээ болгох юм бол охин чинь эдэлж барахгүй хөрөнгөтэй, жаргаж барахгүй буянтай болно гэв. Ноён сонсоод:

- Тэгвэл чи тэр залууг дуудаад ир. Уулзаж ярилцъя гэхэд:

- Ноён минь, тэгэх хэрэггүй. Тэр хүн адуу мал олонтой болохоор завгүй байдаг юм. Та зүгээр л надад итгэж, хуримандаа бэлдээд, өдрөө тогтчихвол би дуудаад ирье гэж хэлжээ.

Ноён үнэгний үгэнд орж лам залж, өдөр судраа үзүүлсэн чинь дараа өдрийн үдэд хамгийн сайн цаг байж гэнэ. Тэгээд ноён:

- Маргааш үдэд хамгийн сайн цаг байна. Чи явж Баян Баргыг дуудаж ир. Маргааш үдэд би охиноо мордуулна гэв.

Үнэг давхиж, сохор залуу дээр ирж:

- За, ноён чамайг дуудаж байна. Чамд охиноо өгч хүргэнээ болгох гэнэ гэж хэлээд залууг дагуулж ноёных руу явав. Маргааш үдийн алдад ноёныд нэлээд ойртож очоод, сохор залууг нэг толгойн ард хүргээд:

- Чи энд сууж бай. Өөр тийшээ явж болохгүй шүү гэж хэлчихээд ноёныд хүрч очив.

Ноён охиноо мордуулах гээд хүргэн охин хоёртоо эд хөрөнгө бэлдчихсэн, найр хийхэд бэлэн болчихсон хүлээж байв. Ноён үнэгийг ганцаараа хүрч ирсэнд гайхаж:

- Хөөе, үнэг чи яасан бэ? Баян Барга яагаад ирсэнгүй вэ? гэж асуусанд, үнэг их л санаа зовсон дүр үзүүлж:

- Их хэцүүхэн юм боллоо. Одоо яадаг билээ? Баян Баргыг аваад ирж явтал замд морь нь булгиж, танай хүргэн болох хүнийг газарт унагаж чирээд хувцас хунарыг нь ураад, нэг нүдий нь сохолчихлоо гэж сандран хэлэв.

Ноён хэсэг дуугүй сонсож сууснаа:

- За, яахав би бол ноён хүн. Хэлсэн үгэндээ эзэн, идсэн хоолондоо сав. Үгийг нэг хэлэхээс хоёр хэлэхгүй. Чи энэ хувцас хунарыг авч очоод Баян Баргад өмсүүлж, нүд нүүрийг нь эмнүүл. Хорин нэг хоноход бараг эдгэх байлгүй. Тэгээд хүрээд ир. Би их найр хийж охиноо мордуулна гээд бэлдсэн хувцас хунараас үнэгэнд өгч явуулав.

Үнэг ноёныг хуурчихаад сохор залуу дээр давхиж ирээд:

- За, одоо хоёулаа хурдан харья гээд буцав.

Буцсаны дараа хорьдахь хоног дээр залууд шинэ сайхан дээл хувцас өмсүүлээд, ноёных уруу явжээ. Замдаа айлуудаар орж:

- Ноён хүүхнээ мордуулж энэ газраар явахдаа та нараас “Энэ мал хэнийх юм? Энэ адуу хэнийх юм?” гэж асууна. Тэгвэл та нар баяр хүргэж “Бүгдээрээ Баян Баргын мал, Баян баргын адуу” гэж хэлдэг юм шүү гэж захиад явах замыг нь мангасын гэр рүү зүглүүлчихээд явав.

Үнэг түрүүлж ноёныд очоод:

- Ноёнтон минь, би нарийн сайн эмчилгээ хийсний хүчинд Баян Баргын шарх сорви ч эдгэх нь эдгэлээ. Гэхдээ нүднийх нь сохор бүрэн эдгэсэнгүй гэхэд ноён охиноосоо асуув.

Охин нь миний төлөө явж байгаад сохорсон юм чинь би тэр хүнтэй сууна гэж зөвшөөрчээ.

Ингээд үнэг, залууг ноёныд авч ирэхэд ноён их найр хуримаа эхлүүлээ.

Сохор залуу “Гэр оронгүй би, ноёны охиныг хаашаа авч явна даа” гэж бодон санаа зовж суутал үнэг залууг ноёны дэргэд авчирч, үлдсэн мөнгийг нь ноёнд өгүүлээд, хүүхэнтэй нь хуримын ёслолыг хийлгэж аваад буцав. Ноён хүүхнээ хүргэж өгөхөөр олон түшмэлээ дагуулан хамт явав. Замдаа ноёны хүүхэн:

- Манай гэр хол уу? гэж асуухад, залуу:

- Холгүй ээ гэж хэлээд яваад байв.

Үнэг хуримын улсын урд нь гарч дагуулж явав. Ноён хүүхэн, хүргэнээ дагаад явж байхад замд нь сүрэг сүргээр мал тэмээ, үхэр адуу бэлчиж байв. Ноён малчнаас:

- Энэ хэний мал юм? гэж асуухад:

- Баян Баргын мал гэв. Сүрэг адууг хараад:

- Энэ адуу хэнийх юм? гэж асуухад:

- Баян Баргын адуу гэв.

Ноён замдаа олон адуу тэмээ, үхэр малтай таарч асуусанд бүгд Баян Баргынх гэж хариулжээ. Ноён дотроо “Энэ Баян Барга чинь үнэхээр баян хүн байна. Надаас хол баян юм” гэж бодож явав.

Үнэг түрүүлж давхиад мангасынд ирэхэд мангас унтаж байв. Үнэг мангасыг дуудаж сэрээгээд:

- Цаана чинь аюул болох гэж байна гэхэд мангас цочиж босоод:

- Юу болов? гэж асуухад:

- Ноён таныг алахаар олон цэрэг морио дагуулан ирж явна. Та одоо хурдан явж хойд уулын ард очиж нуугд. Намайг дуудахаас нааш гарч ирж болохгүй шүү гэж хэлээд мангасыг гэрээс нь гаргаж явуулав.

Хуримын улс явсаар мангасын гэрт хүрч ирэхэд үнэг өмнөөс нь угтаж ирээд:

- За, ноён гуай, энэ бол танай хүргэний гэр шүү гэж хэлэв.

Ноён бууж гэрт орж үзвэл: орд харш шиг сайхан гэр байх ба алт мөнгө дүүрэн дутах юмгүй

айл байв гэнэ. Тэгээд ноён “Энэ Баян Барга гэдэг ч үнэхээр ярихын аргагүй баян хүн байна шүү” гэж бодож суув.

Үнэг ноёныг мэхэлж, мангасын гэрийг Баян Баргын гэр гэж, мангасын зарцыг Баян Баргын зарц гэж тэнд гурван шөнө, гурван өдөр их найр хийж гэнэ. Найр өндөрлөж ноён явах болоход үнэг:

- Та хүүхнээ их сайн айлд өгсөн шүү. Гэвч энд нэг сүрхий мангас байдаг юм. Тэр эндхийн хүн амьтны эд хөрөнгө, адуу малыг булаагаад амар тайван суулгадаггүй юм. Таныг явахаар хүргэн охин хоёрын чинь адуу малыг аваад зовоох байх даа гэхэд ноён:

- Чи тэр мангасыг хаана байгааг мэдэх үү? гэж асуув. Үнэг:

- Мэднэ мэднэ гэж хэлээд ноёныг цэргүүдийнх нь хамт мангасын нуугдаж байсан уулын ар агуйд хүрч ирээд:

- За, ноён гуай, мангас арван таван толгойтой юм шүү. Агуйн амаар нэг нэгээрээ гарч ирээд байх буй. Тэгвэл нэг нэгээр нь цавчиж хаядаг юм шүү гэж хэлчихээд агуйруу гүйж оров. Тэгээд агуйд орж мангаст:

- Мангас ах аа, одоо ноён цэргүүдээ аваад явна. Толгойгоо нэг нэгээр нь гаргаж хараарай. Үгүй бол ноён мэдчихнэ. Яваад дуусахаар нь эндээс гарч, гэртээ харьж болно гэж хэлэв.

Мангас үнэгний үгэнд итгэж агуйн амаар толгойгоо нэг нэгээр нь гаргаж харсанд, ноён түүний толгойг нэг нэгээр нь цавчаад байлаа. Тэгээд ноён мангасын арван таван толгойг бүгдийг цавчиж мангасыг алж гэнэ. Ингээд гуйранч сохор “Баян Барга” үнэгний ач тусаар ноёны охинтой гэрлэж, мангасын гэр орон, адуу малыг эзэлж, баян чинээлэг аж төрөн суусан юм гэдэг.

Бадарчин аргаар чөтгөрөөс салсан нь

Эрт урьд цагт нэг бадарчин эзгүй говийг туулж явжээ. Орой болоход айл таарсангүй. “Хээр хонох болох нь” гэж бодож явтал нэлээд хол газар гэр шиг цагаан юм харагджээ. Бадарчин ихэд баярлаж айлд очиж хонохоор алхаагаа түргэтгэн явсаар очтол гэр биш өгөршсөн сүүжний яс байж гэнэ. Нэгэнт гэгээ тасарч байсан тул аргагүй тэндээ хонов.

Шөнө нойрон дунд нь ганц нүдтэй чөтгөртэй зодолдоод болохоо байхаар нь бадарчин уурлаж “Энэ муу чөтгөр ямар хайшаа юм? Хүнийг зүгээр байлгахгүй” гээд аманд нь атга хөмүүл чихсэн чинь:

- Яасан гашуун юм гэж хашгирч байна гэж шөнөжин зүүдлээд хоножээ.

Маргааш өглөө нь бадарчин үүргээ үүрээд нэлээд хол яваад өчигдөр шөнийн чөтгөртэй ноцолдсон нь санаанд орж, дагаж яваагүй байгаа гэж бодоод:

- Одоо яаж байна? гэж асуусан чинь:

- Гашуун байна гэж чөтгөр хариулав.

Энэ муу чөтгөр надаас салахгүй юм байна гэж бодоод амандаа ном уншиж баахан явж байгаад:

- Одоо яаж байна? гэж асуухад:

- Гашуун байна гэж гэв.

Бадарчин чөтгөрөөс хурдан салах гэж нэг живаа ном уншсан боловч чөтгөр туж дагаад салж өгсөнгүй.

Мөн тэгж явсаар орой болоход нэг айлд хүрч ирэв. Бадарчин тэр айлд бууж, хоол унд идэж уугаад унтахаар хэвтэв. Тэгээд нөгөө чөтгөр одоо нэг салсан байлгүй гэж бодоод:

- Одоо яаж байна? гэж асуутал:

- Гашуун байна гэж орон дотор нь дуугарав.

Бадарчин чөтгөрөөс яаж нэг салъя даа гэж бодож байснаа гэнэт нэг арга олж:

- Чи унтаж бай. Би гарч шээчихээд ирье гэж хэлчихээд гарч явав. Бадарчин айлын гадна гараад:

- Одоо яаж байна? гэж асуусанд юу ч дуугарсангүй. Бадарчин баярлаж тэр чигтээ цаашаа алхав.

Өглөө нь, айлын хүмүүс босч цай ундаа уугаад, бадарчинг босохгүй болохоор нь “Энэ бадарчны бие нь өвдсөн юм биш биз” гэж ярилцаад хөнжлийг нь сөхөөд хартал өгөршсөн

сүүжний яс хэвтэж байжээ. Айлын улс цочин сандарч:

- Өчигдрийн ирсэн бадарчин чинь чөтгөр байсан байжээ гэж хэлэлцээд өгөршсөн сүүжний ясыг галд хийж түлсэн чинь:

- Гацуун байна. Гацуун байна гэж хашгирсаар түлэгдэж үнс болсон гэдэг.

Үүнээс хойш монголчууд идсэн малынхаа сүүжний ясыг гэрт хонуулдаггүй нь ийм учиртай юм гэнэ.

Доголон Дара эх

Эрт урьд цагт үргүй өнчин чөтгөр тэнэж явсаар нэгэн айлд орж гэнэ. Айлын эхнэр нялх хүүхдээ хөхүүлээд сууж байв. Чөтгөр дотроо баярлаж, өнөөдөр нэг хүүхэд олж авах нь гэж чимээгүй харж суув. Айлын хүүхэн хүүхдээ өврөөсөө салгахгүй тэвэрчихээд, нөхөр нь ч гарах янзгүй. Чөтгөр тэсгэл алдахдаа зуухных нь үнснээс атгаж аваад эр эм хоёрын нүдрүү цацав. Айлын эр эхнэртээ уурлаж:

- Чи юунд хүний нүдрүү үнс цацаж байгаа юм бэ? гэж асуухад, эхнэр нь хариу уурлаж:

- Юу гэсэн үг вэ? Харин чи өөрөө миний нүүр рүү үнс цацчихлаа гэж айлын эхнэр нөхөр хоёр хэрэлдэж эхлэхэд чөтгөр баярлаж, одоо л нэг завшаан ирлээ гэж хүүхдээ газар тавихыг хүлээж суутал, хүүхэн хүүхдээ элгэндээ тас тэвэрчихээд нөхөртөө уурлаж, хувцас хунараа авч, хүүхдийнхээ духанд хөө түрхээд, төрхөмдөө буцахаар гарч явав.

Чөтгөр эр эм хоёроос хүүхдийг нь авч чадсангүй боловч сэтгэл мохсонгүй. Айлын эхнэрийг дагаж явав. Хүүхэн шөнийн харанхуйд айдас нь хүрэхдээ дутуу цээжилсэн Дара эхээ хагас дутуу уншиж явжээ. Чөтгөр бүсгүйг хөөж яваад өөр нэг чөтгөртэй таарч:

- Хүүхэд тэвэрсэн бүсгүй хүн харав уу? гэж асуусанд, нөгөө чөтгөр:

- Үгүй, саяхан нэг тал тогоо тэвэрсэн, доголон Дара эх л үүгээр өнгөрсөн гэж хариулав.

Учир нь хөө түрхсэн хүүхдийн магнай нь хагас дугуй тогоо болон харагдаж, хазгай уншсан Дара эх нь доголон Дара эх болж үзэгдэж чөтгөр халдаж чадаагүй юм байж. Хөөрхий бүсгүй хүүхэдтэйгээ амар мэнд төрхөмдөө харьжээ.

Түүнээс хойш монголчуудын дунд шөнө хүүхэд нялхсыг авч явахдаа духан дээр нь хө түрхэж гаргавал муу юм, гай барцад учирдаггүй гэсэн уламжлал тогтжээ.

Поодгор Бүрнээ

Эрт урьд цагт Алшад Поодгор Бүрнээ нэртэй сүрхий хулгайч эмэгтэй байжээ. Тэр жижигхэн биетэй, хэзээд шар хошуу малгай өмсөж, ламын заслаар засдаг гэнэ.

Мөн үлгэр туульс сайхан хэлдэг болохоор заримдаа айлд залагдаж үлгэр тууль хайлдаг байсан бөгөөд нэг айлд үлгэрээ ярьж байхад нөгөө айлын унаа хүлээж байдаг байв. Тэр айл хунарын эд хөрөнгийг хулгайлж, олон удаа баригдаж шүүгдэж байсан боловч хаширдаггүй болохоор хүмүүс түүнээс:

- Чи юунд дандаа хулгай хийж байдаг юм бэ? гэж асуухад, Поодгор Бүрнээ:

Сурсан юмыг сураар боож болдоггүй

Судар баринтагийг олсоор боож болдоггүй

Алтан хумсаа хөдөлгөхгүй бол дотор загатнаад сууж болдоггүй юм гэжээ.

Нэг удаа тэр хулгай хийж яваад баригдаж хүнд шийтгэл хүлээх болоход нутгаасаа оргон зугтаж явав. Тэр бүтэн өдөржин явсаар эзгүй зэлүүд говьд хүрэхэд нар шингэж, шөнө болов. Поодгор Бүрнээ ойр орчимд айл амьтан байна уу? гэж том элсэн манхан дээр гарч хартал өмнө нь нэг айл харагдахад баярлан давхиж хүрээд гэрт ороход нэг эмгэн юм оёж суув. Эмгэн:

- Хаанаас хаа хүрэхээр яваа хэн гэгч хүн бэ? гэж асуухад:

- Миний нэрийг Поодгор Бүрнээ гэдэг. Алша нутгаас ирлээ гэж хариулав. Эмгэн Поодгор Бүрнээг харж эмэгтэй хүн болохоор нь:

- Чи юм оёж чаддаг уу? гэхэд:

- Бага зэрэг оёж чадна аа гэв. Эмгэн:

- Чи холоос ирсэн, ядарч яваа байлгүй. Манайд хэд хоног юм оёж суу гэв.

Поодгор Бүрнээ, эмгэнийд үйл утас оёж суухаар болжээ. Орой нь эмгэн том тогоо дүүрэн мах чанаж:

- Тэр зүүн гэрт орж болдоггүй юм шүү. Би эргэж ирээд хоолоо хийж идье гээд тогоотой хоолоо аваад гарчээ.

Эмгэн нэлээд удаж байгаад хоосон тогоогоо өргөсөөр орж ирэв. Поодгор Бүрнээ түүнийг хараад “Энэ айл олон ам бүлтэй юм байна” гэж бодож суув.

Тийнхүү энэ айлд нэлээд хэд хоноход эмгэн орой болгон хоол хийгээд авч гардаг боловч зүүн гэрээс нэг ч хүн орж ирдэггүй байв. Хоттой хонийг нь хүн хариулж байх шиг өглөө цагтаа бэлчээд орой цагтаа хотолдог.

Поодгор Бүрнээ учрыг мэдэх санаатай орой шээж яваа хүн болж харвал хонийг хүн хариулж яваа бололтой. Гэвч хүн нь харагдсангүй. Тэр бүр гайхаж өглөө мал бэлчих үеэр мөн шээж яваа хүн болж харахад малыг хүн туугаад явж байх шиг боловч хүн нь үзэгдсэнгүй.

Поодгор Бүрнээ учрыг олсонгүй “Энэ зүүн гэрт учир байна” гэж бодоод эмгэнийг орой хоолоо аваад гарсны дараа сэм гэтэж зүүн гэрийн гадаа очиж хатавчаар нь шагайж харвал хүн амьтан алга. Эмгэн ганцаараа хоолоо өмнөө тавьж суусны хойно ханын толгойд өлгөөтэй байсан эсгий уутнаас дөрвөн бор зараа шиг амьтан гарч ирээд тэр том тогооны дөрвөн талд нь суугаад хоолыг нь идчихэв. Эмгэн хажууд үг хэлэхгүй харж суух юм гэнэ. Дөрвөн амьтан хоолоо идчихээд буцаад эсгий уутандаа цувраад орчихлоо.

Эмгэн онго тэжээдгийг Поодгор Бүрнээ мэдээд хурдан гэгч баруун гэрт орж ажиг ч үгүй сууж байтал эмгэн тогоо шанагаа хангинуулан орж ирээд хоол хийж идэв. Поодгор Бүрнээ:

- Өнөөдөр миний бие тааруу байна гэж шалтаглаад хоол идэлгүй унтав.

Шөнө эмгэнийг унтсан хойно “Би тэр эсгий уутыг сэгсэрчихье. Тэгэхгүй бол эрт орой хэзээ нэгэн цагт намайг иднэ” гэж бодоод унтаж чадахгүй босч гараад зүүн гэрт орж эсгий уутыг тэмтэрч үзвэл ам нь тааралджээ. Нөгөө амьтад мэдэх шиг болоход Поодгор Бүрнээ айсандаа амыг нь уруу харуулж хэд сэгсэрч газар шидчихээд баруун гэрт гүйж орвол эмгэний толгой нь газар тулаад хоёр хөл нь дээшээ харчихсан:

- Хүүе, юу болж байна аа? Хурдан намайг тат! гэж орилж байв.

Поодгор Бүрнээ эмгэний байдлыг хараад “Энэ эмгэн чинь чөтгөр байж” гэж мэдээд тэр чигтээ давхиад үүр цайхын үед нутагтаа харьж иржээ. Нутгийн хүмүүс Поодгор Бүрнээг алга болоод удаж удаж буцаж ирсэнд гайхаж:

- Чи чинь хаагуур явж байгаад ирэв? гэж асуухад:

- Би нутгаасаа гарч говьд явж байгаад хоёр гэртэй ганц эмгэнтэй таарч, тэнд хэд хоноод ирлээ гэхэд хүмүүс:

- Хүү минь, Тэр чинь хүн орж болдоггүй онго болсон айл шүү. Тэр эмгэнийг хөх шулам гэдэг юм гэцгээжээ.

Поодгор Бүрнээ онго болсон айлыг дарснаа хэнд ч хэлсэнгүй өнгөрөв. Түүнээс хойш онго тэжээдэг байсан эмгэний тэмээ малыг чоно барьж идээд алга болсон гэдэг.

Тэнэг залуу зууд явсан нь

Эрт урьд цагт тэнэг хүүтэй нэгэн айл байжээ. Нэг өдөр, хүү нь зууд мөргөхөөр явъя гэж аав, ээждээ хэлэхэд нь:

- Чам шиг тэнэг хүн зууд очиж чадахгүй. Замд чинь олон чөтгөр таарна гэж айлгасанд залуу түүнийг тоосонгүй заавал явна гэж шалсаар сүүлдээ явахаар болов.

Тэгээд хүүдээ номхон хүрэн ингээр унаа хийж, зам зуур хэрэглэх юмыг нь бэлдэж өгөв. Мөн ээж нь биенээсээ салгадаггүй, өвөртөлж явдаг бурханы номоо өгч:

- Хүү минь, үүнийг өвөртлөөд яв. Зууд хүрч очтолоо биенээсээ төө ч салгаж болохгүй шүү гэж захив.

Аав нь буугаа өгч, замд нь элдэв дайсан таарвал яаж буудах, унаа малаа хэрхэн хямгадаж явахыг захиж хэлээд хүүгээ холын замд мордуулжээ.

Тэнэг залуу явсаар үдшийн бүрэнхий болох үест нэг газар бууж, хонохоор болов. Гэтэл ойрхон зайд ногоон гэрэл байн байн асаж унтарч байхыг олж хараад, гайхан дөхөж очоод харвал хэдэн ногоон дээлтэй чөтгөрүүд гал тойроод суучихсан ярилцаж байна гэнэ. Залуу амьсгаагаа дарж байгаад сайн чагнавал:

- Нар шингэхийн алдад энүүхэн хойно айл ирж буух шиг болсон. Энэ удаа гүзээндэй нь явах уу? сүүжиндэй нь явах уу? гэж нэг нь асуухад, нөгөө нь:

- Би явна, би явна гэж хэлтэл бас нэг нь:

- Би явна, би явна гэж ам уралдан хэлэв. Тэд хэсэг маргалдаж байснаа нэг нь явах болов.

Залуу тэдний ярилцахыг сонсоод “За, одоо нөгөө чөтгөртэй нь учирсан юм байна. Яаж эднээс салж, маргаашийн нарыг үзэх вэ?” гэж бодоод буцаж тэмээн дээрээ ирэв. Тэгээд аав ээжийнхээ зааж өгснөөр тэмээгээ хойш нь харуулж хэвгүүлээд, шуудайтай ноосоороо хиймэл хүн хийж, гуулин тогоондоо ус гурил хийж дээр нь толгой болгож, ямаан арьсан дээлээ гаргаж хөдөрч тавиад өөрөө тэмээнийхээ буруу талд буугаа барин чөтгөрийг хүлээж суув.

Тэгж байтал ногоон дээлтэй чөтгөр ирж хиймэл хүний хажууд хүрч хэд тонголзсоноо өврөөсөө зэс хошуу гаргаж, гуулин тогооруу шургуулж оруулаад сорж эхлэв.

Хэсэг сорж байснаа, амталж үзээд “Энэ чинь юу вэ? Тархи ч биш. Ус ч биш” гэж амандаа үглэнгүүт тэнэг залуу бууныхаа гохыг дарж амжив. Чөтгөр:

- Гүзээндэйг явуулдаг байж, гүзээндэйг явуулдаг байж гэж гасалсаар дуу нь бүдгэрч алга болов.

Залуу босч хиймэл хүнээ очиж үзсэнд гуулин тогооных нь дээр зэс хошуу нь зоолттой чигээрээ үлдсэн байв. Тэнэг залуу түүнийг авч өвөртлөөд, яаран сандран ачаа бараагаа ачиж аваад цааш хөдлөв. Нэлээд явж байтал ард нь нэг хүн:

- Хөөе, би ядраад горьгүй нь. Намайг араараа сундлуучих гэх дуу гарав. Залуу цочин эргэж харсанд нөгөө ногоон дээлтэй чөтгөр араас нь даган гүйж байв. Залуу түүнийг өрөвдөж сүүжиндэйг араараа сундлуулж цааш явав. Хол явсангүй өнөө чөтгөр:

- Би тэмээнээс унах гээд байна. Танд арга байхгүй юу? гэж хэлэхэд залуу түүнийг бүсээрээ ороож, өөртэйгөө хамт баглаад цааш явав. Хол явсангүй өнөөх чөтгөр:

- Би шахагдаад байна. Жаахан суллагчид гэхэд, залуугийн уур хүрч “Яасан олон үгтэй чөтгөр вэ?” гэж бодоод сулласангүй явсаар үүр цайхын үед чөтгөр дуугарахаа болив.

Тэнэг залуу гайхаад эргэж хартал юу ч байхгүй болохоор нь бүсээ тэмтэрч үзсэн чинь үхрийн сүүжний яс байв. Залуу “Байз, байз. Тэр чөтгөрийн нэрийг сүүжиндэй гэдэг билүү?” гэж бодоод сүүжиндэй гэж дуудсанд, ард нь:

- Аа, би чиний араас явж байна. Чи миний зэс хошууг өгчих гэж хэлэв. Тэнэг залуу эргэн тойрноо харсанд юу ч үзэгдсэнгүй. Өлөн чөтгөр харагддагүй юм гэсэн гэж бодоод явав.

Учир нь ээжийнх нь өгсөн бурханы ном өвөрт нь байгаа болохоор чөтгөр хошуугаа авч чадахгүй байгаа нь тэр байж. Тэнэг залуу ийнхүү олон хоног явж, сүүжиндэй чөтгөр хошуугаа нэхэж дагасаар зууд ойртож ирлээ. Сүүжиндэй чөтгөр дахиж хошуугаа нэхэхээ больж:

- Одоо зууд хүрэх болж байна. Чи миний амийг авар гэж уйлан гуйхад, залуу:

- Би чиний амийг яаж аврах билээ? гэсэнд чөтгөр:

- Чиний өвөрт хайрцагтай чойдан байгаа биз дээ. Би түүнд чинь орж нуугдья. Чи далай ламд золгосны дараа миний зэс хошуу болон чойдангийн хайрцаг хоёроо битгий өгөөрэй гэж захив.

Тэнэг залуу өврөөсөө чойдангийн хайрцага гаргасанд чөтгөр багассаар, багассаар чойдангийн дайтай болж, хайрцагт нь орчихов. Залуу хайрцага өвөртлөөд зууд хүрч, далай ламд мөргөв. Багш лам тэнэг залууг үзээд:

- Чамд хоёр зүйлийн их чухал юм байна. Түүнийгээ хурдан өг гэсэнд тэнэг залуу хэсэг тээнэгэлзэн зогссоноо зэс хошууг гаргаж өгөв. Багш лам:

- Энэ ч нэг нь мөн байна. Бас нөгөөхийг нь хурдан гаргаж өг гэсэнд тэнэг залуу дуугүй хэсэг мэлрэн зогссоноо, багш ламын зарлигийг дагах нь зөв байх гэж бодоод чойдангийн хайрцага гаргаж өгөв. Багш лам:

- За, чи их гавьяа байгууллаа. Маргааш өглөө буцаж ирээрэй гэв. Дараа өглөө нь багш лам залууд адис өгөөд:

- Чи энэ насандаа их буян хийлээ. Ард иргэд зууд мөргөх замд таардаг барцад гайг бариад иржээ. Би түүнийг номын хүчээр дарчихлаа гэж айлтгав.

Ийнхүү тэнэг залуу аав, ээжийнхээ захьсан ёсоор явсны тулд чөтгөр шулмыг барьж их гавьяа байгуулсан юм гэнэ.

Чоно ээж

Эрт урьд цагт зуун хорь насалсан эмгэн байжээ. Тэр эмгэн хэдийгээр өндөр настай боловч өвдөх өвчингүй, хөнгөн шингэн бөгөөд ганц хүүтэй юм гэнэ. Өдөр бүр ганцаараа хонио хариулж амьдардаг байв.

Хүү нь нэг шөнө сэрээд харсан чинь ээж нь шүдээ чигчлээд, галын хүрээрүү түүхий мах тургиж байв гэнэ. Хүү үүнийг үзээд “Ээж ямар сонин юм бэ? Манайх ойрд хонь мал гаргаж идээгүй дээ” гэж бодож хэвтжээ.

Хүү энэ өдрөөс хойш хэдэн шөнө дараалан ээжийгээ ажиглаж харсанд шөнө бүр үүр цүүрээр босч суугаад шүдээ чигчилж, түүхий мах тургиад байхаар нь лав учир байна гэж бодоод шалгаж үзэхээр шийдэв. Өглөө нь хүү босч ирээд:

- Ээж ээ, та гэртээ амарч бай, өнөөдөр би хониндоо явъя гэж хэлээд малаа хариулж явав.

Тэгээд хонио бэлчээрт гаргачихаад “Өнөөдөр би малын захад нэг сайн унтаж авчихаад шөнө ээжийн юу хийдгийг манаж үзье байз” гээд өдөржин малын захад унтаж, нойроо авчихаад орой нь малаа туун гэртээ ирэв. Шөнө нь хүү унтсангүй ээжийгээ манаж хэвтэв.

Ээж нь шөнө дунд босч, дээлээ өмсөөд гарч явав. Хүү сэм босч үүдээ жаахан сөхөж араас нь харсанд үнсэн дээрээ очиж хэд хөрвөөгөөд хөх чоно болж хувираад босоод ирэв гэнэ. Тэгснээ биеийнхээ үнсийг хэд сэгсэрчихээд зүүн хойшоо давхиж оджээ.

Хүү энэ байдлыг нүдээр үзэж мэдээд, айх гайхах зэрэгцэж яах учраа олохгүй хэсэг самгардан зогсов. Үүр цайхын үед ээж нь ирж буй бололтой шир шир гэх хөлийн чимээ сонсогдоход босч харвал мөн л үнсэн дээрээ очиж хөрвөөгөөд хүн болж хувираад гэртээ сэм орж ирээд орондоо оров. Удалгүй өглөө болоход ээж нь сая сэрсэн хүн болж хүүгээ:

- За хүү минь одоо босч малаа бэлчээ. Ээж нь өнөөдөр бие муухан байна гэв. Хүү нь мөн дөнгөж сэрж буй янз гаргаж, босч ирээд, ажиг сэжиг гаргалгүй хоол ундаа идэж уучихаад малдаа явав.

Хүү малаа бэлчээрт гаргамагц сүмд очиж, энэ учрыг багшдаа хэлж, багшаасаа:

- Манай малыг чоно огт иддэггүй, айлын малд чоно ороод байдаг нь ийм учиртай юм байна. Одоо ээжийг яавал дээр вэ? гэж асуухад, багш нь:

- Чи отчийн авшиг авахуул. Отчийн авшиг гурав авахуулахад сайн муу аяндаа ялгардаг юм гэж хэлэв.

Хүүгийн ээж гэрт нь хүн ирэхэд тун дургүй байдаг байлаа. Хүү нь гурван лам залж:

- Та гурав манайд очиж хүн бүр нэг нэг отчийн авшиг уншиж өгөөч. Ээжийнхээ сайн мууг ялгах гэсэн юм. Манай ээж гэртээ хүн оруулах их дургүй байдаг юм. Тийм болохоор та гурав орой хотны захад хоноод өглөө орж ирээрэй гэж захиад орой нь ажиг ч үгүй малаа хотлуулж гэртээ ирэв.

Маргааш өглөө нь хоёр лам хүүгийн хэлснээр гэрт нь орж зул хүжээ өргөчихөөд отчийн авшгаа уншиж эхэлтэл эмгэний толгой өвдөж эхлэв. Хоёрдахь удаагаа унштал эмгэн муурч унажээ. Гуравдахь удаагаа уншсанд эмгэн үхэж гэнэ.

Ингээд хүү отчийн авшиг уншуулснаар эхийнхээ сайн мууг таньж, нутаг усаа аюулт дайснаас аварсан юм гэнэ.

Номгүй банди

Эрт урьд цагт, багш шавь хоёр байж гэнэ. Багш нь шавьдаа арга бүхнийг сүвэгчилж ном заасан боловч эцэстээ юу ч сураагүй тул цөхөрч гүйцээд дахин ном заахаа больжээ. Нэг өдөр, шавь нь багшдаа:

- Би багшийн заасан номоос ганц Пүрэвдоо гэдэг үсэг цээжиллээ. Өөр юу ч сурч чадсангүй. Би ном сурахгүй юм байна гэж хэлээд үүргээ үүрч гэртээ харихаар явжээ.

Явж байтал зам дээр нь бөөн яс таарчээ. Нэг ясыг авч үзсэнд дээр нь дүүрэн номын үсэг бичээстэй хүний яс байв гэнэ. Энэ лав эрдэм номтой ламын яс байх нь гэж бодоод дунд чөмгийг нь авч өвөртлөөд цааш явав.

Хэдэн өдөр яваад нэгэн айл таарахад хоноглоод гаръя гэж бодон ясаа гэрийн тотгон дээр тавиад явж орвол залуухан эзэгтэй сууж байв. Тэр эхнэр бандийг их л хүндлэн дээш суулган, цай ундаар дайлав.

Орой болоход залуу эхнэр том тогоонд дүүрэн хоол чанаад ширээн дээрээ тавьж, хажууд нэлээд хэдэн аяга таваг тавив. Банди:

- Та чинь яасан олон хүний хоол хийдэг юм бэ? гэж асуухад, залуу бүсгүй:

- Манайх уг нь их олуулаа байсан юм. Дахал өвчнөөр бүгдээрээ тэнгэрт хальсан юм. Би орой бүр тэдэндээ хоол хийж тавьдаг юм гэж хэлэв.

Банди их л гайхаж, үхсэн хүмүүст хоол хийж өгдөг нь ямар учиртай юм бол хэмээн бодож суув. Шөнө болж унтахаар хэвтгэл юу юугүй олон морины туурай гарч, хүмүүс шуугилдаад гадаа хүрч ирэх чимээ гарав. Банди одоо л нөгөө улс нь ирж хоолоо идэх нь дээ гэж бодон орж ирэхий нь хүлээн амьсгалаа түгжин хэвтэв. Гэвч олон хүн гэрийн үүдэнд шуугилдаад байхаас бус гэрт орж ирэхгүй байв. Банди ч хол зам туулаад их ядарсан тул төдөлгүй унтаад өгчээ. Өглөө сэрсэн чинь айлын эхнэр ихэд гайхчихсан зогсож байв. Учрыг асуувал:

- Манайхан урьд шөнө яагаад хоолоо идэлгүй явчихсан юм бол? гэв. Банди их л додигор байдал гаргаж, хоолойгоо засаад:

- Би танайд хоносноос танай хүмүүс надаас айгаад гэрт орж ирж чадаагүй юм биш үү? гэж хэлээд гэрээс гартал үүдний тотгон дээр тавьсан яснаас гэрэл цацарч байв.

Банди гайхан нүхээр нь харж үзвэл урд төрөлдөө зовлон эдэлсэн хүмүүс шамбалын оронруу явж байгаа харагдав. Банди залуу эхнэрийг дуудаж харуулсанд эхнэр дуу алдаж:

- Энэ хүмүүс чинь бүгдээрээ манайхан байна шүү дээ. Аав минь хамгийн түрүүнд, дараа нь ээж минь, араас нь миний нөхөр явж байна. Цаад талд нь алтан ганжиртай дугана гялалзаж байх шиг байна гэхэд банди:

- Танай гэр бүлийнхэн шамбалын оронд очиж жаргахаар явж байна гэж хэлэв.

Учир нь тэр шөнө чөтгөрүүд гэрт орж чадахгүй буцсан нь чөмөгний ястай холбоотой байсан бөгөөд түүнээс хойш залуу эхнэр чөтгөрүүдэд хоол хийж зовохоо больсон төдийгүй ном сурдаггүй банди ч нэгэн сэтгэлээр ном эрдэмд шамдан суралцаж, их эрдэм чадалтай лам болсон гэдэг.

Тиймээс их эрдэмтэй ламын сүнс нь хүртэл чөтгөрийг дарж, ясан дээр нь хүртэл номын үсэг тодорч гардаг гэсэн яриа одоо болтол хүмүүсийн дунд хэлэгдэж үлджээ.

Цоожиндай

Эрт урьд цагт Цоожиндай гэдэг нэртэй хувилгаан эмэгтэй, нөхөр болон хоёр хүүхэдтэйгээ аж төрөн амьдарч байжээ. Цоожиндай орчлонгийн хүнийг амьд байхдаа буян хийхгүй, муу үйл хийж үхсэн хойноо тамд очиж зовлон эдэлж байхыг үзээд өөрийн биеэр сургамж болгохоор хорин таван настайдаа гэнэт үхжээ. Цоожиндайг үхэхэд гэрийнхэн нь ихэд гашуудан газар шороо тахиж хөдөө оршуулчихаад араас нь их буян ном хийж гэнэ. Цоожиндайгийн шарилыг оршуулсны дараа эрлэгийн элч сүнсийг нь барьж төмөр гинжээр оосорлон эрлэг номун хаанд өгчээ. Эрлэг номун хаан Цоожиндайг үзээд:

- Цоожиндай чиний ирэх цаг чинь болоогүй байна. Чи хурдан буцаж харь гэж хэлсэнд Цоожиндай:

- Би очиж болохгүй. Би өөрийн биеэр орчлонгийн амьтныг сургах гэсэн юм гэж хэлэхэд, Эрлэг номун хаан элчдээ:

- Та нар түүнийг аваад яв. Арван найман тамын орноор эхнээс нь дуустал дагуулж үзүүлээд гэрт нь явуул. Залуу хүн байна. Олонд дэм болох хүн байна гэж хэлээд явуулав.

Эрлэгийн элч Цоожиндайг хүлээстэй чигээр нь аваачиж, арван найман тамын орноор хэсүүлж үзүүлээд гэрт нь буцаах гэсэнд:

- Би явахгүй гээд буцахгүй болохоор нь дахиад эрлэг номун хаанд хүргэж ирэв. Эрлэг номун хаан элчдээ:

- Цоожиндайгийн сүнсийг хурдан хүүрэнд нь оруул! гэв.

Хоёр элчин Цоожиндайг хар хүчээр буцааж аваачаад хүний орчлонд хүргэж мэлхий үхдэлд нь буцааж оруулжээ. Хүний сүнс гэдэг нь өөрийн хүүрнээсээ туйлын их айдаг юм гэнэ. Хоёр элч сүнсийг нь хүүрэнд нь оруулах гэж урагш татахаар сүнс нь хойшоо ухраад огт болохгүй байв. Аргаа барсан эрлэгийн хоёр элч чоно болж хувираад Цоожиндайгийн сүнсийг барьж идэхээр дайрсанд айхдаа урагшаа ухасхийн гүйгээд санамсаргүй хүүрэн дээрээ гишгэчихжээ. Тэгээд Цоожиндайгийн сүнс хүүрэндээ орж хүн болж гэнэ.

Тэгээд тэр нүдээ нээгээд харсан чинь чармай нүцгэн, үс гэзэг нь сэгсийчихсэн хөдөө хэвтэж байна гэнэ. Цоожиндай “Би чинь юу болчихсон юм бол? Яагаад хөдөө хээр нүцгэн хэвтэж байдаг билээ? Энэ ямар газар юм бол?” гэж бодон хэсэг суужээ.

Гэнэт эрлэг номун хааны хэлж байсан үг, там диваажингийн орноор тойрсон нь санаанд орж, гэртээ харихаар босч явав. Хотны захад ирсэнд гэрийнхэн нь түүний 7 хоногийнх нь буяныг хийж байна гэнэ. Нөхөр нь гэрээсээ гарч ирээд түүнд сор тавьж гэнэ. Цоожиндай сандарч хадны ард ороод, нөхөртөө хандаж:

- Би Цоожиндай байна. Миний хувцасыг аваад ир гэж хашгирав.

Нөхөр нь эхнэрийнхээ дууг сонсоод ихэд цочин балмагдаж, гэртээ гүйж ороод, лам багшдаа:

- Багш аа, Цоожиндай хадны цаана нүцгэн суучихсан, намайг дуудаад байна. Чөтгөр болчихсон юм болов уу? гэж гайхан асуухад, лам багш нь эрихээ эргүүлж үзээд:

- Өө, за за. Тэгэх ч ёстой байсан юмаа гэснээ үгээ үргэлжлүүлж:

- Та нар эсгий аваачиж дэвсээд дээр нь ширээ тавь. Тостой боорцог тавь. Сүүтэй цай чанаж мөнгөн аяганд хийж тавь гэж хэлснээ би эхлээд Цоожиндайгаас хэдэн юм асуугаад ирье гэж хэлээд хотны захад очиж:

- Та хаашаа яваад ирэв? Юу юу хийв? гэж асуухад, Цоожиндай:

- Намайг үхсэний дараа эрлэгийн элч ирж төмөр гинжээр хүлээд Эрлэг номун хаанд аваачиж өгөхөд миний нас болоогүй байна гээд авсангүй. Тэгэхээр нь би ертөнцийн хүнд сургамж болмоор байна гэж хэлсэнд эрлэгийн элч намайг диваажингийн орноор хэсүүллээ. Бас тамын орноор тойрууллаа гэв. Лам багш:

- Бурханы орон гэж ямар газар байна? Тамын орон гэж ямар газар байна? гэж асуув. Цоожиндай:

- Диваажингийн орон гэдэг чинь ёстой сайхан газар байна. Хүн бүхэн бараг арван долоо найман настай залуухнаараа байдаг. Нас нь хасагддаг ч үгүй, нэмэгддэг ч үгүй. Амьддаа буян ном их хийж нүгэлгүй хүн үхвэл шууд диваажингийн оронд очдог. Анх очсон хүн бүр дэлгэрээгүй цэцэг болоод очдог. Бурхан багш түүний дээр рашаан дусаахаар тэр цэцэг дэлгэрч, хүн болж гарч ирдэг. Бурханы орны эргэн тойрон жимс ногоо ургачихсан. Хүмүүс нь зөвхөн жимс идэж амьдардаг.

Арван найман тамын орон гэдэг нь ёстой хэцүү газар юм байна. Хүн амьддаа муу юм хийж явбал үхсэн хойноо зовлон эдэлдэг. Эрлэг номун хаанд нэг толь байдаг ба түүнд нь хүний амьддаа хийсэн нүгэл буян нь тод харагдаж байдаг. Тэгээд нүгэл хийсэн хэмжээгээр нь тамруу илгээж хийсэн нүглийг нь эдлүүдэг.

Тэнд халуун там гэж сүрхий там байна. Эрлэг номун хаан амьддаа хүн алах буюу түүнээс их нүгэл хийсэн хүнийг халуун тамруу оруулдаг. Халуун тамд орсон хүний мах арьс, яс үс нь хайлаад алга болчихдог. Гал нь жаахан намдаад ирэхээр хүний мах арьс, яс үс нь дахиад төлжиж бүтдэг. Дахиад гал нь асч түлээд алга болгодог. Муу хүнийг ингэж дахин дахин тамлаж нүглийг нь эдлүүлдэг юм байна.

Намайг олонд тус болох юм байна гэж миний сүнсийг авчирч хүүрэнд минь орууллаа. Тэгээд би дахиж хүн болж амилаад ирж байгаа нь энэ билээ гэжээ.

Лам багш Цоожиндайгийн хэлсэн үг бүрийг бичиж аваад хувцас хунарыг нь өгүүлжээ. Цоожиндай хувцсаа өмсөөд:

- Би өлсөж цангаж байна. Надад жаахан идэж уух юм өгөөч гэж хэлэхэд гэрийн улс өнөө бэлтгэсэн сүүтэй цай, тостой боорцгоо өгчээ. Цоожиндай түүнээс амсахтай зэрэг хүний ухаан орж, хүн болж, үхээд явсныхаа дараах явдлаа бүгдийг мэдэхээ больсон гэдэг.

Цоожиндай ингэж өөрийхөө биеэр диваажин болон тамын амьдралыг нүдээр үзэж,
орчлонгийн хүмүүст ярьж өгснөөр хүн төрөлхтөн амьд явахдаа буян ном их хийж, муу үйлийг
бага хийхэд сургамж болсон гэнэ.

Бадарчин лам

Эрт урьд цагт, их эрдэм номтой нэгэн лам бадар барьж, зууд мөргөхөөр явжээ.

Нэг өдөр замд нь гадуур нь олон хонь бэлчсэн том цагаан гэр таарчээ. Лам дотроо ”Энэ хараа алдрам эзгүй хээр юун айл байдаг юм бол” гэж бодсон боловч тэр айлд орохоор хүрч ирэв. Гэрт хүн байх янзгүй. Эдлэл хэрэглэлийг нь ажиглавал ганц хүн амьдардаг бололтой. Бадарчин лам үүргээ авч тавиад баруун хойморт нь завилж суугаад гэрийн эзнийг хүлээв. Үдийн хойно болоход баруун хойноос цагаан тоос татуулж хөх торгон дээлтэй, хар торгон хамжаартай, улаан царай хар сахалтай өвгөн хүрч ирэв. Тэр гэртээ орж ирээд ламыг ширүүн харцаар ширвэж хараад:

- Сайн байна уу? Хаанаас хаа хүрэхээр явж байгаа хувраг вэ? гэж асуув.

Бадарчин лам айн сүрдсэн боловч ажиггүй маяг гаргаж:

- Би зууд очиж, богдтой уулзахаар явж байна гэв. Гэрийн өвгөн:

- Өө, тийм үү? Тэгвэл та надад ариун сан уншаад өг. Ойр хавьд гэр орноо ариулж, хийморио сэргээсэнгүй гэв.

Бадарчин лам дуртай зөвшөөрч, хийморийн сан тавьж, хишиг буяныг нь даллаж өгсөнд, айлын эзэн ихэд баярлан цай унд хийх зуураа:

- Би чинь махчин хүн шүү дээ. Ойр орчмынхоо хүнийг идээд барчихсан тул одоо манай энд хүний мөр тасарчээ. Махчин болсноос хойш мал ч олширлоо гэж ярихад бадарчин лам дотроо эвгүйцэж “За одоо л нөгөө махчин чөтгөртэй нь уулзаж дээ. Яадаг билээ? Амьд гарахаасаа өнгөрчээ” гэж бодож суутал гэрийн эзэн гарч яваад нэлээд удаж удаж нэг хонь авчирч төхөөрөөд махыг нь чанаж:

- Би бол их нүгэл хийсэн хүн. Одоо нүглээ наманчилж, буян хийхээр зориг шулуудлаа. Маргааш танаар нэг юм дайж богдод өгүүлнээ гээд бадарчин ламыг хонины махаар дайлж зочлов. Маргааш өглөө нь өвгөн эртлэн босч ламд цай хоол хийж өгөөд хутгаа билүүдэж гэнэ. Бадарчин лам гайхах, сэжиглэх хослон “Энэ чинь арай намайг алж идэх гэж байгаа юм биш биз” гэж бодохоос айдас нь хүрч, аягатай цайгаа том том балгаж суутал өвгөн билүүдсэн хутганыхаа ирэн дээр үс тавин үлээж, хутгаа хурц болсон эсэхийг шалгаж үзсэнээ ламын зүг харж:

- За, би танд зүрхээ дайж өгье. Үүнийг та заавал богдод аваачиж өгөөрэй! гэж хэлээд хутгаараа цээжээ ярж зүрхээ гаргаж хадган дээр тавиад мөнгөн ембүүтэй хамт өгөв.

Бадарчин лам айлын өвгөний зүрхийг аваад цааш аян замаа хөөж явтал нэгэн маань уншсан маажгий эмгэн таарч, бадарчин ламыг зууд очиж богдод мөргөх гэж явааг сонсоод нэг тулам эрих богдод дайв. Бадарчин лам, өвгөн болон эмгэний дайсан юмыг авч, зууд очиж, богдод золгов. Богд бадарчныг хүлээн авч уулзаад:

- За, сайн явж ирэв үү? Зам зуураа юу юу үзэж? Юу юу хийв? гэж асуув.

Бадарчин лам зам зуур тохиолдсон учир явдлаа нарийн тодорхой тоочиж, өвгөний зүрх, эмгэний эрихийг богдод өгөв. Богд өвгөний зүрхийг баруун гэрт, эмгэний эрихийг зүүн гэрт тус тус хийгээд бадарчин ламыг маргааш өглөө буцаж ир хэмээн хэлж явуулав. Бадарчин лам маргааш өглөө нь ирж уулзахад богд:

- За, чи баруун гэрт ороод ир гэв.

Бадарчин лам баруун гэрт орсонд өвгөний зүрхнээс гэрэл цацарч байв. Гэрлийг дагуулан харвал зүрхний эзэн өвгөн шамбалын оронд явж байгаа харагдав гэнэ. Бадарчин лам богдод үзсэнээ хэлэхэд:

- За, тэгвэл тэр махчин өвгөн үнэн сэтгэлээсээ нүгэл хийхээ больж, буян үйлдэхээр шулуудсан байна. Тэгээд сүнс нь шамбалын оронд хүрч байгаа нь тэр шүү дээ. Чи бас зүүн гэрт ороод ир гэв.

Бадарчин лам зүүн гэрт явж ортол шалаар дүүрэн урт өтнүүд арваганаж байв гэнэ. Учир нь эмгэний дайж явуулсан эрих болгон нь өт болсон байжээ. Энэ байдлыг богдод орж хэлсэнд, богд хөмсгөө атируулан хэсэг чимээгүй сууснаа:

- Тэр эмгэн ам дүүрэн маани уншчихаад ар хойно нь хүн алж, хулгай хийдэг шунахай сэтгэлтэн байж дээ гэж хэлээд ламд ном хайрлаж:

- Чи нутгийнхаа ард олонд энэ явдлыг хэлж өгөөрэй. Сургамж болно гэж захижээ.

Бадарчин лам нутагтаа харьж ирээд ард олондоо:

- Буянд их бага гэж байдаггүй, зөвхөн үнэн сэтгэлийн сүжиглэл байвал болно гэсэн их багшийн сургаалыг уламжлан сургажээ.

Гоо хатантай хаан

Эрт урьд цагт гоо сайхан хатантай нэгэн байж гэнэ. Нэг өдөр, тэр хаан ан ойд гөрөө хийж яваад газарт хэдэн алим унасан байхыг үзээд авч идтэл гэнэт модон дээрээс нэг хүн:

- Чи яагаад миний алимыг дураараа авч идэж байгаа юм бэ? Одоо чамайг шийтгэнэ гэж хэлэхэд нь хаан дээшээ хартал нэгэн муухай царайтай эмэгтэй байв. Хаан аргагүй байдалд орж:

- Би харин ан гөрөө хийж яваад өлсөж цангаад алимнаас чинь санамсаргүй идчихлээ. Өршөөгөөрэй гэхэд, эмэгтэй:

- За, яахав чи нэрээ бодож байгаа бол намайг заавал хатнаа болгож авах болж дээ гэж хэлэв.

Хаан гэртээ тийм сайхан хатантай юм чинь яаж ийм муухай царайтай эмэгтэйг хатнаа болгож авах билээ гэж гайхаж байснаа “Шийтгүүлж нэр нүүрээ барснаас, хатнаа болгож авсан нь дээр” гэж бодоод муухай царайтай эмэгтэйг гэртээ дагуулж ирэв.

Хаан гэртээ ирснээсээ хойш сайхан, муухай хоёр хатныхаа дунд ихэд зовох болжээ. Тэгээд сүүлдээ гэрэлд нь зүү сүвэлж, гэгээнд нь адуу манахаар сайхан хатандаа сайрхаж, муухай төрсөн хатнаа илт дорд үздэг болов. Нэг өдөр, царай муутай хатан нь:

- Чи яагаад намайг тоохгүй байгаа юм бэ? Хоёулаа нуурын хөвөөнд очиж, усанд нь зүсээ үзье. Би чиний тэр хатнаас чинь доргүй байх гэж хэлэв.

Хаан царай муутай хатнаа дуртай, дургүй дагаж нуурын хөвөөнд хүрч очоод усанд зүсээ үзсэнд хатан нь гоё сайхан эмэгтэй болж үзэгдэв. Хаан царай муутай хатнаа ид шидтэй хүн юм байна гэж бодоод хамт нуурын хажуу дахь хулсан дотор зугаалж явтал, царайлаг хатан нь мэдээд араас нь хайж ирэв. Хаан айхдаа зугтаасанд царай муутай хатан нь хамт зугтаахдаа нэг шагайгаа хулсан дотор гээчихэв.

Энэ хаан зэргэлдээ улстайгаа зөрчилтэй байсан тул хэзээд дайн дажин хийж нутаг усаа булаалддаг байв. Нэг өдөр, хаан зэргэлдээ улсын хаантай шатрын мөрий тавьж, хэн хожсон нь хоёр улсыг захирахаар тогтов. Царай муутай хатан нь хаантайгаа хамт тоглохоор болов.

Шатар тоглож эхлэхэд хатан нь нэг уут чавга авчирч тавьсанд нөгөө улсын шатарчин чавганд дуртай хүн байсан тул байн байн чавга авч идсээр байгаад хожигдож, хаан нь хоёр улсаа захирахаар болжээ. Нөгөө улс ялагдсандаа сэтгэл мөхсөнгүй, тэднийг буцах замд нь цохихоор болж, заавал дайрч өнгөрдөг уулын хөндийн хоёр талаар цэрэг бүсэлж, хаан хатан хоёрыг гаталж гарах үед нь чулуу нурааж алахаар болов. Хаан хатан хоёр тэр замаар явсангүй өөр замаар явж дайснаас арайхийн мултарч гараад явж байтал өмнөөс нь цэнхэр морьтой хүү ирж:

- Ээж, аав хоёр сайн явж байна уу? гэж мэндлэв. Хаан учир шалтгааныг асуувал, тэр хүү:

- Ээж, аав хоёр нуурын хулсанд зугаалж яваад намайг шагайн дотор гээчихээд явсан юм гэв.

Хатан нь өөрт үлдсэн шагайгаа гаргаж тааруулж үзсэн чинь үнэхээр өөрийнх нь шагай мөн байв. Учир нь энэ хүү бол хаан хатан хоёрын хулсан дотор зугаалж явахад олдсон хүүхэд байв.

Хүү хувилгаан чадалтай тул аав, ээж хоёрыгоо аюулд орсныг мэдээд хайж ирсэн нь тэр байж. Тэнд хаан, хатантайгаа амарч аваад хүүгээ дагуулан буцаж эзэлсэн улсаа хүүдээ өгч захируулаад, өөрөө нутагтаа харьж ирэв.

Нутагтаа ирсний дараа хаан царай муутай хатнаа буулган авч, нижгэр хурим хийхээр бэлтгэж эхлэв. Хаан хуримдаа сайхан царайтай хатнаа урих хэрэгтэй тул яаж залахаа мэдэхгүй арга барагдаж байхад нь царай муутай хатан нь:

- Чи сайхан царайтай хатнаа хөтлөөд ир! Би нэг арга зааж өгье гээд хаанд нэг шидмэс өгч явуулав. Хаан шидмэсээ авч, сайхан царайтай хатнаа залахаар очиход сайхан царайтай хатан нь:

- Тийм муухай царайтай хатантай яаж хурим хийх гэж байгаа юм бэ? Би очихгүй гээд явдаггүй гэнэ.

Тэгэхээр нь хаан шидмэсээ гаргаж хүзүүгээр нь оосорлоод хөтлөөд явах гэсэн чинь сайхан царайтай хатан нь нэг муу үнэг болоод хувирчихжээ. Учир нь сайхан царайтай хатан нь үнэгэн шулам байж, муухай царайтай хатан нь Лхам бурхан байжээ. Тэгээд хаан царай муутай хатантайгаа хурим найр хийж, төр улсаа засан амар тайван суужээ.

Үмхий хар хорхой яагаад бий болсон бэ?

Урьд цагт, нэгэн лам олон шавь нараа цуглуулж ном гүрэм хийж байжээ. Тэгсэн чинь тэр шавь нарын дундаас нэг лам сахил алдаж үмхий унгас тавиад бүх лам нарыг үмхийгээр утаж гэнэ. Түүнд багш лам ихээр уурлаж:

- Сая хэн үмхий унгас алдав? гэж асуусанд хэн нь ч дуугарсангүй. Багш ламын уур бүр их хүрч “Бурханы шавь нар заавал үнэнч шударга байх ёстой” гэж бодоод:

- За, яахав. Саяын унгас алдсан хүн дараа төрөлдөө агаруу зандан үнэртэй, Арьяанчимбу болж төртүгэй гэж хэлсэн гэнэ.

Тэгээд тэр үмхий унгас алдаж үнэнээ хэлээгүй лам дараа төрөлдөө үмхий хар хорхой болж төрсөн гэдэг.

Хурт лам

Урьд Алшад хурт лам гэдэг их эрдэм чадалтай лам хүн байжээ. Тэр хаана явна тэр газар заавал бороо хур буудаг байж.

Нэг жил, ган болж, нутгийн айл Хурт ламыг гэртээ залж ном уншуулж, бороо хур буулгахаар болжээ. Хурт лам ном гүрмээ хийгээд тэр айлаас дөнгөж явсны дараа нэгэн наймаачин залуу айлд ирэв. Залуу айлд орж ирээд наймаа хийх гэсэнд айлын хүмүүс бурханд залбирч наймаа хийх завгүй байв. Наймаачин залуу тэднийг хараад:

- Та нар юунд залбирч байгаа юм бэ? гэж асуусанд, гэрийн хүмүүс:

- Өнөөдөр манайд хурт лам залагдаж ирээд явсан юм. Одоо бороо хур бууна. Тэгээд бид бурхандаа залбирч байна гэж хэлэв. Наймаачин залуугийн инээд хүрч:

- Бороо хур буулгах эрдэм надад ч байна гэв. Айлын хүмүүс итгэж ядан, үл тоосон янзтай:

- Тэгвэл чи мэргэлээд өг. Энэ хоёр өдөрт бороо хур байна уу? үгүй юу? гэж асуухад:

- Болно болно гэж хэлээд гарч, ачаан дээрээ байсан ууттай хар чихрээ барьж үзчихээд:

- Энэ хоёр өдөр бороо орох нь ч орох юм байна гэв. Айлын хүмүүс:

- Яаж мэдсэн юм бэ? гэхэд:

- Та нар хар. Миний хар чихэр ус татсан байна. Хар чихэр ус татахаар бороо ордог юм гэж хэлсэн гэдэг.

Үнэхээр тэр хоёр өдөр бороо хур их орсон бөөд хурт лам, наймаачин залуу хоёрын аль нь ид шидээ гаргасныг ялгаж мэдээгүй юм гэдэг.

Алагсан

Урьд Алшад, Алагсан гэдэг нэртэй сүрхий эрдэмтэй лам байжээ. Тэгээд Алша нутагт ган болж хүн мал ангаж цангаад хэцүү болов гэнэ. Алша ноён нь Алагсанг залж, түүгээр зад барьж, хур бороо буулгахаар болов. Тэгээд тэр ламыг авчирч нэг сар болсон боловч бороо хур орсонгүй гэнэ. Тэгэхээр нь Алша ноён:

- Үгүй, чи ийм их удаж байж яагаад бороо хур буулгахгүй байгаа юм? гэж асуусанд, Алагшан:

- Бороо буух нь ч буух гээд байна. Гэвч ширүүн бороо орох гээд байна. Одоо арав хоночихвол зөөлөн бороо орох юм байна. Тэгээд би зөөлөн бороог хүлээгээд байна гэв. Ноён түүнийг сонсоод итгэсэнгүй:

- Энэ лам биднийг мэхэлж байна. Одоохон барьж гянданд хорь гэж тушаав. Түшмэлүүд нь ноёны зарлигаар Алагсан ламыг барьж төмөр цонхтой гянданд хийж хорив. Алагсан ламыг барьсан тэр шөнө тэнгэрт том хар үүл гарч, бороо орж эхлэв. Бороо орох тусмаа ширүүсч эхлэхэд ноён:

Энэ муу лам биднийг мэхэлж байсан нь үнэн байна. Тэрнийг хорихоор бороо орж байна гэж сайрхаж, одоо тэрнийг суллаж тавь гэж тушаав. Түшмэлүүд гянданд хүрч, ламыг суллахаар очтол Алагсан аль эрт алга болж, хүлсэн дээс нь хэвээрээ байж байв. тэр бороо долоон өдөр долоон шөнө тасралтгүй орж, нутаг ус нь усанд авгаж гэнэ. Зөвхөн ноёны нэг түшмэл айлын тогоон доор сууж амьд гарч ноёны амийг аварч гарчээ. Бусад улс нь бороонд туугдах нь туугдаж, зугтаах нь зугтааж алга болсон байв. Тэр борооноос болж Алша нутагт хар мод, заг хоёр учиргүй их ургасан гэдэг. Улаан морин жилийн дайн болоход Алшагийн ард иргэд тэр хар мод, загны дунд нуугдаж, амьд үлдсэн гэдэг.

Бурханы ачийг хүн мэддэггүй

Урьд нэг залуу хөвийн усанд шумбаж байгаад уснаасаа гарч чадахаа байчихаж гэнэ. Залуу амь тэмцэхдээ хамгийн түрүүнд бурханыг санаж:

- Богд лам аа, амь авар гэж хашгирчээ. Тэр үед богд лам хоолоо идээд сууж байжээ. тэгтэл хүн өөрийг нь дуудаад болохгүй болохоор нь эрихээ тоолж үзсэнд нэг залуу усан дотор гарч чадахгүй аврал эрж байна гэнэ. Тэгэхээр нь богд лам “Энэ залуу хөөрхий уснаасаа гарч чадахгүйдээ намайг шүтэж аврал гуйж байна. Амийг нь аварчихъя” гээд барьж байсан савхаараа хавчаад уснаас гаргаж гэнэ. Уснаас гарч чадахгүй амь тэмцэн сандарч байсан залуу, гэнэт уснаас зүгээр гарчихсанд, өөрөө ч их гайхаж гэнэ. Тэгээд тэр гэрийнхэндээ:

- Өнөөдөр би усанд сэлж байтал гарч чадахгүй үхэх шахлаа гэж хэлсэнд гэрийнхэн нь сандарч:

- Тэгээд чи хүн амьтан дуудсан уу? гэхэд өнөө залуу:

- Дуудах гэнэ ээ? Хэнийг дуудах юм? Харин би усан дотор амь тэмцэхдээ богд ламыг дуудаж тэнхээгээрээ хашгирсан. Гэвч богд лам хаана байхыг хэн мэдлээ. Сүүлдээ би өөрийн хүчээр л арайхийн гарч ирсэн шүү гэж хэлэв.

Түүнээс хойш ард түмний дунд “Бурханы ачийг хүн мэддэггүй” гэсэн үг гарсан юм гэнэ.

Лам үнэн дүрээ гаргасан нь

Урьд цагт нэг лам бурханы оронд хүрч, буян хийхээр явж байжээ. Эрлэгийн элч бурхан болохоор явж байгаа ламыг шалгаж үзэхээр болов. Гэтэл замд нь нэг охин, ямаа хөтөлчихсөн, савтай архи аваад явж байхтай таарав. Эрлэгийн элч ламд:

- Чи тэр ямааг ал. Хоёулаа махыг нь чанаж идье гэхэд лам:

- Би чинь эх болсон зургаан зүйл хамаг амьтны тусын тулд буян үйлдэж яваа амьтан. Тийм хар нүгэлтэй ажил хийхгүй гэв. Эрлэгийн элч “Энэ чинь чухам бурхан болох хүн байна” гэж бодоод улам шалгаж:

- Тэгвэл чи савтай архийг нь уу! гэжээ. Лам:

- Болохгүй. Би чинь сахил санваартай лам хүн. Архи дарс уухгүй гэжээ. Эрлэгийн элч:

- Тэгвэл чи тэр хүүхэнтэй нөхц гэжээ. Лам:

- Үгүй үгүй. Би тийм бузар юм хийхгүй гэж гэлээ. Эрлэгийн элч хамгийн сүүлд:

- Чи яасан сүрхий амьтан бэ? Чамайг барьж аваачаад тамын ёроолд чулуудья гэж айлгажээ. Лам түүнийг сонсоод сандарч “Энэ одоо намайг эрлэг тамд хаях гэж байна. Яаж аргалдаг билээ. Архи нь арай нүгэл багатай байх” гэж бодоод:

- Би архийг нь ууя гээд гуутай архийг бүгдийг нь уучихсанд, хоёр нүд нь улайгаад, царай нь минчийж, өнөө сайхан буян ном хийдэг яралзсан цагаан шүд нь яралзаад, мах идэх дур нь хүрч гэнэ. Тэгээд согтуугаараа ямааг нь алаад идчихэж гэнэ. Архи ууж согтоод, ямаа алж идсэн лам нэгэнт ухаанаа алдаж өнөө хүүхэнтэй нөхцөөд болдоггүй зүйлүүдийг нь бүгдийг хийчихжээ. Эрлэгийн элч түүнийг үзээд “Хүн ямар учраас ингэдэг юм бол?” гэж бодож бодож байгаад хамгийн сүүлд гол зүйл нь архинаас болсон юм байна. Хэрвээ лам архи ууж согтоогүй бол арай ингэж эрээ цээрээ алдаж, сахил санваараа алдахгүй байсан юм гэдгийг мэджээ. Тэгээд архи бол хүн төрөлтний бүх муу үйлийн эх үндэс хэмээн үзэж их уухыг цээрлэж ирсэн уламжлалтай юм гэнэ.

Хөл биш хүзүү

Урьд нэгэн нутагт ганц саглагар мод байжээ. Тэр модноос олон хүн боож үхсэн болохоор чөтгөр шингэсэн гэх яриа ард олны дунд тархаж, сүүлдээ тэр модруу хүн очихоос айдаг болжээ.

Нэгэн саваагүй залуу мөрий тавьж байгаад модыг чөтгөртэй эсэхийг шалгаж үзэхээр болжээ.

Залуу модны дэргэд ирж мөчрөөс нь дээс уяж хөлөндөө уячихаад зогсож байтал тэнгэр харанхуйлж өнөө модноос:

- Хөл биш хүзүү гэж хэлж гэнэ.

Саваагүй залуу өнөө үгийг сонсоод айсандаа годхийн зугтааж явсан гэдэг.

Үрэлт лам

Урьд цагт үрэлт хэмээх лам байсан бөгөөд үснээс нь бурханы үрэл унадаг байжээ. Мань лам бурхан болж хувилгаан дүр нь олонд танигдаагүй байж. Тэгээд ламын хувилгаан дүр бадар барьж айл хэсэж явдаг байв гэнэ.

Нэгэн айлд бадарчин банди ирж хоножээ. Өглөө нь бадарчин банди орноосоо боссонд орон дээр нь дүүрэн улаан үрэл бутарч байж гэнэ. Айлын эхнэр гайхаж:

- Энэ юун улаан үрэл вэ? гэж асуугаад хартал бадарчин бандийн үснээс үрэл унаж байв. Тэгээд тэр хүүхэн:

- Хүүе, ямар сонин юм бэ? Энэ бадарчингийн үснээс улаан үрэл унаж байна гэсэнд гэрийн хөгшчүүл сонсоод:

- Дуугүй бай гэм! Арай манай багш лам биш биз гэж хэлээд харсанд үнэхээр бадарчин бандийн үснээс улаан үрэл бутарч байжээ.

Тэгээд гэр бүлээрээ сандарч, хадаг самбай барьж, мань ламыг хоймроо залж мөргөсөн гэнэ. Ингэж үрэлт ламын хувилгаан дүр олонд танигдсан юм гэдэг.

Баасны ногоон хорхой

Эрт цаг зууд их ламын үймээн болж, Богд лам Алшад бадарчин болж зугтааж иржээ. Их лам бадар барьж явах замдаа Алшагийн Баяннуруу гэдэг газар хүрээд, их цангаж ядраад нэг айлын гадаа очжээ. Тэр айлын гадаа ногоон торгон тэрлэгтэй эмэгтэй үхэр саагаад сууж байв. Богд лам эмэгтэйн дэргэд хүрч очоод, өврөөсөө модон цөгц гаргаж:

- Алив! Та үхрийн сүүнээсээ жаахан хайрлаач! гэж гуйв.

Баян айлын эхнэр Богд ламруу нүднийхээ булангаар омогтой гэгч хялайж харчихаад, үг дуугүй үхрийн бааснаас атгаж аваад Богдын цөгцөнд пял хийтэл хийж орхив. Богд лам түүнийг үзээд юу ч дуугарсангүй, цөгцөндөх нялцгар үхрийн баасыг авч идчихээд, явахдаа:

- За, яахав, ядарсан зүдэрсэн хүнийг доромжилж байна. Чи дараа төрөлдөө элэгдэхгүй хувцастай, барагдахгүй хоолтой болж төрөөрэй гэж хэлээд явж гэнэ.

Тийнхүү ногоон торгон дээлтэй баяны эхнэр дараа төрөлдөө ногоон хальстай, баас иддэг хорхой болж төрсөн юм гэнэ.

Багшийнхаа хэлснээр ханиа олсон нь

Эрт урьд цагт, нэг хүн хүүгээ хөгшин ламд шавь болгон өгчээ. Хүү нь багшаараа ном заалгаж, эрдэм ном сурахын зэрэгцээ багшдаа дэм болж, ажлыг нь хийж өгдөг байв. Нэг өдөр хүү багшдаа сайхан хийцтэй цай хийж суутал багш нь түүнийг хараад гэнэт түсхийтэл инээд алдаж гэнэ. Хүү:

- Багш аа, та юунд инээд алдав? гэж асуухад багш нь:

- Харин хэрэггүй юм үзэгдэх юм. Сая чиний хөдөлж байхыг хараад хань чинь төсөөлөгдлөө гэж хэлэв. Хүү багшийнхаа хэлсэн үгний учрыг олохгүй гайхаж суутал багш нь залгуулан:

- Энэ баруун хойно нэлээд хол газар дөрвөн нүдтэй улаан халтар нохойтой, хотондоо сайхан малтай монгол айл байна. Тэр айлын бүсгүй сая нэг охин хүүхэд төрүүллээ. Тэр хүүхэд эцэстээ чиний хань болно гэж хэлэв.

Шавь нь багшийнхаа хэлэхийг сонсоод мөн л учир утгыг олохгүй “Багш маань өнөөдөр юу болсон юм бол? Би тэр хэрэгтэй хэрэггүй хүүхдээр юу хийх билээ” гэж бодож суув. Хэдэн өдрийн дараа хүү ном уншиж сууж байгаад багшийнхаа хэлсэн үгийг санаж үнэн эсэхийг шалгаж үзэхээр шийдээд багшийнхаа хэлсэн айлд хүрч очжээ. Тэр айл үнэхээр дөрвөн нүдтэй халтар нохойтой, бүсгүй нь охин төрүүлээд удаагүй байв гэнэ. Хүү айлын бүсгүйгээс:

- Хүүхдээ хэзээ төрүүлсэн бэ? гэж асуухад сар өдөр нь яв цав таарч байлаа.

Шавь нь багшийнхаа хэлсэн үгийг үнэн юм байна. Гэвч би энэ нялх хүүхдээр яах юм билээ гэж бодож суутал айлын бүсгүй төл малаа хөхүүлэхээр гарч явахад нь галын шилгүүрээр нь хүүхдийн гэдсийг хага чиччихээд гарч зугтаажээ.

Тэр хэргээс хойш нэлээд хугацаа өнгөрч өнөө шавь ч хөгшрөөд сахал үс нь цайсан ганц бие хөгшин лам болжээ. Тэр насаараа ном үзэж их эрдэм номтой болсон бөгөөд нутгийн малчин ард хэзээд залж ном заслаа хийлгэж хоол ундаар нь хангадаг байв. Нэг өдөр, нутгийн хөгшин авгай ламд хоол хүргээд буцах болсонд их бороо ороод буцаж чадсангүй тул аргагүй хөгшин ламынд хонох болжээ.

Орой унтахаар хувцсаа тайлахад нь авгайн гэдсэнд их том улаан сорви байхыг лам үзээд:

- Чи гэдсэн дээрээ юун том сорвитой юм бэ? гэж асуухад, авгай:

- Намайг өлгийтэй байхад нэг бүтэлгүй лам банди миний гэдсийг галын шилгүүрээр хага хатгачихсан юм гэнэлээ гэв. Лам энэ үгийг сонсоод дотор нь ёг хийж, энэ чинь миний хийсэн хэрэг байна. Тэр хүүхэд үхээгүй юм байна гэж бодоод:

- Ай яа, тэр хэргийг би хийсэн юмаа. Тэр үед би бага байж, юмны учир мэддэггүйгээс багшийн хэлснийг сонсоод арга барагдаж, нүүр барах юм шиг бодогдож билээ. Тэгээд би танайд очиж чиний гэдсийг хагалсан юм гэж бүх үнэнийг ярив.

Авгай хөгшин ламын хэлснийг сонсоод гэмээ хүлээж алдаагаа мэддэг шударга хүн байна гэж

сэтгэл нь уярч багадаа хийсэн хэргийг нь уучилж, ламтай айл болж суужээ. Ийнхүү хөгшин лам багшийнхаа хэлснээр ханиа олж амар сайхан амьдарсан гэнэ.

Нүглийг нүглээр, буяныг буянаар

Эрт урьд цагт нэг сүрхий анчин өвгөн насандаа олон амьтныг алж нүгэл хийж байжээ. Анчин өвгөний ганц хүү нь лам болж ном сурахаар явсанд гэрт нь хөгшин аав ээж хоёр хэвтэрт орсон нагац эмээтэй нь үлджээ. Залуу “Одоо би яваад гурван жил болж ирнэ. Миний муу нагац эмээ минь яадаг бол доо” гэж санаа нь зовсоор явав.

Залуу багшийндаа хүрч ирэхэд хажууд нь нэг гар нь тахир лам банди байв. Тэр бандитай хамт багшаасаа гурван жил ном сураад буцах болоход, тахир гартай банди:

- Танай манай хоёр олон жил айл саахалт явж ирсэн хүмүүс. Би чамаар ээж аавдаа захиа дайя гэхэд, залуу:

- Танай гэр чинь манай гэрийн хаана байдаг юм бэ? Би яагаад мэдээгүй байдаг билээ? гэж асуув. Нөгөө банди:

- Танай гэрийн зүүн хойд зүгт өндөр бүүрэг бий. Тэр бүүргийн бэлд манайх байдаг юм. Чи хажууд нь очоод “Аав аа, би танай хүүгийн захидлыг авчирлаа” гэж хашгирвал аав үүдээ нээж захиаг минь авна гэж хэлэв.

Залуу, түүний захиаг авч, гэртээ харьж ирчихээд захидлыг хүргэхээр явав. Гэрийнх нь зүүн хойд талд үнэхээр нэг бүүрэг байх ба түүний бэлд очиход ямар ч айл байсангүй. Залуу гайхаж хэсэг зогссоноо өнөө бандийн хэлснээр:

- Аав аа, би танай хүүгийн захиаг авчирлаа гэж хашгирав.

Тэгтэл бүүргэн дотроос нэг өвгөн гараад ирэв гэнэ. Залуу түүнийг үзээд гайхаж “Манайх энд үе үеэрээ нутаглаж ирсэн хэрнээ энд ийм айл байдгийг мэдсэнгүй. Яасан сонин юм” гэж бодтол өвгөн:

- Хүү минь гэрт ор гэв. Залуу айлд ороход гэрт нь тахир дугуу зарим нь хөлгүй, зарим нь гаргүй олон хүүхэд байв. Өвгөнд хүүгийнх нь захидлыг өгөөд явах гэтэл өвгөн:

- Чи яарах хэрэггүй. Ном эрдэм сурсан хүн учир мэдэх байх. Манай гэрийг тойрч үзээд ир гэв.

Залуу гэрийг тойрч үзээд хамгийн сүүлчийн гэрт ороход нагац эмээг нь хөлөөр нь төмөр гохоор дүүжилчихсэн байв. Залуу манай нагац эмээ гэртээ байхад яагаад энд бас үзэгддэг юм гэж асуухад өвгөн:

- Танай аав чинь ан гөрөө хийж, хавх олныг тавьж, бидний үр хүүхдийн хөл гарыг хугалсаар ийм боллоо. Тэгээд бид аавыг чинь дийлэхгүй болохоор нагац эмээгийн чинь сүнсийг авчирч тамлаж байгаа нь энэ билээ гэв. Залуу ихэд зовж:

- Хөөрхий нагац эмээ минь хорхойд ч хоргүй сайн хүн юмсан. Одоо би яаж нагац эмээгээ аварч гарах вэ? гэж асуусанд:

- Чи үнэхээр нагац эмээгээ эндээс авч гарья гэж бодож байгаа бол аавынхаа буу сум, хавхыг алга болгож, дахиж биднийг алж нүгэл хийхгүй болговол нагац эмээг чинь тавьж явуулна. Харин би маргааш цагаан үнэгний дүрд хувилаад очиж шалгана гэж хэлэв.

Залуу өвгөний хэлснийг сонсоод гэртээ харьж ирээд аавдаа:

- Аав аа, та энэ өдрөөс хойш битгий ан гөрөө хий. Та энэ насандаа их нүгэл хийсэн болохоор нагац эмээгийн хөл нь тасарч зовж байна. Надад ч бас байсхийгээд барцад тохиолдох юм. Иймээс таны буу зэвсгийг үгүй хийхгүй бол болохгүй гэж үзсэн бүхнээ ярив.

Аав нь сонсоод ан гөрөө хийж, нүгэл их хийсэн хүн ийм үйлийн үртэй байдаг юм байна гэж мэдээд буу сум, хавхаа үгүй хийхээр болжээ. Тэгтэл нэг цагаан буурал толгойтой өвгөн орж ирэв. Залуу нөгөө өвгөн мөн байна гэж мэдээд хоймроо залж, цай унд хийж өгөв. Цагаан толгойтой өвгөн залуугийн аавыг ажиглангаа хоол цай идэж уучихаад яваад өгөв. Залуу араас нь ажиглаж хартал зүүн бүүргийн цаана гараад цагаан үнэг болж хувираад идсэн хоолоо бөөлжиж гаргачихаад гэртээ орчихов.

Анчин өвгөн буу зэвсгээ булж ан гөрөө хийхээ байсны маргааш нагац эмээ нь гэнэт хэвтрээсээ босч явдаг болжээ. Түүнээс хойш нүгэл нүглээрээ, буян буянаараа гэдэг үг гарсан юм гэдэг.

Мөнгө хадгалсан өвгөн

Эрт урьд цагт хоёр хүүтэй харамч өвгөн байжээ. Тэр өвгөн гэртээ хоёр адилхан улаан авдартай бөгөөд нэгэнд нь мөнгөө хадгалдаг юмсанжээ. Өвгөн нас дээр гарч, хадан гэртээ очих цаг нь дөхөхөд том хүү нь:

- Аав аа, та одоо эмчлүүлэхгүй бол болохгүй нь, таны авдартай мөнгөнөөс авч буян хийе гэж хэлсэн чинь аав нь уурлаж буруу харж хэвтэв. Энэ үед бага хүү нь гаднаас орж ирээд:

- Ах та яасан ухаангүй юм бэ? Аавын мөнгийг дээрээс нь нэмэх болохоос авч болохгүй. Аавыг өөд болохоор махыг нь зарж мөнгө болгоод нэмж хадгалах биш үү? гэж хэлэв. Энэ үгийг аав нь сонсоод:

- Миний бага хүү чинь харин ухаантай юм байна гэж баярлан наашаа харж хэвтэв. Удалгүй хэд хоногийн дараа аав нь нас барав. Ах дүү хоёр аавыгаа хэрхэн оршуулах талаар ярилцаж байгаад аав нь мөнгөндөө үхэн хатан хайртай байсан тул аавын хэлсэн ёсоор махыг нь зарж мөнгө болгоод авдартай мөнгөн дээр нь нэмье гэж хэлэлцэж тогтов. Тэгээд ах дүү хоёр:

- Одоо хоёулаа аавынхаа мөнгө хадгалдаг авдрыг нээж үзье! Мөнгө гэж чухам ямархуу юм байдаг бол гээд түлхүүрийг нь авч авдрыг нь нээж үзсэн чинь мөнгөнийх нь дээр том дигваранз хэвтэж байв. Дүү нь аавынхаа гуяны махнаас огтолж:

- За, бид аавынхаа махыг худалдаж мөнгө болгож хийлээ гээд дигваранз дээр хаясан чинь махыг нь идэж байна гэнэ. Ах дүү хоёр дигваранз биш чөтгөр байна гэж түүнийг галын хайчаар барьж, хоосон авдартаа хийгээд мал тэмээгээ хүнд захиж үлдээгээд хоёр авдраа ачаад зууд мөргөхөөр явжээ. Зууд хүрч ирээд лам багшийг хайж очоод:

- Манай аав амьд сэрүүн байхдаа нэг авдар мөнгө хураасан юм. Тэр мөнгөө зарахгүй хадгалсаар байгаад үхчихсэн. Одоо бид тэр авдартай мөнгийг танд авчирч өгч аавынхаа сүнсийг даатгахаар ирлээ гэсэнд багш лам:

- Ээ дээ, би та хоёрын аавын сүнсийг дааж чадахгүй юм байна. Та нар зүүн хөтлийг давж очвол тэнд өдөрт гурван зуун хонь алдаг нэг хүн бий. Тэр хүн л дааж чадаж магадгүй.

Харин намайг хэлсэн гэж хэлж болохгүй шүү гэж захиад явуулав. Ах дүү хоёр зүүн хөтлөөр давж өдөрт зуун хонь алдаг хүн дээр хүрч очоод үнэн учраа хэлэв. Өнөө хүн хоёр залуугийн үгийг сонсоод үлдсэн зуун хонио тавьж явуулаад хутгаа билүүдээд байж, билүүдээд байж. Чухам хэчнээн хурцалсныг бүү мэд. Тэгээд:

- Та нарт авдрын түлхүүр нь байна уу? гэж асуув. Ах дүү хоёр:

- Байна гэж түлхүүрээ гаргасанд:

- Дигваранзтай авдрыг нээ гэж хэлэв. Ах дүү хоёр дигваранзтай авдрыг нээсэнд дигваранзын нэг гар гарч ирэв. Тэр хүн гарыг нь хутгаараа тасдаж аваад идэв. Дахиад нэг гарч ирсэнд хутгаараа тасдаж идэв. Ингэсээр дигваранзын бүх гарыг тасдаж идээд хамгийн сүүлд

толгойгий нь тасдаж идэв. Тэгээд том толгойтой гаансаар тамхи татаад суучихав. Татаж татаж үнсийг нь цагаан цаасан дээр асгатал мөнгөн суварга унаж ирэв. Тэр хүн:

- Та нар үүнийг авч багш ламдаа өгчихөөд гэртээ харь гэв. Ах дүү хоёр дигваранз хорхойг дарж өгсөнд баярлаж авдартай мөнгөө өгсөнд авсангүй. Багш ламынд ирэхэд:

- Тэр хүн мөнгийг чинь авав уу? Аавын чинь сүнсийг даав уу? гэж асуув.

- Аавын сүнсийг даалаа. Авдартай мөнгийг авсангүй. Аварга дигваранзыг дарлаа. Тэгээд гаансаа татаж татаж мөнгөн суварга гаргаж ирлээ. Түүнийг багш танд өг гэж хэллээ гэсэнд:

- Тэр дигваранз хорхой бол хар манзшар гэгч амьтан. Тэр бол дэлхийн хүнийг үлдээхгүй идэх аюултай амьтан байсан юм. Нутагтаа очоод ард олондоо:

- Мөнгө битгий хадгал, шар будаа битгий зээл гэж хэлээрэй хэмээн захисан юм гэдэг.

Бадамсамбуу бурхан, чөтгөрийг дарсан нь

Эрт урьд цагт өнгө зүсэнд дуртай илжгэн чихтэй хаан байжээ. Илжгэн чихтэй хааны сууж байсан газарт нэг Нарансүрэн гэдэг нэртэй уул байжээ. Тэр ууланд суудаг шулам нэг өдөр үзэсгэлэнтэй сайхан хүүхний дүрд хувилаад илжгэн чихтэй хааныд хүрч иржээ. Илжгэн чихтэй хаан түүнийг үзээд ихэд баярлаж хатнаа болгон авч гэнэ. Шулам, илжгэн чихтэй хааны хатан болчихоод удалүй хүнд өвчин тусч хэвтжээ. Хаан сандарч яах учраа олохгүй байсанд хатан нь:

- Миний энэ өвчнийг эмч домч, эм тан эдгээж чадахгүй. Харин өдөрт нэг хүүхдийн зүрх авчирч идүүлвэл зүгээр болчихно гэж хэлэв. Илжгэн чихтэй хаан түүнийг сонсоод тэр амархан хэрэг гээд түшмэлээ дуудаж:

- Хатанд өдөр бүр нэг хүүхдийн зүрх авчирч өгч бай гэж тушаав. Үүнээс хойш түшмэлүүд өдөр бүр нэг хүүхдийн зүрх авчирж өгөөд байсанд хатны бие тэнхэрч иржээ. Нэг өдөр хааны түшмэлүүд нэг айлд очиж хүүхдийг нь авах гэсэнд тэр айлд нэг лам ирчихсэн сууж байжээ. Түшмэл тэр ламыг ойшоосон ч үгүй, айлын хүнд:

- За, өнөөдөр бид хааны зарлигаар танай хүүхдийг авахаар ирлээ гэж хэлсэнд, хүүхдийн ээж аав нь “Одоо манай хүмүүсийг аваачиж ална” гэж уйлж бархиран хүүхдээ өгөхгүй гэжээ. Лам түүнийг сонсоод айлын хүмүүст:

- Хүүхдээ өг, өг гэхэд эхнэр нөхөр хоёр:

- Та чинь юу ярина вэ? Ганц хүүхдээ алуулчихаад амьд явсны хэрэг алга гэж хэлэхэд лам нэг арга бодож, түшмэдэд хандан:

- Та нар түр гадаа байж бай би жаахан арга хийе гээд ирсэн түшмэдийг гаргаад:

- Та нар үүднийхээ зүүн талаар хүүхдээ тэврээд гар гэж хэлээд өөрөө жаахан хүүхдийн дүрд хувилаад орон дээр гарч хэвтэв. Айлын эзэд хүүхдээ тэврээд зүүн үүдээрээ гарч явахад хааны түшмэд орж ирээд айлын “хүүхэд”-ийг авч хааны “хатан”-д аваачиж өгчээ. “Хатан” тэр хүүхдийг үзээд мөн дүрдээ хувилж улаан үнэг болж зугтаасан гэдэг. “Хүүхэд” үнэгний хойноос азарган чоно болж хөөжээ.

Гэтэл үнэг шувуу болж ниссэнд чоно хараацайд хувилж хөөжээ. Хэсэг хөөсөнд шулам ингэн тэмээ болж зугтаахад хараацай буур болж хөөжээ. Тэгж хөөсөөр ингийг шулам дүрд нь оруулж өөрөө бурханы дүрд хувирч Ловончимбын агуйд хөөж оруулаад дарсан юм гэдэг. Тэр лам Бадамсамбуу гэдэг бурхан байсан гэдгийг нутгийн ард мэдээд агуйн дэргэд сүм хийд барьж шүтдэг болсон гэнэ.

Үэ ми, түү пү хоёр

Урьд цагт Үэ ми, Түү пү гэдэг хоёр баян ойролцоо амьдардаг байжээ. Нэг өдөр Түү пү баян Үе ми баянаас жаахан газар түрээсэлж аваад тариа тарихаар болжээ. Түү пү газраа хагалж байтал хүрээнд нь нэг хатуу юм тээглэн торр гэж дуугарав. Юу юм бол гээд малтаад үзтэл нэг том алт байжээ. Тэгээд Үэ мигийн алт биз гэж бодоод алтыг хүргэж өгчээ. Үэ ми өмнөөс нь:

- Тэр миний алт биш. Тэр газрыг чамд түрээсэлсэн болохоор чиний алт шүү дээ гэв. Түү пү хариуд нь:

- Тэгж яаж болох вэ? Би чиний газрыг түрээсэлж авснаас биш алтыг чинь худалдаж аваагүй гээд авсангүй. Тэгж маргалдаж байгаад сүүлдээ хаандаа очиж учир байдлаа хэлжээ. Хаан тэдний үгийг сонсоод:

- Тэгвэл хуваагаад авчих гэж хэлэв. Тэгсэн ч хэн нь ч авсангүй. Хэсэг хугацаа өнгөрсний дараа хааны нутагт сүм барихаар болж, сүмийн чимэглэлд алт хэрэгтэй болоод хаанд мэдүүлжээ. Хаан:

- Энд Үэ ми, Түү пү хоёрын алт байгаа. Тэд алтаа авахгүй байгаа болохоор энэ сүмд хэрэглэцгээ гэв. Тэгээд хоёр баяны алтыг сүмийн чимэглэлд хэрэглэхэд элбэг дэлбэг хүрээд бас жаахан үлдэв. Үлдсэн алтыг хоёр баянд буцааж өгсөнд бас л авсангүй тул хаан тэр алтаар Үэ ми, Түү пү гэдэг нэртэй хоёр суумал бурхан бүтээлгэсэн бөгөөд түүнээс хойш хүмүүс үэ ми түү пү гэж маань уншин залбирдаг болсон юм гэдэг.

Өнчин хүү хааны гүнжийг авсан нь

Эрт урьд цагт нэг өнчин ганц хүү айл хэсэж, хоол олж идэн амьдардаг байжээ.

Өнчин хүү гуйлга гуйж яваад нэг айлд орсонд тэр айл нэг хавх өгчээ. Өнчин хүү хавхтай болсондоо туйлын их баярлаж, үүнээс хойш ан гөрөө хийж амьдаръя гэж гуйлга гуйхаа болиод, хавхаа тавьж зээр гөрөөс агнаж амьдардаг болжээ.

Нэг өглөө хүү эрт босч хавхаа шалгаж үзсэнд сайхан улаан үнэг орчихсон байж гэнэ. Хүү түүнийг үзээд баярлаж “Одоо энэ үнэгний арьсаар сайхан хувцас хийж өмсөе” гэж бодоод, мод олж өнөө үнэгийг алах гэсэнд үнэг гэнэт:

- Хүү минь ээ, Чи намайг битгий ал! Би чамд хүссэн болгоныг чинь олж өгье. Чи үүнээс хойш баян чинээлэг амьдрах болно гэжээ.

Хүү үнэгний хэлэхийг сонсоод итгэж ядан хавхнаас нь салгаж тавиад хавхаа аваад явах гэтэл үнэг өнчин хүүд баярлаж талархаад:

- За, хүү минь, амийг минь өршөөсөнд баярлалаа. Би хэлсэн үгэндээ эзэн болно. Чи долоо хоногийн дараа энэ газартаа ир гэж хэлжээ.

Долоо хоногийн дараа өнчин хүү үнэгний хэлсэн газарт хүрч ирсэнд өнөө үнэг шарх нь эдгэчихсэн хүлээж суув. Хүүг ирэхэд үнэг баярлаж:

- Хүү минь чи хүрээд ирэв үү? Одоо хоёулаа жаргалаа хайж олохоор явна гэж хэлэхэд өнчин хүү дотроо “Жаргалыг хүн хэзээ эрж хайж олдог юм” хэмээн итгэж ядан:

- Жаргалыг яаж олж авах юм бэ? гэж асуухад, үнэг:

- Чи заавал хэлүүлэх гээд байгаа бол хэлж өгье. Хамгийн гол нь чи анхааралтай сонсох хэрэгтэй. Би чамд мангасын хааны гүнжийг авч өгөөд, хааны хүргэн болгоно гэж хэлжээ. Өнчин хүү дотроо итгэхгүй байсан ч “Үнэгний мэх хэр байдгийг үзье” гэж бодоод үг хэлсэнгүй дагаж явав. Үнэг өнчин хүүг дагуулаад хэчнээн хол явсныг бүү мэд нэг мэдэхэд танихгүй газар хүрчихсэн байжээ. Тэгээд үнэг хүүд:

- За, чи эндээ хүлээж бай. Би эхлээд мангасын хаантай хэлэлцэж тохироод ирье гэж хэлчихээд давхиад явчихав. Үнэг мангасын хааныд хүрээд:

- Хаантаан, би ганц хүүтэй юм. Тэгээд хүүгээ танай гүнжтэй суулгахаар алс газраас хэдэн луус алт мөнгөө ачаад танд өгөхөөр ирж явлаа.

Тэгсэн чинь хатан голыг гатлах гэтэл луус мөсөнд халтираад алт мөнгөтэйгөө хамт хатан голд живчихлээ. Ингээд аргагүйдээ хүүгээ хээр орхиод явган хүрч ирлээ гэсэнд. Мангас үнэгний хэлэхийг сонсоод:

- Хүүе, тэгээд хүүгээ дагуулаад ирэхгүй яаж байгаа юм бэ? гэхэд, үнэг:

- Харин хүү маань луусаа усанд унагахгүй гэж ноцолдож байгаад хамаг хувцас хунараа урчихлаа гэв. Мангасын хаан:

- Өө, тийм үү? Ичих юу байдаг юм? Хувцас хунар аваачиж өг гэж хэлээд шинэ сайхан хувцас өгөв. Үнэг мангасын өгсөн шинэ хувцсыг аваад өнчин хүү дээр ирж хуучин хувцсыг нь тайлж, шинэ хувцас өмсгөөд:

- За, одоо чи мангасын хааны хүргэн болох тун дөхөж байна. Мангасын хааныд ороод хаан аав сайн сууж байна уу? Хатан ээж сайн сууж байна уу? гэж мэнд амрыг нь асуугаад зогсож бай. Тэгэхээр мангас чамд суудал тавьж өгнө. Тэр суудалд сууж болохгүй. Би тэр үед үг хэлнэ. Тэгсний дараа суугаарай гэж захиад дагуулж явав. Үнэг, өнчин хүүг дагуулсаар хааныд хүрч ирэв. Өнчин хүү, үнэгний хэлсэн ёсоор мангасын хаан, хатан хоёрын амар мэндийг асуугаад суудал тавьж өгөхөд нь суусангүй. Гэтэл үнэг:

- Хүүе, чи одоо ичих хэрэггүй. Хаан аав, хатан ээж чинь чамайг суу гэж байхад хурдан суу, суу, суу гэж хэлэхэд сая сууж гэнэ. Өнчин хүү суугаад цай хоол идэж уух зуур үнэг гэнэт:

- Үгүй, энэ хурмастын хаан танайд ирнэ гэж байсан. Ирээгүй юу? гэж асуусанд мангасын хаан цочиж:

- Аа үгүй, ирээгүй та хаанаас тийм юм сонсов? гэхэд үнэг:

- Би нэг хүнээс сонссон юм. Тэр хүний хэлснээр ойрдоо орчлонд хэрэг гараад байгаа гэнэ. Тэгээд тантай уулзах юм гэнэ лээ. Ирэх л ёстой доо гэж суув. Мангас ихэд сандарч байх янзтай:

- Үгүй, үгүй ирэхгүй байх гэхэд үнэг мушилзан инээгээд:

- Ирэх байхаа, ирэх байх. Би сүрхий тулхтай хүнээс сонссон. Худлаа яриагүй байх гэхэд мангасын хаан улам сүрдэж байхыг үзээд залгаж:

- Хаантаан? Би тэнгэрт гарч үнэн худлыг мэдээд ирэх үү? гэхэд мангасын хаан сандарч:

- Тэг тэг. Хамгийн гол нь хурмастын хааныг манайд ирэх хэрэггүй гэж хэл гэжээ. Юм гэдэг учиртай юм. Мангасын хааны гэрийн баруун хойдох гол дээр нэг том зандан мод ургасан байдаг байж. Тэр зандан мод бол хурмастын хаан элчээ явуулж хүн төрөлхтний муу сайныг мэдэж авдаг газар байж гэнэ. Түүнийг мангасын хаан мэддэггүй. Харин шөнө гүйдэг үнэг сайн мэддэг байжээ.

Тийм болохоор түрүүний аргыг хэрэглэж мангасын хааныг чадах гэсэн байжээ. Үнэг шөнөөр зандан модны доор очиход хурмастын хааны элч ирчихсэн сууж байв. Тэгээд үнэг хурмастын хааны элчид:

- Элч ээ, Би хурмастын хаанд биеэрээ уулзаж ярих чухал хэрэг байна гэхэд элч:

- Болно болно гээд морь болон хувирч үнэгийг мордуулаад хурмастын хааныд хүргэж өгөв. Үнэг хурмастын хааны амар мэндийг асуугаад хөөргөө гаргаж тамхилангаа:

- Хаантаан, би ганц хүүтэй юм. Түүнийгээ гэрлүүлэхээр таныг тусгайлан залахаар ирлээ. Хаан та хүүгийн хуриманд заавал морилж саатна уу гэж хэлэв. Хурмастын хаан тамхи татангаа:

- Тэгье тэгье. Хүүгийн чинь хурим хэзээ болох юм? гэж асуухад үнэг:

- Энэ сарын арван таванд хийнэ гэж хэлэв. Үнэг мангасын хааныг залж баяртайхан буцаж ирээд мангасын хаанд:

- За, хурмастын хаан танайд ирнэ гэдэг чинь үнэн хэрэг байна. Би өөрийн биеэр очиж асуугаад ирлээ гэхэд мангасын хаан сүнсээ зайлтал айж:

- Хэзээ ирнэ гэнэ? Юу хийхээр ирэх гэнэ? Та яагаад хориглосонгүй вэ? гэхэд үнэг:

- Энэ сарын арван таванд ирнэ гэнэ. Би хориглосон боловч их ууртай байна гэж хэллээ. Мангасын хаан түүнийг сонсоод “Хурмастын хаан манайд ирнэ гэдэг учиртай. Миний хийсэн хэргийг бүгдийг мэдсэн байх” гэж бодоод үнэгэнд:

- Үнэг дүү минь хурмастын хааныг ирэхээр яадаг билээ? Энэ удаа ч тийм амархан гарч чадахгүй байх гэж хэлэхэд үнэгний инээд нь хүрч “Миний хэрэг ч зөв замдаа орж байна” гэж бодоод:

- Тэрэнд зовох юм байхгүй. Надад арга байгаа гэв. Мангасын хаан:

- Танд ямар арга байна? гэж асуухад:

- Та тэр өдөр гүнжээ миний хүүтэй айл гэр болгож, их хурим найр хийвэл болчихно. Миний бодоход тийм том хаан хүн бусдын найр хуримыг сандаргахгүй биз гэж хэлэв. Мангасын хаан:

- Болно болно дүү минь эзэн мэд гэж зөвшөөрчээ. Тэр сарын арван таван болоход мангасын хаан сандарч:

- Би ер нь хурмастын хаантай уулзахгүй байсан нь дээр байхаа. Чамд арга байна уу? гэхэд үнэг:

- За ингэе. Та хатантайгаа гэрийн гаднах морины шонг зайлуулчихаад доор нь нүх ухаж дотор нь орж нуугдвал хурмастын хаан лав олохгүй гэж хэлжээ. Мангасын хаан олон зарц нараараа нүх ухуулж, хатантайгаа дотор нь орсонд үнэг дээрээс нь битүү бүтээгээд бас морины шонг булж тавьжээ.

Энэ үед хурмастын хаан луу хөлөглөн бууж ирэхэд үнэг өнчин хүү, мангасын хааны гүнж хоёрыг айл гэр болгон хуримлуулж, их найр хийжээ. Хурим дууссаны дараа үнэг хурмастын хаанд баярлаж талархсанаа хэлээд:

- Хаан аав аа, манай энэ орон нутагт ойрдоо их хэцүү юм болоод байна. Та шүүж өгөөд явж болох уу? гэхэд хурмастын хаан юу болоод байгааг асуухад үнэг мангасын хааныг нууж булсан морины шонруу зааж:

- Ойрдоо манай нохой тэр шонруу хараад хуцаад байдаг болчихлоо. Тэр лав учиртай биз гэж хэлжээ. Хурмастын хаан үнэгний заасан газарлуу хэсэг харж зогссоноо:

- Пэй. Тэр зэлний чинь доор арван таван толгойтой атагар хар мангас ирээд нуугдаж байна гэж хэлжээ. Үнэг түүнийг сонсоод ихэд айсан янз гаргаж:

- Хаан аав аа, одоо бид яадаг билээ? Та заавал аргалж өгөөд яваарай гэж гуйхад хурмастын хаан:

- Та нар тэр морины шонг зайлуулаатах гэж хэлэв. Үнэг мангасын хааны бүх зарц нарыг дуудаж морины шонг зайлуулсанд хурмастын хаан үүлэнд хөвөлзөн, тасхийтэл дуугаргасанд аянга бууж нүхэн дотор нуугдаж байсан мангасын хаан хатан хоёрыг үнс болгов гэнэ. Ийнхүү өнчин ядуу хүү мангасын хааны гүнжтэй айл гэр болон сууж, нутаг усыг нь эзлэн баян чинээлэг жаргалтай амьдарсан юм гэдэг.

Ядуу ах дүү хоёр баяжсан нь

Урьд цагт Алшад туйлын ядуу ах дүү хоёр байжээ. Тэд өдөртөө зээр гөрөөс агнаж, гоёо малтаж амьдардаг байв.

Нэг өдөр, ах дүү хоёр гоёо малтаж байтал нүхнээс нэг даалин дүүрэн цагаан ембүү гарч иржээ. Ах дүү хоёр энэ насандаа тийм их мөнгө үзээгүй тул яахаа мэдэхгүй сандарч, чи ав, би ав хэмээн хэсэг түлхэлцэж байгаад “Эр хүн, хүний юмыг зүгээр авдаггүй юм. Хүний буян хүнд халддаггүй юм” гээд өнөө даалинтай ембүүгээ буцаагаад нүхэнд нь булчихаад явж гэнэ.

Ах дүү хоёрыг явсны дараа тэр бүүргээр бас нэг шунахай наймаачин явжээ. Тэр наймаачин явж байгаад яг ах дүү хоёрын мөнгө булсан газарт ирэхэд илжигний туурай нүхэнд бүдэрч унаад наймаачныг унагачихжээ. Илжигнээсээ өнхөрч унасан наймаачны уур нь хүрч, босч ирээд илжгээ шавхуурдчихаад цааш явах гэснээ “Сая яагаад илжиг зүгээр явж байгаад бүдэрч унасан юм бол?” гэж бодоод илжиг бүдэрсэн газарт очоод хартал саяхан булаад орхисон нүх байхаар нь малтаад үзсэн чинь дотроос нь даалинтай цагаан ембүү гарч ирж гэнэ. Наймаачин мөнгийг үзээд хагартлаа баярлаж цагаан мөнгийг илжгэндээ цөмийг нь ачиж аваад гэрийн зүг одов гэнэ. Харьж явах замдаа нэгэн айлд хонохоор болоход тэр айлд бас нэг муу санаатай дээрэм хийдэг хүн ирж хоножээ.

Дээрэмчин шөнө дунд наймаачны мөнгийг хулгайлаад зугтаж нар гарах үед Хатан голын эрэгт хүрч, мөнгийг өмдөндөө хийж хүзүүндээ тохоод гол гаталж явжээ. Гэмт хүн гэлбэлзэнэ гэгчээр дээрэмчин баригдах вий хэмээн айхын хажуугаар хүзүүн дэх мөнгө нь ч хүндэрч байв. Гэтэл гэнэт хуй салхи дайрч сал нь холбилзон дайвалзахад дээрэмчин тэнцвэрээ алдаж голын усанд унаж, хүзүүн дэх мөнгө нь түүнийг усны ёроолд живүүлж үхүүлэв гэнэ.

Тэр жилийн намар Алшагийн айлууд их аян хийж нэг айл, ах дүү хоёрыг хөлсөлж, хоёр гар тэмээ өгөөд хужир давс ачуулжээ. Ах дүү хоёр гар тэмээгээ хөтлөөд аян жин хийж, Хатан голын хөвөөгөөр явж байтал нохой нь голын хөвөөн дэх мөсрүү хуцаад байж гэнэ. Хоёр залуу “Нохой яагаад хуцаад байгаа юм бол” гэж бодоод очиж үзсэн чинь мөсний доороос даавууны өөдөс цухуйж байв.

Татаад гаргатал дотор нь дүүрэн мөнгө хийгээд шуумгийг нь боочихсон өмд байв. Ах дүү хоёр мөнгийг задалж үзээд урьд өөрсдийн олоод газарт булж орхисон мөнгө болохыг таниад яах учраа олохгүй хэсэг ярилцаж байгаад төлөг буулгаж үзжээ. Төлгөнд нь: “Энэ мөнгө бол ах дүү хоёрт тэнгэрээс өгсөн хишиг мөн тул авах ёстой гэж буужээ”. Тэгэхээр нь авахгүй бол яах вэ? гэж төлөг тавьж үзсэнд: “Хэрвээ авахгүй бол нэгд тэнгэр гомдоно. Хоёрт лус гомдоно. Гуравт нохой гомдоно” гэж буужээ.

Тэгээд ах дүү хоёр тэнгэрийн хишиг хэмээн тэнцүү хувааж авахад нэг ембүү сондгойрч үлдэв. Монгол хүн юмыг барж дуусгах цээртэй, тэнгэр газрын хишиг тул өнөө үлдсэн ганц цагаан ембүүгээрээ тэнгэр газрыг тахижээ.

Түүнээс хойш ах дүү хоёр дутах юмгүй сайхан амьдарчээ.

Тэмээний эзэн савдаг

Эрт урьд цагт, говь газарт тэмээ хариулдаг айл байжээ. Айлын эмгэн өглөө бүр цай сүүнийхээ дээжийг Алшагийн савдагт өргөдөг байжээ. Өвгөн нь үүнийг дургүйцэж:

- Би бол бор гэртээ богд хар гэртээ хаан байхад чи яагаад надад эхэлж цайныхаа дээжийг өгдөггүй юм гэж хэлэхэд эмгэн:

- Та өдөр болгон тэмээндээ явахад чинь Алшагийн савдаг таныг дагаж яваад, орой ирэхэд чинь хамт ирж, шөнө тэмээг чинь манаж хонодог юм. Чи өдөр бүр тэмээгээ хариулж байна гэж бодож байна уу? Хар сахалт л хариулдаг юм шүү дээ. Тийм болохоор шүтэхгүй байж болохгүй гэж хэлэхэд өвгөн нь:

- Хөөе, Юу гэсэн үг вэ? Би өдөртөө тэмээгээ хариулж байхад юунд хар сахалт тууж ирдэг юм гэж маргажээ. Эмгэн нь “Хар сахалт” гэж яриад байхаар нь өвгөн “Энэ эмгэн хар сахалт гэж хэнийг хэлээд байна. Намайг өдөрт тэмээнд явсан хойно муу золиг чинь хүнтэй ханилж байгаа юм биш биз” гэж хар бууж, шалгаж үзье гэж боджээ. Нэг өдөр, залуу тэмээндээ явсан хүн болж, гэнэт буцаж ирээд гэрийнхээ гаднаас чагнаж үзжээ. Тэгсэн чинь эхнэр нь нэг нарийхан дуутай хүнтэй чанга чанга ярьж байна гэнэ. Өнөө нарийн дуутай хүн:

- Одоо Алшад тэмээ сайхан өснө. Тэмээний түүх тасрахгүй. Мянгын эх нэг үлдвэл болох нь тэр гэж хэлэхэд, эхнэр нь:

- Хүүе, юу гэсэн үг вэ? Алшад ганц тэмээгээр юу хийх билээ. Ийм өргөн сайхан нутаг байхад? гэж асуухад, нөгөө хүн:

- Алшад нэг айлд зуун цагаан тэмээ хүрэх ёсгүй. Харин зуун цагаан ямаа хүрэх түүхтэй юм гэж хэлэхэд, эхнэр нь:

- Манай тэмээ зуу хүрэхэд ойрхон байгаа гэхэд:

- Хүрэхгүй хүрэхгүй. Тийм түүх байхгүй. Хожим ч байхгүй. Арав таваар цуглуулвал зуу хүрэх байлгүй. Алшагийн ямаа ч зуу хүрэхээ болино гэж хэлж байна гэнэ. Тэр хоёр нэлээд ярилцаж сууснаа өнөө нарийн дуутай хүн:

- Одоо тэмээ холдоод явчихлаа. Би нөгөөдөр танай нөхөртэй уулзах ажил байна. Ирэхээр нь хэлчих гэж хэлэв. Залуугийн уур улам их хүрч, нарийн дуутыг барьж авахаар үүдээ татаад ухасхийн орж ирсэнд эхнэр нь ганцаараа сууж байв гэнэ. Залуу гайхаж:

- Сая чи хэнтэй чалчаад байсан юм? гэж асуухад, эхнэр нь:

- Хар сахалттай л ярьж суулаа. Тэр өдөр бүр манайд ирдэг юм. Нөгөөдөр ирж тантай золгоно гэсэн гэж ажиг ч үгүй хэлжээ. Нөгөөдөр нь болжээ. Залуу тэмээгээ хариулаад явж байхдаа “Өнөөдөр нарийн хар сахалт надтай золгох юм гэсэн. Яаж золгох бол” гэж бодоод явж байв. Бага үдийн алдад тэмээ услахаар худаг дээр ирэхэд нэг хүн дээлийнхээ хормойг шуучихсан онгоцонд ус хийгээд зогсож байв. Залуу “Манай худаг дээр хэн ирчихсэн ус хийж байгаа юм

бол” гэж бодоод тэмээнийхээ сүүлчийг туугаад хүрч ирээд амар мэнд асуухад, тэр хүн цэвэрхэн хувцастай ааш зан сайтай, Алшагийн нэлээд дээгүүр зиндааны хүн байх шиг харагдахад дотроо жаахан сүрдэж, учрыг асуухад:

- Би танай энд нутаглаад нэлээд олон жил болж байна. Танай энд айл амьтан алга гэж хэлжээ. Залуу:

- Юу гэсэн үг вэ? Манай ойр орчин ийм олон айл байхад гэсэнд өнөө хүн:

- Таны хэлж байгаа тэр айлууд харахад айл боловч үнэндээ мануухай байна гэж хэлжээ. Залуу бүр гайхаж:

- Тэгээд та ер хэн байна? Би яагаад таныг танихгүй байна? гэхэд:

- Та намайг танихгүй байна уу? Та олон жил миний өвөр дээр суулаа. Би танай хэдэн тэмээний чинь эзэн байна гэж хэлэхэд залуу сая ухаарч, эмгэн нь өглөө болгон цайныхаа дээжийг өргөдөг нь тийм учиртай байсныг ойлгожээ.

Шидийн судар

Эрт цагт нэг их аймхай авгай адуу эрж Баадайн жарны элсэнд явж байжээ.

Нар жаргаж орой болоход “Гэртээ яаж харинаа. Хээр хонож чадахгүй” гэж санаа зовж явтал гэнэт өөдөөс морь унасан охин гараад ирж гэнэ. Охин авгайг үзээд:

- Та хаашаа явж байгаа юм бэ? гэж асуухад, авгай:

- Би адуугаа алдчихаад эрж явна. Чи харав уу? гэж асуусанд:

- Өө тийм үү? Харсангүй. Би бас адуу хайж явна гэжээ.

- Тийм үү? Яасан сайн юм бэ? Би энэ насандаа хөдөө ганцаараа хонож үзээгүй. Одоо ханьтай боллоо гэж баярлахад охин:

- Би бас хөдөө хонож үзээгүй. Тантай таардаг нь сайн юм боллоо гэв.

Тэгээд хоёулаа морио тавьчихаад нэг элсэн хонхорт хоножээ. Угтаа тэр охин чөтгөр байсан бөгөөд хүүхэн түүнтэй хамт хөдөө хоносноос болж чөтгөр шүгэлж гэртээ харилгүй хээр хөдөө тэнэж явдаг болж гэнэ.

Авгайн гэрийнхэн түүний мөрөөр хайсан боловч морины шинэхэн баас таарах боловч олдсонгүй гэнэ. Охин чөтгөр авгайг мэхэндээ оруулж өдөрт адуу хайж байна гэж дагуулж явах бөгөөд авгайг идэх гэхээр түүний биед бурханы ном байсан тул халдаж чаддагүй байж. Нэг өдөр, охин:

- Эгч ээ, таны биед нэг муухай юм байна. Би айгаад байх юм. Та тэр юмаа алга хийчихвэл хоёулаа сайхан амьдарна гэж хэлэв.

Авгай миний биед юу байдаг билээ? гэж бодоод биеэ тэмтэрч үзэв. Тэгсэн чинь дотоод энгэрт нь ээжийнх нь өгсөн шидэт судар байв. Охин тэр үед:

- Мөн мөн гэж хэлэв. Авгай “Энэ чинь чөтгөрөөс хамгаалдаг ном байхад яагаад муухай болчихдог билээ” гэж бодоод номоо гаргасан чинь охин нэг муухай хашгираад хол очоод суучихав. Авгай инээд нь хүрч, номоо гартаа бариад охиныг шоолж:

- Чи чинь хорин хэд хүртлээ “Шидийн судар” үзээгүй хаагуур явж байсан юм гээд толгойруу нь номоороо цохисон чинь охин алга болчихов. Авгай ч өөрөө ухаан алдан унажээ. Тэгээд гэрийнхэн нь авгайг хайж явсаар ухаангүй хээр хэвтэж байхад нь олж аваад лам гэгээн залж, ном гүрэм уншуулж сэргээсэн гэдэг.

Хүүхэд иддэг шар дээлтэй лам

Эрт урьд цагт Алшад нэг Барга лам байдаг байж. Тэр нутгаасаа гарч яваад нэгэн ноёны найр хурим дээр таарав. Аз болоход ноёныд хоол хийх хүн дутаад байсан тул ламыг хоол хийхэд тусалж хэд хонооч гэж гуйв.

Лам ноёныд хоол хийлцэж хэд хоноход тогооч нарын дотор нэг шар дээлтэй, өндөр биетэй, өвөр ханцуй нь тос болсон лам хүн байдаг байв. Барга лам тэр тогооч ламыг ажиглаад байтал өдөр ер хоол идэхгүй байв. Тэр үед ноёны нутагт дандаа хүүхэд алга болдог байжээ. Ялангуяа найр хурим тарах үед заавал нэг хүүхэд алга болдог болжээ.

Нэг шөнө, Барга лам ноёны хоол хийж байсан олон хүмүүстэй хамт унтаж байгаад сэрсэн чинь өнөө шар дээлтэй лам толгойгоо бүтээчихсэн орон дотроо “шал шал” гээд юм идэж байна гэнэ. Барга лам “Энэ хүн өдөр юм идэхгүй хэрнээ шөнө юу иддэг юм бол” гэж гайхаад сэм босч очоод хөнжлөөс нь сөхөөд хартал нэг жаахан хүүхдийг идэж байв гэнэ.

Тэгээд Барга лам энэ нутагт хүүхэд алга болоод байдгийн учрыг мэдэж маргааш өглөө нь ноёнд очиж энэ хэргийг мэдүүлжээ. Ноён уг хэргийг сонсоод найранд барилдахаар ирсэн олон бөхчүүдэд:

- Та нар одоохон шар дээлтэй ламыг барьж авч ялла гэж зарлигдав.

Шар дээлтэй лам бөхчүүдийг түүдэг шиг авч шидээд хавьтуулсангүй. Ноён аргаа барж эцэстээ сураар оосорлож бариулаад үхэр алж, нойтон ширэнд ширэлж тавьжээ.

Олон хоногийн дараа үхрийн шир хатаж, шар дээлтэй лам ширэн дотор хатаж үхсэн гэдэг.

Хуримын газар бузар гэх үгийн учир

Эрт урьд цагт нэгэн бүтэл муутай алиа залуу айлын хуриманд явж гэнэ. Замдаа морио амрааж, гаансаа татаж суутал хажууд нь үхсэн хүний гавлын яс хэвтэж байжээ. Залуугийн саваагүй зан нь хөдөлж, гаансныхаа бохийг сэтгүүрээр сэтгэж аваад хуухай толгойн ухархайруу нь хийгээд:

- Нүд чинь хорсож байна уу? гэж асуусанд өөдөөс нь:

- Хорсож байна гэж хэлж гэнэ. Саваагүй залуу чөтгөр ирлээ хэмээн ухаангүй айж, мориндоо мордоод тэр чигтээ давхив. Хэсэг явж байгаад одоо ч чөтгөрөөс салсан биз гэж бодоод:

- Хорсож байна уу? гэж асуутал, чөтгөр яг ард нь:

- Хорсож байна гэж хэлэв. Нэлээд хол яваад дахиад асуусан чинь мөн л хорсож байна гэж хариулжээ. Залуу чөтгөр надаас салахаа байлаа гэж бодоод давхисаар хуримын айлд хүрч ирэв. Залуу айлд орж цай хоол ууж идэж суугаад:

- Хорсож байна уу? гэж амандаа асуусанд:

- Хорсож байна гэж байна гэнэ. Залуу чөтгөрөөс яаж салъя даа гэж бодож суугаад нэг арга бодож, айлд малгайгаа авч тавьчихаад, үг дуугүй гарч морио унаад давхичихав.

Залууг явсны дараа айлын хурим эхлэх цаг болж шинэ гэрийн цай болж байтал гэнэт үүдээр нь бондгос гээд үхсэн хүний гавлын яс “Хорсож байна” гэж хэлээд өнхөрч орж ирэв. Учир нь саваагүй залуугийн малгайд чөтгөр тогтож үлдсэн байсан бөгөөд хуриманд ирсэн улсаас хэд хэдэн хүн үхсэн гэнэ.

Түүнээс хойш хуримын газар бузар гэж хүүхэд хөгшдийг хуриманд явуулдаггүй заншил тогтжээ. Мөн хөдөө хээр гавлын яс таарвал дэргэд нь үг дуугарч болдоггүй гэж цээрлэдэг болжээ.

Ганц залуу гурван чөтгөрийг дарсан нь

Эрт урьд цагт нэг бүсгүйн хадам аав, ээж, нөхөр гурав нь айлын хуриманд яваад бүсгүй гэртээ ганцаараа үлджээ.

Тэр бүсгүй их зоригтой, гэртээ голдуу ганцаараа үлддэг байсан боловч тэр өдөр яагаад ч юм бие нь эвгүйцэж айдас төрөөд болохгүй байж гэнэ. Орой болж нар жаргахад бүсгүй айж, хоёр зуудаг нохойгоо гэрийнхээ хоёр талд уяад унтахаар хэвтэв.

Тэгтэл хоёр нохой нь боорч хуцаад нэг амьтан хүрч ирэх чимээ гарч байв. Бүсгүй, хүн мөн үү? Биш үү? гэж харсан чинь өрхөн дээр нь том толгойтой, алд хэртэй хэл унжуулсан амьтан зогсож байв. Бүсгүй айхдаа толгойгоо бүтээгээд хэвтэв. Удалгүй нөгөө амьтан хөгшдийн гэрт орж юм хошийг нь түжигнүүлж, түжигнүүлж байгаад чимээ тасарчээ.

Тэр өдрөөс хойш бүсгүйн бие муудаж, лам гэгээн залаад ч нэмэр болсонгүй нас баржээ. Бүсгүйг нас барсны дараа өнөө шулам дахин хүрч иржээ. Айлын залуу чимээ чагнаж хэвтгэл:

- Энэ шөнө яах вэ? Тогоонд нь орж хангинах уу? Халив дээр нь харайлах уу? гэсэнд нэг нь:

- Үгүй, Өрхөн дээр нь өнхөрье гэв. Бас нэг нь:

- Хэрэггүй. Нүдүүр дотор нь хэвтье гэв.

Тэгээд гурван шулам нүдүүр дотор орж хэвтэв. Залууд сайн юм болж, ухасхийн орноосоо босч манзыг нь авч нүдэж гарав. Нүдэж нүдэж гурван шулмыг жанз хийж даржээ.

Хар Цорж

Эрт урьд цагт Алшад хар Цорж гэдэг сүрхий номтой лам байжээ. Хар Цорж Утайд мөргөл хийхээр Ордын нутагт хүрч нэг айлд хоноод явахад айлын хүмүүс:

- Одоо манайхаас урагш нэлээд газар айл амьтан гэж байхгүй. Та их элстэй эзгүй тал туулна. Хоол ундаа сайн идэж, сүү савлаж аваад яв гэв.

Хар Цорж айлд цай хоол сайн идэж ууж, шанага сүү савалж аваад явав. Тэгээд өнөө эзгүй элсэнд орсон чинь өмнөөс нь олон үхэр тосоод ирж гэнэ. Тэр “Сая энэ айл ойр хавьд хүн мал байхгүй” гэж бодоод явж байтал, өнөө олон үхэр давхиж ирээд хар Цоржийг тойроод зогсчихлоо гэнэ. Хар Цорж түүнийг үзээд дотроо жаахан сэжиг аваад үхэртэй наадаж наадчихаад цаашаа явав. Жаахан яваад эргээд харсан чинь юу ч байхгүй байв.

Орой болж тэр хавьдаа хоноод өглөө нь босоод харсан чинь энд тэндгүй том том чулуу байв. Сайн харсан чинь юун чулуу байхав, хүний толгойны яс байв. Хар Цорж тоосонгүй гал түлж цай чанаж уучихаад явж байтал хоёр том гэр харагдав. Яваад очсон чинь нэг гэрт нь ном уншиж гүрэм хийж байв. Айлын дүгжир хариулсан гэрт ороод яхав гээд нөгөө гэрт нь ороход нэг сайхан зантай өвгөн угтаж:

- Та сайн морилж байна уу? Багш гэрт морилж саат гэж гэртээ залж оруулав. Хар Цорж айлын гэрт ороод цай ууж суутал өнөө цогжийн түгжил хийж байгаа лам номоо зогсоочихоод гэрт орж ирээд:

- Өө, нэг бадарчин ирсэн юм уу? гэхэд гэрийн эзэн:

- Тийм тийм, багш дээшээ суу гэхэд өнөө лам хэнэг ч үгүй хар Цоржийн өмнүүр өнгөрч дээд талд нь гарч суугаад:

- Чи хаанаас хаашаа явж байгаа хүн бэ? гэж асуув: хар Цорж:

- Би Зуугаас Утай орохоор явж байна гэж хариулав. Өнөө лам:

- Чи тэгвэл Зуугийн долоон түмэн ламын хуралд суусан уу? гэж асуухад нь:

- Суусан гэж хариулав. Лам:

- Өө тийм үү? Чи тэгвэл сүрхий лам байх нь. Энэ айлын бэр хүүхэн солио өвчин тусчихаад намайг залж цогжийн түгжил уншуулж байгаа юм. Би ч хүчрэх янз алга. Чи их газрын хүн байна. Чамд арга байна уу? гэхэд хар Цорж:

- Надад бас арга байхгүй. Би зөвхөн дамар л эргүүлдэг гэж хэлэв. Лам:

- Бололгүй яхав. Юу хийдэг бол түүгээрээ аргалчих гэв.

Айлын хүмүүс ч мөн хар Цоржийг аргалж өг гэж гуйгаад болохгүй болохоор нь аргагүйд хүрч догжир хаячихаад ловон уншив. Хэсэг уншиж байгаад:

- Тэр солиотой хүүхнээ аваад ир гэлээ. Айлын хүмүүс солиотой хүүхнийг оруулж ирэхэд, нөгөө солиотой хүүхэн хар Цоржийг харснаа:

- Намайг олон хүн дийлээгүй юм. Чам шиг бадарчин дийлэхгүй гэж орилж хашгирахад хар Цоржийн уур гэнэт хүрч, гэрийн эзэнд:

- Бүтэн боодол зүү, архи хоёр байвал аваад ир гэв.

Айлын эзэн хар Цоржид боодол зүү, лонх архи хоёр авчирч өгөхөд хар Цорж боодол зүүг амандаа хийгээд шажигнатал зажилж идээд араас нь лонхтой архиар даруулж уугаад:

- За, одоо наад солиотой хүүхнийхээ цамцыг тайлаад барьж бай гэв. Нөхөр, хадам ээж хоёр нь хүүхний цамцыг тайлж барихад бас нэг хутга авчруулаад хутганы мөрийг хазаж мөс шиг тачигнатал зажилж араас нь архи балгаад хүүхний цээжрүү тургисанд хүүхэн удалгүй солиорох нь гайгүй болж гэнэ. Лам түүнийг хараад:

- Энэ хүн их чадалтай хүн байна. Барьц өргөлөө сайн өгөөрэй гэж хэлэв. Гэрийн хүмүүс хар Цоржоос:

- Манайд өөр юу байна? гэж асуув. Хар Цорж би зүүд манадаг хүн. Маргааш өглөө хэлж өгье гэж хэлээд унтав.

Шөнө нь хар Цоржийн зүүдэнд өнөө солиотой хүүхэн орж, хадам ээжээсээ:

- Ээж ээ, би нэг морь, буу, торгон хувцсаа авья гэж хэлж байна гэнэ. Хар Цорж өглөө босоод гэрийн хүмүүст:

- Танай бэр та нараас нэг морь, нэг буу, торгон хувцсаа авья гэж гуйж байна гэхэд айлын эмгэн:

- Тийм тийм, тээр жил манай хүү дээрэмчин алаад морь, буу, торгон хувцсыг нь авч ирсэн юм. Тэрний сүнс бэрд минь шингэсэн байх нь гэж хэлэхэд, хар Цорж:

- Тийм байна. Тэр юмнуудаа хурдан устгах хэрэгтэй. Тэгвэл бэр чинь эдгэнэ гэж хэлжээ.

Айлын улс зөвшөөрч дөчин есөн цагаан ембүүгээр өргөл өгч явуулав. Хар Цорж цааш явж утайд мөргөчихөөд буцахдаа мөн айлаар ороход бэр хүүхнийх нь өвчин эдгэж эрүүл болоод ойр зуурынхаа ажлыг хийж байв. Айлын хүмүүс хар Цоржийг ирсэнд баярлаж:

- Багш таны ачаар манай бэр зүгээр боллоо. Та тэмээ авах уу? гэхэд хар Цорж авахгүй гээд байхаар нь айлын эзэн түүнд тавин цагаан зоос өгч явуулжээ.

Ийнхүү хар Цорж Утайд мөргөх замдаа нэг чөтгөрийг дарж, нэг айлыг аварч нэрд гарсан гэнэ.

Шулмын нүдэнд далай ширгэнэ

Эрт цагт хоёр хүүтэй нэг эмгэн байжээ. Эмгэн шулам болж хувираад айл амьтны адуу мал, байр бэлчээрийг сүйтгээд тун болох юм биш. Тэгээд хоёр хүү нь “Ээжийгээ яаж эрүүл болгодог билээ” гэж нэг мэргэн хүнээс асуув. Мэргэч мэргэлж үзээд:

- Та хоёр ээжээрээ шашин шүтүүлж, маани уншуулж яв. Тэгвэл дахин хүн болж хувирна гэв. Хоёр хүү гэртээ хариад ээждээ “Ум ма ни бад мэ хум” гэж маани зааж өгсөнд ээж нь “Манай хүн саяын хүн, манай хүн саяын хүн” гээд тун маани уншихгүй байв гэнэ.

Хоёр хүү нь аргаа барж ээжийгээ үүрээд сүмд очиж ном уншуулахаар явж байтал өмнө нь нэг их нуур таарав. Нуурын хажууд хэсэг бялзуухай буучихаад ус ууж байжээ. Түүнийг ээж нь үзээд:

- Хөөе, хурдан яв. Нуур хатчихна. Би цангаж байна. Надад уух ус үлдэхгүй юм байна гэж тийчилж гэнэ.

Иймээс монгол үгэнд “Шулмын нүдэнд далай ширгэнэ” гэдэг үг бий болжээ.

Долоон хүү ганц охинтой эмгэн өвгөн хоёр

Эрт урьд цагт Ар шил, Адуун гол гэдэг газарт, долоон хүү ганц хүүхэнтэй ядуувтар эхнэр нөхөр хоёр амьдардаг байжээ. Тэр хоёр хэдэн хүүхдээ тэжээхийн тулд өглөөнөөс орой хүртэл цөхрөлтгүй ажилладаг байв.

Нэг өдөр эхнэр нь аргал түүж явтал Ар шилд их бороо орж, Адуун голыг үерлүүлж, бүсгүйг аваад явчихаж гэнэ.

Түүнээс хойш залуугийн амьдрал улам хэцүү болж, өдөр шөнөгүй зүтгэж байж хүүхдүүдээ гарыг нь ганзаганд хөлийг нь дөрөөнд хүргэж, өөрөө ч хөгширч нас дээр гарчээ.

Өвгөн нэг удаа ууланд гарч ан гөрөө хийж байгаад нэгэн сайхан эмгэнтэй таарч, түүнтэй уулзаж танилцаад гэртээ авчирч хамт амьдрах болж хүүхдүүддээ хэлтэл, хэн нь ч зөвшөөрөхгүй байв. Сүүлдээ өвгөн хүүхдүүдээсээ зөрсөөр байгаад өнөө эмгэнтэй айл гэр болон суужээ. Уг нь бол тэр эмгэн хүн биш шулам байжээ. Өдөр ирэх бүр айлын эрх мэдлийг гартаа авч, сүүлдээ үнэн дүрээ харуулах болов гэнэ. Нэг өдөр эмгэн, өвгөнийг гадагш гарсан хойгуур хүүхдүүдэд нь:

- Та нарын эх чинь усанд үхсэн. Одоо та нар эхийнхээ араас очиж усанд амьдарцгаа гэж хэлээд долоон хүүг нь галуу болгон хувиргаж нууранд оруулаад, охин дүүг нь асга хадтай ууланд аваачиж өлсгөж алахаар хаяв.

Долоон ах нь галуу болсноос хойш өдөр бүр охин дүүдээ загас жараахай хүргэж тэжээдэг байв. Ингээд долоон хүү галуу болж хувираад охин дүүгээ тэжээж нэлээд олон жил болжээ. Нэг өдөр охин дүү нь:

- Энэ сүмд нэг лам бий. Тэр сүмд очиж мэргэн ламаас асуувал та нарыг хүн болгох аргыг зааж өгөх байх гэж хэлэв.

Ах дүү долоо охин дүүгийнхээ хэлснээр сүмд очиж, мэргэн ламд үнэн учраа хэлсэнд, лам мэргэлж үзээд:

- Та нар хүн болж хувирахад амархан. Энэ ууланд халгай гэдэг нэг зүйлийн ургамал бий. Түүгээр нэг, нэг хувцас хийж өмсвөл хүн болж хувирна гэж хэлжээ.

Ах дүү долоо галуу болсон болохоор халгай өвсөөр яаж хувцас хийж өмсөхөө мэдэхгүй гайхаж, охин дүүдээ очиж хэлэхэд:

- Ах нар минь ээ, та нар зүгээр л халгай өвсөө түүгээд ир. Би хувцас нэхээд өгье гэж хэлээд халгай өвс түүлгэж ах нартаа хувцас нэхэж гэнэ. Нэхээд байж, нэхээд байж.

Зургаан ахдаа нэхэж өгөөд долоо дахь ахдаа нэхэж байтал халгай өвс нь дуусч нэг ханцуйг нь дутуу нэхэж өгчээ. Ингээд ах нар нь халгай өвсөөр хийсэн хувцсаа өмстөл бүгд хүн болж хувираад харин хамгийн бага ахынх нь өрөөсөн далавч хэвээрээ үлджээ.

Далавчтай ах нь дүүгээ асга хадтай уулнаас тэвэрч буулгаад наймуулаа гэртээ харьж хөгшин

аавгайгаа уулзаж, эвгэй сайхан амьдарч гэнэ.

Таван настай хүү

Эрт урьд цагт эмгэн өвгөн хоёр, таван настай ганц хүүтэй байжээ. Хүү, аав ээжийгээ харж хандаж, асарч халамжилж байгаад насан өөд болгож гэнэ. Өнчирч хоцорсон жаахан хүү өдөртөө малдаа явахдаа ээж, аавыгаа санан “Аав аа? Ээж ээ?” гэж дуудаж явдаг болжээ. Нэг өдөр далайн хөвөөгөөр малаа хариулж яваад “Аав аа? Ээж ээ?” гэж хашгирч явтал далай дотроос цагаан толгойтой, цагаан морь унасан өвгөн гарч ирээд:

- Хөөе, жаалхүү! Чи юунд хашгираад байгаа юм бэ? гэж асуусанд, хүү:

- Өвөө, миний аав, ээж өөд болчихлоо. Би аав, ээжийгээ амьдад нь гомдоосонгүй, сайхан харж асарч явсан. Одоо үгүй болчихсон гэж хэлжээ. Цагаан морьтой өвгөн сонсоод толгой дохиж:

- Чи тэгвэл их сайн хүү байна. Аав, ээжийгээ амьд сэрүүн байхад нь гомдоолгүй, харж асарч яваад, өнгөрснийх нь дараа бас санаж дурсаж явдаг чинь сайна байна. Одоо чи аав, ээжийгээ дуудаж хашгирах хэрэггүй. Маргааш өглөө энэ газартаа хүрээд ир. Би буян хийж өгье гэж хэлээд далайдаа буцаад орчихож гэнэ. Маргааш өглөө нь жаахан хүү хэдэн ямаагаа туугаад далайн хөвөөн дээр хүрээд ирсэнд, өнөө цагаан морьтой өвгөн ирчихсэн түүнийг хүлээгээд сууж байжээ. Өвгөн:

- За, хүү минь өнөөдөр би чамайг аваад далайд орж, лусын хаантай уулзуулна. Чи нүдээ аниад, миний араар морд гэж хэлжээ. Жаалхүү дотроо ихэд гайхаж байсан боловч өвгөний хэлсэн ёсоор нүдээ аниад араар нь сундлав. Тэгтэл морь нь харайх шиг болоод далайруу орчихож гэнэ. Удалгүй далайн ёроолд ороод мориноосоо бугаад нүдээ нээгээд үзсэн чинь далай дотор морин толгойтой хүн, тэмээ толгойтой хүн, могой толгойтой хүн, мэлхий толгойтой хүн гээд баахан хүн байх юм гэнэ. Хүү дотроо “Энэ ямар сонин, сонин толгойтой хүн бэ?” гэж гайхтал цагаан морьтой өвгөн:

- За, хүү минь! Одоо лусын хааны ордонд ирсэн шүү. Лусын хаан туйлын баян амьтан байдаг юм. Түүнд алт мөнгө, шүр сувд тоо томшгүй байдаг юм. Чи тэдгээр юманд нь огт дурлаж болохгүй. Харин түүнд нэг жижигхэн ногоон хайрцаг байдаг юм. түүнийг нь л авья гэж гуйгаарай гэж захиад лусын хааны ордонд оруулав. Жаалхүү үүнийг гайхаж, түүнийг харж явсаар лусын хааны өмнө хүрч очив. Лусын хаан түүнийг үзээд:

- За, хүү минь, Чи юу хийхээр ирэв? гэж асуухад нь хүү:

- Би хөгшин аав, ээжийгээ гомдоолгүй харж асарч байгаад насан өөд болгов. Дараа нь би аав ээжийгээ санан гашуудаж, дуудан хашгирч явтал далай дотроос цагаан толгойтой, цагаан морьтой өвгөн гарч ирээд, намайг нааш нь авчирлаа гэж хэлэхэд нь лусын хаан түүнийг сонсоод:

- Тэр цагаан морьтой хүн чинь миний элч байгаа юм. Тэгвэл чи их сайн хүү байна. Эцэг, эхийгээ амьд сэрүүнд ачилж халамжилж байгаад нас барсных нь дараа санан дурсаж байдаг чинь сайн хэрэг. Одоо би чамд тус больё. Чи миний ордон дотроос дуртай зүйлээ ав гэж хэлэв. Жаалхүү ордон доторхыг эргүүлж тойруулж хартал, тэнд ч алт мөнгө, энд ч шүр сувд

овоолгоотой байх ба нэг жижигхэн ногоон хайрцаг нүдэнд нь тусав. Хүү цагаан морьтой өвгөний захиасыг санаж:

- Хаан аав аа? Би танаас зөвхөн тэр ногоон хайрцгийг чинь л авъя. Өөр зүйл авахгүй гэхэд, лусын хаан гайхасхийж:

- Үгүй, хүү минь, чи миний ордонд ийм их эрдэнэс байхад яагаад тэр муу жижигхэн ногоон хайрцгийг авах гэдэг юм? гэж асуухад, хүү:

- Надад тэр хайрцаг л болчихно. Та түүнийгээ л надад өгчих гээд гуйж мөргөөд байжээ. Лусын хаан “Энэ хүү яасан сүрхий амьтан бэ? Энэ их алтан эрдэнэс байхад тэр муу жижигхэн ногоон хайрцгийг сонирхоод байдаг” гэж бодоод, аргагүйдэж:

- За, яахав, хүү минь чи алт мөнгө сонирхдоггүй сайн хүү байна. Би чамд ногоон хайрцгаа өгье. Чи энэ хайрцгийг гэртээ аваачиж тахиж, шүтээрэй. Тэгвэл чиний хийморь чинь сэргэж, хишиг буян чинь дэлгэрнэ. Харин дураараа нээж огт болохгүй. Цаг нь болохоор өөрөө нээгдэнэ гэж захиад хүүд ногоон хайрцгаа өгчээ. Жаалхүү ногоон хайрцгаа тэврээд лусын хааны ордноос гарч ирэхэд цагаан морьтой өвгөн хүлээж байв. Тэр жаалхүүг бас араараа суулгаад далайгаас гаргаж өгч гэнэ. Түүнээс хойш жаалхүүгийн хэрэг зориг аяндаа бүтдэг болж, идэж уух, өмсөж зүүхээр дутахаа больж, амьдрал нь өдрөөс өдөрт дээшилсээр нэлээд олон жил болов. Өсч том болоод, арван хэдтэй болж, ухаан орсон хүү нэг өдөр гэнэт “Энэ олон жил болоход ногоон хайрцгийг ганц ч удаа нээж үзсэнгүй. Дотор нь юу байдаг юм бол?” гэж бодоод ногоон хайрцгаа нээгээд үзтэл дотор нь юу ч байсангүй. Түүнээс хойш жаалхүүгийн амьдрал өдрөөс өдөрт муудсаар хуучин хэвэндээ хүрчихэж гэнэ. Уг янзандаа орсон жаалхүү аав, ээжээ санан өдөр бүр хэдэн ямаагаа хариулж явахдаа аав, ээжийгээ дуудан хашгирч явдаг болж гэнэ. Тэгээд нэлээд хэдэн жил болжээ. Гэнэт нэг өдөр малын хажууд нь шар морьтой хүн хүрч ирээд:

- Хүүе, жаалхүү? Чи юунд өдөр бүр хашгирч явдаг юм бэ? гэж асуухад нь, жаалхүү өнгөрсөн бүх амьдралд нь болсон бүх үнэн учраа ярьж өгөв. Шар морьтой хүн түүнийг сонсоод:

- Өө, тийм үү? Тэгвэл гэрт чинь очиж үзье гэж хэлээд, хүүтэй хамт гэрт нь очиж үзээд байдлыг мэдчихээд, явахдаа:

- За, хүү минь, чи бол лусын хааны үгэнд оролгүй, ногоон хайрцгийг нээж үзээд буян чинь үгүй болжээ. Гэвч чи шударга сайн хүү байна. Маргааш чи малаа баруун хойш нь бэлчээж хариулаарай. Тэнд нэг дэр шиг цагаан чулуу бий. Түүнийг дэрлээд унтаарай гэж хэлээд явчихав гэнэ. Маргааш нь хүү хэдэн ямаагаа баруун хойш нь бэлчээгээд хариулж явтал үнэхээр нэг дэр шиг цагаан чулуу таарч гэнэ. Хүү түүнийг үзээд шар морьтой хүний хэлсэн ёсоор дэрлээд унтжээ. Нэг сэрээд үзсэн чинь мал нь сайхан тогтоод идээшилж байх ба хажууд нь гурван цагаан гэр барьчихсан байжээ. Хүү түүнийг үзээд гайхаж “Энэ чинь ямар сонин юм бэ? Хэдийдээ хэн ирээд гэр барьчихсан юм бол?” гэж бодоод гэрийн хажууд очиж, хамгийн зүүн гэрийн үүдийг сөхөж үзвэл гэр дотор нь туйлын хөөрхөн ногоон торгон дээлтэй охин гэгээ самнаад сууж байна гэнэ. Хүү түүнийг хараад баярлахдаа үг дуугүй айлын гэрт үсрэн орж очтол, охин цочиж:

- Таны орж ирэх цаг арай болоогүй байна шүү дээ. Та юунд ороод ирэв ээ? гэж асуухад нь хүү жаахан эвгүйрхэж байснаа, нэгэнт гэрт ороод ирчихсэн болохоор гэрийн баруун талд суугаад:

- Танайх чинь хэнийх гэдэг айл вэ? гэж асуув. Охин түүнийг нэг сайн харснаа:

- Та чинь намайг танихгүй байгаа юмуу? Би лусын хааны гүнж байна. Таны хоолыг олон жил бэлдэж өгсөн байтал танихгүй байна уу? Хэрвээ та лусын хааны үгэнд орж, ногоон хайрцгийг дураараа нээгээгүй бол би аль эрт гарч ирэх байсан юм. Аав, миний ахаас чиний шударга занг олж мэдээд сэтгэл нь хөдөлж, намайг дахин явуулсан юм гэж хэлэв. Хүү түүний үгийг сонсоод ихэд гэмшиж, үг дуугүй толгойгоо унжуулж зогстол гэрийн гадаа олон адуу пижигнэх чимээ гарчээ. Хүү, охин хоёр гэрээс гарч харсанд өнөө шар морьтой хүн олон адуу тууж ирээд, бүгдийг зэллэж уяачихаад гэрт орж ирээд, охиныг зааж:

- За, энэ бол миний төрсөн дүү, чи одоо үүнийг эхнэрээ болгож аваад айл гэр болон суу. Би та хоёрт нэг сүрэг адуу тууж ирлээ. Энэ сүрэг адуу та нарын амьдралд хүрнэ гэж хэлээд гарч явав. Хүү, эхнэрээ дагуулан гэрээсээ гарч ирээд хартал өнөө шар морьтой хүн бараа сураггүй алга болчихсон байжээ. Адуунууд нь алтан шон, мөнгөн шон хоёр дээр уяатай байв гэнэ. Хүү адуунуудаа алтан шон, мөнгөн шон хоёроос суллаж тавьсанд, алтан шон нь шар бударгана болж, мөнгөн шон нь цагаан бударгана болж хувирсан гэнэ. Тийм учраас монгол хүн улаан бударгана гэдэг ургамлаас унаа малаа уядаг болсон гэдэг. Улаан бударгана, хэдий догшин унаанд ч булгардаггүй юм гэнэ. Ийнхүү жаалхүү ээж, аавыгаа амьд сэрүүнд нь хайрлаж, ачилж байсан болохоор лусын хааны ач ивээлд орж, жаргалтай сайхан амьдарсан юм гэдэг.

Ах дүү гурав

Эрт урьд цагт өвгөн, эмгэн хоёр хурван хүүтэйгээ амьдардаг байжээ. Гурван хүүгийнх нь гар нь ганзаганд, хөл нь дөрөөнд хүрэхэд, аав нь:

- За, одоо миний хүүхдүүд өөр өөрийн амьдралын замаа хайхаар явцгаа гэж хэлээд гурван хүүгээ гэрээсээ явуулжээ.

Ах дүү гурав гэрээсээ гарч явсаар, гурван салаа замын эхэнд хүрч гэнэ. Тэгээд ах дүү гурав салаа замын уулзвар дээр нэг, нэг зандан мод тарьчихаад том ах нь хамгийн зүүн талын замаар явж, бага ах нь дунд замаар нь явж, хамгийн бага дүү нь баруун талын замаар нь тус тус явцгааж гэнэ.

Хамгийн бага дүү нь явж явж нэгэн айл таарч орсонд нэг эмгэн, охинтойгоо сууж байв. Тэд хүүг:

- Хаанаасаа хаана хүрэхээр явж байна? Хэрэг зориг юунд? Хэт нутаг хаана вэ? гэж асуув. Хүү:

- Би гэртээ ах дүү гурвуулаа амьдарч байлаа. Биднийг өсч том болсонд аав, ээж хоёр минь биднийг өөр өөрийн амьдралын замаа олж амьдар гэж явууллаа. Тэгээд би өөрийн амьдралын замаа хайж явна гэж хэлэхэд, эмгэн сайхан загнаж:

- Яасан сайн юм бэ? манайд хүн дутаад байгаа юм. Чи манайд хүргэн болж суу! гэж хэлээд нүдний чинээ жижиг тогоонд гурван цагаан өвс чанаад хоол хийж өгөв. Тэр цагаан өвс нь сахиусны өвс байжээ.

Залуу ч өөр явах газаргүй тул тэр айлд хүргэн болж суужээ. Тэр айлын хажууд нэг сайхан булгийн ус урсаж байдаг юм байж. Залуу өдөр болгон эхнэртэйгээ тэр булгийн усанд очиж нүүр гараа угаадаг байжээ.

Нэг өдөр, залуу эхнэртэйгээ булгийн усанд нүүр гараа угаачихаад харьтал эхнэр нь алтан бөлзгөө булгийн хажууд мартаад орхижээ. Бүсгүй гэртээ харьсны дараа бөлзгөө гээснээ мэдэж нөхөртөө хэлтэл, нөхөр нь:

- Өө, тийм үү? Би очиж аваад ирье гэж хэлээд булгийн ус руу явж гэнэ. Залуу тэр булгийн хажууд очиж явтал гэнэт тэнгэр бүрхэж их аянга дуугарч, гялбаан гялбаад ширүүн бороо бууж, үер ирээд алтан бөлзгийг нь урсгаад явчихаж гэнэ.

Тэр үер алтан бөлзгийг урсгасаар нэг харгис ноёны хүрээлэнд хүргээд хаячихжээ. Түүнийг ноёны адуучин адуугаа хариулж яваад олж ноёндоо хүргэжээ. Ноён тэр алтан бөлзгийг үзээд:

- Ямар сайхан алтан бөлзөг вэ? Энэ алтан бөлзгийг ерийн хүн зүүх ёсгүй. Лавтай нэг дагина хүнийх байх. Чи одоо хурдан явж, эзнийг нь олоод ир гэж хэлээд адуучнаа явуулжээ.

Ноёны адуучин нь мөрөөрөө буцаж очоод үертэй голыг дагаж явсаар байгаад булаг дээр хүрч өнөө охиныг олоод очтол, тэр охин туйлын хөөрхөн хүн байжээ. Ноёны адуучин буцаж очоод

ноёндоо хэлтэл, ноён түүнийг сонсоод тэр охиныг хатнаа болгож авья гэж горьджээ. Тэгээд даамай удсангүй ноён нэг шалтаг гаргаж охиныд хүрч, охиныг таалж авч явах гэсэнд, залуу зөвшөөрсөнгүй. Түүнд ноён муу арга гаргаж, залууг хорлож авгайг нь булааж авахаар болжээ. Нэг өдөр ноён залууг авгайтай нь хамт дуудаж ирээд, нэг модон сагс дээр дээс уяад:

- За, залуу минь, миний газар нутаг багадаад адуу мал багтахаа болилоо. Та нар одоо энэ сагсанд суугаад доод тивд очиж амьдар, тэр газар чинь жаргалангийн ордон шүү гэж хэлээд залууг барьж авгайтай нь хамт нэг сагсанд хийгээд худгийн ам шиг нүхэнд тавиад явуулах гэжээ. Охин, ноёны муу санааг мэдээд нөхөртөө:

- За, та эрэгтэй хүн, хүндээрээ дээр нь суу, би эмэгтэй хүн, хөнгөнөөрөө доор нь сууя гэж хэлэхэд залуу, авгайнхаа үгний учрыг олсонгүй, эхнэрээ дарчихна гэж айгаад:

- Би хүндээрээ доор нь сууя, чи хөнгөнөөрөө дээр нь суу гэж хэлэв. Энэ үед зальтай ноён охины санааг ухаж мэдээд:

- За, юуг нь булаалдаад байдаг юм. Залуу хүн хүндээрээ доор нь суу, охин хүн хөнгөнөөрөө дээр нь суу гэж хэлээд, залууг нь доод талд нь суулгаад, зарц нараа:

- Хурдан тавь, тавь! гэж хашгирсанд, охин залуу хоёрыг нүхэнд тавьж оруулжээ.

Тэгтэл мэхтэй ноён нүх уруу орсон охины гараас барьж аваад өөд нь таттал, зарц нар нь залууг сагстай дээстэй нь хамт нүхний ёроолд явуулав. Тэгээд харгис ноён зорьсондоо хүрч, залуугийн эхнэрийг булааж өөрийн хатнаа болгожээ. Залуу нүхний ёроолд унасан хүчиндээ хөлөө хугалчихжээ.

Тэгээд тэр хугархай хөлтэйгөө нүхний ёроолд “Одоо яадаг билээ” гэж хэсэг арга барж, хэвтээд харсан чинь нүхний ёроол харин их сайхан тал газар байжээ. Залуу “Энэ чинь чухам доод тивд ирчихжээ. Одоо яаж байгаад нэг босч явъя даа?” гэж арга яадан хэвтэж байтал, нэг доголлон үнэг дэгэн догон хийж явсаар нэг том чулууны хажууд хүрч өнөө чулууг хэсэг тойрч шөргөөчихөөд зүгээр болж аваад явчихаж гэнэ. Тэгж байтал бас нэг доголлон чоно гүйж ирээд тэр чулууг үнэртэж, тойрч шөргөөж шөргөөж, зүгээр болоод явчихаж гэнэ. Залуу түүнийг үзээд “Энэ чулуу лав учиртай чулуу байна. Би ямар нэг аргаар чулууны хажууд нь хүрч очвол миний хөл ч эдгэж мэднэ” гэж бодоод өнөө чулууруу хугархай хөлөө чирээд мөлхөж явжээ. Тэгээд мөлхсөөр мөлхсөөр нөгөө чулууны дэргэд иржээ. Чулууны хажууд хүрээд үзсэн чинь өнөө чулууны дээр нь жаахан булаг ус байна гэнэ. Залуу цангаж байсан тул өнөө уснаас ханатлаа ууж авчихаад чоно, үнэгийг дуурайж хугархай хөлөө чулуунд шөргөөв.

Нэг шөргөөхөд хөлийн өвчин нь багасч, бас нэг шөргөөхөд улам намдаж, гурав шөргөөхөд хөл нь гүйцэд эдгэж гэнэ.

Залуу хөлөө эдгээж аваад “Эхнэр минь одоо юу болж байгаа бол?” гэж бодоод нүхнээс гарах гэж мацсан боловч тун гарч чадсангүй. Тэгээд арга барагдаж, талаар хаашаа хамаагүй тэнүүчилж явгал замд нь том чулуу таарчээ. Чулууг холдуулаад явах гэтэл доороос нь могойны толгой цухуйж харагджээ. Залуу гайхаж “Энэ могой яагаад энд дараатай байдаг юм бол?” гэж бодоод могойноос:

- Чи юунд чулуун доор дараатай хэвтэж байгаа юм бэ? гэж асуусанд, могой:

- Өө, харин дээд тивийн ноён миний эд хөрөнгөнд шунаж намайг чулуугаар дарж хаялаа. Энэ чулуу ч айх юм биш байна. Харин миний духан дээр наасан цаас л сүрхий юм байна. Чи хэрвээ түүнийг аваад хаячихвал бусдыг би өөрөө аргалчихна гэж хэлжээ.

Залуу могойны духан дээрх цаасыг сайн хартал маанийн үсэгтэй цаас байжээ. Тэгээд залуу өнөөх номын үсэгтэй цаасыг хуулж авгал гэнэт их чимээ гарч могойны дээрээс дарсан чулуу түсхийгэл бяцарч хагарав гэнэ. Могой чулуунаас салаад баяр хөөртэй босч ирээд өнөө залуутай ах дүү барилдаж, түүнийг гэртээ залж гэнэ.

Могойны таван хошуу малыг хотгороор хэмжихээс тоолж барахын аргагүй, алт мөнгө гэрээр нь дүүрэн хураалттай байжээ. Залуу ч гэрээсээ төөрөөд явах газаргүйдээ могойны гэрт сууж мал адууг нь маллаж гурван жил болжээ. Дараа нь залуу, могойд:

- Могой ах аа, би одоо гэр орноосоо салаад гурван жил болж байна. Гэрийнхэнтэйгээ уулзмаар байна гэж хэлсэнд, могой:

- Чи бол миний амийг аварсан ачит хүн мөн. Тиймээс би чиний ачийг хариулах ёстой гээд залууд нэг эрдэнийн үрэл өгч “Энэ үрэл бол санасан бүхнийг биелүүлдэг ид шидтэй үрэл юм. Тиймээс чи хүслээ залбирч хэлэхэд л хангалттай” гэж хэлэв.

Залуу өнөө эрдэнийн үрлийг авч “Одоо би дээд тивд гарч гэр бүлдээ очмоор байна” гэж залбиртал тэр дороо дээд тивд нисээд гарчихаж гэнэ. Залуу дээд тивд гараад шууд харгис ноёныд хүрч ордонд орох гэтэл огт оруулдаггүй гэнэ. Залуугийн уур хүрч ноёны харуултай хэрүүл хийжээ.

Түүнийг эхнэр нь олж сонсоод ноёны ордноос гарч ирээд нөхрөө таньж авчээ. Залуу хэрүүл хийсэн хүн болж байгаад захад нь ойртож очоод завшааныг далимдуулж эхнэрээсээ:

- Чи надаас сэтгэл хувирсан уу? гэж асуухад эхнэр нь

- Би өчүүхэн ч сэтгэл хувираагүй гэжээ. Залуу баярлаж:

- Тэгвэл аргалж байгад эндээс хурдан зугтаая гэхэд эхнэр нь

- Хүүе, тэнэг минь! болохгүй, ийм олон харуул байхад яаж зугтах юм. Харин ямар нэг завшаан олох хэрэгтэй гэж хэлжээ.

Тэгтэл ноёны харуул хүрч ирээд:

- Чи муу хурдан ордны дэргэдээс зайл! Юу хийгээд манай хатантай зууралдаад байгаа юм гэж хараагаад хөөжээ.

Залуу харуулыг явсны дараа морины хашаанд орж эрдэнийн үрлээ гаргаж морины хашааг хааны ордон шиг засч, өөрийн биеэ хаан шиг чимээд сууж байв.

Харгис ноён шөнө гадаалж яваад морины хүрээнд нь их гэгээ гарч дуу хөгжим шуугиж байхыг үзээд гайхаж очиж харсанд нэг хаан ширээн дээр суучихсан найр наадам хийж байна гэнэ. Түүний морины хашаа нь харин өөрийн ордноос ч сайхан хааны ордон болчихсон байна гэнэ. Ноён учрыг олохгүй яваад орсонд тэр дороо гэгээ шуугиан юу ч үгүй болж морины хашаа хуучин янзаараа байж байна гэнэ. Ноён учрыг олохгүй ордондоо ирж хатандаа үзсэн харснаа яриад:

- За чи очиж үзээд ир. Юу байна гэж хэлээд хатнаа явуулжээ. Хатан яваад морины хашаанд ортол нөхөр нь эрдэнийн үрлээ гаргаж нэг залбирсанд тэр хоёр гэртээ хариад ирчихжээ.

Цааш яваад ах дүү гурвын салсан зам дээрээ очсон чинь өөрийн тарьсан зандан мод нь сагалгар болтлоо ургаж хоёр ахынх нь тарьсан мод үжрээд уначихсан байна гэнэ. Залуу гайхаж хоёр ах минь одоо яаж байгаа бол гэж бодоод цааш явж байтал хоёр ах нь баяжаад хөл хөөртэй явж байхтай таарчээ. Тэд хотоор мал тууж, хомоор ачаа ачсан явна гэнэ. Залуу хоёр ахыгаа гүйцэж ирээд хамт явах гэсэнд хоёр ах нь:

- Чам шиг олиггүй амьтан бидний хажууд битгий яв. Бид ингэж баяжсан байхад чиний олсон юм хаана байна? Хүний нүүр барах амьтан гэж хэлээд дүүгээ хөөж явуулжээ.

Дүү нь ах нартаа гомдож цааш хэсэг яваад үнэн дүрээ үзүүлэхээр эрдэнийн үрлээ гаргаж залбираад хаан болон хувирч хоёр ахынхаа өмнүүр гарчээ. Тэгээд буцаж очсонд хоёр ах нь дүүгээсээ:

- Сая чиний өмнүүр нэг хаан өнгөрөв үү? гэж асуухад дүү нь:

- Юм үзсэнгүй гэж хариулжээ. Хоёр ах нь түүнийг сонсоод улам уур нь хүрч:

- Буянгүй амьтанд хаан ч харагддаггүй юм байна. Чи одоо хол яв. Бидний буянг битгий барчих гэж зандраад хөөжээ. Дүү нь “Манай хоёр ах ч манайг халгаах янзгүй” гэж бодоод хол явж эрдэнийн үрлээ гаргаж залбираад тэр газрын хаан болж суужээ.

Ингээд нэлээд олон жил болжээ. Нэг өдөр залуу эхнэртээ:

- За өнөөдөр манайд дөрвөн гуйранч ирнэ. Чи тэднийг залаад ир гэжээ. Эхнэр энэ үгийг сонсоод учрыг ойлгосонгүй сууж байтал, удсан ч үгүй харуул гүйж ирээд:

- Хатантаан? Гадаа дөрвөн гуйранч ирлээ гэж мэдүүлэхэд хатан түүнийг сонсоод хааны хэлсэн үг үнэн болохыг мэдээд:

- Хурдан гэрт оруулаад ир гэж хэлээд ордондоо залжээ.

Гэтэл тэр дөрвөн гуйранч нь хааны аав, ээж, хоёр ах нь байж гэнэ. Учир нь хоёр ах нь дүүгээ хөөж явуулаад, адуу малаа тууж, аав, ээждээ очсоны дараа ган гачиг болж бүх адуу мал нь барагдаж амьдрах аргагүй болсон байжээ.

Дүү нь хоёр ахдаа хэдий гомдсон боловч, өс санасангүй аав, ээж, ах нартайгаа уулзаж сайн сайхан жаргалтай амьдарсан гэнэ.

Мэлхий хүү

Эрт урьд цагт үр хүүхэдгүй эмгэн, өвгөн хоёр амьдран суудаг байжээ. Өвгөн нь их ааш муутай юм гэнэ. Тэр үргэлж эмгэнээ хүүхэд төрүүлсэнгүй гэж харааж загнадаг байв.

Нэг намар өвгөнөө аянд явсан хойгуур эмгэний гарын алга загатнаад болохоо байчихав. Эмгэн гарынхаа алгыг маажиж суутал дороос нь мэлхий гараад иржээ. Эмгэн мэлхийг үзээд “Мэлхий ч миний үр” гээд манцуй оёж манцуйлаад хүүхэд шиг арчилж суудаг болж гэнэ. Хэдэн сарын дараа өвгөн нь аянаасаа буцаж ирэхэд эмгэн:

- Өвгөөн бид үртэй болсон шүү гээд манцуйтай мэлхийгээ харуулсанд өвгөн үзээд ихэд уурлаж:

- Пэй. Бузар гэм. Чи чинь яасан муухай юм гаргадаг юм бэ? гэж хэлээд өнөө мэлхийг алах гэтэл эмгэн нь:

- Тэгвэл та өөрөө мэд. Бид хоёр үр хүүхэдгүй арга ядаж байхад мэлхий ч гэсэн үр заяасан байхад та ална гэж байдаг хэмээн уйлахад өвгөн зөрүүдэлж ална гээд хутгаа гаргаж мэлхийг дүрэх гэтэл мэлхий гэнэт:

- Аав аа , та намайг алах гэж байгаа бол нүдүүрэнд хийгээд цохиж ал. Тэгэхгүй бол би үхэдгүй юм гэж хэлжээ.

Өвгөн мэлхийг нүдүүрэнд хийгээд цохих гэтэл нүдүүрнээсээ бултгас гээд гараад ирэв. Дахиад хийсэнд мөн л бултгас гээд гарч ирээд тун болсонгүй. Өвгөн түүнийг үзээд элгээ хөштөл инээгээд:

- Энэ муу золигийг чинь алахаа больчихъё гэж хэлээд алсангүй гэнэ.

Хавар болж өвгөн тариа тарихаар явах болсонд мэлхий:

- Аав аа, би явж тариа тарья гэхэд өвгөн:

- Элэнцгийн чинь тариа тарих. Чи тариа тарьдаг байсан бол би юунд ингэж зовж явах билээ гээд үгийг нь тоож авсангүй.

Эмгэн үүнийг хараад:

- Хүүхэд ажил хийнэ гэж байхад сайн хэрэг биш үү. Яваг яваг гэж хэлээд мэлхий хүүг газар хагалдаг хар илжигнийхээ чихэн дээр суулгаад явуулжээ.

Тэгсэн чинь мэлхий хүү илжгийг унаад нааш цааш нь явуулж, тариа сайхан тарьж, өвгөнд их тус болжээ.

Ингээд гурван жил болжээ. Нэг өдөр, мэлхий хүү:

- Аав аа, ээж ээ? Энэ хойд зүгт нэг хөөрхөн охинтой айл байна. Би тэр охиныг эхнэрээ болгож

авна. Та хоёр сүй төхөөрөөд өгөөч гэж гуйсанд өвгөн:

- Цөг гэм. Чи эхнэр авчих байсан бол бид юунд зүдэрч байдаг юм. Би лав төхөөрч өгөхгүй гэж зандраад зоос мөнгө юу ч өгсөнгүй. Эмгэн нь аргагүйдэж:

- Байг байг. Та төхөөрөхгүй юм бол би төхөөрье. Яасан ч миний гаргасан үр гэж хэлээд өөрт байсан таван лан мөнгөө гаргаж даалинд хийж мэлхий хүүдээ өгч явуулжээ.

Мэлхий хүү өнөө айлд хүрч очиход айлын нохой хуцаж эхэлжээ. Айлын өвгөн гарч хараад:

- Өмнө айлын хар илжиг гадаа ирчихсэн зогсож байна гэхэд эмгэн нь гарч хараад:

- Тэр хоосон айлын мэлхий хүү хар илжигнийхээ чихэн дээр суучихсан ирж байна гэхэд өвгөн нь:

- Муухай амьтныг хөөж явуулья гэхэд эмгэн нь:

- Хөөж болохгүй ирчихлээ гэж хэлээд мэлхий хүүгийн ачаа хөсгийг дэмнэж буулгаад гэртээ оруулжээ.

Мэлхий хүү айлд ороод учир байдлаа хэлсэнд эмгэн нь дуугүй суугаад байв. Харин өвгөн нь ихэд уурлаж:

- Чам шиг шулам миний хүүхнийг авна гэнэ ээ. Одоохон чамайг алчихья гээд дайрахад мэлхий:

- Та намайг ална гэвэл алж болно. Гэхдээ намайг тээрмийн нүхэнд хийж цохь. Үгүй бол би үхдэггүй юм гэжээ.

Өвгөн мэлхий хүүгийн хэлснээр тээрмийн нүхэнд хийгээд цохих гэтэл мэлхий бултгас гэж гарч ирээд тун цохих завшаан өгөхгүй байв. Түүнийг үзээд айлын хүмүүс элгээ хөштөл инээгээд, өвгөн нь охиноо:

- Муу хүүхэн чи дагах дуртай бол хурдан дагаад арил гэж хараагаад охиноо мэлхий хүүтэй хамт хөөж явуулжээ.

Мэлхий хүү охиныг хар илжгэн дээрээ мордуулаад гэртээ харьж явах замдаа нэг сайхан хавтгай мод олоод, охинд:

- За, чи энэ дээр унтаж бай. Би гэртээ хариад ирье гэж хэлээд даалингаа өгч дэрлүүлээд явчихаж гэнэ.

Охин унтаж унтаж нэг сэрсэн чинь хавтгай модон дээр таван ханатай сайхан гэр босчихсон, тойроод таван хошуу мал бэлчиж байв гэнэ. Охин гэрт орж үзэхээр хажууд нь очсоноо: “Энэ арай чөтгөрийн гэр биш биз” гэж хэсэг тээнэгэлзэн зогсож байгаад “За юу болвол болог” гээд хөгшдийн хэлдгээр: “Чөтгөрийн гэр буюу хойшдын заяагаа гэрийн буруу хатавчаар нь сөхөж үздэг юм гэсэн” гэж бодоод гэрийн зүүн талаар очиж, үүдийг нь сөхөж харвал гэр дүүрэн эд

хогшил хураасан байх ба мэлхий хүү өндөр цагаан залуу болж хувираад нааш цааш холхиж байжээ. Охин гэрт гүйн орж залууг тэвэрч аваад:

- Миний хань чинь ийм сайхан хүн байсан юм уу? гэж хэлэхэд, залуу инээмсэглээд:

- Одоо энэ бүхэн бүгд бид хоёрынх болсон гэж хэлээд эхнэртээ хуримын учраа хэлэлцэж, хорин хүний зарцтай, наян хүний дагуултай, сарын хурим хийж, түмэн хүн залахаар тогтжээ.

Мэлхий хүү эхнэртэйгээ аав ээжийгээ хуримдаа залж, шинэ гэрийн цай уулгах гэсэнд аав нь:

- Би очихгүй гээд явсангүй. Ээж нь:

- Хөөрхий миний үр айл гэр болж байхад очиж хүүгийнхээ шинэ гэрийн цайг ууна гээд мэлхий хүүгийнхээ шинэ гэрт очиж цайг нь уужээ.

Тэр жилийн хавар орчлон дэлхий дулаараагүй байтал гэнэт луу дуугарч бороо орж, солонго бууж иржээ. Мэлхий хүү эхнэртэйгээ ээжийгээ аваад солонгын дээр гарч суугаад тэнгэрт гарч амьдрахаар явжээ.

Муу санаатай өвгөн тэндээ үлдэж насаараа тариа тарьж амьдарсан гэдэг.

Учир нь мэлхий хүү бол лус байсан бөгөөд сайн санаатай эмгэнд хүү болж заяажээ. Мэлхий хүүгийн шинэ гэрийн цай бол рашаан байсан бөгөөд түүнийг уусан хүн бүр сахиус болж, тэнгэрт гарч амьдрах хувь заяатай байжээ.

Тиймээс монгол хүн үр хүүхэддээ “Хүнд битгий муу юм сана”, “Сайн санааны үзүүрт тос, муу санааны үзүүрт ёр” гэж сургаж захисаар иржээ.

Цоохор тугалтай эмгэн

Эрт урьд цагт ганц цоохор тугалтай эмгэн байжээ. Эмгэн цоохор тугалаа шар өвстийн хөндийд хариулдаг байв.

Нэг өдөр эмгэн цоохор тугалаа хариулж тугал нь онцгой сайхан тогтож гэнэ. Тэгээд эмгэн гэртээ харьж жаахан юм уучихаад ирье гэж дөнгөн данган явж гэртээ иртэл гэнэт харанхуй хар салхи босчээ. Эмгэн сандарч тэр дороо цай ч уусангүй буцаж тугал байсан газраа иртэл салхи ч зогсож гэнэ. Тугал ч бараа сураггүй алга гэнэ.

Эмгэн тугалаа алдчихаад уйлж унжин хайж явтал өмнө толгой дээр нэг том хүн сууж харагдав. Эмгэн яваад хүрч очиход тэр хүн эмгэний өмнөөс нь:

- Хөгшөөн, та юунд уйлж байгаа юм бэ? гэж асуухад эмгэн:

- Би ганц цоохор тугалаа алдчихаад айж явна гэсэнд тэр хүйтнээр инээж:

- Намайг мангас гэдэг. Цоохор тугалыг чинь би идчихсэн. Энэ орой чамайг ч бас барьж иднэ. Мэдэв үү? гэж хэлжээ.

Эмгэн үүнийг сонсоод газар тэнгэр нийлэх шиг болж айн чичирч гэр уруугаа буцаж явтал замд нь нэг шөвөг таарч гэнэ. Тэр шөвөг эмгэнээс:

- Хөгшин ээж ээ? Та юунд уйлж байгаа юм? гэж асуухад нь эмгэн:

- Мангас миний ганц цоохор тугалыг идчихээд энэ орой намайг барьж иднэ гэнэ гэж хэлэв. Шөвөг сонсоод:

- Та битгий санаа зов. Би таны аминд орьё. Та одоо хариад гурван жин гурилаар боорцог шараад тавьж бай гэж хэлэв.

Эмгэн түүнийг сонсоод сэтгэл нь жаахан тайвшраад явж байтал хайч тааралдаад:

- Хөгшин ээж ээ, та юунд уйлж яваа юм бэ? гэж асуухад эмгэн:

- Мангас манай ганц цоохор тугалыг барьж идчихээд одоо бас намайг иднэ гэнээ гэж хэлжээ. Хайч түүнийг сонсоод:

Хөгшин ээж ээ, та санаа зовох хэрэггүй. Би таны аминд орьё. Та харьж очоод гурван жин гурилаар боорцог шараад байж бай гэж захижээ.

Эмгэн түүнийг сонсоод сэтгэл нь жаахан тайвшраад явж байтал тахианы өндөг тааралдаж:

- Хөгшин ээж ээ, та юунд уйлж яваа юм бэ? гэж асуухад эмгэн:

- Мангас манай ганц цоохор тугалыг барьж идчихээд одоо бас намайг иднэ гэнээ гэж хэлжээ. Өндөг түүнийг сонсоод:

- Хөгшин ээж ээ, та санаа зовох хэрэггүй. Би таны аминд орьё. Та харьж очоод гурван жин гурилаар боорцог шараад байж бай гэж захижээ.

Эмгэн түүнийг сонсоод сэтгэл нь бүр уужирч цааш явж байтал зам дээр нь том үхэр чулуу тааралдаж, тэр

- Хөөе, хөгшин ээж ээ, та юунд уйлаад явж байгаа юм бэ? гэж асуув. Эмгэн:

- Мангас миний ганц цоохор тугалыг идчихжээ. Энэ намайг бас барьж иднэ гэсэн гэж хэлжээ. Том чулуу түүнийг сонсоод:

- Хөгшин ээж ээ, та санаа зовох хэрэггүй. Би таны аминд орьё. Та харьж очоод гурван жин гурилаар боорцог шараад байж бай гэж захижээ.

Эмгэн түүнийг сонсоод “Хөөрхий энэ юмс бүгд миний аминд орох гэж хичээж байна” гэж туйлын их баярлаж гэртээ харьж ирээд тэр юмсын хэлсэн ёсоор гурван дөрвийн арван хоёр жин гурилаар боорцог хийж тавьчихаад хүлээж суусан гэнэ.

Тэгээд шөнө болоход өнөө дөрвөн юмсын сүүдэр ч харагдахгүй болохоор нь айж сандарсан эмгэн “Одоо хурдан ирэхгүй бол мангас ирнэ” гэж зовоод уйлж суутал гэнэт нэг юм газар тэнгэр доргиулан ирэх чимээ гарахад эмгэн “Өнөө дөрөв юм уу? Мангас юмуу” гэж харсан чинь өнөө дөрөв дөрвөн зүгээс сүртэй нь аргагүй ирж гэнэ. Эмгэн тэр дөрвийг ирэхийг хараад баярлахдаа ухаан алдан унажээ. Тэр дөрөв эмгэний хийж тавьсан боорцгийг идчихээд яаж мангасыг дарах тухай ярилцахад, үхэр чулуу:

- Би гэрийн тонон дээр сууж үүдийг нь харж сууя гэхэд, шөвөг хайч хоёр:

- Бид эмгэнийг сахиж сууя гээд орон дээр гаргаж хэвтүүлээд, шөвөг:

- Би толгойг нь сахъя гэхэд, хайч:

- Би хөлийг нь сахъя гэж тус тусын үүргээ хувааж авав. Өндөг:

- Би гал дотор манаж сууя гээд галтай тулганд орж суув. Тэгээд бэлтгэл ажлаа бүрэн хийж дууссаны дараа мангас хүрч ирээд:

- Муу эмгэн, муу эмгэн чи хурдан үүдээ нээ! гэж хашгирахад гэр дотроос хариу чимээгүй тул мангасын уур нь хүрч, гэрийн үүдийг ганц өшиглөж орж ирээд:

- Хурдан дэнгээ барь! Нэг муухай үнэр ханхалж байх чинь ямар амьтан ирсэн юм? гэж хэлээд харанхуйд нааш цааш тэмтэрч байтал үхэр чулуу тонон дээрээс унаж ирээд мангасын нэг хөлийг нь хуга цохиход мангас:

- Хөл хугарчихлаа. Муу хөгшин золиг яасан хүчтэй юм? Би чиний хаанаас чинь эхэлж идэх үү? гээд эмгэн рүү дайр ч очиход шөвөг дуурайж:


- Толгойноос нь эхэлж ид гэж хэлжээ. Мангас эмгэний толгойноос нь идэх гэсэнд толгойг нь

манаж байсан шөвөг мангасын уруулыг нэг сайн хатгасанд мангас өвдөхдөө:

- Ёо, ёо, муу хөгшин золиг чинь яасан сүрхий шүдтэй юм! Толгой нь шүдтэй бол хөлөөс чинь эхэлж идье гээд хөлд нь хүрч очиход хөлийг нь манаж байсан хайч уруулыг нь юу ч үгүй болтол хайчилж хаясан гэнэ. Мангас өвдөхдөө:

- Ёо, ёо, муу хөгшин золиг чинь хөлийн хуруу нь хайч шиг ямар сүрхий юм. Миний байдаг уруулыг хайчилчихлаа. Одоо чамайг идэж чадахгүй юм байна. Энэ шөнө би энд хононо. Хаагуур нь унтах вэ? гэж асуусанд тахианы өндөг:

- Галын тулганы хажууд унт! Тэнд дулаан байгаа гэж хэлжээ. Мангас сонсоод тэгвэл тэлье гээд галын тулганы хажууд хүрч очтол гал дотор байсан тахианы өндөг дэлбэрч, нурам цог нь мангасыг түлж алсан гэдэг.



БААТАРЛААГ ҮЛГЭР



Гурван настай гунан улаан баатар

Нар сар жаргаж байхад

Навч цэцэг дэлгэрч байхад

Захын мод зулзагалж байхад

Загал бугыг янзага байхад

Самуун цагийг шувгарч байхад

Сайхан жаргалыг эдэлж байхад

Сүм далайг шалбааг байхад

Сүмбэр уулыг дов байхад

Манай энэ орны эзэн

Манлай баатрын хүүг

Ачтай гэж ард нь хүрээлсэн

Алдартай гэж дайсан нь сүрдсэн

Хүний сайн хөхөлдэй мэргэн гэж байжээ.

Ордон өргөө нь гэвэл:

Барьж суудаг гэр нь

Дэнж газар барьсан

Тэгш газар тааруулсан

Холбоо толгойн хооронд

Хоёр зааны аманд

Зуун найман ханатай

Зургаан мянган уньтай

Хөх мөнгөн цавагтай

Цардмал мөнгөн дээвэртэй

Шижир алтан довжоотой

Ширмэл мөнгөн туургатай

Могойн ясан тоонотой

Молор эрдэнэ хаалгатай

Хөх хамбан хөшигтэй

Халзан хамбан дээвэртэй

Хар магнаг хаяавчтай

Дэлхий газраас өөрцгүй

Далай цагаан өргөө гэнэ.

Гэр бүл нь гэвэл:

Хэргийн үнэнийг мэддэг

Гэгээн мэргэн аавтай

Хөрст алтан дэлхий болсон

Гоо мэргэн ээжтэй юм гэнэ.

Ирэх гурван жилийн гайг

Урьтаж нэг мэддэг

Дагах гурван жилийн гайг

Таньж нэг мэддэг

Магнай талдаа өлзийтэй

Майдар сэцэн хатантай гэнэ.

Хөрөнгө мал нь гэвэл:

Довын чинээ дэлэнтэй

Домбын чинээ хөхтэй

Хул хонгор гүүнээс үржсэн

Найгал азарганы сүрэг

Найман живаа адуугаа

Бага боловч эрийн шинжтэй хүү

Балчир боловч баатрын шинжтэй хүү

Галт гэдэг уулыг энгэрлүүлж

Гишүүнт гэдэг уулыг бэллүүлж

Цант гэдэг уулыг арлуулж

Цахиурт гэдэг уулыг өвөрлүүлж

Цэнгэл талдаа бэлчээж

Цэлгэр цагаан далайдаа усалдаг гэнэ.

Арав арван мянгаараа

Ар хөндий дүүрэн агтай

Гурав гурван мянгаараа

Гуу жалга дүүрэн гунжтай

Дөрөв дөрвөн мянгаараа

Дөрөлж хөвөөгөө дүүрэн

Танхил эмнэг тайлагтай

Энгэр газрыг бүрхсэн

Эх зах нь үзэгддэггүй

Ижил зүсээрээ нийлсэн

Энгүй олон ингэтэй

Архирч хүрхэрэх дуу нь

Арван бээрээс сонсогддог

Алд дэлэм зогдортой

Аягын чинээ нүдтэй

Өвдгөөрөө хоёр алд

Өехийгөөрөө таван алд

Хар халиун сортой

Харгиа улаан бууртай гэнэ.

Ар хөндийгөөрөө дүүрч байвал

Алаг үхрээ бүрэн гэдэг

Өвөр хөндийгөөрөө дүүрч байвал

Үй олон адуугаа бүрэн гэдэг

Унадаг морь нь гэвэл:

Жаран алд соёотой

Жалгын чинээ амтай

Үе болгондоо нугастай

Үс болгондоо үсэгтэй

Унахад эрхэм сайхан

Усан тэлсэн жороо

Эрдэнэт цон хүрэн морьтой гэнэ.

Хөндлөнгийн юмнаас хамгаалах гэж

Хүрэн бүргэд хагссан байдаг гэнэ.

Нутаг ус нь гэвэл:

Тэнгэрийн шувууд нисэн буудаг

Тэнүүн уудам нутагтай гэнэ.

Ууланд нь ургамлын сайхан

Ургаа зандан молцоглосон

Бэлд нь цэцгийн сайхан

Бэр цэцгүүд алагласан

Арц хөхөл нь ханхалсан

Араатан жигүүртэн нь шивээлсэн

Өнгө бүрийн шувуунууд нь

Нутаг усаа дагасан

Дөрвөн тал болгондоо

Дөрөө шүргэм буудайтай

Найман тал болгондоо

Нарийн сайхан бэлчээртэй

Эрдэнийн шинж бүрдсэн

Ийм сайхан нутагтай юм гэнэ.

Дайнд бэлтгэл хийсэн нь:

Гурван настай Гунан улаан баатар

Гуа сайхан ууландаа гарч

Сүлд хийморио сэргээе

Сүрэг малаа харъя

Алсын барааг ажиглая

Ан аваа хийе гэж

Цул хүрэн морио бариулж

Цог жавхлангаа бадруулж

Зааны ясан гөлөмтэй

Зандан модон бүүрэгтэй

Зааны ясыг залж

Загасны ясыг зүйж

Ган болдоор тоноглосон

Гардийн ясаар чимэглэсэн

Задгай сайхан эмээлийг

Зоод нь тааруулж

Хойгуур нь татвал олойртоно гээд

Урдуур нь татвал улдана гээд

Дундуур нь татаж оломдоод

Дахин нэг чангалж гэнэ

Хөндийн чинээ зэвтэй

Хөтлийн чинээ оньтой

Хөнгөн сумаа авав гэнэ.

Элгэн бие дээр нь

Элээ шувуу сийлсэн

Хажуу тал дээр нь

Харцгай шонхор барилцуулсан

Хүрэн улаан нумыг нь

Хөвөөндөө тааруулж

Түмэн дайсны хүзүүг

Түдэлгүй цавчиж чаддаг

Түүхий төмөр илдээ

Ташаандаа зүүжээ.

Ууландаа гарсан нь:

Алтай богд ууландаа гарч

Адуу малаа харж гэнэ.

Алсын барааг ажиглаж

Арван зүгийг саравчилж гэнэ.

Айхын аюул алга гэнэ.

Ан аваа хийж гэнэ.

Дайсан ирсэн нь:

Зүүн хойд тивийг

Зүгээр байхад нь эзэлсэн

Хүйтэн төмөр мангас

Гунан настай гунан улаан баатрыг

Толгойгоор нь тасална

Төрсөн нутгийг нь эзэлнэ

Албат иргэдийг нь боолчилно

Эд хогшлыг нь хураана гээд

Хурдан морио шилэн унаад

Хууртай зэвсгээ агсан бэлтгээд

Ариун нутагт нь ирж гэнэ

Зандан мод нь найгав гэнэ

Салаа мөчир нь шуугив гэнэ

Арц хөхөл нь үнэртэв гэнэ

Араатан жигүүртэн нь цуглав гэнэ.

Дайсан сүрдэн айсан нь:

Хүйтэн төмөр мангасын

Хүч нь сулран муурч

Хангайн чинээ цээж нь

Харанхуйлан багтарч гэнэ.

Уур нь ч баахан хүрч

Ааш нь ч баахан сагсайж гэнэ

Гурав хоног хэвтэж гэнэ

Гунин гутран өндийж гэнэ.

Мангасын хар цоохор морь нь давхиж ирээд эзэндээ ингэж хэлжээ:

- Эх нутгийг нь үзээд

Ингэж байгаа юм

Эр биеийг нь үзвэл яах юм?

Эрмэг унагыг нь үзвэл хэрхэх юм?

Нэг бол довтлон очъё

Нэг бол гэлдрэн буцъя гэж гэнэ.

Хүйтэн төмөр мангасын

Хүч нь аяндаа гарч

Уулаглан айн сандарч гэнэ

Уг бие нь догдолж гэнэ

Ухасхийтэл мордов гэнэ

Тасхийтэл ташуурдав гэнэ

Өрлөг зандан уулын

Өврөөр нь тойрон явтал

Найгал алаг азарга нь

Найман живаа адуугаа хураагаад

Үрээ байдсаа дундаа хийгээд

Үмхэн чулуудаж байв гэнэ.

- Хаанаас ямар аюул болов? гэж

Хулан гүү нь асууж гэнэ.

- Хөх жигүүртний дүү

Өрлөг зандан уулыг өвөрлөн

Өршөөлт эзнийг алах гэнэ гэв.

- Дайснаа түргэн дарж

Дархан цолыг олоорой

Хол битгий яв гэж

Хулан гүү хэлж гэнэ.

Найгал алаг азарга нь:

- Намайг битгий мартаарай

Ижлээ олон болгоорой

Энгэр газар байлгаарай

Хурц дөрвөн туурай нь

Хумхийн тоостой уралдаж

Хур сайхан дэл нь

Хөрст дэлхийг бүрхэв

Өрлөг зандан уулаа

Өвөрлөн давхиж одов гэнэ.

Хүйтэн төмөр мангас

Гунанхан улаан баатрыг гээд

Тасхийгэл ороолгоод

Давхиж угтан очиж гэнэ.

Хорт цамаа сунгаж гэнэ

Хуудуу үгээ шившиж гэнэ

Бөхөс гээд чулуудаж гэнэ

Бүдүүн хүзүүнд нь орж гэнэ

Цааш нэг тонгоров гэнэ

Цаад уулан дээр тогтов гэнэ

Хадан янгиа нь хазайв гэнэ

Галт гэдэг уулыг энгэрлүүлээд

Цант гэдэг уулыг арлуулаад

Цахиурт гэдэг уулыг өвөрлүүлээд

Цангал цагаан хадныхаа

Цаана нь гартал чирж гэнэ.

Хад түшин унав гэнэ

Хажуу хөвөөнд нь тогтов гэнэ

Хар цам нь тасрав гэнэ

Харах чадалгүй хоцров гэнэ

Барьж авах санаатай

Босоод явах гэсэн чинь

Богт чөмөг нь хугарч гэнэ

Богино хавирга нь мултарч гэнэ

Хар цоохор дээрээ ирж гэнэ

Хар янгиагаа эмээллэж гэнэ

Хар цоохор морь нь

Хайрт эзэндээ хэлж гэнэ:

- Азаргыг нь үзээд дийлэхгүй юм

Амьд биеийг нь үзээд яах юм бэ? гээд

Гэр нутгаа бэдэрч гэнэ

Гунин гутран явж гэнэ.

Гурван настай гунан улаан баатар

Гэртээ ирж хэд хоноод

Агт морио юүлье

Адуун сүргээ харья даа гэж

Өрлөг зандан ууландаа гартал

Урьд үзэгдээгүй морь байв гэнэ

Эрдэнийн цул хүрэн морио авчирч

Хойш нь харуулж нэг зогсоож үзэв гэнэ

Урагш нь харуулж нэг зогсоож үзэв гэнэ

Хажуу тийшээ алд илүүдэж байна гэнэ

Урагш нь харуулж нэг зогсоож үзэв гэнэ

Урагшаа хойшоо дэлэм илүүдэж байна гэнэ

Ямар хүний морь болохыг

Ярин хэлж хайрла гэж

Хаан аав, хатан ээждээ очиж

Хамаг учрыг хэлж өгч гэнэ

- Жиг ч бий, учир ч бий

Хүүгээс минь илүү эр

Хүрэн мориноос минь илүү хүчтэн

Энэ тивд байхгүйсэн

Ээ, хүү минь юу болоо юм бол

Уржигдар, өчигдрийн турш

Улаан тоосоор шуурсан

Чухам юуны тоос болохыг

Чухалчилж ер мэдсэнгүй

Таван хааны төлгийг

Тас няс хийтэл хаяж гэнэ

Хүйтэн төмөр мангас

Хүйс тэмтрэн ална гээд

Өрлөг зандан уулын чинь

Өвөр тойронд ирээд

Найгал алаг азаргыг чинь уургалаад

Нарийн хуйваа тасдуулаад

Хойш урагшаа чирэгдээд

Хад ууланд тогтоод

Нааш цаашаа чирэгдээд

Намаг шаварт шигдээд

Богт чөмөг нь хугараад

Богино хавирга нь мултраад

Амьд мэнд зугтсан байна гэнэ.

Уур нь баахан хүрч

Уушги нь баахан сагсайж

Гэртээ яаран ирээд

Хэргээ дахин бодоод

- Ирэх гурван жилийн гайг

Урьдчилан мэддэг чинь яалаа?

Дагах гурван жилийн гайг

Таньж мэддэг чинь яалаа?

Алах дайсан ирээд

Адуу малыг чинь хөөж байна

Мэдээгүй учраа хэл гэж

Мэргэн хатнаа загнаж гэнэ

Хормойгоо дэвсэн сөгдөж

Хошуугаа дэвсэн гуйж

- Алах хүний үгийг сонсдог

Алахгүй үхрийн дөрийг авдаг

Учиртай хэдэн үг хэлье

Уучилж та хайрла! гэв

- Ирэх гурван жилийн

Гайг ил тод мэдсэн билээ

Дагах гурван жилийн гайг

Таньж лав мэдсэн билээ

Наян бурхадын сэтэртэй

Найгал алаг азаргыг чинь явуулсан билээ гэв.

Цул хүрэн мориноосоо үсрэн буугаад

Чухам учрыг мэдлээ гээд

Жаран хүлгийн жаварт

Жаргал гацааны адагт

Жаран хасаг тэрэгнээс

Хана мэт хантайрч

Хайрцаг мэт уяв гэнэ

Жар хоног жаргаж гэнэ

Ная хоног найрлаж гэнэ

Эрдэнийн цул хүрэн морь нь

Эзэндээ ирж ингэж хэлж гэнэ:

- Ташааны мах чангарлаа

Тавагны цус тарлаа

Зооны мах зузаарлаа

Зулайны үс дарлаа

Явах дайн байдаг бол

Явах цаг чинь боллоо гэв.

Далан лангийн товчтой

Тайж хамбан дээлтэй

Зуун лангийн товчтой

Зузаан дээлээ өмсөж гэнэ

Далан бугын зооны арьсаар хийсэн

Даргай гутлаа өмсөв гэнэ.

Далан булгын зоогоор урласан

Дайчин бүргэд малгайгаа өмсөж

Нумаа үүрч, сумаа агсан

Мориндоо мордож гэнэ

Дайнд явсан нь:

Хөдлөшгүй хөх манан даваа

Цаглашгүй цагаан манан даваа

Цаг бүрийн алаг шаазгай

Цаана наана нь цугларч гэнэ

Магнай цагаан арслан нь

Малаа тойроод тоглож гэнэ

Алтай богд хангайдаа гарч

Ариун харгуй ууландаа ирж гэнэ

Аягын чинээ алаг нүдээрээ

Ар замбуутивийг ширтэж гэнэ

Хүйтэн төмөр мангас гэдэг

Хөдөө тийшээ буцаад явж гэнэ

Уур нь гэнэт манасхийж

Ухасхийн түргэн мордож гэнэ

Үүлтэй тэнгэрээс доохнуур

Өргөстэй модноос дээхнүүр

Хумхын тоосонд гүйцэгдэхгүй

Хурдан давхиж явсаар

Мангасын гадаа ирж

Мал сүргийг нь ажиглаж гэнэ

Хангайн чинээ биетэй

Хавцлын чинээ амтай

Хар цоохор морь нь

Хажууд нь уяатай байж гэнэ.

Цул хүрэн морио

Цуг зогсоогоод үзэж гэнэ

Гүү унага шиг зөрөөтэй гэнэ

Хөвөө хангай шиг ялгаатай гэнэ.

- Амь биеийг чинь ална

Аалзны шүлс хийнэ

Өөрийн биеийг чинь ална

Өвч амьтныг чинь аварна гэж

Үүдийг нь тас татан

Үсрэн дэвхрэн орж гэнэ.

Ар талын бие нь

Ангийн цусанд будагдсан

Өвөр талын бие нь

Хүний цусанд түлэгдсэн

Хүрэн хар мангас

Хурхираад унтаж байж гэнэ

Хажуу дахь хүүхэн нь

Хамбан дээлээ нөмрөөд

- Нүдэндээ галтай

Нүүрэндээ цогтой

Шилэндээ шөрмөстэй

Шилбэндээ чөмөгтэй

Гартаа чадалтай

Ганзагандаа өлзийтэй

Хэн хүний үр вэ?

Хэрэг зориг хэнд вэ?

Хэтийн нутаг хаана вэ? гэжээ

Нэр алдраа хэлж гэнэ

Нэг удаа бөхийж гэнэ

- Нүдний минь галыг ухаж үзсэн билүү?

Шилний минь шөрмөсийг барьж үзсэн билүү?

Шилбэний минь чөмгийг ташиж үзсэн билүү?

Гарны минь чадлыг барилдаж мэдсэн билүү?

Ганзаганы минь өлзийг харж үзсэн билүү?

Олон үгээ татвал таарна

Олиггүй мангасаа сэрээвэл таарна гэжээ.

Нарангоо хүүхэн нахилзан босч бөхийгөөд

Нэг удаа татаж гэнэ

Даанч нэг сэрсэнгүй гэнэ

Гучин гурван алд хүрэл сэлмийг нь аваад

Гуяруу нь дүрж гэнэ

Дав гээд сэрж гэнэ

Тов гээд өндийж гэнэ

- Аман дахиа хувааж идэх

Ашдын чинь нөхөр ирлээ гэж

Хүүхэн нь хэлээд хүзүүгээ сунгаад зогсож гэнэ

- Тавагтай будааныхаа хог

Домботой цайныхаа шавхрууг өгөөд

Түргэн гарга гэж мангас тоох янзгүй хэлж гэнэв

- Анд явах хооронд

Азаргыг минь уургалдаг чинь юу юм?

Анд нөхөр болох байтугай

Алалцах дайсан мөн гэж

Шуун дээрээс нь татаж гэнэ

Шууны мах нь шувтраад

Бугуйн дээр нь ирж гэнэ

Нарангоо хүүхэн

Нохойны сүүг босгоны шороотой холиод

Боогоод өгч байна гэнэ

Мах цус нь эдгэж гэнэ

Мангасын царай сайжирч гэнэ

Маргаашийн мандах нарнаар уулзъя гээд

Мангас унтаж гэнэ.

Шөнө дундын үед

Сөл нойрны сүүлд

Ногоон торгон дээлтэй

Нарангоо хүүхэн

Мангас эрийнхээ байдлыг

Магадлан шинжиж үзвэл

Дээгүүрээ зуун лууны хүчтэй

Дундуураа зуун шулмын чадалтай

Доогуураа зуун чөтгөрийн биетэй гэнэ

Гурван настай гунан улаан баатрыг

Гурвантаа харж шинжвэл

Тэнгэр эцгээс хувилж

Газар эхээс төрсөн

Гай зовлонг арилгадаг

Гамшиг аюулаас зайлуулдаг

Хүч чадал гэдэг нь

Хүйтэн булаг шиг оргилдог

Дэлхийг эргүүлэх хүчтэй

Дайсны хүзүүг таслах чадалтай

Сайн хүний үр байна гэнэ

Мангас тоохгүй янзтай

Маргаашийн улаан нарнаар

Болзоотын бор толгой дээр

Биеийн чадлаар үзэлцье гэжээ.

Маргааш өглөө нь болж

Мангас баатар хоёр уулзаж гэнэ

Хэн урьтаж харвахаа хэлэлцье гэжээ.

- Хүзүү сээрний махаа идэж

Хүний цусыг сордгоороо

Чи урьтаж харва даа

Дараа нь би харвая гэж

Гурван настай Гунан улаан баатар

Ажиг ч үгүй хэлж гэнэ

Энгэрийн найман товчийг тайлж

Энгэрийн чинээ хэнхдэгээ

Яранхан байж зогсоод

Яралзанхан байж инээв гэнэ.

Ханан улаан хадны хажуу дээр гарч

Ханхар өргөн цээжрүү нь харваад орхисон чинь

Харвасан сум нь хуга үсэрч

Хажуугийн чулуу мөргөөд

Хоёр хэсэг болж гэнэ.

Гурван настай гунан улаан баатар

Хүрэн улаан нумаа

Гурвантаа онилоод тавиад орхисон чинь

Тархиар нь хага харваж

Ташаагаар нь нэвт оржээ

Тавхайн махыг нь тасалж

Бөөрөөр нь цөмлөн ороод

Бүдүүн нарийн гэдсийг нь сүлбэж гэнэ

Ган болд илдээ ганц нэг цохиж

Галуун хүзүүн гаансандаа

Галзуу улаан тамхиа нэрж

Ганц хоёр татаж

Хамар амныхаа утаагаар

Гамшиг зовлонг арилгаж

Жаргал мөргөлийг авчирч

Эндээ долоо хонож гэнэ.

Эргэж буцахынхаа урьд

Муу ч болсон эрийн зоригтй

Муухай ч болсон гар цустсан

Мангасыг очиж үзэхээр

Маргааш өглөө нь очтол

Хүдэрхэн бор хүү болоод

Хүч тэнцэн ноцолдож гэнэ

Хүрсэн газар болгоноос

Хүрзний чинээ мах аваад

Барьсан газар болгоноосоо

Бариулын чинээ мах аваад

Ач тач ноцолдож

Арван тав хонож гэнэ.

Хоёр бие тэнцэж хорин тав хонож гэнэ

Тал газрыг нүх болтол

Уул газрыг тал болтол

Ургаа модыг хугартал

Хуурай модыг булгартал

Хүчээ бартал ноцолдож гэнэ

Гурван настай Гунан улаан баатар

Дийлэх цаг нь болж гэнэ

Дэлгэрэх ухаанаа гаргаж гэнэ.

Эрдэнийн цул хүрэн морь нь

Эмээл хазаараа чирээд

Жолоо цулбууртайгаа зогсож байхыг харж гэнэ

- Чи ч нэг хүний үр

Би ч нэг хүний үр

Чиний морь ч нэгэн гүүний унага

Миний морь ч нэгэн гүүний унаган

Эр хүн эзгүй хээр

Эмээлт мориндоо хайртай гэдэг билээ

Эмээлийг нь салгаад орхиё

Ижилд нь явуулаад орхиё гэв.

Эрдэнийн цул хүрэн морин дээрээ очиж

Эмээл хазаарынх нь ороолдоог гаргахад

- Баруун нүдрүү нь нясал

Баруун өвдөгрүү нь өшгил

Ар далан дээр нь байдаг

Аягын чинээ мэнгийг нь хагал гэжээ.

Ухасхийн давхиж очоод

Угзран барьж дараад

Толгойгоор нь тэвэрч

Нүдийг нь цоо няслаад

Тохойноос нь угзран татаад

Мэнгийг нь бяц хагалж

Өвдөгрүү нь өшиглөвөл

Омог хүч нь барагдаж гэнэ

Өөрийн эрхгүй гуйж гэнэ

- Аянд явахад чинь

Ачааг чинь даая

Анд явахад чинь

Ангийг чинь цуглуулъя

Архи уухад чинь

Сөнг чинь түшье

Номхон морины чинь ногт больё

Догшин морины чинь чөдөр больё

Ах болон нөхөрлөө

Амийг минь өршөө гэжээ.

Аавынхаа төлгөнд үзэж гэнэ

Алах ёстой байна гэнэ

Ээжийхээ төлгөнд үзэж гэнэ

Энд нь ал гэж байна гэнэ

Орчлонгийн мууг шингээсэн энэ муу амьтны

Элэг зүрхийг нь тасдаад

Элс манханд хаяж гэнэ

Өлссөн цангасан амьтанд

Өмч хөрөнгийг нь түгээн өгч гэнэ

Зовсонд жаргал олгож

Жаргасанд сургаал болгож

Хорин гурав хонож гэнэ

Хол ойрыг ажиглаж гэнэ.

Хар цоохор морийг нь хөтлөөд

Хүүхэн дээр нь ирэхэд

- Дайснаа дараа юу?

Дархан цолоо олоо юу?

Өсөөтнөө дараа юу?

Өргөн цолоо олоо юу? гээд

Таван давхар олбог дэвсэж

Тансаг сайхан идээгээ өрж

Таван тогоо цайгаа аягалж

Тавин лонх архиа сөгнөж гэнэ.

- Хан хурмаст тэнгэрийн

- Хамгийн бага дагина билээ

Зовсон зүдэрсэн амьтанд

Жаргал өгөхөөр ирсэн билээ

Аюулт хар мангас

Авгайгаа болгоод гурван жил боллоо

Гэрт минь хүргэж аль гээд

Хив хадгаа барьж гэнэ

Гунан настай гунан улаан баатар

Гэрээс гарч явж

Сүлд таван тэнгэрээ тахиж

Сүр хүчээ бадруулж

Сэр сэр салхилуулж

Ширүүн бороо оруулж

Өнгийн солонго татуулан

Өнөөх дагиныг суулгаж

Тэнгэрийн оронд нь явуулж

Төрсөн ах дүү шиг болов гэнэ.

Мангасын мал хөрөнгийг цуглуулж

Олон ардад хуваан өгөөд

Овоо хангайгаа санагалзаж

Орон гэртээ буцаж

Ариун нутагтаа ойртоход

Ард олон нь угтаж гэнэ

Аав, ээж нь айсуй гэнэ

Зандан мод нь найгав гэнэ

Загал буга нь урамдав гэнэ

Арц хөхөл нь ханхалж гэнэ

Амьтан бүхэн цугларч гэнэ

Өрлөг хангай нь өндийж гэнэ

Өргөн далай нь цалгиж гэнэ

Найгал азарга нь янцгааж гэнэ

Навч цэцэг нь дэлгэрч гэнэ

Баяр цэнгэл нь дүүрч гэнэ

Багачууд хүүхэд нь цэнгэж гэнэ

Сархдын сайныг ууж гэнэ

Идээний сайныг идэж гэнэ

Аав ээжээ дээш нь суулгаж

Ачит хатнаа дараа нь суулгаж

Бүгд олноороо найрлан сууж

Бүх нутгаараа жаргаж гэнэ.

Шоргоолжны хааныг дарсан нь

Эрт урьд цагт нэг айлын эгч дүү гурван өнчин хүүхэд амьдарч байжээ. Эгч нь том болж айлд мордох насанд хүрэхэд том дүү нь хорь хүрч, бага дүү нь долоон нас хүрч байжээ.

Эгч нь шоргоолжны мэргэн хаанд дурлаж хатан нь болохыг хүссэнд шоргоолжны мэргэн хаан их дүү нь баатар хүн болохоор айж:

- Чи бид хоёр айл гэр болж болно. Гэвч чи том дүүгээ алга хийхгүй бол эрт орой бид хоёрт төвөг болно гэжээ.

Эгч нь шоргоолжны мэргэн хааны үгийг сонсоод их дүүгээ хорлох санаа төрж нэг арга бодож олоод:

- Дүү минь ээ, Чи морио барьж унаад баруун тивийн бор халзан туулайг бариад ир гэж модон хайрцаг өгөв. Их дүү нь явахад морь нь :

- Тэр газар чинь явж болдоггүй газар шүү. Явахдаа сам шүүр хоёроо ав. Нум сумаа ав гэж хэлэв. Их дүү нь эгчдээ сэжиг төрж бага дүүгээ дуудаж:

- Эгч намайг баруун тивийн бор халзан туулайг бариад ир гэж байна. Ах нь амьд ирж чадах юм уу? үгүй юу? Мэдэхгүй. Дүү минь малаа хариулж явахдаа сэрэмжээ хичээж явах хэрэгтэй. Эгч юу хийхийг сайн ажиглаж бай гэж захичихаад тэнгэр дээгүүр жирийлгэж, газар дээгүүр харайлгаж, цагийн газрыг мөчөөр товчилж, сарын газрыг өдрөөр товчилж, жилийн газрыг сараар товчилж явсаар нэгэн газар хүрэхэд морь нь:

- За, энэ газар хоёулаа жаахан амаръя гэхэд мориноосоо бууж тамхиа татаж суухад утаа нь үүл болж, үнс нь уул болж байв. Хэсэг амраад босч явах гэхэд морь нь:

- Тэр газрын алсад байх хоёр том хар юмыг харж байна уу? Тэр юу болохыг мэдэх үү? гэж асуув. Залуу тэр зүг хараад:

- Мэдэхгүй. Хоёр том уул л биз гэхэд морь нь:

- Тэр чинь уул биш ээ. Харин хоёр буур шүү дээ.

Энэ хоёр байсан цагт үүгээр ямар ч амьтан гарч чаддаггүй юм. Одоо тэр хоёр буур бид хоёрыг хүрч очиход цагаан хөөсөө сагуулж хүржигнэж ирнэ. Тэр үед чи сам шүүр хоёроо нэг нэгээр нь шидээрэй гэж захиад цааш явав.

Явсаар уул шиг хоёр том юмны хажуу ирсэнд үнэхээр хоёр том буур цагаан хөөсөө бургиулан хүнгэнэн тэшиж ирэв. Залуу сам шүүр хоёроо хоёр буурын өмнөөс нэг нэгээр нь шидэж явуулсанд хоёр буурын нэг нэг хөлийг нь хуга цохиж хэвгүүлэв. Тэгээд тэр газраар амар мэнд гарч цааш явж байтал өмнө нь бас нэг толгой таарав. Толгой дээр гараад морь нь:

- За, энэ газар хоёулаа жаахан амраад явья гэсэнд залуу мориноосоо бууж тамхиа татаж суухад утаа нь үүл болж, үнс нь уул болж байв. Хэсэг амраад залуу босч явах гэхэд морь нь

өмнө зүгрүү хараад:

- Тэнгэрийн хаяанд гялайж байх нуур шиг юмыг харж байна уу? Тэр юу болохыг мэдэх үү? гэж асуухад залуу:

- Мэдэхгүй. Ус юм уу гэсэнд морь нь:

- Тэр бол ус ч биш, мөс ч биш. Харин аварга могой байгаа юм. Түүгээр өнгөрч гарах туйлын бэрх. Чи одооноос эхэлж нумаа эвшээлгэж ав. Бид наран шингэх үед хүрэх байх. Тэр үед тэр голын ус шиг юм чинь нуурын толь шиг болох байх. Тэр бол аварга могойн нүд нь юм. Тэр үед чи нүдрүү нь хараалж байгаад харваарай. Тэгээд онож чадвал бид гарч чадна. Чадахгүй бол аварга могой залгина гэж хэлжээ.

Тэгээд залуу мориндоо мордож, өглөөний нарнаар нумаа эвшээлгэж, орой наран шингэх үед ус шиг гялгар юмны хажууд ирсэнд үнэхээр нуурын толь шиг юм болсон байв. Залуу эвшээлгэсэн нумаа онилж онилж харвасанд аварга могойн нүдээр нь ороод толгойг нь хага харвасан байв. Морь нь түүнийг үзээд:

- Чи сайн эр байна. Одоо аварга могойн арьсыг өвч гэсэнд залуу аварга могойн арьсыг өвчиж аваад явав. Морь нь:

- Бид одоо Шар хадны зэс амт гэдэг газраар явна. Тэнд бас нэг аюул хүлээж байгаа. Чи могойн арьсаар биеэ гурав ороогоод миний биеийг хоёр ороо. Тэгээд миний нуруунд лавтайхан суу, би эрчээрээ давхиж тэр аюулыг давж гаръя гэв. Эс бөгөөс бид зэс хошуунд хатгуулж үхнэ гээд явжээ.

Тэгээд шөнөөр шар хадныг туулахад юм мэдэгдсэнгүй. Үүр цайхын үед биен дээр нь бороо орж байгаа юм шиг олон юм пид пид хийтэл унаж байв гэнэ. Үд болоход арай цөөрч чимээгүй болжээ. Нэлээд явж байгаад морь нь:

- За, одоо ч аюул өнгөрлөө. Хурдан бууж миний биеийг ороосон арьсыг хуулж ав гэв. Залуу мориноосоо бууж аварга могойн арьсыг хуулж автал дүүрэн зэс хошуу зоогдсон байжээ. Дараа нь өөрийн биеийг ороосон арьсыг хуу татаж хаяад цааш явж байтал морь нь:

- Чи одоо бор муур болоод бутны доор хэвтэж бай. Би хангарьд болоод тэнгэрт гарч дөрөөгөө хангинуулаад нисье. Тэгэхээр бор халзан туулай айхдаа бутруу гүйгээд ирнэ. Тэгэхээр нь чи бариад аваарай гэж хэлээд хангарьд шувуу болон хувилаад тэнгэрт гарч нисэхдээ дөрөөгөө хангинуулаад ирэв. Тэгсэн чинь бор халзан туулай айхдаа бутны доор гүйгээд ирэв. Бор муур болж хувирсан залуу өмнөөс нь бариад авчээ. Тэгээд модон хайрцагт туулайгаа хийгээд буцаж явав гэнэ.

Явсаар гэрийнхээ баруун хойд толгой дээр гараад иртэл хонь хариулж явсан бага дүү нь ахыгаа ирж явахыг үзээд угтан ирж:

- Ахаа та хүрээд ирэв үү? гэж баярлан хэлэхэд ах нь бас дүүгээ хараад баярлаж:

- Хариад ирлээ, хариад ирлээ. Гэрт юу болж байна? Эгч яаж байна? гэж асуухад дүү нь:

- Эгч таныг ирж явааг сонсоод “Муу хар гайхал үрэгдсэнгүй, хүрээд ирлээ” гээд гэрт гурван жин гүн нүх ухаад дээр нь цагаан эсгий дэвсээд голд нь нэг сайхан олбог дэвсчихсэн байгаа. Таныг дээр нь суулгаж нүхэнд унагаж дарна гээд айргийг нэрж архи болгоод архийг нэрж арз болгоод арзыг нэрж хорз болгоод хорзыг нэрж хор болгоод хүлээж сууна. Ахыг хүрээд очихоор эгч сайхан загнаж архи хийж өгөх байх. Түүнийг ууж огт болохгүй шүү. Таныг архи уухгүй болохоор эгч аргагүйдэж дээшээ суу, дээшээ суу гээд цагаан эсгийний голд зассан олбог дээр суулгах гэх байх. Түүн дээр нь сууж огт болохгүй шүү гэж захижээ.

Ах нь дүүгээсээ байдлыг ойлгож мэдээд гэртээ харьж, мориныхоо амгайг мулталж нум сумаа эвхчихээд морио тавьж байтал эгч нь гарч ирээд:

- Хүүе , чи чинь хариад ирэв үү? Морио яагаад тавьж байгаа юм бэ? гэж асуусанд, их дүү нь эс мэдсэн янз гаргаж:

- Өө, хөөрхий морь минь зүдэрлээ. Жаахан өвс идэг гэж хэлээд гэртээ оров. Эгч нь:

- Дүү минь, ядарсан байлгүй. Сайн яваад ирэв үү? гээд их баярласан царай гаргаж, цай хоол хийж өгөв. Их дүү нь:

- Ядарсангүй ээ, сайн яваад ирлээ гээд бор халзан туулайгаа гаргаж эгчдээ өгөв. Эгч нь:

- Өө, яасан сайн юм бэ? Болзоотын бор туулайг бариад ирэв үү? Энэ чинь ёстой ховор амьтан гэж хэлээд хайрцгийг тосч аваад нээсэн ч үгүй гэрээсээ гарч гэрийнхээ ардуур урсч байгаа Инжийн голд тавьж явуулжээ.

Тэр Инжийн гол бол шууд урсаад шоргоолжны хааны гэрт ордог байжээ. Эгч нь тэр туулайг хайрцагтай нь тавьж явуулсан нь шоргоолжны мэргэн хаанд дүү нь харьж ирснийг мэдэгдэж буй хэрэг байжээ. Залуу цайгаа ууж суухдаа ажиглавал гэрийн баруун талд урт цагаан эсгий дэвсэж голд нь олбог зассан харагдав. Эгч нь гаднаас орж ирээд:

- Дүү минь чи яагаад эсгийний үзүүр дээр сууж байгаа юм бэ? дээшээ суу, дээшээ суу гэхэд нь дүү нь:

- Болно болно гэв. Эгч нь цаашаа харж авдарнаасаа өнөө хор болтол нэрсэн архиа гаргаж ирээд:

- За, миний дүү хол газар яваад ядраа биз. Би чамд айргаар архи нэрж тавьсан юм гээд архи хийж өгөхөд дүү нь:

- Эгч ээ, би архи ууж чаддагүй шүү дээ гэсэнд эгч нь:

- Чи чинь болзоотын бор халзан туулайг барьж ирсэн их гавьяатай хүн байж архи уулгүй яахав гээд шахаад байв. Дүү нь ууж чадахгүй гээд байсанд уурлаж:

- Чи ууна уу? үгүй юу? гэж амруу нь цутгахаар ойртоход дүү нь арагшаа ухраад нүхрүү

уначихаж гэнэ. Эгч нь баярлаж “Одоо чамайг нэг алга болгоё” гээд шороогоор булж нүхийг таглаад дээрээс нь том чулуугаар дарж тавиад өөрөө шоргоолжны хааныд очиж эхнэр нь болж суув.

Түүний дараа олон богширго шувуу ах залууг нүхэнд булагдсаныг мэдээд дарсан чулууг хошуугаараа тоншоор байгаад буталж хаяжээ. Тэгээд богширгоны хошуу элэгдэж мухар болсон гэдэг. Түүний дараа хулгана мэдээд булсан шороог урд хоёр хөлөө элэгдтэл малтаж залууг нүхнээс гаргаж авчээ. Тэгээд хулганы урд хоёр хөл охор болсон гэдэг.

Залуу нүхнээс гарч ирээд морио дуудахад морь уулнаас эмээл хазаартайгаа, нум сумыг нь ачаад давхиж ирэв. Залуу морио унаад нум сумаа үүрээд эгчээсээ өшөөгөө авахаар явжээ. Явж байтал замд нь нэг монгол гэр таарахаар нь орж очтол жаахан хүүхэдтэй эхнэр нөхөр хоёр уйлаад сууж байв. Залуу түүнийг үзээд учрыг асуусанд, хүүхдийн аав ээж хоёр:

- Манай нутагт шоргоолжны мэргэн хаан байдаг юм. Тэр нэг хатан залж ирснээс хойш өдөр бүр нэг хүүхдээр овоо тахидаг болсон. Маргааш манай хүүхдийг авч явна гэж хэлжээ. Залуу түүнийг сонсоод эгчдээ бүр их өширч:

- Та нар бүү санаа зов. Би танай хүүхдийг аварч чадна. Тэр хүүхэн бол миний эгч байгаа юм. Би түүнийг лавтай дийлнэ гэж хэлэв.

Маргааш нь сүйх тэрэгтэй хүн тэр айлд ирж хүүхдийг нь аваад явахад залуу нэг муу ноорхой хувцастай бадарчин болж, морь нь даахьтай хар даага болж хувираад өнөө хүнийг дагаж явав. Яваад овоо тахидаг найрын газарт хүрсэнд харуулын цэрэг түүнийг хориглоод оруулсангүй. Тэгэхээр нь залуу:

- Та нар овоо тахиад буян хийж байгаа юм бишүү? Тийм бол надад ч бас жаахан буян болчих. Би орж жаахан будаа олж идье гэсэнд түүнийг тавьж оруулав.

Залуу даахьтай хар даагаа хөтлөөд овооны хажууд ирж хүмүүсийн дундуур чихэлдэж явсаар шоргоолжны мэргэн хаан, эгч хоёрынхоо дэргэд очиж зогсоод чангаар найтаасанд эгч нь дүүгийнхээ дууг таниад ихэд гайхаж “Энэ юун танил дуу гарав” гэхэд их дүү нь хуучин дүрдээ хувилж ухасхийн үсэрч эгчийгээ барьж аваад хүүхдийн оронд овоог нь тахиж өргөжээ.

Шоргоолжны мэргэн хаан түүнийг үзээд ухаан жолоогүй зугтаж алга болсон байв. Залуу өнөө хүүхдийн амийг авраад гэрт нь хүргэж өгөхөөр буцаж явах замдаа нэг уулан дээр гарч амсхийж суутал уул хөдөлж байв гэнэ. Залуу босч эргэн тойрныг харсан чинь шогоолжны хаан олон цэргүүдээ дагуулж ирээд залуугийн сууж байсан уулны тал талаас бүсэлж сэт нүхэлж ирж байв гэнэ. Залуу мориндоо:

- За, чи хурдан нис гэж хэлсэнд морь нь газар хүчтэй тийрээд тэнгэрт гарч нистэл уул нурж шоргоолжны мэргэн хааныг цэргүүдтэй нь дарж гэнэ.

Тэгээд шоргоолж уулны хад чулуунд дарагдсанаас болж нуруун дундуураа тасархай болсон гэдэг.

Эрхий мэргэн хаан

Эрт урьд цагт, нэг залхуу өвгөнтэй ядуу эмгэн байжээ. Өвгөн нь өдөртөө юу ч хийхгүй ангайж идчихээд тонгойж хэвтдэг байв. Эмгэн нь өдөр бүр хэдэн үхрээ хариулж яваад орой ирэхэд өвгөн нь нэг үхрээ алж иддэг байв. Сүүлдээ хотондоо ганц үнээтэй үлджээ. Эмгэн нь уурлаж:

- Та байдаг үхрээ барж идээд дууслаа. Одоо бид юугаараа амьдрах юм бэ? гэхэд өвгөн их дургүйцэж, эмгэнээ хөөж гаргаад аргал түүгээд ирэх хооронд үлдсэн ганц үнээгээ алж махыг нь гэртээ оруулаад, эмгэнээ оруулахгүй гэж арьсаар нь гэрээ битүү бүрээд ганц дэлэнг нь эмгэний хувь гээд тооноороо гаргаж хаяжээ.

Эмгэн гэртээ ирээд орох аргагүйдээ өнөө үнээнийхээ дэлэнг аваад уйлж явав. Тэгээд нэг том хадны дэргэд ирж үнээнийхээ дэлэнг хадан дээр тавиад жаахан амарч суув. Хэсэг амраад босч дэлэнгээ аваад явах гэсэнд дэлэн нь хаданд наалдчихаад авагдахаа байчихав. Хэсэг татсанд дэлэнгээс сүү гоожиж гарав. Эмгэн аргагүйн эрхэнд тэндээ сууж дэлэнгийнхээ сүүгээр өрөм шахаж, сааль цагаа хийж идэж амьдрах болов гэнэ.

Хэдэн сарын дараа эмгэн өвгөнөө яаж байгаа бол гэж санаа зовоод уутанд өрөм бяслаг хийж үүрээд гэртээ очтол үхрийн шир нь хатаад гэрийг нь баглаад улам ч орж болохооргүй болчихжээ. Тэгэхээр нь эмгэн гэр дээрээ гараад тооноороо шагайж хартал өвгөн нь аль эрт үхрийн махаа идэж бараад галынхаа үнсийг “Энэ өнөөдрийн хоол, энэ маргаашийн хоол” гээд хэдэн хэсэг овоолж сууна гэнэ. Эмгэн өвгөнөө өрөвдөж ууттай өрөм бяслагаа тооноор нь хаяж өгөв. Өвгөн гэнэт бууж ирсэн өрөм бяслагийг үзээд тэнгэрээс унаж ирэв үү? Муу хар эмгэний минь буян ирэв үү? гээд ухаангүй идэж эхлэв. Эмгэн буцаж хадныхаа дэргэд ирээд үнээнийхээ дэлэнг сааж суутал өвгөн нь өнөө ууттай өрөм ааруулаа идэж барчихаад эмгэнийхээ мөрөөр мөшгиж явсаар хүрч иржээ. Өвгөн, эмгэнээ хараад:

- Өө, би өлсөж цангаад үнс идэж байхад чи дэлэнгээс сүү сааж сайхан амьдарч байна гээд хадан дээр наалдсан үнээний дэлэнг хуу татаж идчихээд зугтаад явчихав.

Эмгэн, өвгөндөө гомдож уйлаад цааш явав. Явсаар нэгэн айлд хүрч ирэхэд хэдэн хүүхэдтэй эмгэн өвгөн хоёр сууж байв. Айлын улс эмгэнээс:

- Хаанаас хаа хүрэхээр явж байна? гэж асуухад эмгэн:

- Би амьдрах аргагүй болчихоод ажил хийж амь зуухаар явж байна гэв.

Айлын хүмүүс эмгэний ярихыг сонсоод:

- Тийм бол та дуу чимээ гаргахгүй, хашгирч хангинахгүй манай малыг хариулж, сүү саалийг нь авч амьдар гэж хэлэв.

Эмгэн айлыг малыг гардаж аваад хариулсанд мал биш зээр байв. Зээрнүүд хүнээр хариулуулахгүй, цаг нь болохоор хүрч ирээд саалгадаг байв. Эмгэн айлын хүмүүсийн захиснаар хашгирч хангинахгүйгээр “мал”-ыг нь саагаад байж байтал нэг хүн бүдүүн

дуугаар:

- Хүүе, чи энд байсан юм уу? гэж хашгирав. Эмгэн цочоод эргэж харсан чинь өвгөн нь ирчихсэн байв. Тэгтэл зээр нь хүний дуунаас үргээд год үсрэн давхисанд эмгэн сандрахдаа сүүлий нь тасдаад хоцорчээ. Тоос татуулан алга болсон зээрийн сүргийн араас эмгэн алмайран харж зогсоод өнөө сүүлээ өвөртөө хийж хадгалав. Өвгөн нь ухаан сэхээгүй гүйж ирээд хувинтай сүүг нь уучихаад зугтаад явчихав. Эмгэн бас амьдрах аргагүй болоод уйлан хайлан цааш явсаар хол замыг туулсан тул өлсөж цангаад “Яаж нэг жаахан хоол олж иддэг билээ” гэж бодож байтал нэг жаахан хүүхэд:

- Ээж ээ, тэр цайдмын нууранд очиж ус ууя гэж хэлэх нь дуулдав. Энд юун хүүхэд намайг ээж ээ гэж дууддаг билээ гэж бодоод эргэж харвал юу ч байсангүй. Дахин сайн чагнасанд өвөр дотор нь дуугарч байжээ.

Тэгээд өврөөсөө нөгөө зээрийн сүүлээ гаргаж үзсэн чинь дотор нь эрхийн чинээ хүү байв. Эмгэн баярлаж эрхийн чинээ хүүтэйгээ хамт цайдмын нуурын хажууд очиж ус уугаад модны ёроолд амарч суутал хэдэн үхэр усанд ирэв. Эрхий хүү:

- Ээж ээ, одоо энэ үхэрнээс нэгийг алж идье гэв. Эмгэн сандарч:

- Хүүе хүү минь, тэгж болдоггүй юм. Хэрвээ энэ чинь баяд ноёдын үхэр байгаад биднээс асуувал юу гэж хэлэх юм? гэсэнд Эрхий хүү:

- Ямар ч гэм болохгүй ээ. Хоёулаа зүгээр л алаад идчихье. Надад арга байгаа гэв.

Тэгээд хоёулаа нэг бүдүүн шар барьж алж идээд үлдсэн махыг нь хоёр модны хооронд дээс татаад борцолж байтал гэнэт нэг хүн:

- Хэн та нарыг миний үхэрнээс хулгайлж ид гэсэн юм? гэж хашгирав. Эмгэн очиж хартал нэг ноён олон цэргүүдээ дагуулж ирээд зогсож байв. Эмгэн түүнийг үзээд ухаангүй айсанд, эрхий хүү:

- Ээж айх хэрэггүй, та тэр ноёны өөдөөс “Нэг ноён нь үнээ бол. Олон цэрэг нь бух бол” гэж хэл гэв. Эмгэн хүүгийн хэлсэн ёсоор:

- Нэг ноён нь үнээ бол, олон цэрэг нь бух бол гэж хэлсэн чинь, үнэхээр хэлснээр болж, нэг үнээний төлөө олон бухын зодоон болж, орой болтол зодолдов гэнэ. Тэгэхээр нь эмгэн:

- Ноён нь гэртээ харь. Цэргүүд нь цэрэгтээ буц гэж хэлсэнд ноён болон цэргүүд зам замдаа орж, мөр мөрөө хөөж гэнэ.

Маргааш өглөө нь өнөө ноён мөн л олон цэргээ дагуулан ирж:

- Хэн та нарыг миний үхэрнээс алж ид гэсэн юм? гэж асуусанд:

- Би алж идсэн юм гээд эрхий хүү гараад ирэв. Ноён Эрхий хүүг үзээд:

- Чи юунд миний үхрийг алж идсэн юм? гэж асуухад Эрхий хүү:

- Яах юу байх билээ. Өлсөж ядрахдаа алж идлээ. Та хэлэх зүйл байвал надтай ярь. Миний ээж буруугүй гэж хэлэхэд ноён “Энэ муу хүү яасан их санаатай юм” гэж басамжлан санаад:

- Хэлэлцэх юу байхав. Чамайг би ална. Гэхдээ би чамтай хоёр мөрий тавина. Чи авч чадвал би чамайг алахгүй гэв. Эрхий хүү:

- Болно, болно. Гэхдээ би бол хүүхэд. Та бол ноён хүн. Мөрийний өмнө бас нэг нөхцөл тавина гэсэнд ноён:

- Болно болно чи хэл гэв. Эрхий хүү:

- Хэрвээ би таны хоёр мөрийг авч чадвал та надад ноён зэргээ тавьж өг. Авч чадахгүй бол амайг ал гэж хэлэв. Ноён үл тоомсорлож:

- Тэгье тэгье гэж зөвшөөрөв. Эрхий мэргэн:

- Ноён таны эхний мөрий юу билээ гэж асуухад, ноён:

- Чи миний хатны насаараа зүүсэн алтан бөгжийг хуруунаас нь хулгайлж ав гэж хэлээд яваад өгөв.

Ноён гэртээ хариад олон цэргээр гэр хүрээгээ завсаргүй хүрээлүүлж, гадна талд нь хоёр нохойгоо уяад, үүдэн дээрээ хоёр бага хатнаа унтуулаад, наад талд нь босго манадаг эмгэнийг унтуулав. Мөн гэртээ нэг номч ламыг унтуулснаар барахгүй, хатны алтан бөлзгийг авч гээгнийх нь үзүүрт уяад аман дотор нь хийж, бас нэг гүзээ шар тос гэрийн тоононоос дүүжилж, доор нь нэг хувинтай цог тавьж анир чимээ гарвал тосыг хатгаж гэгээ гаргахаар бэлтгэж тавиад унтав.

Шөнө нэлээд орой болсон хойно Эрхий хүү ноёныд хүрэв. Ноёны харуулын цэргүүд бүгд унтацгааж байв. Эрхий хүү тэдний гэзгийг хооронд нь холбож сүлжээд, бууг нь өөр газар зөөж овоолчихоод, хотонд нь орж нэг хуцыг нь алж махыг нь хүрээний гадаа байгаа хоёр нохойд нь хаяж өгөөд, арьсыг нь авч хүрээний үүдэнд дэлгэж хуцных нь хоёр засааг дээр нь тавьчихаад, гадаа унтаж байсан хоёр хатны өвөрт ходоодтой баасыг нь хийж тавив. Бас үүдэнд унтсан эмгэний өвөрт нь олгойтой баасыг нь хийж, сэмжээр нь ламын толгойг бүтээгээд, шар тосных нь оронд гүзээтэй баасыг нь дүүжлээд, хатных нь хоёр алган дээр нохойны баас тавьчихав.

Тэгээд нэг шөвгөөр хатны хамарлуу шөвөгдсөнд хатан өвдөхдөө:

- Ёо, ёо гэж цочиж сэрээд хоёр гараараа хамраа илсэнд алган дахь нохойны баас хамар аманд нь шавж огиудас нь хүрч, бөөлжөөд амандаа үмхэж байсан алтан бөлзгөө гаргав.

Тэр үед Эрхий хүү алтан бөлзгийг булааж аваад:

- Алтан бөлзгийг чинь Эрхий хүү булааж аваад явлаа гэж хашгираад зугтааж явав.

Ноён түүнийг сонсоод сандран босч гүзээтэй шар тосоо хатгаж галаа асаах гэсэн чинь баахан сэвс унаж галыг нь унтраачихав. Ноён улам сандарч:

- Хүүе, хатаан, чи яав? гэсэнд хатан нь огихоос өөр үг дуугарч чадахгүй байв гэнэ. Ноён:

- Хүүе, үүдэнд унтсан эмгэн яачихав? гэхэд зарц эмгэн нь би орондоо баачихсан гэж гэнэ. Ноён гэрээсээ үсэрч гараад:

- Гадаа унтсан хоёр хатан яачихав? гэхэд хоёр бага хатан нь:

- Чи төрчихөв үү? Би төрчихөв үү? гэж бие биенээ түлхэж байна гэнэ. Ноён гэртээ орж:

- Номч лам яачихав гэхэд лам:

- Та нар төрдгөөрөө төрнө л биз. Хүний толгойг ороож яадаг байна аа? гээд толгой дахь сэмжтэйгээ ноцолдож байв. Ноён гадаа харайж гараад:

- Харуулын цэргүүд яачихав? гэхэд, олон цэргүүд:

- Чи миний хүзүүг тавь. Би чиний хүзүүг тавь гэцгээн толгой толгойгоо таталдаж байв гэнэ. Ноён хүрээнээсээ гарч “Хоёр нохой яалаа?” гээд цааш явах гэтэл өнөө хуцны арьсан дээр хальгарч унахдаа хоёр гараараа хуцны хоёр засааг бариад авав. Тэгээд ноён цочиж:

- Ёо, Ёо, Ёо миний засаа сугарчихлаа гэж хашгирав.

Ингээд алтан бөлзгөө Эрхий хүүд алдаж явуулав. Маргааш өглөө нь Эрхий хүү инээчихсэн ноёныд хүрч очоод:

- За, таны алтан бөлзөг энэ байна. Нэг мөрийгөө алдлаа. Бас нэг мөрий чинь юу вэ? гэж асуув. Ноён нэг мөрийгөө алдсандаа нэлээд царай нь барайж “Энэ удаа ч авч чадахгүй мөрий тавина даа” гэж бодоод:

- Энэ өмнө галт ууланд дэл сүүлнээс нь гал бутарсан морь бий. Чи түүнийг барьж унаад ир гэж хэлэв. Эрхий хүү:

- Болно, болно гэж хэлээд явав.

Өмнө галт ууланд байх дэл сүүлнээс нь гал бутарсан морь гэдэг нь хүнд үзэгддэггүй, амьтанд баригддаггүй, хөдөлвөл дэл сүүлнээс нь улаан гал бадардаг сахиусан морь юм.

Эрхий хүү мянган лангийн мөнгөн хазаараа авч, түмэн лангийн алтан эмээлээ үүрч гарсны дараа, галт ууланд сан тахилгаа тавьж, тэнгэр газарт мөргөчихөөд:

- Миний унаа минь хүрээд ир. Би бол лусын хааны хүү Эрхий мэргэн хаан мөн гэж хашгирсанд, цолмон нүд нь бүлтийсэн, чонон чих нь соотойсон, дэл сүүлнээс нь гал бадарсан, дөрвөн туурайнаас нь цог бутарсан морь хүрээд ирэв.

Эрхий мэргэн хүү хаан биедээ хувилж, мянган лангийн мөнгөн хазаараа хазаарлаж, түмэн лангийн алтан эмээлээ тохож, морио унан ноёныд хүрээд ирэв. Ноён түүнийг үзээд “Энэ чинь жирийн хүн биш байна” гэж бодоод бас нэг мөрийгөө алдсандаа аргагүй ноёны ширээнээсээ бууж, отго жинсээ авч, Эрхий мэргэн хаанд тушаагаад түүнийг ширээндээ залж суулгасан гэнэ.

Тэр үеэс Эрхий мэргэн хүүг Эрхий мэргэн хаан хэмээн нэрлэж, алдар цолоо мандуулан, ард олноо захирч, ээжтэйгээ хамт амар сайхан жаргаж гэнэ.

Баруун уулын нусгай бор хүү хийгээд зүүн хойд орны Түдэв ноён

Эрт урьд цагт баруун уулын нусгай бор хүү гэж сүрхий баатар эр байв. Тэр нэг хар даагатай, хугархай нум сумтай, эвдэрхий янгиатай юм гэнэ.

Нэг өдөр, нусгай борхүү өндөр ууланд гарч, ан гөрөө хийж байтал, гэнэт уулын гуунаас муухай дуу гарч байх сонстов. Нусгай бор хүү уулын орой дээр гарч гууруу өнгийж үзсэн чинь, зүүн хойд орны Түдэв ноён ан гөрөө хийж яваад гуунд уначихсан хэвтэж байв. Нусгай бор хүү ноёныг татаж гаргая гэж бодоод мориноосоо тасархай жолоо цулбуур, олом, чөдрөө тайлж аваад хугархай нум сумандаа залгаж уяад Түдэв ноёныг уулын гуунаас татаж гаргав. Тэр зүүн хойт Түдэв ноён бол туйлын баян хүн бөгөөд зөвхөн цагаан зүстэй агт нь л түм хүрдэг. Бусад зүсмийн адуу нь хэд гэдгийг хэн ч мэддэггүй гэнэ. Түдэв ноён нусгай бор хүүд ихэд баярлаж:

- Чи миний амийг аварлаа. Би чамайг агт морь, алт мөнгөөр шагнана гэж хэлэхэд. Хүү:

- Би тийм их юм авахгүй. Харин та надад ганц охиноо хатан болгож өгвөл болно гэв. Түдэв ноён аргагүй зөвшөөрч:

- За тэгвэл чи хэзээ авах өдөр судраа товлочихоод надад хэл. Би охиноо чамд өгье гэж хэлээд ноён, нусгай бор хүү хоёр гэр гэртээ харьцгаав. Нусгай бор хүү гэртээ харьж сайн цаг сайхан өдрийг сонгож, Түдэв ноёны охиныг буулгаж авахаар хүлээж байтал, улс амьтан:

- Түдэв ноён ганц охиноо тэнгэрийн гурван алд алтан хүнд буулгаж өгөөд гурван жилийн найр наадам хийх гэнэ гэж шивэр авир хэлэлцэж байв. Нусгай бор хүү түүнийг сонсоод үнэн худлыг нь мэдэхээр хамуутай хар даагандаа балбархай янгиагаа тохоод, хугархай нум сумаа үүрээд Түдэв ноёныруу явав. Замдаа олон залуучууд наадаж найрлан, үлгэр түүх ярилцаж байхтай таарав. Нусгай бор хүү хамуутай даагаа ташуурдаад олон залуусын хажуугаар гарах гэтэл олон залуус босч ирээд “Энэ чинь нүүрэндээ галтай, нүдэндээ цогтой ямар сайхан залуу вэ?” гээд нусгай бор хүүгээс:

- Хаанаас хаа хүрэхээр морилж явна вэ? гэж асуухад хүү:

- Аа, энүүгээр хоёр тэмээ өнгөрөв үү?. Алтан буйлтай хөгшин бор буур, мөнгөн буйлтай цагаан гунж, хажуу хавирганд нь хана хом хүргэж үзээгүй тийм хоёр тэмээ алдчихаад хайж явна. Та нар олж үзэв үү? гэж асуув. Залуучууд:

- Үзсэнгүй, тэр зүүн хойд орны Түдэв ноён хүүхнээ тэнгэрийн гурван алд алтан хүнд өгч гурван жилийн найр наадам хийх гэж байна. Тэнд олон хүн цугларсан байх. Тэднээс очиж асуу гэж хэлж өгөв. Нусгай бор хүү нойр сайтын гадуур найрлан шуугитал дуулаад, нохой муутын гадуур наргиулан даргиулан явж байтал зам дээр нь олон хүүхнүүд “хи хи, хэ хэ” гэж найрлан шуугилдаж байхтай таарав. Нусгай бор хүү хүүхнүүдийн хажуугаар гарах гэтэл тэр олон хүүхэн, нусгай бор хүүг үзээд “Хөөе, энэ чинь нүүрэндээ цогтой, нүдэндээ галтай яасан сайхан залуу вэ” гэж хоорондоо хэсэг шивэгнэж аваад:

- Хаанаас хаа хүрэхээр морилж явна вэ? гэж асуухад хүү:

- Аа, энүүгээр хоёр тэмээ өнгөрөв үү?. Алтан буйлтай хөгшин бор буур, мөнгөн буйлтай цагаан гунж, хажуу хавирганд нь хана хом хүргэж үзээгүй тийм хоёр тэмээ алдчихаад хайж явна. Та нар олж үзэв үү? гэж асуув. Хүүхнүүд:

- Үзсэнгүй, тэр зүүн хойд орны Түдэв ноён хүүхнээ тэнгэрийн гурван алд алтан хүнд өгч гурван жилийн найр наадам хийх гэж байна. Тэнд олон хүн цугларсан байх. Тэднээс очиж асуу гэж хэлж өгөв. Нусгай бор хүү “Түдэв ноён хүүхнээ тэнгэрийн гурван алд алтан хүнд өгч, гурван жилийн найр наадам хийх гэдэг нь үнэн юм байна” гэж бодоод нойр сайтын гадуур найрлан шуугитал дуулаад, нохой муутын гадуур наргиулан даргиулан гараад явж Түдэв ноёныд хүрэв. Түдэв ноёны харуул нь нусгай бор хүүг ноёны хүрээнд оруулсангүй гэнэ. Нусгай бор хүү:

- Би ноёны хуучин танил нь байна. Ноёнтой уулзаж найранд нь оролцохоор ирлээ гэсэнд харуул нь энэ үгийг сонсоод Түдэв ноёнд очиж хэлсэнд Түдэв ноён нусгай бор хүүг ирснийг мэдээд:

- Би тийм хүн таньдаггүй, хурдан хөөж явуул гэж зарлигдав. Харуул нь буцаж гарч ирээд ноёны үгийг дамжуулсанд нусгай бор хүү “Заавал орж уулзана” гээд явахгүй болохоор нь Түдэв ноён аргагүйд хүрч, оруул гэж хэлэв. Нусгай бор хүү Түдэв ноёны ордонд орж очиход ноёны охин түүнийг хараад:

- Хүүе, миний сайн найз ирлээ. Хурдан цай барья. Аав та миний алтан аягыг нааш нь өгөөч гэв. Түдэв ноён нусгай бор хүүг нүднийхээ булангаар ширвэж хараад “Энэ муу амьтанд алтан аягаар цай барих нь ахадна” гэж бодоод алтан аягыг дуртай дургүй авч өгөөд:

- Чи ямар хэргээр ирэв? гэж асуухад нь нусгай бор хүү:

- Аа, би таны эрийн гурван наадамд оролцохоор ирлээ гэж ажиг ч үгүй хариулав. Түдэв ноён:

- Тэр бололгүй яахав. Гэхдээ чи эхлээд энэ олон амьтны үнс хогийг гурван жил дараалан цэвэрлэж чадвал наадамд оролцуулна гэж хэлэхэд, нусгай бор хүү:

- Би эрийн гурван наадамд оролцохоор ирснээс биш, үнс хогтой чинь ноцолдохоор ирээгүй гэж хариулав. Түдэв ноён аргагүй байдалд хүрч, нусгай бор хүүг наадамдаа оролцуулахаар болжээ. Тэгж байтал эрийн гурван наадам эхлэв. Нусгай бор хүү, Түдэв ноёноос:

- Танай эндхийн эрийн гурван наадам гэж юу байдаг юм бэ? гэж зориуд асуувал, Түдэв ноён:

- Манай эндхийн эрийн гурван наадамд хамгийн түрүүнд морь уралддаг юм гэв. Нусгай бор хүү:

- Тэгвэл морины уралдааныг чухам аль зэргийн газраас тавьдаг юм? гэж асуув. Түдэв ноён:

- Гурван сарын газраас тавьдаг юм гэхэд нь:

- Ха ха, танай эндхийн морины уралдаан чинь шүдлэн байдас шургадаг шиг инээдтэй юм байна гэж элэглэн инээв. Түдэв ноён түүнийг сонсоод “Энэ муу амьтан чинь яасан их

тохуутай юм” гэж бодоод:

- Тэгээд танай тэнд чухам аль зэрэг холоос уралддаг вэ? гэж асуухад нь:

- Манай тэнд гурван жилийн газраас уралддаг юм гээд бас:

- Дараа нь юу байдаг юм бэ? гэж асуусанд, Түдэв ноён:

- Нум харвадаг юм гэв. Нусгай бор хүү:

- Аль зэргийн газраас харвадаг юм? гэж асуухад нь:

- Арван таван хоногийн газраас харвадаг юм гэхэд, нусгай бор хүү бас дооглож:

- Гурван настай хүүхдийн наадам шиг амархан юм байна. Манай тэнд бол гурван сарын газраас харвадаг гэж хэлээд шоолон инээгээд дараа нь юу байдаг юм? гэж асуухад, Түдэв ноён:

- Бөх барилддаг юм гэв. Хамгийн түрүүнд морины уралдаан тавив. Нусгай бор хүү, өнөө муу хамуутай бор даагаа унаад гурван сарын газарт хүрч очсон чинь баяд ноёдын сайн морьд гэдэг нь байх л юм. Хажууд нь нусгай бор хүүгийн хамуутай хар даага гэдэг нь жаахан ч юм. Уралдаан эхэлсний дараа, нусгай бор хүү:

- Энүүхэн газар юу байхав. Тэд түрүүлээд явж байг. Сайн морь гурван жил зогсдог. Сайн эр гурван жил унтдаг юм. За чи зогсож бай. Би унтана. Гурван өдрийн дараа намайг дууд гэж мориндоо хэлчихээд унтаад өгөв. Унтаж, унтаж морь нь дуудахаар сэрээд харсан чинь баяд ноёдын морьд ор сураггүй болсон байв. Нусгай бор хүү босч ирээд жаахан тэмээний ноос авч, дотор нь модны нүүрстэй бургасан модыг хийж ганзагалаад уралдааны морьдын араас давхив. Тэгсэн чинь ноостой нүүрс нь морины бөгснөөс гал утаа баагиулан, удалгүй уралдааны морьдыг гүйцээд түрүүлж ирэв гэнэ. Дараа нь нум харвав. Нусгай бор хүү хугархай нум сумаа аваад харвах гэсэнд баяд ноёд дооглож:

- Тэрийг хараач! Нэг муу хугархай нумаар бидэнтэй уралдана гэнэ гэж инээлдэж байв. Нусгай бор хүү юу ч дуугарсангүй, арван тав хоногийн газар хүрээд харвасанд, сумнаас нь гал манарч, бүх хүмүүсийн тавьсан сумны хамгийн цаана нь гарч түрүүлэв. Хамгийн сүүлд бөх барилдав. Нусгай бор хүү бөхийн барилдаанд орсонд баяд ноёд:

- Энэ муу нусаа даахгүй амьтан бас бидэнтэй барилдана гэнээ? гэцгээж байв. Нусгай бор хүү, Түдэв ноёны тоо томшгүй олон бөхийг гартаа торохгүй нэг нэгээр нь барьж шидээд байв. Олон түшмэл нь сандарч ноёндоо мэдүүлэхэд ноён нь:

- Шилдэг бөхчүүдээсээ сонгож тал талаас нь дайр гэж зарлигдав. Түшмэлүүд хамгийн сайн бөхчүүдээ шилж аваад нусгай бор хүүгийн хэдэн талаас нь хамт дайрсанд тал тал тийш нь тариа шиг цацаж хаяв. Түдэв ноён түүнийг хараад тэнгэрийн гурван алд алтан хүнийг барилдуул гэж зарлигдав. Түшмэлүүд тэнгэрийн гурван алд алтан хүнийг тавьсанд, нусгай бор хүү түүнийг хөлөөс нь барьж аваад газарт алд дэлэм зоож орхив. Түшмэлүүд бүр их

сандарч түүнийг арай гэж малгаж гаргав. Ингээд нусгай бор хүү Түдэв ноёны эрийн гурван наадамд түрүүлж, охиныг буулгаж аваад гэртээ харьж иржээ. Түдэв ноёны охин, нусгай бор хүүгийн гэрт нь хүрч очсонд, түүний гэр нь сүмбэр уул шиг том сайхан гэр байв. Гэрт нь алтан нум сум дүүрэн өлгөөстэй. Нусгай бор хүү өөрөө хүдэр чийрэг эр болж хувирав. Түүний унадаг хамуутай хар даага нь алт мөнгөн хазаартай, уул шиг ханагар сайхан хүлэг болж хувирав. Морин дээр тохсон эмээл нь ч уулын хөтөл шиг болж хувирчээ. Нусгай бор хүү хатандаа:

- За, сайн морь гурван сар зогсдог, сайн эр гурван сар унтдаг юм. Би одоо унтана. Чи намайг тун чухал үед дуудах болвол миний чихрүү усны саваар ус цутга. Тэгээд сэрэхгүй бол гуяруу сэлмээр хатга. Тэгвэл сэрж магад. Өөр аргаар намайг сэрээж дийлэхгүй гэж хэлээд унтжээ. Нэг өглөө, хатан нь босч өрхөө татахаар гартал аав нь өмнө уулын орой дээр ирчихсэн тэвхийтэл зогсож байв. Дагуулсан цэрэг нь уулыг харлатал нь бүрхжээ. Хатан нь сандарч “Одоо яадаг билээ. Аав цэргүүдээ дагуулж ирээд хайрт ханийг минь алах гэж байна” гэж бодоод, хурдан гэгч гэртээ гүйж ороод нөхрөө дуудсанд сэрсэнгүй. Нусгай бор хүүгийн унтахдаа хэлсэн үг санаанд нь орж, тэр ёсоор хийх гэж бодсон боловч “Хэрвээ чихрүү нь савтай ус хийвэл чих нь юм сонсохгүй болчихвол яана? Гуяруу нь сэлмээр хатгавал хөл нь доголчихвол яана” гэж бодоод алийг нь ч хийж чадсангүй, арга барагдаж нөхрийнхөө хүзүүг тэвэрч, хацраа нүүрэн дээр нь наагаад уйлж суув. Тэгсэнд хатных нь нулимс урсаад чихрүү урсаж орсонд нусгай бор хүү цочиж сэрээд:

- Чи чинь яаж байгаа нь энэ вэ? Хүн унтуулахгүй уйлаад гэж хэлсэнд хатан нь:

- Аав цэргээ дагуулж ирээд өмнө уулын орой дээр зогсож байна гэв. Нусгай бор хүү босч нум сумаа шүүрч аваад гарсан чинь үнэхээр Түдэв ноён ирчихсэн өмнө уулын орой дээр зогсож байв. Дагуулсан цэрэг нь уулыг бүрхээд, хар батгана шиг харлаж байв. Нусгай бор хүү хатнаасаа:

- За, одоо аавыг чинь харвах уу? Уулыг харвах уу? гэж асуусанд хатан нь:

- Аавыг харва! гэв. Нусгай бор хүү “Хуучны үгэнд: Эр хүн эм хүний үгэнд битгий ор гэж байдаг” гэж бодон, Түдэв ноёныг харвасангүй, түүний зогсож байсан уулыг нь харвав. Тэгсэн чинь уулыг эргүүлээд хөмөрчихөв. Түдэв ноён уулын хонин чинээ чулуун дотор хонд хонд өнхрөөд үхрийн чинээ чулуун дотор өнд өнд өнхрөөд нусгай бор хүүгийн гэрийн үүдээр өнхөрч орж ирэв. Түдэв ноён сандарч:

- Амь өршөө! гэж бархирсанд нусгай бор хүү:

- Хн, Амь өршөө гэнэ ээ? Би чиний амийг аврахад, чи юу гэж хэллээ? Би өдөр, цагийн сайныг сонгоод очиход: “Гурван жил үнс хог гарга” гэж байсан. Одоо чи нэг насаараа манай хог үнсийг гарга! Тэгвэл би чиний амийг чинь өршөөж болно гэв. Түдэв ноён:

- Болно болно гэж хэлээд нусгай бор хүүгийн хог үнсийг нэг насаараа гаргахаар болж, амиа аварч гарав. Тэгээд баруун уулын нусгай бор хүү, зүүн орны Түдэв ноёныг дарж, эд хөрөнгө, нутаг дэвсгэрийг нь хурааж энх тайван амьдарсан гэнэ.

Хатанбаатар

Эрт урьд цагт, Хатанбаатар гэдэг сайн эр байж гэнэ. Нэг өглөө босоод Алтай дээрээ гарч арван гурван сангаа тавьж хамаг амьтныг ариулж, хойд уулын орой дээр гарч хорин гурван сангаа тавьж, хонсим бодисадваг ариулаад байж байтал нар гарах зүгээс нэгэн хэрээ дуугараад ирж байна гэнэ. “Энэ юу болж байгаа юм бол” гээд чагнаад сууж байтал, хэрээ:

- Арван толгойтой атгар мангасын хүү, тэнгэрийн лусын хүү, цагаан лусын хүү гурвуулаа, эрийн гурван наадам хийж, Саран дагина авхайг авна гэж хэлж байна гэхэд Хатанбаатар “Энэ муу хэрээ орчлонгийн олон амьтанд хэл түгээчих юм байна” гээд ганц харваж оноод хүзүүг нь мушгиж эргүүлээд, харьж иржээ. Хатанбаатар аавдаа:

- Аав аа, одоо надтай ханилах сайн дагина хэн байна? Харшлах муу дайсан хаана байна? гэж хайж яваад ирье гэжээ. Аав нь:

- Өө, хүү минь, юу хийх вэ? Хүний газар хэцүү, хүн болгон омогтой шүү. Одоо нас чинь бага, цус чинь шингэн байна. Байг байг гэж хэлжээ. Тэгэхээр нь ээждээ очоод:

- Ээж ээ, одоо надтай ханилах сайн дагина хэн байна? Харшлах муу дайсан хаана байна? гэж хайж яваад ирье гэжээ. Ээж нь:

- Өө, хүү минь, юу хийх вэ? Хүний газар хэцүү, хүн болгон омогтой шүү. Одоо нас чинь бага, цус чинь шингэн байна. Байг байг гэж хэлжээ. Хатанбаатар:

- Би заавал явдаг хүн гээд хоёр хормойгоо хондлой дээрээ хавчуулж, нэг дов даван даван гишгээд, хоёр дов даван даван гишгээд явжээ. Аав, ээж хоёр нь хориглоод дийлэхгүйдээ:

- Хүү минь, заавал явах юм бол, аавынхаа алтайгаар дүүрэн алаг адууг тууж ирээд, аль сайн хүлгээс нь нэгийг барьж унаад яв гэв. Хатанбаатар алтайгаар дүүрэн алаг бараан адуугаа тууж ирээд мөнгөн цалам, алтан цалам хоёроороо бугуйлдаад авсан чинь нэг хамуутай бор даага орж гэнэ. “Үүгээр чинь юу хийх вэ?” гэж хамуутай бор даагыг цалмаасаа мулталчихаад бас нэг цаламдаад авсан чинь мөн өнөөх хамуутай бор даага орж гэнэ. “Аавын сайн хүлгээс унах заяагүй юм болов уу?” гэж тэр хамуутай бор даагыг дахин тавьж хөөчихөөд, гуравдахь удаагаа цаламдаад авсан чинь бас тэр хамуутай бор даага цаламд нь оржээ. Хатанбаатар “Одоо аавынхаа сайн хүлгүүдээс унаж явах заяагүй юм байна” гэж урам хугараад дахин нэг цалмаа татаад авсан чинь өнөө хамуутай бор даага магнай халзан морь болчихоод иржээ. Тэр морь тэнгэрт гарч од тоолон булгиж, тэгш сайхан тогтож, газарт орж хөрс тоолон булгиж, гавшгай сайхан тогтож гэнэ. Хатанбаатар баярлаж магнай халзан мориндоо хөдөөгийн чинээ хөвөн цагаан тохмоо тохож, уулын чинээ улаан зандан эмээлээ тохож, хад болтол сойж, хайрцаг болтол хагсаачихаад гэртээ ороод ирсэн чинь ээж нь утаагүй галаа түлээд, уургүй цайгаа чанаад, баг том домбондоо хийгээд зандан улаан ширээгээ тавьж, далан хүн дааж дэмнэдэггүй даргар цагаан шаазандаа цай дүүргээд өгөв. Хатанбаатар шаазантай цайг нь тосч аваад таван хурууныхаа өндгөн дээр тавьчихаад амталж шиншилж байгаад ханатлаа уув. Аав нь:

- За, хүү минь, хүний газар хэцүү, хүн болгон омогтой шүү. Ерэн тэхийн эврээр хийсэн их

хар нум, далан тэхийн эврээр хийсэн даш хар нум, гурын хүзүүгээр гурамсалж хийсэн хөвч нь уулын чинээн улаан зандан эмээлийн чинь урд бүүргэн дээр бий шүү гэж захив. Ээж нь:

- За, хүү минь, хүний газар хэцүү, хүн болгон омогтой шүү. Хүү минь өлсөж цангаж ядарвал, ээжийн чинь баруун хөхний сүүнээс хольсон, хөрөв хонины сүүгээр хийсэн хурууд уулын чинээ улаан зандан эмээлийн чинь хойд бүүргэнд бий шүү гэж захив. Хүү нэг гүвээ даван даван гишгээд, хоёр гүвээ даван даван гишгээд явж байсан чинь морь нь:

- Чи намайг сайн морь гэж унаж байна уу? Би чамайг сайн эр унуулж байна уу? Хоёулаа ид шидээ үзэлцье гэжээ.

- За, тэгвэл тэгье. Хэн нь түрүүлж үзүүлэх вэ? гэвэл морь нь:

- Та эхэлж үзүүл гэв. Хатанбаатар хүзүүн дээгүүрээ хөх гал бадруулан, цэнхэр будан гүйлгэж, хоёр хамраасаа мөнгөн луу алтан луугийн толгой цухалзуулаад, оройноосоо Очирваань бүтээгээд, гар хөл хоёроосоо гал оч бутруулан шидээ үзүүлэв. Морь нь үзээд:

- Би таны гарыг даавал та ч сайн байна гээд дэлэн дээгүүрээ хөх будантай гал бадруулж, хоёр хамраасаа алтан луу мөнгөн луугийн толгой цухалзуулаад, оройноосоо Очирваань бүтээгээд, дөрвөн туурайнаасаа гал гялбаа бадруулан шидээ үзүүлэв. Хатанбаатар:

- Би чиний гарыг даадаг юм бол чи ч сайн хүлэг байна гэж хэлээд:

- За, одоо хоёулаа явья. Хүний газар хэцүү. Хүн болгон омогтой тул чи нэг хамуутай бор даага болчих, би нэг нусгай бор хүү болоод явья гэв. Тэгээд Хатанбаатар нэг муу нусгай бор хүү болж хувилаад, магнай хүрэн морь нь хамуутай бор даага болж хувираад цаашаа явав. Яван явсаар нэг өвс устай сайхан талд хүрэв. Нусгай бор хүү жаахан залхуурч “Энд морио идүүлж авья” гэж морио чөдөрлөж тавьчихаад, уулын чинээ улаан зандан эмээлээ дэрлэж, талын чинээ хөвөн цагаан тохмоо дэвсэж хэвтэж байсан чинь унтчихжээ. Нэг мэдэхэд морь нь хүрч ирээд:

- Та чинь яасан сайн эр вэ? Нумны хөвчийг барс ирж тас хазаж аваад явлаа гэв. Нусгай бор хүү:

- Өө, тэгвэл тэгэг. Миний аавын хийсэн нумны хөвч бас бий гэж босоод, гурын хүзүүгээр гурамсалж хийсэн нумныхаа хөвчийг эмээлийнхээ урд ганзаганаас авч нумандаа хийчихээд, ээжийнхээ хийж өгсөн хуруудаа эмээлийнхээ хойд ганзаганаас авч идчихээд цааш явав. Явж байтал замд нь ар дээрээ араг үүрсэн, өвөр дээрээ савар хадсан нэг эмгэн явж байжээ. Нусгай бор хүү эмгэнээс:

- Та хаашаа явж байна вэ? Таны гэр хаагуур байдаг вэ? гэж асуув. Эмгэн түүнийг үзээд:

- Нүдэнд үзэгдэхгүй, чихэнд сонсогдохгүй нусгай бор хүү, хамуутай даагатайгаа хаанаас хаана хүрэхээр явж байгаа юм бэ? гэж гэдэргэ асуув. Нусгай бор хүү:

- Би танай ноёны найранд бараа больё гэж явна гэсэнд, эмгэн:

- Хэй, хүү минь, чи тоосонд нь дарагдчихна биз, хурдан буц буц! гэв. Нусгай бор хүү:

- Муу ч гэсэн эр хүний зориг байна. Саран дагина авхай чухам хаана байхыг та надад зааж хайрла гэж гуйв. Эмгэн хэлж өгсөнгүйд, хүү:

- Ээжтэй минь адил ээж байна. Та зааж хайрла. Би хүнд хэлэхгүй гээд дахин дахин гуйсанд эмгэн аргагүй байдалд хүрч:

- Чи ингээд явж байтал үдийн газарт нэг хас худагнаас алтан ховоогоор ус татаж, мөнгөн саванд хийж байх гурван охин зогсож байх буй. Түүний дундах нь Саран дагина авхайн бараа болооч охин нь юм, чи түүнээс л асуувал хэлж өгнө гэж хэлж өгөв. Нусгай бор хүү:

- Баярлалаа. Ээжтэй минь адил ээж байна. Дараа ачийг чинь хариулнаа гэж хэлээд цааш явжээ. Явж байгаад үдийн газарт хүрсэн чинь үнэхээр нэг хас худагнаас алтан ховоогоор ус татаж, мөнгөн саванд хийж байх гурван охинтой таарав. Хажууд нь хүрээд очсон чинь тэр гурван охин ер үг дуугарах биш. Нусгай бор хүү:

- Хол газраас ирсэн билээ. Миний хамуутай бор даага минь өлсөж цангаад хатаж үхэх гэж байна. Та нар ховоогоо зээлж өгнө үү? Би морио усалъя гэв. Тэр гурван охин дуртай дургүй ховоогоо өгөв. Нусгай бор хүү морио усалж авчихаад гээгнийхээ даруулган доороос бичиг гаргаж дундах охинд өгөөд:

- Үүнийг Саран дагина авхайд өгчих гэсэнд, охин дуртай дургүй авав. Нусгай бор хүү худгийн цаана гарч, морио идүүлж явав. Нөгөө охин усаа аваад гэртээ харьж ирэхэд Саран дагина авхай:

- Чи өнөөдөр усан дээр яагаад удав? Хэнтэй уулзав? гэж асуухад, охин:

- Юм алга гэж хариулахад, Саран дагина авхай:

- Шувуу шаазгай ч алга уу? гэсэнд, охин:

- Нүдэнд үзэгдэхгүй, чихэнд сонсогдохгүй нэг муу хамуутай бор даага хөтөлсөн нусгай бор хүү ирээд алтан ховоогий маань зээлж аваад морио усаллаа. Тэр морио усалчихаад гээгнээсээ нэг бичиг гаргаж танд өгөөрэй гэлээ гэв. Саран дагина авхай:

- Тэгээд тэр бичгийг яасан бэ? гэхэд охин:

- Энэ сайхан өргөөнд тийм муу бичгийг яаж оруулах билээ гээд гэрийн гадна бүсэнд хавчуулчихлаа гэв. Саран дагина авхай:

- Тэгж болдог юм уу? Муу ч гэсэн эр хүний бичиг байна. Чи хурдан оруулж ир! гэв. Бараа болооч охин гарч нусгай бор хүүгийн өгүүлсэн бичгийг авч Саран дагина авхайд өгөв. Саран дагина авхай тэр бичгийг үзээд:

- Чи одоохон явж, тэр нусгай бор хүүг цай зоогло гэж залж ир гэж бараа болооч охиныг явуулав. Өнөөх охин удсангүй араас нь давхиж ирээд нусгай бор хүүд:

- Саран дагина авхай таныг цай зоогло гэж залж байна гэв. Нусгай бор хүү түүнийг сонсоод:
- Явдлын саад байна. Гэхдээ яахав залж байгаа бол очье гээд өнөө охиныг дагаж Саран дагина авхайнд хүрч очив. Тэгээд тэр далан тэхийн эврээр хийсэн далай хар нумаа гэрийнх нь баруун тал дээр тавьсан чинь гэр нь овос гэж гэнэ. Ерэн тэхийн эврээр хийсэн их хар нумаа гэрийнх нь зүүн тал дээр тавьсан чинь гэр нь ялбис гэж гэнэ. Нусгай бор хүү:
- Ийм муу мод шор хоёрыг даадаггүй яасан өргөө вэ? гээд шорыг нь авч газар хатгаад нумаа дээр нь өлгөөд гэрт оров. Тэгсэн чинь Саран дагина авхай гэртээ утаагүй галаа түлж, уургүй цайгаа чанаад, баг том домбондоо хийж, зандан улаан ширээн дээрээ далан хүн даадаггүй далай цагаан шаазандаа хийгээд тавьж өгөв. Нусгай бор хүү тэр шаазанг авч таван хурууныхаа өндгөн дээр тавиад ууж гэнэ. Нусгай бор хүү цай ундаа ууж дуусахаар нь Саран дагина авхай гэрт байгаа нэг өвгөний зүг зааж:

- За, та манай энэ өвгөнийг дагаж сааль сүүний газраар явж хэд хоног сааль цагаа зооглоод ир. Манай наадам болтол гурав хоногийн зай байна гэв. Нусгай бор хүү тэр өвгөнийг дагаад гэрт нь хүрсэнд нэг эмгэн байв. Тэр эмгэн нусгай бор хүүг үзээд:

- Нүдэнд үзэгдэхгүй, чихэнд сонсогдохгүй нусгай бор хүүг хаанаас дагуулаад ирэв? гэж өвгөнөөсөө асуув. Өвгөн нь:

- Манай ноёны найранд бараа болохоор ирсэн юм гэнэ. Манай ноёных цагаа идэж уугаад ир гэж явууллаа гэв. Эмгэн өвгөнийхөө хэлсэн үгийг сонсон, нусгай бор хүүд хандан:

- Өө, тийм үү? Тэгвэл цаад ханын толгойд байгаа хөхүүртэй айрагнаас хийгээд уу! гэв.

Хатанбаатар хүү үг дуугүй тэр хөхүүртэй айргийг авч, өвгөн эмгэн хоёрыг нааш цааш харж байх зуур цөмийг нь уучихжээ. Эмгэн түүнийг үзээд:

- Хүүхдийн найр наадам дээр аваачих гэсэн юмыг чи цөмийг нь уугаад барчихлаа. Манай ноён ямар сүрхий юмаа явуулсан юм. Одоо айраг цагаа байхгүй яадаг билээ гэж дуу тавин гаслав. Өвгөн:

- Хол газраас өлсөж зүдэрч ирсэн юм байлгүй. Ханаж цадаж аваг хөөрхий. Чи бид хоёр тэр далан цагаан ботгоо зэллэчихвэл юу эс дүүрдэггүй юм гэж хэлээд нусгай бор хүүд хандан:

- Чи тийм сүрхий юм бол манай хорин жилийн хортонд автагддаггүй ёлго шарга буурыг орой ирэхээр нь бариад идчих гэв. Орой болж тэмээн сүрэг хүрч ирэхэд хамгийн түрүүнд нь хоёр бөх нь үүлэнд хүрсэн, дөрвөн таваг нь газрын хөрс бүрхсэн ёлго шарга буур хүрч ирэв. Нусгай бор хүү өөдөөс нь угтаж очоод дээд уруул дээрээс нь барьж аваад тавхийтэл газар цохиод:, доод уруулаас нь татаж аваад дувхийтэл газар цохиод сээрийг нь шигдтэл, сэмжийг нь гоожтол цохичхов. Тэгээд нэг талыг нь чанаж идчихээд, нэг талыг нь шороонд хатгаж болгочихоод эмгэн өвгөн хоёрт тавьж өгөв. Тэр хоёр идэж ууж чадсангүй. “Яасан ядарсан хоёр вэ” гэж эмгэн өвгөн хоёрын нааш цаашаа харахын хооронд өнөөх тал махыг нь бас идчихээд арьсыг нь элдээд тавьчихав. Тэгээд ноёны найр наадамд очжээ. Тэгсэн чинь арван толгойтой атгар хар мангасын хүү, тэнгэрийн лусын хүү, цагаан лусын хүү бүгд ирчихсэн

байв. Наадам эхлэв. Хамгийн түрүүнд нум харвана гэнэ. Яаж харвах юм гэхээр түмэн хасаг түлээг бут бут харваж, шүд чигчлэх юмгүй болтол харвах юм гэнэ. Бас боохой хар чулууг бяцартал нь харваж, хэтэд хийх юмгүй болтол харвана гэнэ. Нумны уралдаан эхлэв. Хамгийн түрүүнд атгар хар мангасын хүү харважээ. Тэгсэн чинь түмэн хасаг түлээ болон боохой хар чулууны цаана нэг пирд гээд, наана нь нэг пирд гээд онож чадсангүй. Дараа нь цагаан лусын хүү харвав. Тэгсэн чинь энд нэг түсгээд, тэнд нэг түсгээд бас онож чадсангүй. Дараа нь тэнгэрийн лусын хүү харвав. Тэгсэн чинь наана нь нэг тоос бургиад, цаана нь нэг тоос бургиад ер онож чадсангүй. Хамгийн сүүлд нусгай бор хүү харвав. Тэгсэн чинь тэр үдшийн улаан нарнаар уушгин улаан царайгаа гаргаж байгаад түсгээд түмэн хүний чимээ гаргаад, тасгээд тавин хүний чимээ гаргаад түмэн хасаг түлээг нь шүд чигчлэх юмгүй болтол, боохой хар чулууг хэтэд хийх юмгүй болтол харвав. Нусгай бор хүү:

- Энэ хэний наадам болов? гэж асуухад ялагдсан гурван хүү бүгдээрээ:

- Чигчийн чинээ чиний наадам боллоо гэв. Дараа нь бөх барилдах болов. Яаж барилдах юм гэвэл шавар байшин модон байшин бариад модон гадас шааж тавьчихаад түүнийг хуга хуга дэлээд барилдах юм гэнэ. Нусгай бор хүү:

- Өө, энэ чинь ямар хүүхдийн тоглоом, балчирын наадам биш, төмөр байшин шилэн байшин бариад төмөр гадас шааж уячихаад шавар байшин, модон байшин, төмөр байшин, шилэн байшин цөмийг нь дэлбэ дэлбэ дэлээд барилдацгаая гэв. Олноороо:

- Тэгвэл тэгье гэж зөвшөөрч, уралдаан эхлэв. Хамгийн түрүүнд арван толгойтой мангасын хүү байшинд орж дэлсэн чинь энд жирс тэнд жирс гээд байшингуудыг тэлж чадсангүй гараад ирэв. Дараа нь цагаан лусын хүү орж дэлсэн чинь энд ширт, тэнд ширт гээд мөн дийлсэнгүй. Дараа нь тэнгэрийн лусын хүү дэлэхээр орсон чинь энд пирд, тэнд пирд гээд дийлсэнгүй гэнэ. Хамгийн сүүлд нусгай бор хүү орж дэлжээ. Тэр төмөр байшин, шилэн байшинг модон байшин болон шавар байшинтай нь хамт хага хага дэлээд, төмөр гадас модон гадсыг нь цөм хуга хуга татаж хаячихаад гарч ирэв. Нусгай бор хүү:

- Энэ одоо хэний наадам болов? гэж асуухад нь гурван хүү бас:

- Чигчийн чинээ чиний наадам боллоо гэв. Хамгийн сүүлд морины уралдаан тавихаар болов. Яаж уралдах юм гэхээр үдийн газраас тавина гэнэ. Нусгай бор хүү:

- Энэ чинь ямар хүүхдийн тоглоом, балчрын наадам биш. Өдрийн газраас тавья гэв. бүгдээрээ:

- Тэгвэл тэгье гэж зөвшөөрч, морины уралдаан тавив. Нусгай бор хүүгийн хамуутай бор даагыг Саран дагина авхайн бараа болооч охин нь унахаар болжээ. Явахад нь нусгай бор хүү охинд:

- За, чиний замд айраг цагаа, сүү хайлмаг зэрэг амттан барьсан эмгэн өвгөн хоёр зогсож байх буй. Түүнээс нь чи огт амсаж болохгүй шүү. Зүгээр л шулуухан өнгөрөөд яваарай гэж захив. Бараа бологч охин явж байтал үдийн газар хүрэхэд зам дээр нь үнэхээр эмгэн өвгөн хоёр айраг тараг, сүү хайлмаг барьчихсан:

- Холоос явж байгаа хүн цангаж зүдэрч байгаа байлгүй. Цагаанаас идэж уугаад яв гээд зогсож байв. Бараа бологч охин харангадаж цангаж байхлаар тэссэнгүй өнөөх цагаанаас нь уучихав. Тэгсэн чинь ухаан алдан унав. Нэг сэрсэн чинь морь нь нулимс унаган толгой талд нь зогсож байна гэнэ. Морины нулимс охины аманд тусаж тэр охин сая сэрсэн юм байжээ. Морь нь охины сэрснийг үзээд:

- Чи сайн эрийн минь нэрийг гутааж байна. Чамайг замдаа хүний юмыг битгий идээрэй гэж захиж байхад чи юунд идэв? Одоо хурдан морд. Би харайхаараа харайна. Чи тогтохын чинээгээрээ тогт гэв. Бараа бологч охин мориндоо мордож давхисаар уралдааны морьдыг гүйцэж, нэг нэгээр нь ардаа орхиж явсаар Саран дагина авхайн бэлхүүстэй хээр морийг нь гүйцэж иржээ. Охин хажуугаар нь орж ирээд:

- Чиний морь хэдий сайн ч эмэгтэй хүний морь юм. Миний морь хэдий муу ч эр хүний морь юм. Чи миний баруун ташааг дэрлүүлээд яваад бай гэв.

Саран дагина авхайн морийг унасан хүү:

- Үгүй, чадал чадлаараа больё гэв. Тэгсэнд нусгай бор хүүгийн хамуутай бор даага олныг тоосон дундаа хаячихаад түрүүлж давхив. Үдийн хойно орой болоход нэг цагаан тоос харагдав. Барианы газарт байсан хүмүүс:

- Чиний морь болов уу? Миний морь болов уу? гэгцгээв. Нусгай бор хүү:

- Миний хамуутай хар даага биш үү? гэхэд наадамчид:

- Чиний тэр муу хамуутай бор даага чинь аль эрт тоосонд дарагдчихсан. Энэ ирж байгаа морь бол бидний аль нэгний морь байлгүй гэгцгээж байв. Тэгтэл нусгай бор хүүгийн хамуутай хар даага магнай халзан морь болчихсон хоёр хамраасаа алт мөнгөн луугийн толгой цухалзуулсаар ирж байна. Барианд хүрч ирээд тэр морь тэнгэрийн одыг тоолон булгиж, газрын хөрсийг тоолон булгиж яг сайхан тогтож гэнэ. Нусгай бор хүү:

- Энэ хэний наадам болов? гэхэд нь бүгдээрээ:

- Чигчийн чинээ чиний наадам боллоо гэв. Энэ үед нусгай бор хүү Хатанбаатар болон хувирч, орой дээрээсээ Очирваань бүтээгээд, гэгсэн дээрээ хөх гал бадруулан цэнхэр будан гүйлгэж, гар хөл хоёроосоо гал гялбаа бутруулан, хоёр хамраасаа мөнгөн луу алтан луугийн толгой цухалзуулаад сайн эр болов. Тэр эрийн гурван наадмын манлай болж, Саран дагина авхайг хатнаа болгож аваад, гэртээ харьж аав ээж, ах дүү нартайгаа уулзаж амар түвшин жарган суужээ.

Хажил харын Хавхаг соёо

Эрт урьд цагт, Хажил харын хавхаг хар гэдэг хүүхэд ээж аавтайгаа амьдарч байжээ. Түүнийг есөн настай байхад нь эгчийг нь тэр нутгийн хаан хатнаа болгоно гээд аваад явчихжээ. Хаан, эгчийг нь аваад явсны дараа Хажил харын хавхаг соёо нэг багшид шавь орж, багшийндаа арван тав хүртлээ есөн шид сурч суув. Тэр есөн шид сурчихаад гэртээ харьж явсан чинь замд нь хааны гүнж илбийн хар малгай, далдын хүрэн цэцэг, хас манхан туурай гурван эрдэнээр наадаж байв. Тэр шидээ гаргаж гурван зүйлийн эрдэнийг нь аваад явав. Энэ илбийн хар малгайг зүүчихээд хас манхан туурайгаа барьвал хаана хүрье гэвэл тэр газраа хүрчихдэг бөгөөд далдын хүрэн цэцгээ барьвал үзэгдэхээ байчихдаг юм гэнэ. Хажил харын хавхаг соёо тэр гурван зүйлийн эрдэнээ аваад гэртээ ирж, хаанд мордсон эгчийнхээ төлөө санааширч суутал тэр айлд хааны адуу харсан хүн ирэв. Адуучнаас эгчийгээ сурагласанд нөгөө хүн:

- Ай даа, хэлэхийн арга байхгүй. Хаан эгчийг чинь аваачиж хатнаа хийсэнгүй, харин өмнө нь төмөр савар бариулж, ард нь модон арга үүрүүлээд зарцаа болгосон гэж хэлэв. Хажил харын хавхаг соёо түүнийг сонсоод уур нь дүрсхийж, хааныг олж өшөөгөө авахаар явав. Тэгээд яваад хүрсэн чинь эгч нь үнэхээр төмөр савар барьж, модон арга үүрээд аргал түүж явах нь таарав. Хажил харын хавхаг соёо “Энэ арай миний эгч биш биз?” гэж лавлаж үзсэн чинь эгч нь танигдахын аргагүй болчихсон байв. Хажил харын хавхаг соёо “Хөөрхий эгчийг минь ийм болгох гэж” хэмээн харуусаад бодсон боловч, эгч нь харин дүүгээ таньсангүй:

- Та хаашаа явж байгаа юм бэ? гэж асуусанд, дүү нь:

- Би хааныхруу явж байна гэж хэлэв. Эгч нь мөн дүүгээ таньсангүй:

- Болохгүй. Чи хааныд яасан ч очиж болохгүй. Тэр чинь тоодог дөчин хоёр шувуутай, асар басар хоёр нохойтой юм. Тэр хэдэн амьтан нь бэрх юм бий. Барагтай амьтан орж чаддаггүй юм гэж хэлсэнд, Хажил харын хавхаг соёо:

- Гэмгүй. Надад арга бий гэж хэлээд явж хааныд хүрсэн чинь тоодог дөчин хоёр шувуу нь өмнөөс нь нисээд ирэв. Тэр нэг шидээ гаргаж хоёр шувууг нь намначихжээ. Тэгтэл хоёр нохой нь дайраад ирэв. Тэр бас нэг шидээ гаргаж, хоёр нохойг нь намначихаад хааны ордонд оров. Хаан Хажил харын хавхаг соёог үзээд “Хүүе энэ чинь сүрхий амьтан байна” гэж бодоод түүнтэй үг дуугүй тулалдаж эхлэв. Хэдэн өдрийн турш тулалдаад хааны хүч сулраад ирэхээр нь Хажил харын хавхаг соёо:

- Чи миний эгчийг хатнаа болгоно гэж худал хэлж авч ирчихээд зарцаа хийж дарлаад үйл тамыг нь үзсэн учраас би чамаас өшөөгөө авч, эгчээ дагуулж явна гэв. Хаан түүнийг сонсоод ялагдаж буйгаа мэдэхгүй:

- Чи чинь их шид сурсан хүн гэл үү? Чи шидээ гаргаад эгчийгээ авч яв гэж омогдож хэлж гэнэ. Хажил харын хавхаг соёо “Энэ муу үхлийн амьтан бас саваагүй үг хэлнэ гэнэ ээ?” гэж шидээ гаргасанд хааны бүх алба, адуу мал цөм хамагдаад хүрээд ирэв. Тэгээд эгчийгээ дагуулаад хааны бүх эд хөрөнгө, адуу малыг хурааж аваад гэртээ харив. Хажил харын хавхаг соёо явсны дараа хаан хэсэг зарцаа түүний араас явуулж эд хөрөнгөө булааж ирэх гэсэнд, Хажил харын хавхаг соёо нэг модон шүүр гаргаж шидээ үзүүлсэн чинь хааны зарц нарын

өмнөөс хэсэг харанхуй хар хулс ургаж юу ч үзэгдэхээ байв. Тэгээд Хажил харын хавхаг соёо хаанд баригдсангүй гэртээ хүрэв. Хэдэн жилийн дараа, хаан гуйлгачин болж хоол гуйгаад Хажил харын хавхаг соёогийнд хүрч ирэв. Хажил харын хавхаг соёо сайхан хоол хийж хааныг долоон өдөр дайлав. Хаан учрыг нь олохгүй гайхаж асуусанд, Хажил харын хавхаг соёо учраа хэлж хаанаас эгчийнхээ өшөөг авна гээд шавар цөгц хийчихээд хааныг голд нь зогсоож тос цацаад, зулын гол болгож алсан гэнэ. Тэгээд Хажил харын хавхаг соёо өшөөтнөө дарж, аав ээж эгч нартайгаа амар тайван амьдарсан гэдэг.

Шилийн сайн эр Дохиур Тангад

Эрт урьд цагт, Дохиур Тангад гэдэг нэртэй шилийн сайн эр байж гэнэ. Тэр үргэлж баяд ноёдын адуу малыг хулгайлж, ядуу зүдүүг тэтгэж явдаг байжээ. Нэг удаа, ядуу залуу Дохиур Тангадынд хүрч ирээд түүний шавь больё гэж гуйгаад хэд хоножээ. Дохиур Тангад аргагүйдэж:

- За, чи миний шавь болж болно. Гэхдээ гурван ес эхлэхэд хорин бурантаг, хорин богт чөмөгний залаа, хорин шагай бэлдэж, нэг сайн морь унаад ир гэж явуулав. Гурван ес эхлэхэд өнөө залуу багшийнхаа хэлсэн ёсоор алив юмаа бэлтгэж аваад, нэг сайн морь унаж болзсон газартаа хүрээд ирсэн чинь багш нь эрт гэгч нь ирчихсэн хоёр том ирэгийн мах чанаад сууж байв. Залууг ирэхэд багш нь хоёр ирэгийн махныхаа нэгийг нь өөрөө идэж, шавьдаа нэгийг нь өгөв. Дохиур Тангад нэг ирэгийн мах идчихээд шөлөнд нь бас атга будаа чанаж идээд унтчихав. Шавь нь өнөө тарган ирэгний махнаас жаахан жуухан идээд тун идэж чадсангүй. Багш нь унтаж унтаж сэрээд босч ачаа бараагаа ачиж шавиа дагуулж долоон өдөр, долоон шөнө унаанаасаа буулгүй явж, нэг уулан дээр ирж, том хадаар амыг нь дарсан агуйд хүрээд мориноосоо бууж, шавьдаа:

- За, чи очиж тэр хадыг аваад хаячих, бид дотор нь орьё гэж хэлэв. Шавь залуу шальтай юм идээгүй, долоон өдөр долоон шөнө морин дээрээ хоосон явсан болохоор өлсөхийн хажуугаар бөгс хас нь шалбарч өвдөөд явж чадахаа байчихав. Тэр арайхийж мориноосоо бууж, агуйн аман дээр ирээд тагласан чулууг нь авч хаях гэсэн боловч өчүүхэн ч хөдөлгөж чадсангүй. Дохиур Тангад түүнийг үзээд үг дуугүй очиж өнөө агуйн амыг тагласан чулууг өвс авч байгаа юм шиг авч чулуудчихаад дотор нь оров. Шавь залуу агуйд ороод үзсэн чинь дотор нь түлээ түлш, ус цас, малын хатсан борц, тогоо шанагаас эхлээд юм бүхэн бүрэн байв гэнэ. Багш шавь хоёр тарган малын борцноосоо цадталаа чанаж идчихээд унтав. Хэдэн өдөр унтаж аваад багш нь:

- За, одоо босъё, хоёулаа явцгаая гэж хэлээд агуйнаасаа гарч агуйн амыг нөгөө чулуугаараа дарчихаад явав. Бас цааш явж, уулын бэлд ирж морио чөдөрлөж тавьчихаад, уулын орой дээр гарсан чинь тэр уулын зүүн өмнө зүгт хоёр сайхан монгол гэр байх бөгөөд цаана нь олон тэмээ мал нэлийж үзэгдэв. Багш шавь хоёр нар шингэхийг хүлээж орой болоход багш нь:

- За, одоо хоёулаа мордьё. Тэр айлд нэг сүрхий эмгэн хоёр зүүлэг хүүтэйгээ байдаг. Түүнээс айх юмгүй. Харин хоёр сүрхий нохойтой. Түүнээс нь болгоомжлох хэрэгтэй гэж хэлээд явав. багш шавь хоёр айлын гадаа бууж малынх нь хашаанаас морио уячихаад, багш нь хашааны арын чулуунаас сугалж эхлэв. Шавь нь бас очоод суглах гэсэн чинь огт дийлсэнгүй. Багш нь хашааны чулуунаас сугалсаар байгаад том нүх гаргав. Тэгээд багш нь нөгөө нүхээр хоёр хонь гаргаж алаад, дотор гэдсийг нь авч, шавьдаа:

- За, чи энэ хоёр хонины махыг эмээлийн бүүргэнд янгинатал баглаж тавь. Би очиж нохой тэжээе гээд дотор гэдсийг авч яваад хоёр нохойд нь хаяж өгөв. Хоёр нохойг хоолоо идэж байх хооронд багш, шавь хоёр арван бурантаг, арван богт чөмөгний залаа болон арван шагай хувааж аваад, айлын тэмээний хотонд орж богт чөмөгний залаагаа тэмээний хамарт нь оруулаад, бурантгаар нь оосорлон шагайгаараа торгоогоод хүний арав арав барьж хөтлөөд явав. Тэгээд цаашаа нэлээд явж байгаад эргээд харсан чинь араас нь айлын шон дээр уяатай

байсан буур нь модоо чирээд ирж байв гэнэ. Дохиур Тангад түүнийг үзээд баярлаж шавьдаа:

- За, чи тэмээ морьдоо хөтлөөд яв. Би энэ буурны аргыг олъё гэж хэлээд, өнөө хавшсан буурыг барьж авчрахаар давхив. Дохиур Тангад буурыг барьж аваад бурантагнаас нь чирэгдсэн шонг сугалж хаячихаад унаж явав. Тэр хоёр явсаар үүр цайхын үед нэгэн том ууланд хүрч, бас нэг агуйн гадаа ирээд ачаа бараагаа буулгав. Шавь залуу нь агуйн амыг тагласан чулууг авах гэж оролдсон боловч бас л чадсангүй. Багш нь үг дуугүй ирж, том чулууг авч хаячихаад:

- Хоёр хонины махаа өвчиж чана гэж хэлэв. Залуу махаа өвчих гэсэн чинь гурван есийн хүйтэнд тэс хөлдсөн махыг яагаад ч дийлсэнгүй. Тэгээд яах учраа олохгүй гайхан зогсож байтал багш нь хүрч ирээд өнөө хөлдүү махыг хадан дээр хэд шавхардаж гэсгээгээд, арьсыг нь хуулж өвчөөд чанаж иджээ. Тэгээд хэдэн өдөр унтаж босоод, багш нь шавьдаа:

- За, одоо хоёулаа салж явъя. Би чамд арван тэмээ өгье. Чи түүнийг аваад гэртээ хариарай. Аав ээждээ энэ тэмээг буруу талаасаа туйлдаг юм гэж хэлээд өг гэж захиад:

- Үүнээс хойш намайг битгий дага. Өөрийн хүчээр хоолоо олж ид. Дахиж хулгай зэлгий битгий хий! гэж хэлээд явчихаж гэнэ.

Эрээн цагаан тоодогны мэргэн хаан

Эрт урьд цагт Эрээн цагаан тоодогны мэргэн хаан хэмээх сайн эр байж гэнэ.

Тэр газар Хар тоодогны хаан хар тарлан ахтай, дун цагаан дүүтэй, дуран навай эгчтэй, гэр мэдэх гэдэнтэй, гэдэс унжих бичигтэй юм байжээ.

Нэг өдөр, Хар тоодогны хан Эрээн цагаан тоодогны мэргэнтэй андуурахдаа, түүнийг алах арга хайж:

- За, чи очиж Цагаан тогооч хааны Алтаншан хатныг аваад ир. Үгүй бол толгойг чинь авна гэж тушаав. Цагаан тогооч хааныд очиход замд нь гурван барцадтай юм гэнэ. Энэ гурван барцад нь юу гэвэл: Нэгдүгээрх нь уул шиг том буур гэнэ. Хоёрдугаарх нь хоёр уулыг дамжлах том хорт могой гэнэ. Гуравдугаарх нь арван таван толгойтой атгар хар мангас гэнэ. Энэ гурван амьтныг дийлж гарвал сая цагаан тогооч хааныд хүрч чаддаг, үгүй бол замдаа үрэгдэх нь тэр юм гэнэ. Эрээн цагаан тоодогны мэргэн хаан түүнийг мэдэх боловч “Хаан хүний зарлиг байна. Яаж яв гэвэл түүгээр нь явъя” гээд хуй татдаг хул морио барьж, салхи татдаг саарал морио барьж, хий татдаг хээр морио барьж, ерэн есөн шилтэй бөмбөр шарга морио барьж, алтай ууландаа гарч арван гурван сангаа тавьж, алдар шар хадгаа барьж, амь насаа даатгачихаад сайн тохой мод зорж аваад явав. Тэгээд явж байтал замын дундаас уул шиг том буур нь түүнийг барьж идэхээр гараад ирэв. Эрээн цагаан тоодогны мэргэн зорж ирсэн модоороо тэр буурын амыг нь чагтлаад хаячихав. Модоор амаа чагтлуулсан буур амаа хамхиж чадахгүй болохоор Эрээн цагаан тоодогны мэргэнийг барьж идэж чадсангүй тэндээ зогсож хоцров. Эрээн цагаан тоодогны мэргэн эхний саадаа даваад бас хэдэн өдөр явсан чинь өмнө нь нэг уул таарч, дээр нь уул алдалсан сүрхий том юм үзэгдэв. Тэр “Энэ чинь одоо толгой нь энэ ууланд байхад сүүл нь тэр ууланд байдаг аварга могой юм байна” гэж морио уяж тавьчихаад, өдөр шөнө хоёр нумаа эвшээлгэж байгаад тавьсан чинь өнөө аварга могойг унагачихав. Тэр могой уул хадыг ороож, газар тэнгэрийг хөдөлгөх шиг туйлж байгаад үхсэн чинь могойн цус нь далай болов. Эрээн цагаан тоодогны мэргэн цааш явж байтал өмнө нь хөлний тоос нь хуй салхи болчихсон арван таван толгойтой атгар хар мангас таваргаад ирж байна гэнэ. Жаахан хүлээж байтал мангас ойртох тусам газар дүнгэнэх шиг болж хажууд нь хүрч иржээ. Тэгээд хоёулаа барилдаж эхлэв. Барилдаад байж, барилдаад байж. Гурван өдөр гурван шөнө барилдсанд уяатай морь нь янцгаав. Эрээн цагаан тоодогны мэргэн зориг орж “Би лавтай хүчрэх юм байна. Морь минь янцгааж байна” гэж бодоод хүчлэн барилдсанд, арван таван толгойтой атгар хар мангасын хүч нь суларч доороо унав. Эрээн цагаан тоодогны мэргэн (халуун дээр нь бүлээн нэмж)* мангасыг алж орхив. Ийнхүү зам дээрх гурван саадаа давчихаад цааш Цагаан тогооч хааны хатныг булаахаар явав. Гэрийнх нь наана гурван өдрийн газарт хүрч очиход түүний цагаан тэмээ нь буйлж, цагаан морь нь янцгааж, цагаан шувуу нь донгодож, цагаан нохой нь хуцаж эзэндээ мэдээ барьжээ. Цагаан тогооч хаан гайхаж, ламаар зурхай татуулсанд:

- Хаан танайд одоо сүрхий юм ирж явна. Таныг бараг авах янзтай байна гэж хэлж өгөв. Цагаан тогооч хаан:

- Хн, чи буруу хэлээ биз. Хаан намайг хэн дийлэх юм бэ? гэж хэлээд тэр зурхайч ламын үгийг эс тоов. Бас хоёр хоносонд, хааны цагаан тэмээ нь буйлж, цагаан морь нь янцгааж, цагаан

шувуу нь донгодож, цагаан нохой нь хуцаад байхаар нь хаан уурлаж:

- Энэ муусайн амьтан ямар төвөгтэй юм. Цөмийг нь ал гэж зарлигдав. Тэдгээр амьтныг алж дуусах үед эрээн цагаан тоодогны мэргэн хүрээд очжээ. Цагаан тогоочийн хаан тоож ядан:

- Чи муу, орчлонд нэргүй, огторгуйд цолгүй амьтан юу хийж ирэв? гэж асуухад,, эрээн цагаан тоодогны мэргэн:

- Би хааныхаа зарлигаар чиний авхайг авахаар ирлээ гэв. Цагаан тогооч хаан:

- Чадал байвал аваад яв гэж сэлмээ суга татаж алалдаж эхлэв. Гурван шөнө, гурван өдөр тулалдаад Цагаан тогооч хаан ялагдав. Эрээн цагаан тоодогны мэргэн хий хуй татдаг мориороо цагаан тогооч хааны Алтаншан дагиныг нь булааж авчраад хар тоодог хаанд хүргэж өгөв. Хар тоодог хаан, эрээн цагаан тоодогны мэргэн замдаа гурван сүрхий дайснаа дараад, эзэрхэг цагаан тогооч хааныг ялаад түүний хатныг булааж ирсэнд:

- Чиний хүч шид чинь надаас илүү байна. Миний чадал чамд огт хүрэхгүй. Би одоо цагаан тогооч хааны Алтаншан дагинаас өөр юу ч авахгүй гэж хэлээд хаан ширээнээсээ бууж нутаг бэлчээр, ард иргэн алив юмаа бүгдийг Эрээн цагаан тоодогны мэргэнд өгөв. Тэгээд эрээн цагаан тоодогны мэргэн “эрээн цагаан тоодогны хаан” болж алдар цолоо мандуулж, хар тоодог хааны тавьж өгсөн хаан ширээнд гарч, нутаг усыг нь эзэлж, ард иргэдийг нь амрааж, амар тайван жаргаасан гэдэг.

Гунан улаан баатар

Эрт урьд цагт Гунан улаан баатар хэмээх баатар эр байжээ. Тэрээр гэр нэвт гэгээ туссан, туурга нэвт туяа туссан гуа сайхан хатантай юм гэнэ. Нэг шөнө гуа хатан нь Гунан улаан баатрыг “Олбог дээрээсээ унаж, ширээн дээрээсээ шилжиж гарлаа” гэж зүүдлэв. Тэгээд хатан нь Гунан улаан баатраас:

- Урьд шөнө би таныг “Олбог дээрээсээ унаж, ширээн дээрээсээ шилжиж гарлаа” гэж зүүдэлдэг нь ямар учиртай юм бол? гэж асуув. Гунан улаан баатар:

- Харанхуй шөнийн зүүд худал байдаг юм гээд гэрээсээ гарч уул давж, адуугаа харахаар явав. Тэгсэн чинь түүний унадаг хувилгаан шарга морь нь адууныхаа түрүүнд чадлаараа давхиад ирж байна гэнэ. Гунан улаан баатар “Хувилгаан шарга морь минь ингэж сүрхий давхиж байхыг бодоход лав нэг учиртай биз” гэж өмнөөс нь угтаж очоод уужим хормойгоо дэвсэж, уудам сугаа дэлгээд мориныхоо өмнө мөргөж, учрыг нь асуув. Морь нь:

- Энэ баруун хойд захаас тэнгэр тулсан өндөр юм гараад ирж байна. Би унаган цагаасаа ийм юм олж үзсэнгүй гэв. Гунан улаан баатар морины хэлэхийг сонсоод “Хатны зүүд лав учиртай юм байна” гэж бодоод мориндоо эмээл, тохмоо тохоод, уран хатныхаа оёсон торгон олмоороо гурав гурав жирэмдэж татаад, сайн хатныхаа оёсон цагаан торгон олмоор тав тав жирэмдэж татаад мориндоо мордож, баруун хойд зүгт тэнгэр тулсан өндөр юмыг хайж давхив. Хайж явсаар чухам хэчнээн явсныг бүү мэд. Тун хол явсны дараа эгц өмнөөс нь тэнгэр тулсан хар юм гараад ирэх нь үзэгдэв. Гунан улаан баатар өмнөөс нь хүрч очсон чинь харин эмээл хазааргүй хар халзан луус уначихсан, хүний махыг богц дүүрэн ганзагалчихсан, хүрэн эрээн могойг хүзүүгээрээ ороочихсон, давхар эрээн могойг давсгаараа ороосон мангас явж байв. Мангас гунан улаан баатрыг үзээд:

- Нүүрэндээ цогтой, нүдэндээ галтай, шилэндээ шилбэтэй, шилбэндээ чөмөгтэй хүү чи хаашаа явж байна? Нэр ус чинь хэн бэ? гэж асуув. Гунан улаан баатар:

- Таныг хэн гэдэг вэ? Юу хийж явна вэ? гэж хариу асуув. Мангас:

- Би бол мангас байна. Чиний гэр нэвт гэгээ туссан, туурга нэвт туяа туссан хатныг чинь авах санаатай явж байна. Одоо хоёулаа харвалцаж үзэлцэх үү? гэж хэлэв. Гунан улаан баатар:

- Харвалцвал харвалцъя гэв. Мангас:

- Холоос би түрүүлж харвана. Хоёулаа гурван сарын газраас байлдах уу? гэж асуусанд Гунан улаан баатар:

- Балчир хүүхдийн тоглоом биш. Эр хүн байж гурван сарын газраас байлдна гэдэг чинь юу гэсэн үг вэ? Гурван жилийн газраас байлдъя гэв. Мангас зөвшөөрч, гурван жилийн газраас эхэлж харвав. Гунан улаан баатрын морь нь мангасыг харвахтай зэрэг доошоо хэвтсэнд сум нь гунан улаан баатрын толгой дээгүүр нь гараад явчихав. Дараа нь Гунан улаан баатар далан тэхийн эврээр давтаж хийсэн дархи ширэн нумаа адагт нь хүртэл сааж байгаад нэг харвасан чинь сум нь гарахдаа гал улаан, газар дунд цог улаан хүрч ирээд өнөө мангасын хүрэн улаан

уушгийг нь хүзүүгээр нь гартал харваад алчихав. Гунан улаан баатар цааш босоод мангасуудыг дарахаар баруун хойд зүгт хайж явжээ. Хэдэн өдөр явсны дараа, замд нь Түнгэтэйгийн голоор байршсан, түмэн харлаг хонь хариулсан, төмөр таяг тулсан нэг өвгөн явж таарчээ. Гунан улаан баатар тэр өвгөнөөс:

- Таны нэр ус чинь хэн гэдэг вэ? Хэний хонь малыг хариулж яваа юм бэ? гэж асуусанд өвгөн:

- Надад нэр ус гэх юмгүй. Би чинь угтаа хаан байсан хүн. Мангас миний нутаг ус, эд хөрөнгийг эзэлж аваад надаар хонио хариулуулж байна гэж хэлэв. Гунан улаан баатар түүнийг сонсоод:

- Өө, тийм үү? Би бол мангасыг дардаг хүн байна. Танай нутагт мангас олон байна уу? Хаана хаана суудаг юм? гэж асуув. Өвгөн:

- Манай тэнд есөн мангас байдаг гэхэд:

- Мангас, орчлонгийн амьтнаас булааж ирсэн эрдэнээ хаана тавьдаг вэ? гэж асуусанд, Өвгөн:

- Мангасын тэнд тэнгэр тулам улаан, ногоон хоёр ордон байдаг юм. Булааж ирсэн эрдэнээ тэндээ тавьдаг юм гэж хэлж өгөв. Гунан улаан баатар:

- Мангасын байдаг газарт яаж очих вэ? гэхэд өвгөн:

- Тэнд хүрэхэд туйлын хэцүү. Наана нь нэг ясан уул, цусан далай бий. Түүнийг даваад гарчих юм бол хүрч чадна гэж хэлэв. Гунан улаан баатар өвгөний зааж өгсөн зүгт явсаар өнөө ясан уулан далайд дөхөж ирээд, мориноосоо:

- Одоо яаж тэр ясан уул, цусан далайг гаталж гарах вэ? гэж асуухад морь нь:

- Би унаган харайлтаар харайя, чи миний нуруун дээр хүүхэд шиг сууж тогтоорой. Тэгж л чи бид хоёр энэ далайг гаталж чадна гээд харайв. Хоёулаа ясан уулан дээгүүр гаталж явтал мориных нь буруу талын хөл ясан ууланд хүрч арьс нь шалбараад явж чадахгүй болж гэнэ. Ясан ууланд хэд хонож, мориныхоо хөлийг эдгээгээд, морь нь унаган харайлтаар харайж, Гунан улаан баатар хүүхэд шиг сууж тогтоод цусан далайг гаталж мангасын дэргэд хүрэв. Гунан улаан баатар хамгийн түрүүнд мангасын үүдийг сахьдаг асар басар хоёр нохойг нь алаад, олон мангасыг унтаж байхад нь нэг нэгээр нь алав. Мангасуудыг алж дууссаны дараа ордон дахь эд эрдэнэсийг олзолж аваад, цаашаа мангасын үндсийг таслахаар хайж явжээ. Явж байтал зам дээр нь нэг сайхан цагаан гэр таарчээ. Яваад хүрсэн чинь дотроос нь хөгшин эмгэн гарч ирээд Гунан улаан баатрыг үзээд:

- Нүүрэндээ галтай, нүдэндээ цогтой ийм сайхан хүү хаана хүрэхээр явж байгаа юм бэ? гэж асуув. Гунан улаан баатар:

- Би мангасыг дарахаар явж байна гэсэнд, эмгэн:

- Юу гэнэ ээ? Би мангасын ээж нь байна гээд Гунан улаан баатрыг бариад авав. Хоёулаа нэг нэгээ дарах гэж ноцолдсоор Гунан улаан баатар арай гэж мангасын ээжийг хүчээр дийлсэн

боловч, үхдэггүй гэнэ. Хамгийн сүүлд мангасын ээж:

- Чи нэгэнт дийллээ. Хэрэв намайг алья гэж бодож байгаа бол баруун гуяыг огтол, үгүй бол би үхэхгүй шүү гэж мэх гаргав. Гунан улаан баатар мангасын ээжийн үгээр нь баруун гуяыг огтолсонд бас нэг мангас гарч ирээд Гунан улаан баатартай уулыг тал болтол, талыг там болтол ноцолдож, ноцолдож мангас эцэж ядраад:

- Би одоо болтол эцгийнхээ нүүрийг үзээгүй, эхийнхээ цагаан сүүг амсаагүй, эрийн сайнд хүрээгүй. Энэ гурвыг үзэлгүй үхнэ гэдэг даанч харамсалтай. Амийг минь өршөө гэж гуйж эхлэв. Гунан улаан баатар түүнийг тоосонгүй далан жалга дамжуулж, наян хөвөө давуулж алав гэнэ. Гунан улаан баатар олон мангасыг дарж, нутаг усандаа ирж, эд хөрөнгийг нь ард түмэндээ түгээж өгөөд амар түвшин суужээ.

Гунан хар баатар

Эрт урьд цагт, Гунан хар баатар хэмээх сайн эр байжээ. Тэр Нарандулам гэдэг эгчтэй, асар басар хоёр нохойтой, харцгай бүргэд хоёр шувуутай, уулын чинээ хөх морьтой, далан тэхийн эврээр давгаж хийсэн дархи шар нумтай, өдөржин ан гөрөө хийж амьдардаг байжээ. Нэг өдөр, Гунан хар баатар ан гөрөө хийж явахдаа Нарандулам эгчдээ:

- Зүүн хөтөл дээр гарахдаа зүүн үсээ самна, баруун хөтөл гарахдаа баруун үсээ битгий самна гэж захиад, асар басар хоёр нохойгоо дагуулж, хараацай бүргэд хоёроо авч, далан тэхийн эврээр давгаж хийсэн дархи нумаа үүрч, уулын чинээ хөх морио унаад, үндэстэй модны дээгүүр жингэнэтэл дуулж, жирийтэл хатируулж, талд нь таваргаад, хөдөөд нь хөөлгөөд, тав хийтэл давхисаар явж болзоотын бор нуруун дээр гараад үзсэн чинь өмнө нь нэг хүн явж байна гэнэ. Гунан хар баатар:

- Хаанаасаа хаана хүрэхээр явж байна вэ? Хэт нутаг хаана вэ? Хэрэг зориг юунд вэ? гэж асуухад нь нөгөө хүн:

- Миний нэрийг Тоодог ноён гэдэг. Би Гунан хар баатрын Нарандулам эгчийг хатнаа болгож авахаар явж байна гэхэд Гунан улаан баатрын уур нь ихэд хүрч:

- Би эгчээ чам шиг муу юманд өгөхгүй гэж хэлээд Тоодог ноёныг барьж аваад суганых нь арьсыг тохойгоор нь гартал, хөлийнх нь арьсыг өвдгөөр нь гартал багалж хаяад цаашаа явав. Дүүгээ явсны дараа Нарандулам бүсгүй зүүн хөтөл дээрээ гарч зүүн үсээ самнаж суутал тэнгэр газрыг нийлүүлсэн зовлонт амьтны дуу гарч гэнэ. Нарандулам “Энэ юун дуу байдаг билээ” гээд Болзоотын бор толгой дээр гарч хартал Тоодог ноёныг хүлж баглаад хаясан байжээ. Нарандулам суллаж тавиад учрыг асуухад Тоодог ноён бүхнийг хэлж өгөв. Нарандулам Тоодог ноёнд дурлаж, түүний хатан нь болохоор шийдээд гэртээ аваачиж, гэрийнхээ зүүн хойд эргэнд нууж тавив. Гунан хар баатар ан гөрөөнөөсөө буцаж ирээд:

- Эгч ээ, хурдан гарч ирээд ачаа буулгалцаад өг гэж дуудсанд дуу чимээ байсангүй гэнэ. Бас дахин дуудсан чинь мөн гарч ирсэнгүй. Гунан хар баатар “Ердөө ганц дуудахад эгч минь гарч ирээд ачаанаас дэмнэн буулгадаг юмсан. Өнөөдөр юу болчихов?” гэж санд мэнд ачаагаа буулгачихаад гэртээ орж ирэхэд эгч нь зүүн талдаа сур болтол сунайж, сухай болтлоо улайгаад хэвтэж байжээ. Гунан хар баатар:

- Эгч минь ээ, Юу болов? Ямар өвчин тусав? гэж асуухад эгч нь:

- Чи хэлэх үү? Би үхэх үү? Би хэлэх үү? Чи үхэх үү? Ийм нэг сүрхий өвчин тусчихлаа гэв. Гунан хар баатар эгчийнхээ хэлсэн үгний учрыг сайн ойлгосонгүй:

- Эгч ээ, одоо яавал дээр вэ? Юу увал эдгэх вэ? гэж асуув. Нарандулам аль эрт Тоодог ноёнттой нийлж, дүүгээ хорлохоор шийдчихсэн байжээ. Тэгээд дүүгийнхээ хэлсэн үгийг сонсоод дотроо баярлаж байвч, гаднаа зовсон янз гаргаж:

- Өө, би эмчид үзүүлсэн. Эмчийн хэлэх нь: Миний өвчнийг арван таван толгойтой атгар хар мангасын уушги зүрхийг идвэл эдгэнэ гэж байна гэв. Гунан хар баатар үүнийг сонсоод

дуугарсангүй, далан тэхийн эврээр давгаж хийсэн дархи нумаа үүрээд, асар басар хоёр нохойгоо дагуулж, харцгай бүргэд хоёр шувуугаа авч, уулын чинээ хөх морио унаад үндэстэй модны дээгүүр жингэнэтэл дуулж, жирийтэл хатируулж, талд нь давхиад, хөдөөд нь гүйлгээд, давхийтэл давхиж явтал өмнө нь гурван цагаан өргөө үзэгджээ. Энэ чинь юу байдаг юм гээд хүрээд очсон чинь өргөө биш тэнгэрийн гурван дагина байжээ. Тэр гурван дагина Гунан хар баатрыг хараад:

- Хөвгүүн, хөвгүүн? Нүдэндээ галтай, нүүрэндээ цогтой ямар сайхан хүү вэ? Чи хаанаас хаана хүрэхээр явж байгаа юм бэ? гэж асуув. Гунан хар баатар:

- Нарандулам эгч минь өвдчихлөө. Одоо арван таван толгойтой атгар хар мангасын зүрх, уушгийг нь идвэл эдгэнэ гэнэ. Би түүнийг хайж явна гэв. Гурван хатан:

- Ай даа, арван таван толгойтой атгар хар мангас гэдэг чинь сүрхий амьтан шүү. Эхнэр хүний санаа хар байдаг билээ. Чи минь мэхэнд нь битгий ор. Эртхэн буцсан дээр байх гэхэд нь:

- Болохгүй! Эр хүн зорьсон доо эмээлт морь харайсандаа гээд гурван дагины үгийг сонсолгүй, үндэстэй модны дээгүүр жингэнэтэл дуулж, жирийтэл хатируулж, талд нь давхиад, хөдөөд нь гүйлгээд, давхийтэл давхисаар болзоотын бор толгой гараад очжээ. Тэгсэн чинь зүүн өмнө зүгт нь бөөн цагаан тоос гарч байна гэнэ. Яваад хүрсэн чинь арван таван толгойтой атгар хар мангас байж байв. Мангас түүнийг олж үзээд:

- Чи хаанаас ирсэн юун хүн бэ? гэж асуув. Гунан хар баатар:

- Нарандулам эгч минь өвдчихлөө. Чиний уушги зүрхийг идвэл эдгэнэ гэнэ. Одоо би, чиний уушги зүрхийг чинь авна. Хоёулаа нум сумныхаа хурцаар уулзах уу? Ээжийн хайрласан элбэг шар махаар уулзах уу? гэж асуусанд, арван таван толгойтой атгар хар мангас:

- Нум сумныхаа хурцаар уулзъя. Маргааш өглөө болзоотын бор толгой дээр үзэлцье гэж болзов. Дараа өдрийн өглөө, Гунан хар баатар эртлэн босч болзоотын бор толгой дээр хүрч ирээд гаанс тамхиа ганц нэг татаж суутал арван таван толгойтой атгар хар мангас хүрээд иржээ. Гунан хар баатар:

- Хүлээж байснаараа би харвах уу? Болзож ирснээрээ чи харвах уу? гэсэнд мангас:

- Хүлээж сууснаараа чи эхэлж харва гэв. Гунан хар баатар далан тэхийн эврээр давгаж хийсэн дархи шар нумаа авч арван таван толгойтой атгар хар мангасын толгойруу нь хандуулж байгаад, өглөөний нарнаар эвшээлгээд үдийн нарнаар харваад унагажээ. Тэгээд хажуу хавиргыг нь хатгаад үзсэн чинь гэдсэн дотроос нь айл амьтан, ачаа тэмээтэйгээ гарч чадахгүй нааш цааш зөрөлдөж байжээ. Түүнийг нь гаргаж уушги, зүрхийг нь аваад гэртээ харьж эгчдээ өгөв. Эгч нь амссан идсэн болж байгаад нүд алдуулж, зүүн хойд шүүгээрүүгээ шидчихэв. Тэгээд дүүдээ:

- За, одоо нэг өвчин нь эдгэрлээ. Хоёрдахь өвчнийг заавал хорин таван толгойтой холтгор хар мангасын уушги зүрхийг идвэл эдгэрэх юм гэнэ гэв. Гунан хар баатар эгчээ эдгээж авахын төлөө далан тэхийн эврээр давгаж хийсэн дархи шар нумаа авч, асар басар хоёр нохойгоо

дагуулж, харцгай бүргэд хоёр шувуугаа авч, уулын чинээ хөх морио унаад үндэстэй модны дээгүүр жингэнэтэл дуулж, жирийтэл хатируулж, талд нь давхиад, хөдөөд нь хөөлгөөд, давхийтэл давхисаар явж, тэнгэрийн гурван дагинын хажууд хүрэв. Гурван дагина Гунан хар баатрыг үзээд:

- Чи бас хаашаа явж байгаа юм бэ? гэхэд нь:

- Нарандулам эгч минь арван толгойтой атгар хар мангасын зүрх, уушгийг нь идээд нэг өвчин нь эдгэлээ. Одоо хорин таван толгойтой хотгор хар мангасын уушги зүрхийг идвэл хоёрдахь өвчин нь эдгэрэх юм гэнэ. Тэгээд би түүнийг хайж явна гэв. Гурван хатан:

- Ай даа, хорин таван толгойтой хотгор хар мангас гэдэг чинь сүрхий амьтан шүү. Эхнэр хүний санаа хар байдаг билээ. Чи минь мэхэнд нь битгий ор. Эртхэн буцсан дээр байх гэхэд нь:

- Болохгүй! Эр хүн зорьсон доо эмээлт морь харайсандаа гээд гурван дагинын үгийг сонсолгүй, үндэстэй модны дээгүүр жингэнэтэл дуулж, жирийтэл хатируулж, талд нь давхиад, хөдөөд нь гүйлгээд, давхийтэл давхисаар болзоотын бор толгой дээр гараад очжээ. Тэгсэн чинь баруун өмнө зүгт нь бөөн цагаан тоос гарч байна гэнэ. Яваад хүрсэн чинь хорин таван толгойтой хотгор хар мангас байж байв. Мангас түүнийг олж үзээд:

- Чи хаанаас ирсэн юун хүн бэ? гэж асуув. Гунан хар баатар:

- Нарандулам эгч минь өвдчихлөө. Чиний уушги зүрхийг идвэл эдгэнэ гэнэ. Одоо би, чиний уушги зүрхийг чинь авна. Хоёулаа нум сумныхаа хурцаар уулзах уу? Ээжийн хайрласан элбэг шар махаар уулзах уу? гэж асуусанд, хорин таван толгойтой хотгор хар мангас:

- Нум сумныхаа хурцаар уулзъя. Маргааш өглөө болзоотын хар толгой дээр үзэлцье гэж болзов. Дараа өдрийн өглөө, Гунан хар баатар эрт гэдэг нь босчихоод болзоотын бор толгой дээр хүрч ирээд гаанс тамхиа ганц нэг татаж хүлээтэл хорин таван толгойтой хотгор хар мангас хүрээд иржээ. Гунан хар баатар:

- Хүлээж байснаараа би харвах уу? Болзож ирснээрээ чи харвах уу? гэсэнд мангас:

- Хүлээж сууснаараа чи эхэлж харва гэв. Гунан хар баатар далан тэхийн эврээр давтаж хийсэн дархи шар нумаа авч арван таван толгойтой атгар хар мангасын толгойруу нь хандуулж байгаад, өглөөний нарнаар эвшээлгээд үдийн нарнаар харваад унагажээ. Тэгээд хажуу хавиргыг нь хатгаад үзсэн чинь гэдсэн дотроос нь айл амьтан, ачаа тэмээтэйгээ гарч чадахгүй нааш цааш зөрөлдөж байжээ. Түүнийг нь гаргаж хаячихаад уушги, зүрхийг нь аваад гэртээ харьж эгчдээ өгөв. Эгч нь амссан идсэн болж байгаад нүд алдуулж, зүүн хойд шүүгээрүүгээ шидчихэв. Тэгээд дүүдээ:

- За, дүү минь, одоо миний хоёрдахь өвчин эдгэлээ. Одоо бас нэг өвчин байна. Түүнийг ерэн таван толгойтой этгэр шар мангасын уушги зүрхийг идвэл эдгэрэх юм байна гэжээ. Гунан хар баатар үг дуугүй далан тэхийн эврээр давтаж хийсэн дархи шар нумаа авч, асар басар хоёр нохойгоо дагуулж, харцгай бүргэд хоёр шувуугаа авч, уулын чинээ хөх морио унаад үндэстэй

модны дээгүүр жингэнэтэл дуулж, жирийтэл хатируулж, талд нь давхиад, хөдөөд нь гүйлгээд, давхийтэл давхисаар явж, тэнгэрийн гурван дагинын хажууд хүрэв. Гурван дагина гунан хар баатрыг үзээд:

- Хөвгүүн минь ээ? Чи бас хаашаа явж байгаа юм бэ? гэхэд нь:

- Нарандулам эгч минь хорин таван толгойтой хотгор хар мангасын зүрх, уушгийг нь идээд хоёрдахь өвчин нь эдгэлээ. Одоо бас нэг өвчин байна. Түүнийг ерэн таван толгойтой этгэр хар мангасын уушги зүрхийг идэж эдгээх юм гэнэ. Тэгээд би түүнийг хайж явна гэв. Гурван хатан:

- Ай даа, ерэн таван толгойтой этгэр хар мангас гэдэг чинь сүрхий амьтан шүү. Эхнэр хүний санаа хар байдаг билээ. Чи минь мэхэнд нь битгий ор. Эртхэн буцсан дээр байх гэхэд нь:

- Болохгүй! Эр хүн зорьсон доо эмээлт морь харайсандаа гээд гурван дагинын үгийг сонсолгүй, үндэстэй модны дээгүүр жингэнэтэл дуулж, жирийтэл хатируулж, талд нь давхиад, хөдөөд нь гүйлгээд, давхийтэл давхисаар болзоотын бор толгой дээр гараад очжээ. Тэгсэн чинь баруун хойд талд бөөн цагаан тоос гарч байна гэнэ. Яваад хүрсэн чинь ерэн таван толгойтой этгэр хар мангас байж байв. Мангас түүнийг олж үзээд:

- Чи хаанаас ирсэн юун хүн бэ? гэж асуув. Гунан хар баатар:

- Нарандулам эгч минь өвдчихлөө. Чиний уушги зүрхийг идвэл эдгэнэ гэнэ. Одоо би, чиний уушги зүрхийг чинь авна. Хоёулаа нум сумныхаа хурцаар уулзах уу? Ээжийн хайрласан элбэг шар махаар уулзах уу? гэж асуусанд, хорин таван толгойтой хотгор хар мангас:

- Ээ, тэнхээ байвал ээжийн хайрласан элбэг шах махаараа уулзсан нь дээр байх. Маргааш өглөө болзоотын хар толгой дээр үзэлцье гэж болзов. Дараа өдрийн өглөө, Гунан хар баатар эрт гэдэг нь босчихоод болзоотын бор толгой дээр хүрч ирээд гаанс тамхиа ганц нэг татаж хүлээтэл ерэн таван толгойтой этгэр хар мангас хүрээд иржээ. Гунан хар баатар үг дуу гарахын завдалгүй барьж аваад ноцолдож эхлэв. Тэр хоёр үдийн хойно болтол үзэлцээд хэн хэн нь дийлсэнгүй. Тэгтэл гунан хар баатарын морь нь цаашаа хандаад явав гэнэ. Нэлээд хол явсны дараа Гунан хар баатар ерэн таван толгойтой этгэр хар мангаст:

- За, чи жоохон байж бай. Морь минь явчихлаа. Би очиж морио бариад ирье гэж хэлээд мориныхоо араас яваад очсон чинь мориных нь баруун нүд нулимстай байв. Гунан хар баатар морь минь яагаад нулимстай байна гээд хурдан гэгч дотоод хормойгоо дэвсээд мориндоо мөргөж, учрыг асуусанд морь нь:

- Тэр ерэн таван толгойтой этгэр хар мангаст одоо гунан бугын тэнхээ нэмэгдэж байна. Чамаас гунан бугын тэнхээ хасагдаж байна. Ингэж ноцолдоод байвал чи дийлэхгүй алагдаж мэднэ. Одоо чи амандаа цагаан мод зуугаад ноцолдвол нэг дийлэх байх. Тэр мангасын баруун хөлийн тавагт нэг хар мэнгэ байна. Чи дийлснийхээ дараа заавал түүнийг нь авч хая. Үгүй бол үхэхгүй гэж хэлж өгөв. Гунан хар баатар морио барьж уячихаад амандаа цагаан мод хөндлөн зуугаад ерэн таван толгойтой этгэр хар мангастай дахиж ноцолдов. Мангас түүнийг үзээд:

- Өө, Мод идвэл тэнхээ ордог гэж морь чинь хэлж байна уу? гээд Гунан хар баатрыг дуурайж газраас нэг атга цагаан өвс авч амандаа чихээд ноцолдов. Гунан хар баатрын тэнхээ нэмэгдээд ноцолдсонд мангас сандрахдаа хяхчихжээ. Тэр завшаанд Гунан хар баатар мангасыг доороо хийж дараад хөлийнх нь тавагт байх хар мэнгийг нь авч хаяхаар хөлийн тавагт нь хүртэл гурав хоног явж гэнэ. Яваад хүрсэн чинь хөлийн тавагт нь үнэхээр нэг том хар мэнгэ байв. Түүнийг нь аваад хаятал мангас тэр дороо үхэж гэнэ. Гунан хар баатар мангасын уушги зүрхийг нь аваад гэртээ харьж эгчдээ өгөв. Эгч нь мөн идсэн, амталсан болж байгаад нүд алдуулж гэрийн зүүн шүүгээрүүгээ хаячихав. Тэгээд дүүдээ:

- За, дүү минь! Удаан жил явж, олон мангасыг алж ирснээс миний өвчин цөм эдгэлээ. Одоо би чиний ачийг чинь хариулахын төлөө чамд арз нэрж тавьлаа. Чи уу гэв. Үнэндээ эгч мангасын хүчээр дүүгээ хорлох гээд чадсангүй болохоор дүүгээ алахаар арзыг чанаад хорз болгож, хорзыг чанаж хор болгоод сууж байжээ. Гунан хар баатар эгчийнхээ өвчнийг эдгээж чадсандаа баярлаж, өнөө арзыг нь аваад уучихсан чинь хорзонд нь хордоод нүд нь эрээлжилж, газар тэнгэр эргэлдэн согтуу хүн шиг болов.

Тэгтэл гэрийн зүүн хойд шүүгээнээс мангасын мах идэж тэнхээ орсон Тоодог ноён үсрэн гарч ирээд, Гунан хар баатрыг барьж аваад алах гэж ноцолдов. Ноцолдоод байж, ноцолдоод байж, долоон өдөр долоон шөнө ноцолдоод талыг там болгож, уулыг тал болгосон ч нэг нэгийгээ дийлсэнгүй. Тэгэхээр нь Гунан хар баатар эгчдээ:

- Өшөөтний доор буурцаг цац, миний доор гурил цац гэж хашгирав. Эгч нь дүүгийнхээ доор буурцаг цацаж, Тоодог ноёны доор гурил цацсанд Гунан хар баатар буурцаган дээр хальгарч унаад Тоодог ноёнд дйилдэж алуулчихав.

Тоодог ноён Гунан хар баатрыг алсны дараа ес есөн наян нэгэн алд гүн худаг малтаж, түүнийг дотор нь хаяж дээрээс нь үхэр хар чулуугаар дарж элсээр булж хаячихаад, Нарандулам эгчийг нь эд хөрөнгөтэй нь нүүлгэн явах гэжээ. Гунан хар баатрын асар басар хоёр нохойг нь барих гэсэнд баригдсангүй. Хараацай бүргэд хоёр шувууг нь барих гэсэнд нисээд явчхав. Уулын чинээ хөх морийг нь барих гэсэнд давхиад явчихжээ. Тоодог ноён уруу царайлж, усан нүдлэн Гунан хар баатрын далан тэхийн эврээр давтан хийсэн дархи хар нумыг нь үүрч Нарандулам эгчийг нь аваад явав. Гунан хар баатрын үүлэн хөх морь нь явж тэнгэрийн гурван дагинын гадаа хүрч ирсэнд гурван дагина морины дууг сонсоод гэрээсээ гарч ирэв. Гурван дагина:

- Хүүш, хайран хүү алагдсан бололтой, гурвуулаа очвол арга бий байх. Ганц мориор бид гурав яаж явдаг билээ? гэв. Гунан хар баатрын морь нь сонсоод үнсэн дээр очиж хоёр хөрвөөгөөд гурван адилхан үүлэн хөх морь болоод босоод ирэв. Гурван дагина тэр гурван морийг нэг нэгээр нь унаад Гунан хар баатрын нутаг дээр нь хүрээд иржээ. Энэ үед, Гунан хар баатрын асар басар хоёр нохой улин хуцаад, хараацай бүргэд хоёр шувуу нь донгодон дуугараад, гунан хар баатрыг булсан газрыг малтаж байжээ. Гурван дагина хүрч ирээд нэг нь алчуураараа савж:

- Энэ шороо юу ч үгүй болох болтугай! гэсэнд Гунан хар баатрыг булсан шороог хоггүй алга болов. Бас нэг дагина нь алчуураараа савж:

- Энэ үхэр хар чулуу алга болох болтугай! Гэсэнд гунан хар баатрыг дарж тавьсан бух хар чулуу үгүй болов. Гуравдахь дагина алчуураа савж:

- Гунан хар баатрын мах цус нь бүрэлдэж босоод иртүгэй! гэсэнд Гунан хар баатрын мах цус нь бүрэлдэж:

- Хүүе, яасан их унтсан юм бэ? гэсээр босоод ирэв. Гунан хар баатар нь амь орсонд асар басар хоёр нохой, хараацай бүргэд хоёр шувуу, уулын чинээ үүлэн хөх морь нь туйлын ихээр баярлацгаав. Тэд Гунан хар баатарт Тоодог ноён түүнийг яаж алж, яаж булсан, яаж амь оруулж гаргаж ирснийг бүгдийг ярьж өгөв. Гунан хар баатар түүнийг сонсоод, Тоодог ноён болон Нарандулам эгчдээ хорсож, өшөөгөө авахаар зориг шулууджээ.

Гурван дагина харихдаа:

- Хүү минь, хичээгээрэй. Тоодог ноён гурван мангасын махыг идээд гурван мангасын тэнхээ орсон шүү гэв. Гунан хар баатар:

- За гээд уулын чинээ үүлэн хөх мориороо гурван дагиныг хүргүүлэв. Морио эргэж ирсний дараа Гунан хар баатар асар басар хоёр нохойгоороо хэт хутга хийж, хараацай бүргэд хоёроороо хоёр тээг хийж, уулын чинээ үүлэн хөх морио хамуутай хар даага болгож хувиргаад өөрөө нусгай бор хүү болж хувираад Тоодог ноён болон Нарандулам эгчээ хайж өшөөгөө авахаар явжээ. Гунан хар баатар явсаар Тоодог ноёныд хүрч очиход тэд хурим найраа хийхээр бэлтгэж байхтай таарч, гэрт нь орж очоод цай уугаад сууж байтал тоонон дээгүүр нь элээ нисч өнгөрөв гэнэ. Гунан хар баатар элээний зүг сонирхон харсанд Тоодог ноён түүнийг үзээд:

- Чи нум сум харваж чадах уу? гэж асуув. Гунан хар баатар:

- Муухан харвадаг юм гэв. Тоодог ноён:

- Чи тэгвэл энэ элээг харваж үз гэж хэлээд нэг нум сум авч өгчээ. Гунан хар баатар тэр нумыг нь авч нэлээд хэдэн нумыг нь хугалж хаясанд Тоодог ноён уурлаж, Нарандулам эгчид нь:

- Миний нумыг аваад өг гэхэд Нарандулам эгч нь ханын толгойноос өлгөөтэй байсан далан тэхийн эврээр давгаж хийсэн дархи шар нумыг нь аваад өгөв. Гунан хар баатар өөрийнхөө нумыг авч түмэн хүн айдаг түнтгэр хар царай нь гарч, мянган хүн айдаг мэргэ улаан царай нь гарч, угийн дүрдээ хувилж оржээ. Тоодог ноён түүнийг үзэнгүүтээ сүнсээ зайлтал айж, ширээнээсээ санд мэнд бууж, зүүн хойшоо зугтаав. Гунан хар баатар далан тэхийн эврээр давгаж хийсэн дархи шар нумаа адагт нь хүртэл саагаад Тоодог ноёныг ганц харваж алав. Гэрт орж очиход Нарандулам эгч нь нэг цагаан царайлж, нэг улаан царайлаад:

- За, дүү минь, Тоодог ноёныг алсан нь сайн боллоо. Одоо чамайг долоон гүүгээр шагнаж гэв. Гунан хар баатар ч түмэн хүн айдаг түнтгэр хар царайгаа барайлгаж, мянган хүн айдаг мэргэ улаан царайгаа улайлгаж:

- Эгч ээ, намайг шагнасан долоон гүү чинь аль байна? гэв. Эгч нь гадна зэлэн дээрээ уяатай

байсан долоон гүүгээ зааж:

- Тэнд байна гэв. Гунан хар баатар үг дуугүй эгчийгээ чирч зэлэн дээр хүрээд, долоон гүүг долоон талаас нь барьж уяад эгчээ долоон тийш нь тэлж алав. Тэгээд Гунан хар баатар өшөөт дайснаа дараад амарсайхан жаргаж гэнэ.

Хэрээдэй мэргэн

Эрт урьд цагт, хэт торгон дээлтэй, хэл гуталтай, хэрээ хар сахалтай, буурын цагаан соёотой Хэрээдэй мэргэн гэдэг нэг сайн эр байжээ. Түүний баруун сахлын буланд булаг ус урсаад ботго тором усалж, зүүн сахлын буланд өргөн хөдөө уужраад адуу мал идээшилдэг байжээ.

Хэрээдэй мэргэн нэг уулын чинээ хар морьтой юм гэнэ. Тэр морины уруул ам нь ангас гэж, чонон чих нь сэртэс гэж байвал сая морь гэж таньдаг байжээ. Тэр бас далан тэхийн эврээр давтан хийсэн дархи шар нумтай, хөдөө болсон хөтөл цагаан тохомтой, хангай болсон зандан улаан эмээлтэй юм гэнэ. Нэг өдөр, Хэрээдэй мэргэн амь залгахын төлөө ан гөрөөндөө явж байтал өмнө нь гурван цагаан өргөө харагдав. Яваад хүрсэн чинь харин өргөө биш тэнгэрийн гурван дагина байжээ. Тэд Хэрээдэй мэргэнийг үзээд:

- Нүүрэндээ галтай, нүдэндээ цогтой ямар сайхан эр вэ? Чи хаанаас хаана хүрэхээр явж байна вэ? гэж асуусанд Хэрээдэй мэргэн:

- Би өмнийн говиос ирлээ. Атгар хар буур алтан буйлтай, мираг цагаан ингэ мөнгөн буйлтай, арван хоёр тором модон буйлтай, ийм хэдэн тэмээ хайж явна гэж тоглож хэлэв. Гурван дагина түүнийг сонсоод:

- Ишц, хүү минь, тэнгэрийн алд алтан хүн, Тоодог ноёны толь манхан авхайг гурван жилийн найр наадам хийж авах юм гэнэ. Чи тэмээгээ хайхаа болиод тэр наадамд нь явахгүй юу? гэв. Хэрээдэй мэргэн гурван дагинын үгийг сонсоод “Тийшээ очиж, Толь манхан авхайг нь авья” гэж ан гөрөөгөө хийхээ больж, өөрөө нусгай бор хүү болон хувираад, уулын чинээ хар морио хамуутай хар даага болгож хувилгаад Тоодог ноёны найранд хүрчээ.

- Тоодог ноёныд очиход найр наадам эхлэх гэж байжээ. Хэрээдэй мэргэн “Аль гэрт нь ордог билээ?” гэж урьдаар Тоодог ноёны зүүн гэрт нь орсон чинь Толь манхан авхайн гэрт яваад орчихож гэнэ. Толь манхан авхай засал чимгээ хийж, толгой түрүүгээ угааж, гээг үсээ самнаж суув гэнэ. Тэр Хэрээдэй мэргэний орж ирэхийг үзээд:

- Зочин ирлээ гэж хэлээд цай хийж өгөв. Хэрээдэй мэргэн цай ууж суух зуур Толь манхан авхай гээг үсээ засаж дуусаад:

- Та юу хийхээр ирэв? гэж асуухад нь Хэрээдэй мэргэн.

- Би танай ноёны гурван жилийн найр наадамд оролцохоор ирлээ гэхэд толь манхан авхай:

- За, тэгвэл би очиж, Тоодог ноёнд мэдүүлье гэж хэлээд гарч явав. Тоодог ноён Толь манхан авхайн хэлсэн үгийг сонсоод:

- За, болно болно. Түүгээр чинь тогоо шанага бариулбал зүгээр юм байна. Хурдан очиж түлээ мод түүлгэ гэв. Толь манхан авхай Тоодог ноёны зарлигийг Хэрээдэй мэргэнд дамжуулсанд, Хэрээдэй мэргэн дургүйцэж:

- Би тийм ажлыг чинь хийхгүй. Найр наадамд чинь оролцоно гэв. Тоодог ноён түүнийг

сонсоод дэлбэртлээ уурлаж, Хэрээдэй мэргэнийг дуудаж ирүүлээд:

- Чи яасан хэтэрсэн амьтан бэ? Хувхай модыг шалбартал, бургас модыг бяцартал нь цохимоор байна гэж хараав. Үүнд Толь манхан авхай сандарч:

- Ноён аав аа, тэгж болохгүй. Найр наадамд ирсэн хүн юм чинь оруулчих гэж гуйхад Тоодог ноён аргагүйд хүрч Хэрээдэй мэргэнийг найр наадамд оролцуулахаар болов. Найр эхэлж хамгийн түрүүнд морь уралдав. Морио гурав хоногийн газраас тавихаар тогтжээ. Хэрээдэй мэргэн гурав хоногийн газарт хүрээд буцаж уралдах гэсэнд морь нь урагш гишгэдэггүй гэнэ. Тэгэхээр нь “Энэ морь яаж байгаа юм бол. Энэ лав нэг учиртай биз” гэж бодоод дотоод хормойгоо дэвсэж мөргөөд асуусанд морь нь:

- Та чинь яачихсан юм бэ? Өдий газарт яараад юу хийнэ. Хүний хэлэхээр “Сайн эр гурван жил унтдаг. Сайн морь гурав хоног зогсдог” гэдэг биз дээ. Одоо явах цаг болоогүй байна. Та нэг тэвэр сухай модыг баглаад тавьчих, бас нэг сав үнс хийж тавиад хурдан унт гэж хэлэв. Хэрээдэй мэргэн мориныхоо хэлсэн ёсоор нэг тэвэр сухай баглаж, нэг сав үнс хийж тавиад унтав. Нэг мэдэхэд морь нь:

- Эзэн минь одоо явах цаг боллоо. Хурдан бос гэж хэлэв. Хэрээдэй мэргэн сэрээд харсан чинь уралдааны морьд аль эрт бараа сураггүй алга болж, уралдааны хамгийн сүүлийн өдрийн үдийн хойно болсон байж гэнэ. Хэрээдэй мэргэн бэлдэж тавьсан сухай, үнс хоёроо ачаад мориндоо мордож, уралдааны морьдын араас давхив. Морь нь:

- Одоо баглаатай сухайгаа бутаргаж, савтай үнсээ цац! гэж хэлсэнд, Хэрээдэй мэргэн баглаатай сухайгаа бутаргаж, савтай үнсээ сацаад давхиулсан чинь морь нь нисч байх мэт, газрын хөрс хөдлөөд, ширүүн мөндөр цацлаад, манан будан татуулаад удсан ч үгүй бүх морьдыг гүйцэж, ардаа хаяаад хагас өдрийн түрүүнд хүрээд иржээ. Хэрээдэй мэргэн морины уралдааныг авав. Дараа нь бөхийн мөрий тавьжээ. Тэнгэрийн алд алтан хүнийг дийлэх хүн огт үгүй байв. Тэр хүн бөхчүүдийг цөмийг нь давчихаад хамгийн сүүлд Хэрээдэй мэргэнтэй барилдав. Тэр Хэрээдэй мэргэнийг үзээд “Энэ муу нусгай бор хүү гар хөлд юу баригддаг юм. Газарт юу тавьдаг юм” гэж тоомжиргүй байв.

Тэгсэн чинь овоо юм байж. Хүчээ өгөх шинжгүй гэнэ. Тэр хоёр барилдаад байж, барилдаад байж. Хамгийн сүүлд тэнгэрийн алд алтан хүн Хэрээдэй мэргэнийг хоёр мөрөн дээрээс нь ганц ташаад газарлуу алд оруулжээ. Хэрээдэй мэргэн хамуутай хар даагандаа:

- Хурдан баруун гарын доор алтан дөш тавь, зүүн гарын минь доор мөнгөн дөш тавь гэв. Морь нь эмээлийн өмнө бүүрэгнээс алтан дөшийг нь суга татаж гаргаад Хэрээдэй мэргэний баруун гарын доогуур тавьж, хойд бүүргэнд байсан мөнгөн дөшийг нь суга татаж гаргаад зүүн шуун доор нь тавив. Хэрээдэй мэргэн хоёр гараа алт мөнгөн дөшин дээр тулж, ганц үсрээд газраас гараад ирэв. Хэрээдэй мэргэн мөн тэнгэрийн алд алтан хүнийг хоёр мөрөн дээрээс нь ганц алгадаад газар уруу алд оруулчихав. Тэнгэрийн алд алтан хүн Хэрээдэй мэргэнийг дуурайж Тоодог ноёнд: Ноён аав аа, Хурдан миний баруун гарын доор алтан дөш тавь, зүүн гаын доор мөнгөн дөш тавь гэж хашгирсанд Тоодог ноён тэнгэрийн алд алтан хүний хэлсэн ёсоор хийсэнд тэр хоёр гараараа алт мөнгөн дөшин дээр тулаад газраас гарах гэсэнд хоёр гар нь хугараад уначихав. Ингээд Хэрээдэй мэргэн бөхийн барилдааныг авав.

Хамгийн сүүлд нум харвав. Хэрээдэй мэргэн далан тэхийн эврээр давтаж хийсэн дархи шар нумаа адагт нь хүртэл саагаад, наян хасаг түлээний дотор найгал туулайн сүүжний нүхэн дотор, алтан тэвний нүхэн дотор, шүдлэн хонины шагайг гурав хуваагдтал харваад нумын уралдааныг авчээ. Хэрээдэй мэргэн Тоодог ноёны гурван жилийн найр наадамд оролцоод эрийн гурван наадмын түрүүг авч, Толь манхан авхайг хатнаа болгохоор болов. Толь манхан хатны зарц нар нь түүний уулын чинээ эмээлийг нь аваачиж өмчний зуун агтанд тохсонд морьдын нуруу нь хугараад унажээ. Аргагүйд тэр эмээлийг Хэрээдэй мэргэний хамуутай хар дааганд тохох болжээ. Гэтэл өнөө хамуутай хар даага огт тохуулсангүй гэнэ. Хэрээдэй мэргэн түүнийг хараад:

- Та нар тохож чадахгүй. Наад муу даага чинь муухай ааштай юм гээд зарц нарын гараас эмээлийг авч үзсэн чинь голд нь алтан тэвнэ хатгасан байжээ. Хэрээдэй мэргэн алтан тэвнийг авч хаяад, хамуутай хар даагандаа тохчихоод Толь манхан хатнаа араараа сундалж, адуу мал, өмч таваараа авч гэрийн зүг газрын хөрс хөдөлгөн, ширүүн мөндөр цацуулаад, манан будан татуулаад алга болов. Тоодог ноён хүүхэн, хүргэнээ аль зүгт явсныг ч мэдсэнгүй хоцорчээ. Хэрээдэй мэргэн Тоодог ноёны Толь манхан авхайг хатнаа болгож нутагтаа ирж амьдарсан юм гэнэ.

Арслантай мэргэн

Урьд Арслантай мэргэнийх гэж туйлын баян айл байжээ. Тэр ар хөндийгөөр дүүрэн арван түмэн адуутай, өмнө хөндийгөөр дүүрэн үй түмэн адуутай юм гэнэ. Нэг өдөр Арслантай мэргэн адуугаа эргэж үзээд явж байтал адуун сүрэг дотор нь гурван саарал чоно орчихсон адуунаас нь барьж идчихээд давхиж гэнэ. Арслантай мэргэн уурлаж:

- За та нар тэгж л бай. Маргааш би зээр гүйцдэг халиун саарлаараа та нарыг барьж, арьсыг нь өвчье гэж хэлээд явжээ.

Тэр гурван чоно ч бас учиртай чоно байжээ. Нэг нь мэргэн саарал, нэг нь бөхөн саарал, бас нэг нь хурдан саарал гэдэг нэртэй гэнэ. Мэргэн саарал нь туйлын мэргэн чоно юм гэнэ. Хүн амьтны юу санаж хэлэхийг андахгүй мэддэг амьтан байжээ. Тэр Арслантай мэргэний хэлсэн үгийг сонсоод нөгөө хоёр чонондоо:

- За, хичээгээрэй. Маргааш Арслантай мэргэн зээр гүйцдэг халиун саарал мориороо бид гурвыг хөөж гүйцээд арьсыг минь өвчинө гэж байна. Тэр морь бол хөгшин гүүний унага бөгөөд газрын өөд явахдаа муу, бид маргааш газрын өөд зугтаад байвал гүйцэгдэхгүй амьд гарна. Үгүй бол үхнэ гэж хэлжээ. Маргааш нь Арслантай мэргэн үнэхээр зээр гүйцдэг халиун саарлаа унаад шуугиулаад буучихжээ. Гурван чоно мэргэн саарлын хэлснээр өдөржин газрын өөд зугтаасаар байгаад гүйцэгдэлгүй амьд үлдэж гэнэ. Арслантай мэргэн бүтэн өдөржин хөөгөөд нэгийг нь ч барьж чадаагүйдээ:

- За, яахав. Маргааш би буга гүйцдэг буурал халиунаа унаж ирээд та нарыг барьж арьсыг чинь өвчье гэж хэлчихээд явжээ. Мэргэн саарал түүнийг сонсоод наадах хоёртоо:

- За, хичээгээрэй. Маргааш Арслантай мэргэн буга гүйцдэг буурал халиун мориороо бид гурвыг барьж, арьсыг минь өвчинө гэж байна. Тэр морь бол залуу гүүний унага бөгөөд газрын уруу явахдаа муу. Тиймээс гурвуулаа дээд газраас уруу газарлуу зугтаад байвал гүйцэгдэхгүй амьд гарч чадна гэж хэлжээ. Маргааш өглөө нь Арслантай мэргэн буга гүйцдэг буурал халиунаа уначихсан сүртэй нь аргагүй давхиж ирж гэнэ. Гурван чоно мэргэн саарлын хэлснээр газрын уруу зугтаажээ. Тэгээд бүтэн өдөр газрын уруу зугтаасаар Арслантай мэргэнд баригдсангүй амьд үлдэж гэнэ. Арслантай мэргэний уур хүрч:

- Та нар хүлээж бай! Маргааш би шувуу гүйцдэг атар хүрнээ унаж ирээд та нарын арьсыг нэг нэгээр нь өвчихгүй бол! гэж шүд зуун хэлчихээд явж гэнэ. Арслантай мэргэнийг явсны дараа мэргэн саарал нэлээд санаа зовсон шинжтэй нөгөө хоёртоо:

- За, хөөрхий маргааш ч нэг сүрхий юм болох нь дээ. Арслантай мэргэний шувуу гүйцдэг атар хүрэн гэдэг чинь таван жил сувайрсан эрмэг гүүнээс гарсан хулангийн унага шүү дээ. Тэр бол жигүүртэн шувууг ч урдуураа гаргадаггүй сүрхий хурдан хүлэг юм. Бид түүний гараас гарч чадах ч амаргүй. Одоо ямар арга байна ? гэж хэлсэнд, бөхөн саарал, хурдал саарал хоёр нь санаа зовж:

- Одоо тэгээд яах вэ? гэж арга мөхөн ангайж хэвтэв. Мэргэн саарал хэсэг бодож байгаад:

- Ай даа бэрх байна. Гэвч ганц арга л байна. Өнөө шөнө Арслантай мэргэний адуунд нь очиж, атар саарлыг нь бариад идчихвэл бид амьд гарах нэг арга байна гэж хэлэв. Бөхөн саарал, хурдан саарал хоёр амь аварлаа гэсэн тэр дороо ухасхийн босож, Арслантай мэргэний адуунд сунаж хүрсэнд адууны захад нэг эцэнхий морь зугтах ч үгүй зогсож байна гэнэ. Хоёр чоно түүнийг тоосонгүй, адуун сүргээс хамгийн тарганыг нь шилж “Энэ лав Арслантай мэргэний атар саарал нь мөн биз” гээд барьж иджээ. Бараг идээд дуусч байтал мэргэн саарал араас нь хүрч ирлээ. Бөхөн саарал, хурдал саарал хоёр:

- Наашаа хурдан ирээд мах ид гэхэд мэргэн саарал учрыг мэдчихээд бидний амьд явах насны тоо гүйцсэн болохоор мах идсэн ч адил, идээгүй ч адил гэж гэнэ. Тэгээд мэргэн саарал:

- За, одоо учир иймээс хойш. Маргааш гурвуулаа алтай хангай уулын орой дээр нэг уулзъя. Атар хүрэн морины ар зоон дээр нэг уулзъя. Арслантай мэргэний ар нуруун дээр нэг уулзъя гэж хэлчихээд урамгүйхэн яваад өгч гэнэ. Хоёр нөхөр нь түүнийг сонсоод учрыг нь олсонгүй “Энэ мэргэн саарал юу хэлж байгаа юм бол. Бид маргааш амьд үлдээд гурав уулзах юм байна” гэж баярлаад тарган махаа идэж хэвтсэн гэнэ. Маргааш нь Арслантай мэргэн шувуу гүйцдэг Атар хүрэн морио унаж ирээд гурван чоныг нэг нэгээр нь хөөж Алтай хангайн орой дээр аваачиж алаад арьсыг нь өвчиж, мориндоо ганзагалж гэртээ хүрээд, идээлж элдэн дээл хийж өмссөн гэнэ. Учир нь мэргэн саарлын хэлсэн нь “Алтай хангай уулан дээр нэг уулзъя” гэсэн нь Арслантай мэргэн гурван чоныг Алтай хангай уулын орой дээр аваачиж алаад арьсыг нь өвчихийг хэлсэн байжээ. “Атар хүрэн морины ар зоон дээр нэг уулзъя” гэдэг нь чоныг өвчөөд арьсыг нь мориндоо ганзагалж гэртээ харихыг хэлжээ. “Арслантай мэргэний ар мөрөн дээр уулзъя” гэдэг нь Арслантай мэргэн гурван чонын арьсаар дээл хийж өмсөхийг хэлсэн байжээ.

Бяцхан хүү Алтангалуу хааны гүнжийг авсан нь

Эрт урьд цагт, нэг өвгөн хүүтэйгээ хоёулаа амьдарч байж гэнэ. Нэг өдөр энэ айлд мэргэн хүн ирсэнд өвгөн, мэргэн хүнээр амь нас ажил үйлсийг нь мэргэлүүлж үзжээ. Тэр мэргэн хүн өвгөний хүүг мэргэлж үзээд өвгөнд:

- Танай хүү чинь баруун хойд зүгт гурван жилийн хол газар Алтангалуу хааны арван найман настай гүнжийг эхнэрээ болгож авах юм байна. Хань ижлээ авснаар хүүгийн чинь ажил үйл, амь нас аяндаа сайжирна гэж хэлжээ. Хүү, мэргэн хүний үгийг сонсоод аавдаа хань нөхрөө хайхаар явна гэж хэлэхэд аав нь ч үг дуугүй зөвшөөрч хүүгийнхээ аян замын юмыг төхөөрч өгөв. Хүү нь гэрээсээ гараад баруун хойд зүгийг чиглэн явж байтал замд нь айл тааралдаж, гэрт орсонд өвгөн, эмгэн хоёр сууж байв. Өвгөн эмгэн хоёр хүүгийн хэрэг зоригийг асуухад:

- Би баруун хойд зүгт байдаг Алтангалуу хааны арван найман настай гүнжийг хатнаа болгож авахаар явж байна гэж хэлэв. Эмгэн өвгөн хоёр түүнийг сонсоод жаахан гайхасхийж:

- Болохгүй, болохгүй. Тэр Алтангалуу хааны гүнжийг хэдэн өдрийн өмнө мангас аваад явчихсан. Чи очвол амиа өгнө. Одоо хурдан буц гэсэнд хүү:

- Хөгшин аав, ээж ээ би буцахгүй. Эр хүн санасандаа хүрэхгүй бол элэг нь хатдаг, эмээлт морь харайсандаа хүрэхгүй бол туурай нь хатдаг юм гэж хэлээд алд хадгаа гаргаж аргачлан гуйгаад, дэлэм хадгаа гаргаж дэмчлэн гуйгаад цааш явжээ. Тэгээд яван явсаар байтал замд нь дун цагаан гэртэй айл тааралдаж гэнэ. Яваад орсон чинь хөгшин эмгэн сууж байв. Эмгэн хүүгийн хэрэг зоригийг асуухад нь хүү:

- Би баруун хойд зүгт байдаг Алтангалуу хааны арван найман настай гүнжийг хатнаа болгож авахаар явж байна гэж хэлэв. Эмгэн түүнийг сонсоод жаахан гайхасхийж:

- Болохгүй, болохгүй. Тэр Алтангалуу хааны гүнжийг хэдэн өдрийн өмнө манай өвгөн аваад ирсэн юм. Чи одоо хурдан буц! Үгүй бол манай өвгөн ирээд чиний амийг авна гэж хэлэв гэнэ.

Хүү түүнийг сонсоод “Одоо эрийнх сайныг үзэж, миний хэрэг бүтэх нь” гэж баярлаад:

- Би буцахгүй. Харин мангасыг хүлээж байгаад учраа олно гэж хэлээд морь, нумаа хэт хутгандаа хийж тавиад айлын цавганд орж мангасыг хүлээж суув. Тэгтэл даамай удсангүй мангас гэртээ харьж ирээд, эмгэнээсээ:

- Манайд юун түүхий махны үнэр ханхалж байдаг билээ. Ямар хүн ирэв? гэж асуусанд, сайн санаат, мангасын эмгэн:

- Үгүй, үгүй. Манайд хүн ирээгүй гэхэд мангас үнэртэж зогссоноо:

- Ай даа, манайд яалт ч үгүй хүний үнэр ханхалж байна даа гэж хэлтэл, хүү:

- Ирсэн. Чи яах нь вэ? Би Алтангалуу хааны арван найман настай гүнжийг эхнэрээ болгож авахаар иртэл чи аваад явчихсан байна. Тэгээд би чиний араас хүрч ирлээ гэв. Мангас хүүгийн үгийг сонсоод тоомжиргүйхэн:

- Өө, тийм үү? Тэгвэл хоёулаа маргаашийн улаан нарнаар болзоотын бор толгой дээр уулзаж учраа ололцъё гэж хэлжээ. Маргаашийн мандах улаан нарнаар хүү болзоотын бор толгой дээр аль эрт гарчихаад нум сумаа эвшээлгэж, мангасыг хүлээж байтал, мангас ч болзсон цагтаа сар сар дуугараад сүрхий мөндөр хаялаад, хүр хүр дуугараад хүрээ мөндөр хаялаад, аянга буулган шидээ үзүүлэн хүрч иржээ. Хүү, мангаст:

- За, мангас гуай, хоёулаа ээж аавынхаа хайрласан найман чөмөг, наян шандсаар уулзах уу? Эрийн сайн зэр зэвсгээрээ уулзах уу? гэж асуусанд, мангас омогтойхон дуугаар:

- Эрийн сайн зэр зэвсгээр юу хийх вэ? Ээж аавынхаа хайрласан найман чөмөг, наян шандсаар уулзъя гэжээ. Тэгээд хүү, мангас хоёр долоон өдөр, долоон шөнө тэнгэрт гарч од тоолон ноцолдож, газарт орон үндэс тоолон ноцолдоод, хэн хэн нь дийлсэнгүй. Энэ үед, бяцхан хүүгийн аав “Эртийн гарсан нар буцаж шингэж байна. Нар сар хоёр хиртэж байна” гэж зүүдэлжээ. Үүнд өвгөн сэжиглэж “Энэ зүүд ямар учиртай юм бол? Муу хүү минь аюулд орчихоогүй биз” гэж шар зурхайчаа залж, зурхай татуулж үзжээ. Зурхайч зурхайгаа татаж үзээд:

- Танай хүү чинь баруун зүгт, гурван жилийн газарт атгар хар мангасын гарт ороод, амиа өгөх дээр тулчихсан байна гэж хэлэв. Аав нь түүнийг сонсоод сэтгэл нь ихээр зовж, тэр дороо бөх Лайчиныд гүйж хүрээд, учраа хэлж, туслахыг гуйсанд, бөх Лайчин:

- Болно болно. Би тусалъя гээд эмээлгүй эрвээлжээр*, дээлгүй цамцаар, өмдгүй уяавчаар, гуталгүй улавчаар, малгайгүй оройвчоор хувцаслаад, хурдан хонгор морио:

- За, морь минь, одоо явна гэж дууджээ. Хурдан хонгор морь нь түүнийг сонсоод, ижил ханьдаа:

- За, одоо би явна. Эзэн минь дуудлаа. Эмээл минь хөтөллөө. Хаан минь дуудлаа, хазаар минь хөтөллөө гэж хэлээд явах гэсэнд, ижил хатан нь:

- За, сайн яваарай. Дайснаа дараарай, дархан цолоо олоорой. Хурц дэлээ ургуулаарай, хурдан цолоо олоорой гэж ерөөгөөд явуулжээ. Бөх Лайчины хурдан хонгор морь нь хань ижлээсээ салаад, сүүлнээсээ үргээд, сүүдэрнээсээ жигшээд, тавь тавьсаар, яв явсаар хүрээд иржээ. Тэр үед эзэн нь гурван үе модны дунд гурван алд цулбуураа бариад сууж байжээ. Бөх Лайчин морио барьж зайдан мордоод гурван жилийн газрыг гурван сараар товчлоод, гурван сарын газрыг гурван өдрөөр товчлоод, гурван өдрийн газрыг гурван цагаар товчлоод, тавь тавьсаар, яв явсаар Болзоотын бор толгой дээр гараад очжээ. Тэгсэн түүний баруун хойд зүгт уул гэхэд уул биш, үүл гэхэд үүл биш, тийм нэг сонин юм үзэгджээ. “Энэ юу байдаг юм?” гээд давхиад хүрсэн чинь хүү, мангас хоёр уулыг тал болгоод, талыг шалбааг болтол ноцолдож байна гэнэ. Бөх Лайчин хүрч очоод мангасыг эгэмнээс нь нэг тугтарсанд мангас хөл алдаж газар унажээ. Бяцхан хүү, бөх Лайчин хоёр нийлж байгаад атгар хар мангасыг дарав гэнэ. Ийнхүү зоригт бяцхан хүү зорьсондоо хүрч, баатар цолоо олж, барцад дайснаа дараад Алтангалуу хааны арван найман настай гүнжийг хатнаа болгож аваад нутагтаа ирж, удтал их найр хийж, жарган суужээ.

Шилэн галзуу баатар

Эрт урьдын цагт Шилэн галзуу баатар гэж жигж шарга морьтой сүрхий баатар хүн байж гэнэ.

Нэг өдөр түүний хатан нь Шилэн галзуу баатрыг “Орноосоо олгиж, ширээнээсээ шилгэж байна” гэж зүүдлэв. Тэгээд хатан гартаа хадаг бариад Шилэн галзуу баатарт толгойгоороо мөргөн, өвдгөөрөө сөхрөөд зүүдний учрыг асуужээ. Шилэн галзуу баатар түүнийг сонсоод үл тоож:

- Хатан хүний үг, хар шөнийн зүүд юу мэддэг юм! гэж хэлээд гарч адуугаа харахаар явжээ.

Тэгсэн чинь түүний жигж шарга морь нь хэсэг хэсэг адуунаасаа хөлөглөн тоглоод, олон олон адуунаасаа онцгойлон тоглоод ирж гэнэ. Шилэн галзуу баатар морио бөх хүнээр бариулаад, бөхтөр хүнээр чөдөрлүүлээд авчээ. Тэгээд морио уран авгайн оёсон улаан торгон олмыг гэдсээр нь гурван хуруу шигдтэл татаад, царайлаг авгайн оёсон цагаан торгон олмыг цавиар нь дөрвөн хуруу шигдтэл татаад авахад морь нь:

- За, явах юм бол хурдан яв! гэж хэлээд шалбаагийн чинээ шээж, саарийн чинээ бааж гэнэ.

Тэгээд Шилэн галзуу баатар гэрийн сангаа гэртээ тавиад, замын сангаа замдаа тавиад, морины аяар яваад аргийн чинээ чулуу хаялаад, ширүүн яваад ширээн чинээ чулуу өшиглөөд явжээ.

Явж явж том ногоон байшинд хүрсэн чинь цаана наана нүдтэй, царил зээтүү хошуутай, үмхий нохойн үнэртэй тийм нэг эмгэн сууж байж гэнэ. Түүнд учраа хэлээд асуусанд, эмгэн:

- Хүү минь, энэ хойно туурайтай амьтан гаталж чадах нь бүү хэл, тураг шувуу нисээд хүрэхгүй газар бий. Чи харин энэ хойд талын байшинд хураалгаатай байгаа хоргой торгоноос аваад буц буц! гэж хэлжээ.

Шилэн галзуу баатар түүнийг сонсоод “Би заавал мангасыг дарна” гэж эмгэний үгэнд оролгүй хойд зүгрүү явжээ. Тэгээд явж байсан чинь зам дээр нь буцлам халуун далай таарч гэнэ. Морь нь Шилэн галзуу баатарт:

- За, би одоо унаган харайлтаар харайна, чи хүүхдийн суултаа суу! гэж хэлээд унаган харайлтаар харайсанд болсонгүй. Морины хойд туурай нь далайд дүрэгдэж түлэгджээ. Тэгээд явах аргагүйдээ тэнд гурван жил мориныхоо туурайг эдгээж суужээ.

Мориныхоо туурайг эдгээж аваад хойд зүгт мангасыг дарахаар явж байтал замд нь хүний махыг уутанд хийгээд ганзагалчихсан, хөлийн хумс нь гадагшаа ургасан хүйтэн төмөр хумстай, гарын хумс нь гадагшаа ургасан ган төмөр хумстай, хангай зайдан луус зайдалсан нэг хүн явж байна гэнэ. Шилэн галзуу баатар тэр хүнээс:

- Та хэн гэгч, хаана хүрэхээр явж байгаа хүн бэ? гэж асуухад:

- Би бол мангас байна. Харин та хэн гэгч хаашаа явж байгаа хүн бэ? гэж хариу асуув. Шилэн галзуу баатар:

- Өө, тийм үү, би бол Шилэн галзуу баатар гэгч хүн байна. Чамайг дарахаар явж байна гэж хэлжээ. Мангас Шилэн галзуу баатрын үгийг сонсоод үл тоомсорлосон царай гаргаж, хүйтэн инээгээд:

- За тэгвэл хоёулаа байлдах уу? Өдрийн газраас харвах уу? гэхэд, Шилэн галзуу баатар:

- Хүүхдийн наадам биш дээ. Сарын газраас харвацгаая гэж хэлэв. Тэгээд тэр хоёр сарын газраас байлдахаар болж, Шилэн галзуу баатар “Мангасын уушги зүрхийг оноё” гэж харвасанд сум нь гарахдаа гал болж, газрын дундаас цог болж, хүрэхдээ хүрэн улаан аянга болоод мангасын уушги зүрхийг нь онож гэнэ. Тэгсэн чинь мангас өвс дэрсээр уушги зүрх хийгээд дахин байлдах гэж байна гэнэ. Шилэн галзуу баатар “Өвсөн уушги зүрхтэй амьтан хэдий юу шалих билээ” гэж бодоод мангасыг хаячихаад цаашаа бас мангасыг дарахаар явжээ. Тэгээд цааш явж байсан чинь замд нь нэг том гэр таарч гэнэ. “Энд юун гэр байдаг юм бол?” гээд гэрийн үүдэн дээр нь морьтойгоо очиж зогсонд, гэрийн дотор:

- Хүүе, баруун нүд татаатахлаа. Тэр төлөг судар аваад өг. Энэ үүдэн дээр ямар учир болж байна гэх эмгэн хүний дуу сонсогджээ. Тэгээд номоо үзчихээд:

- Энэ үүдэн дээр нэг сайн эр, нэг сайхан морь хоёр ирчихсэн байна. Хоёр хүү минь хурдан очиж бариад ир! гэж эмгэн дахиад хэлж байна гэнэ. Тэгтэл хоёр зулзаган мангас үүдний хоёр талаар гараад шилэн галзуу баатрын хоёр талд нь гартал Шилэн галзуу баатар хүүе хаая гэхийн зуургүй гэрт ороод хойд талд нь гарч суув. Хоёр зулзаган мангас гэрийн хойд талд гартал Шилэн галзуу баатар бас гэрийн зүүн талд гарчээ. Шилэн галзуу баатар дахиж зугтаах гээд чадсангүй хоёр зулзаган мангаст баригдаж байлдаж гэнэ. Байлдаж байлдаж Шилэн галзуу баатар хоёр зулзаган мангасыг дийлээд алах гэсэнд:

- Ах минь, амийг минь өршөө! Бид таны гутлын ул больё, оймсны зулаг больё гэж гуйжээ. Шилэн галзуу баатар аавынхаа төлгөнд үзсэнд “Алаад өвчиж хая” гэж буужээ. Ээжийнхээ төлгөнд үзсэнд “Эвдэж хагалж хая” гэж буужээ. Тэгэхээр нь хоёр зулзаган мангасыг алж хаятал, мангас эмгэн дөрвөн мөчиндөө Замбуутивийг давхийлгэн гарч ирж, Шилэн галзуу баатартай ноцолджээ. Тэгээд ноцолдож, ноцолдож Шилэн галзуу баатар дийлээд ирэхээр эмгэн мангас:

- Баатар эр ээ? Би тийм амархан үхэхгүй. Миний амь баруун гуянд байдаг юм. Баруун гуяыг минь хагалбал нэг үхэж магадгүй гэж хэлж гэнэ. Шилэн галзуу баатар “Үнэн юм болов уу” гээд баруун гуяыг нь хагалсанд мангас эмгэн үхэж, харин гуян дотроос нь төмөр нум сумтай хүүхэд мангас гарч ирээд тулалджээ. Шилэн галзуу баатар тэр мангастай тулалдаж, тулалдаж дийлээд ирсэн чинь хүүхэд мангас:

- Ах минь ээ, Би үхэхээсээ өмнө танд хэлэх гурван гомдол байна. Нэг нь би ээжийнхээ хэвлийнээс гараагүй, хоёр бол аавынхаа зүсийг үзээгүй, гурав бол ээжийнхээ сүүг хөхөөгүй. Ингээд үхэх жаахан харамсалтай юм. Амий минь өршөөх болов уу? гэж гуйжээ. Шилэн галзуу баатар аавынхаа төлгийг буулгаад үзсэн чинь “алж хая” гэж буужээ. Ээжийнхээ төлгийг буулгаад үзсэнд “Эвдэж хая” гэж буужээ. Тэгээд Шилэн галзуу баатар тэр мангасыг алж хаячихаад буцжээ. Гэртээ хариад ирсэн чинь түүний эзгүй хойгуур нутаг хотыг нь мангас аваад явчихсан байжээ. Шилэн галзуу баатар олон мангасыг дараад ирэхэд бас юун мангас

байдаг юм гэж уур нь хүрч:

- Аавын тахисан алтан зуу, ээжийн тахьсан эрдэнийн зуу гэж хэлээд сэлмээ аваад бурханруугаа далайсанд, бурхан нь:

- Өө, Үүл байвал бороо байлгүй гэжээ. Шилэн галзуу баатар учрыг нь мэдэж, гэрээсээ гарч хатнаа хайхаар явах гэсэнд морь нь алга болчихжээ. Мориныхоо мөрийг мөшгиж үзсэнд мангас аваад явчихсан байжээ. Шилэн галзуу баатар мориныхоо мөрөөр, жаран жалгыг навгайтал гишгээд морь, хатнаа хайж явжээ. Зам дээр нь нэг хүүхэд хар унаа уначихсан давхиад иржээ. Тэр унаатай хүүхэд Шилэн галзуу баатрын хажууд ирээд:

- Чи надаар хүүхдээ хийчих, миний мориор унаагаа хийчих гэв. Шилэн галзуу баатар түүнийг сонсоод олон юм бодсонгүй “Эр хүний олз байна” гэж бодоод хүүхэд, морь хоёрыг аяныхаа богцонд хийж дүүрээд цаашаа явжээ. Тэгээд бас нэлээд явсан чинь нэг манханы орой дээр нэг хүн:

- Манай хаан чинь богинохон бариултай хаан. Мангасын хаан чинь манхан бариултай хаан гэж дуулаад сууж байжээ. Шилэн галзуу баатар түүнийг үзээд хүрээд очсон чинь харин хатныг нь мангас авчраад хаячихсан байжээ. Тэгээд хатнаа олж очсонд, хатан нь туйлын их баярлаж:

- Та мангасыг бүгдийг нь дараагүй байна гэж хэлжээ. Шилэн галзуу баатар гайхаж:

- Үлдсэн мангас хаана байна? гэж асуусанд, хатан нь:

- Замд чинь унаа унасан хүүхэд таарсангүй юу? Тэр чинь намайг барьж явсан мангас шүү дээ. Түүний унаж яваа морь чинь таны алдсан морь гэж хэлэв. Шилэн галзуу баатар хатныхаа үгийг сонсоод сая л ухаарч, аяны богцондоо хийсэн мангасыг дарж, өөрийн морь, хатан хоёроо авч гэртээ хариад, хутга тавилгүй мах идэж, хундага тавилгүй архи ууж, хотол олноороо найрлан суужээ.

Шилийн галзуу баатар

Эрт урьд цагт хоёр гэр бүл, айл саахалт нутагладаг байжээ. Нэг жил хоёр айлын эхнэрүүд нэгэн зэрэг хөл хүндтэй болсон бөгөөд тэд хоорондоо:

- Бидний хүүхдүүд хүү, охин төрвөл хожим эхнэр нөхөр болгоё, хоёр хүү төрвөл ах дүү болгоё, хоёр охин төрвөл эгч дүү болгоё гэж хэлэлцээд өндгөн сүй тавьжээ. Нэг айлынх нь эхнэр түрүүлж өвдөөд, хоёр гартаа нум сум барьсан, хоёр хөлөндөө гутал өмссөн хүү төрүүлж гэнэ. Аав ээж нь “Энэ хүү чинь буг юм уу? бурхан юм уу” гэж аврал айлтгагчид очиж бүхэн дөрвөн хормойгоо бөхийсхийж мөргөөд, навчин дөрвөн хормойгоо нахисхийж мөргөөд аврал асуусанд, лам мэргэлж үзээд:

- Танай энэ хүү чинь буг ч биш, бурхан ч биш, харин Шилийн галзуу баатар байна. Арван долоо нас хүрээд аяндаа мэдэгдэнэ гэж хэлжээ. Хэдэн өдрийн дараа нөгөө айлын эхнэр төрж, хоёр гартаа нум сум барьсан, хоёр хөлөндөө төмөр гутал өлгөсөн хүү төрүүлж гэнэ. Аав ээж нь “Энэ хүү чинь буг юм уу? бурхан юм уу” гэж аврал айлтгагчид очиж дөрвөн хормойгоо бөхийсхийж мөргөөд, навчин дөрвөн хормойгоо нахисхийж мөргөөд аврал асуусанд, лам мэргэлж үзээд:

- Танай энэ хүү чинь буг ч биш, бурхан ч биш, ажиг тэнэг баатар байна гэж хэлэв. Тэгээд хоёр айл хоёр хүүгээ хэлэлцсэн ёсоороо ах дүүс болгож гэнэ. Ах дүү хоёр арван долоо хүрсэнд, ах нь дүүдээ:

- За, би одоо зүүн зүгийг эзэлсэн Зүсэр хааны охиныг хатнаа хийж авна. Баруун тивийг эзэлсэн Бамбар дайчин хааны алтан тамгыг булааж авч төр нийгмээ байгуулж, хаан эзэн сууна гэж хэлээд “Билэг ямар байна?” гэж аврал айлтгагчаас асууж гэнэ. Аврал айлтгагч лам:

- Зүүн зүгийн Зүсэр хааны охиныг авах нь байтугай зүүн зүгт гурав ч алхаж болохгүй юм байна гэсэнд Шилийн галзуу баатар дэлбэ уурлаж, хаалгыг нь балба цохиод, дүүгээ дагуулаад гарч явж гэнэ. Аврагч лам сандарч:

- Хүүе, хүүе. Та нар байз байз гээд араас нь гарахын завдалд хоёр баатар ор сураггүй алга болчихсон байв гэнэ. Лам араас нь хэдгэнэ дамраа авч хөөгөөд явав. Ах дүү хоёр нэг амьсгаагаар давхиад доорх нь домбо, дундахь нь дун, орой нь очир болсон уулын оройд гарч тамхиа татаад сууж байв. Лам гүйцэж ирээд:

- Та хоёр зүүн зүгт явж болохгүй. Яасан ч явж болохгүй гэж ятгасанд хоёр баатар яасан ч явна гээд зөрөөд болохгүй, гурвуулаа маргалдаад сууж байтал хойд зүгээс гурван хүүхэн бор саарал илжгийг ногтгүй зайдалчихсан, хар саарал илжгийг хазааргүй зайдалчихсан, эм саарал илжгийг эмээлгүй зайдалчихсан ирлээ гэнэ. Тэр гурав хүрч ирээд:

- За, нүүрэндээ галтай, нүдэндээ цогтой залуу хаа хүрэхээр явж байна? гэж Шилийн галзуу баатраас асуусанд, Шилийн галзуу баатар:

- Би зүүн зүгийн Зүсэр хааны охиныг эхнэрээ болгож авахаар явж байна гэж хэлэв. Тэр гурван хүүхэн бол арван хоёр толгойтой, атгар хар мангасын хүүхдүүд байжээ. Тэд Шилийн галзуу

баатрын үгийг сонсоод:

- За, чи овоо сүрхий хүү байна. Чи сонс! Маргааш өглөөний мандахын улаан нарнаар миний аавын гарын шөрмөсийг дийлэхгүй бол явна гэж битгий сана! гэж хэлээд явчихаж гэнэ. Мангасын хүүхдүүд, гэртээ хариад аавдаа:

- Аав аа? Тэр уулын орой дээр нэг ламын хамт хоёр хүү сууж байна. Тэд “зүүн зүгийн Зүсэр хааны охиныг эхнэрээ болгож авах гэнэ” гэж хэлэв. Мангас үүнийг сонсоод мар мар инээж:

- Ямар сайн юм. Би яг тэмцэлдэх хүн хайж байсан юм гэж хэлээд Шилийн сайн баатрын хажууд давхиж ирээд:

- Сонсоод байхнээ та нар зүүн зүгийн Зүсэр хааны охиныг эхнэрээ болгож авахаар явж байгаа гэнэ. Маргааш өглөөний мандахын улаан нарнаар миний гарын шөрмөсийг сунгаж чадвал яв. Үгүй бол би та нарыг барьж иднэ гэж хэлээд явчихав.

Мангасыг омогдож байх хооронд Ажиг тэнэг баатар ид шидээ гаргаж байгаад мангасын толгой, шүдийг нь мултлаад авчихаж гэнэ. Харин мангас толгой шүдээ алдсанаа мэдэлгүй харьжээ. Хоёр баатар мангасын толгой, шүдийг ламд үзүүлсэн чинь өнөө толгой нь гэр байшингаас том, араа шүд нь ачаа тэгнээгээр ч даахааргүй юм байв гэнэ. Лам түүнийг үзээд айхдаа:

- Байг, байг. Би та хоёрыг дааж чадахгүй юм байна. Одоо би хурдан буцаж гэртээ харилаа. Мангасын араа шүдийг ч би дийлэхгүй юм байна гээд зугтаад явчихав. Маргааш өглөө нь хоёр баатар босоод харсан чинь мангас гэрээсээ гэгээ улаан шидэм бариад гарч ирэв. Замын дунд ирэхэд өнөө барьсан шидэм нь зандан улаан шидэм болж хувирав. Хоёр баатрын хажууд хүрээд ирэхэд шидэм нь хүрэн улаан өнгөтэй болж хувирч гэнэ. Мангас:

- Ойр байснаараа би түрүүлэх үү? Холоос ирснээрээ та хоёр түрүүлэх үү? гэж асуусанд Шилийн галзуу баатар:

- За, ойр байснаараа чи түрүүл гэж хэлсэнд, мангас гурван өнгөөр хувилдаг шидмээрээ нэг цохиод авсанд, Шилийн галзуу баатар шидмийн үзүүрээс нь бариад авав. Мангас, Шилийн галзуу баатар хоёр өнөө шидмээ булаалдаж эхлэв. Мангас:

- Аавын үеийн шидэм билээ гэж хэлээд цаашаа татсанд, Шилийн галзуу баатар:

- Аянчин маянчны гэсэн мод байлгүй гээд нааш нь татав. Мангас:

- Хоёр үеийн шидэм билээ гээд цааш нь татсанд, Шилийн галзуу баатар:

- Хоньчин моньчин гэсэн мод байлгүй гээд хүчтэй татаад булаагаад авчаж гэнэ. Тэгээд мангас, Шилийн галзуу баатар хоёр гараараа тулалдаж эхлэв. Хэсэг тулалдаж байгаад, Шилийн галзуу баатар:

- Хөөе, Чиний нөгөө олон толгой чинь хаачсан юм бэ? Араа шүд чинь яасан юм бэ? гэж асуусанд, мангас толгойгоо тэмтэрч үзтэл хамаг толгой нь аль эрт алга болсон байжээ. Амаа

ангайгаад үзсэн чинь араа шүд нь ч алга байв гэнэ. Тэгээд ах дүү хоёр баатар:

- За, одоо энэ мөрий биднийх болсон гээд мангасыг барьж аваад үлдсэн арван нэгэн толгойг нь нэг нэгээр нь цавчиж унагаад алсан чинь, алсан газраас нь арван мангас босоод ирж гэнэ. Хоёр баатар түүдэг түүдгээр нь шатаагаад алсан чинь, шатаасан газраас нь түмэн мангас босоод ирж гэнэ. Хоёр баатар түмэн мангасын толгойг түүхий гурилын боорцог шиг “Түс түс” хийтэл хэрчээд, болсон гурилын боорцог шиг “бөнтөр бөнтөр” хийтэл хэрчээд алга хийсэн гэнэ. Тэгээд мангас ч дахиж гарч ирсэнгүй тонилов. Ах дүү хоёр баатар мангасыг дарчихаад зүүн зүгийн Зүсэр хааны охиныг авахаар хайгаад явав. Явж байтал замд нь хэдэн хүн таараад:

- Нүүрэндээ галтай, нүдэндээ цогтой жаахан залуус хаашаа явж байна? гэхэд Шилийн галзуу баатар:

- Би зүүн зүгийн Зүсэр хааны охиныг хатнаа болгож авахаар явж байна гэж хэлэв. Тэр хүмүүс сонсоод:

- Чи чинь хэлдэггүй үгийг хэлэх юм. Ярьдаггүй яриаг ярих юм. Би чинь зүүн зүгийн Зүсэр хаан гэгч мөн байна. Чамд би охиноо өгөхгүй гээд, зарц нартаа:

- Хоёр залуу цангаж яваа байлгүй, түмэн агтын онгоцонд цийдэм хийж өг гэж зарлигдав. Олон зарц нь түмэн агтын онгоцонд цийдэм хийж өгсөнд, ах дүү хоёр араа шүдээ гаргаж байгаад гэдсээ гурав илээд сорсонд аманд ч үгүй, хамарт ч үгүй алга болж гэнэ. Тэгээд хоёр баатар, зүүн зүгийн Зүсэр хааныг барьж аваад:

- Чи хаан хүн байж худал хэлдэг чинь юу вэ? Чиний түмэн агтын онгоцонд хийсэн цийдэм чинь хаана байна? Яагаад цангаж явсан бид хоёрын уруулыг ч дэвтээж чаддаггүй юм? гэж хэлээд зодож гэнэ. Тэгсэнд хаан:

- Хийсэн, хийсэн гээд бархирав. Хоёр баатар:

- Чи бас худал хэллээ гээд зодоод байв. Хаан бүр тэсч ядахдаа:

- Би худал хэлсэн юм, худал хэлсэн юм гэж хашгирч гэнэ. Хоёр баатар:

- За, тэгвэл одоо яах гэж байна? гэж асуухад нь зүүн зүгийн Зүсэр хаан:

- Хоттой малаа өгье гэсэнд, хоёр баатар:

- Болохгүй гээд бас зодоод байв. Тэгэхээр нь хаан:

- Би хатнаа өгье гэж гуйв. Хоёр баатар:

- Авахгүй гэж хэлээд зодоод байв. Хамгийн сүүлд зүүн зүгийн Зүсэр хаан аргаа барж:

- Би охиноо өгье гэж хэлсэнд, хоёр баатар:

- За, охиноо өгвөл яахав гээд зодохоо болив. Зүүн зүгийн Зүсэр хаан цаашаа харж уйлж, наашаа харж инээж байгаад:

- Би та нарт нэг таяг, нэг маани өгье. Доголон хүнийг таягаар шагнаж, сохор хүнийг мааниар шагнаж яв гэж хэлээд охиноо Шилийн галзуу баатарт хатан болгож өгч гэнэ. Шилийн галзуу баатар зүүн зүгийн Зүсэр хааны охиныг хатнаа болгож аваад харьж ирэхэд, аав ээж нь нэг их том ордон барьчихсан, тэрэг мориор тосч авав гэнэ. Шилийн галзуу баатар ордондоо хүрч иртэл, ордон нь: Зүүн үүдэнд нь зөнжир мөнжир сийлсэн, зүүн зүгийн дайсан зугтаамаар, өмнө талын үүдэнд нь өнжир мөнжир сийлсэн, өмнө зүгийн дайсан өмнүүр нь хандан зугтаамаар, баруун үүдэнд нь банзар занзар сийлсэн, баруун зүгийн дайсан баруун зүгээд нь зугтаамаар, хойд талын үүдэнд нь хонжир минжир сийлсэн, хойд талын дайсан хойшоо хандан зугтаамаар сайхан шилэн байшин байж гэнэ. Шилийн галзуу баатар хатнаа буулгаж, дүүтэйгээ хамт ордондоо оруулчихаад, баруун тивийг эзэлсэн Бамбар дайчин хааны алтан тамгыг нь булааж авахаар баруун гэртээ орж байсан юмаа авч, дунд гэртээ орж дуртай юмаа авч, зүүн гэртээ орж зүйтэй юмаа авч, аав ээждээ ч хэлсэнгүй морио эмээллэж аваад нэг хөлөө дөрөөнд нь гишгэж нөгөө хөлөө газраас авах гэтэл ээж нь хүрч ирээд мориных нь зуузай дээрээс барьж аваад:

- Хүү минь чи одоо бас хаашаа явах нь вэ? асуусанд, хүү нь:

- Би баруун тивийг эзэлсэн Бамбар дайчин хааны алтан тамгыг булааж ирэхээр явна гэж хэлэв. Ээж нь:

- Хүүе, чи бол өөрийнхөө бэлчээрээс гараагүй балчир шүү, өөр мужийн дайсныг үзээгүй тэнэг шүү, хониныхоо бэлчээрээс гараагүй балчир шүү, хоёр мужийн дайсныг үзээгүй тэнэг шүү гэж хэлээд хориглосонд, Шилийн галзуу баатар сонсоод, дургүй нь хүрээд дуугарсангүй давхиад явчихаж гэнэ. Тэгээд дээгүүр жороо, доогуур сайвар явж, жилийн газрыг сараар товчилж, сарын газрыг өдрөөр товчилж, өдрийн газрыг цагаар товчилж, цагийн газрыг мөчөөр товчилж явсаар нэг жижигхэн толгой дээр амарч суугаад, гаансаа татаад сууж байтал баруун талаас цэнхэр манан дундуур хөх морьтой залуу ирж яваа харагдав.

Тэр шилийн галзуу баатрын дэргэд иж зогсоод:

- За, нүүрэндээ галтай, нүдэндээ цогтой залуу хаанаас хаана хүрэхээр явж байна? гэж асуусанд, Шилийн галзуу баатар:

- Би баруун тивийг эзэлсэн Бамбар дайчин хааны алтан тамгыг булааж, хаан төр байгуулж, хаан ширээнд суухаар явж байна гэж хэлэв. Гэтэл тэр залуу баруун тивийг эзэлсэн Бамбар дайчин хаан гэгч мөн байжээ. Тэгээд өнөө залуу Шилэн галзуу баатрын үгийг сонсоод ихэд цочиж:

- Юу гэнэ ээ? Баруун тивийг эзэлсэн Бамбар дайчин хаан гэгч би байна. “Гал дээр цог, цогон дээр ус” гэдэг юм. Одоо хоёулаа гал ус шиг уулзлаа шүү дээ гэж хэлээд мориноосоо үсрэн буув. Шилийн галзуу баатар ч мориноосоо үсэрч буугаад хоёулаа зодолдож эхлэв. Тэгээд хоёулаа газарт шорооны тоогоор зодолдож, тэнгэрт гарч одны тоогоор зодолдоод хэн нь хэнийгээ дийлсэнгүйд Бамбар дайчин хаан:

- За, яахав чи ч сайн эр байна. Би чамд алтан тамгаа өгье. Гэхдээ нэг мөрий тавина. Тэр мөрийг дийлвэл ав, үгүй бол өгөхгүй гэв. Шилийн галзуу баатар:

- Болж байна. Тэр чинь тэгээд ямар мөрий юм бэ дээ? гэж асуухад Бамбар хаан:

- Одоо бид хоёрын хэн нь ч хөдлөхгүй цаашаа харж зогсож байгаад харвая. Хэнийх нь сум морины эмээлийн бүүрэгний хөндийгөөр онож гарч чадвал тэр мөрийгөө авна гэж хэлжээ. Шилийн галзуу баатар дуртай зөвшөөрч:

- Хэн түрүүлж харвах уу? гэсэнд баруун тивийг эзэлсэн Бамбар дайчин хаан:

- Нас багаараа чи эхэлж харва гэв. Шилийн галзуу баатар дархи шар нумаа авч даамай ч тэмтэрсэнгүй харвасанд сум нь эмээлийн бүүрэгний хөндийгөөр орж, мориных нь хоёр чихэн дундуур гараад явчихаж гэнэ. Баруун тивийг эзэлсэн Бамбар дайчин хаан дархи хар нумаа авч, тэмтэрч тэмтэрч байгаад харвасанд сум нь Шилийн галзуу баатрын морины эмээлийн бүүргийг балба харваад, мориных нь чихийг сэт харваад явав гэнэ. Тэгээд баруун тивийг эзэлсэн Бамбар дайчин хаан мөрийгөө алдаж, хэлсэн үгээрээ алтан тамгаа гаргаж Шилийн галзуу баатарт өгөв. Шилийн галзуу баатар ч баруун тивийг эзэлсэн Бамбар дайчин хааны амийг өршөөгөөд алтан тамгыг нь авч нутагтаа харьж гэнэ. Ингээд Шилийн галзуу баатар зорьсон хэргээ бүтээж ирээд гурван жилийн найр наадам хийж, нэр цолоо мандуулж, төр нийгмээ байгуулж, хаан ширээндээ сууж, ард олноо амруулж, амар жимэр амьдран суусан юм гэдэг.

Хөхөлдэй мэргэн баатар

Эрт урьд цагт, Хурмаст тэнгэрт хөх бор хүлэг морьтой Хөхөлдэй мэргэн баатар байжээ.

Нэг өдөр, Хөхөлдэй мэргэн баатар “Би одоо хөрст орчлонд бууж, ан гөрөө хийж, хүн шиг амьдарвал ямар сайхан байх бол” гэж бодоод эрдэнийн сайн хүлэг морио унаад хөрст орчлонд бууж иржээ.

Хөхөлдэй мэргэн баатар хөрст ертөнцөд бууж ирээд өдөртөө ан гөрөө хийж сайхан амьдарч байжээ.

Хожим нь Хөхөлдэй мэргэн баатар ан гөрөөгөө хийгээд явж байтал замд нь нэг хүн толгойгоо гилжийлгээд юм чагнаад зогсож байв. Хөхөлдэй мэргэн баатар тэр хүнийг хараад гайхаж, нэр усыг нь асуусанд, өнөө хүн:

- Миний нэрийг Чагнаарай гэдэг юм гэв. Хөхөлдэй мэргэн баатар бүр гайхаж:

- Чи юунд ийм нэр авсан юм? гэж асуусанд, өнөө хүн:

- Би орчлонгийн юм бүхнийг чагнаад мэдчихдэг юм. Одоо тэнгэрийн хүмүүс юу ярьж байгааг чагнаж байна гэв. Хөхөлдэй мэргэн баатар “Энэ хүн чинь хэрэгтэй хүн байна” гэж бодоод:

- Өө, тийм үү? Тэгвэл хоёулаа ах дүү болцгоох уу? гэж асуухад өнөө хүн:

- Бололгүй яахав. Тэгье гэж хариулав. Ингээд Хөхөлдэй мэргэн баатар, Чагнаарай хоёр ах дүүгийн барилдлага тогтоож, хоёулаа хамт цааш явав. Нэлээд олон ан хийчихээд явж байтал замд нь нэг хүн хад чичээд зогсож байв гэнэ. Тэр хоёр гайхаж өнөө хүний нэр усыг асуусанд:

- Намайг Чичээч гэдэг гэв. Тэд бүр гайхаж:

- Яагаад ийм нэртэй болсон юм бэ? гэхэд нь өнөө хүн:

- Би хаднуудыг чичээд гарчихдаг юм. Энэ орчлон дэлхий дээр зам дугаах хэрэг гарвал би бүгдийг чичээд гатлаад гарчихдаг юм гэж хариулав. Хөхөлдэй мэргэн баатар, Чагнаарай хоёр түүний хэлэхийг сонсоод “Энэ чинь их хэрэгтэй хүн байна” гэж бодоод:

- Гурвуулаа ах дүүгийн барилдлага тогтоовол ямар вэ? гэж асуусанд, өнөө хүн:

- Бололгүй яахав. Тэгье гэж хариулжээ. Ингээд Хөхөлдэй мэргэн баатар ах дүү гурвуулаа болж цааш явав. Хэсэг ан гөрөө хийж явтал тэр гурвын замд нэг хүн зээр барьж тавьчихаад араас нь хөөж гүйцэж барьж аваад наадаж байхтай таарч гэнэ. Хөхөлдэй мэргэн баатар ах дүү гурвуулаа өнөө хүнийг хараад ихэд гайхаж, хажууд нь хүрч очоод, нэр усыг нь асуусанд, өнөө хүн:

- Өө, миний нэрийг Гүйцэгч гэдэг юм гэв. Тэр гурав түүнээс бас дахин:

- Яагаад ийм нэртэй болсон юм бэ? гэж асуувал:

- Би хурдан гүйдэг болохоор ийм нэр авсан юм. Энэ орчлон дээр ямарч хурдан амьтан намайг гүйцдэггүй юм гэж хариулж гэнэ. Ах дүү гурав түүнийг сонсоод “Энэ чинь их хэрэгтэй хүн байна” гээд:

- Чи бид гуравтай ах дүүгийн барилдлага тогтоох уу? гэж асуусанд, өнөө хурдан хүн:

- За, бололгүй яахав гэж хариулжээ. Хөхөлдэй мэргэн баатар ах дүү дөрвүүлээ болж, цааш ан гөрөөгөө хийхээр явав. Нэлээд явж байтал замд нь нэг хүн газар шагайгаад зогсож байхтай таарчээ. Хөхөлдэй мэргэн:

- Хүүе, хүн гуай? Чиний нэрийг хэн гэдэг вэ? гэхэд, өнөө хүн:

- Аа, миний нэрийг Мөрдөгч гэдэг юм гэв. Тэр дөрөв гайхаж:

- Чи юунд Мөрдөгч гэдэг нэр авсан юм бэ? гэж асуухад нь өнөө хүн:

- Би амьтны мөр гаргахдаа их сайн юмаа. Арван жилийн өмнө явсан аргалийн мөр, хорин жилийн өмнө явсан хорхойны мөрийг ч алдалгүй мөшгидөг юм гэж хэлэв. Хөхөлдэй мэргэн тэр дөрөв энэ үгийг сонсоод “Энэ чинь бидэнд их хэрэгтэй хүн байна” гэж ах дүү бололцоё гэж хэлсэнд тэр зөвшөөрч гэнэ. Ах дүү тавуулаа болж цааш явж байтал замд нь том мөрөн тааралдав гэнэ. Тэр мөрний хөвөөн дээр нэг хүн суучихсан мөрний усыг ууж, бүгдийг нь амандаа балгаж байгаа харагдав. Хөхөлдэй мэргэн баатар ихэд гайхаж “Энэ ямар сонин хүн бэ? Ийм их мөрний усыг бүгдийг амандаа балгаж болдог юм байх даа” гэж бодоод, тэр хүний хажууд очоод нэр усыг нь асуусанд:

- Миний нэрийг Балгагч гэдэг юм гэв. Хөхөлдэй мэргэн баатар:

- Чи яагаад ийм нэртэй болсон юм бэ? гэж асуухад, өнөө хүн:

- Би дэлхий дээрх бүх гол мөрний усыг балгаж нааддаг юм. Тэгээд хүмүүс намайг Балгаач гэж дууддаг юм гэв. Хөхөлдэй мэргэн ах дүү тавуулаа түүнийг сонсоод “Энэ хүн чинь бидэнд хэрэгтэй хүн байна” гэж хэлэлцээд:

- Бүгдээрээ ах дүү болцгоох уу? гэсэнд өнөө хүн:

- Тэгье, тэгье гэж зөвшөөрөв. Тэгээд Хөхөлдэй мэргэн ах дүү зургуулаа болоод цааш ан гөрөөгөө хийхээр явцгаажээ.

Хөхөлдэй мэргэн баатар таван хүнтэй ах дүү болж, ан гөрөө хийгээд хөрст орчлонд сайхан амьдарч байжээ. Нэг өдөр, Хөхөлдэй мэргэн таван дүүтэйгээ ан гөрөөгөө хийж, далайн хөвөөн дээр хоол ундаа хийж цадталаа идэж уугаад амарч суухдаа:

- За, одоо бид хэд ах дүүгийн барилдлага тогтоогоод их удлаа. Нас ч багагүй болчихлоо. Хүн төрөлхтөн нэг насандаа салалгүй хамт амьдрах аргагүй. Заавал айл гэр болцгоож, гэр орон толгойлж, чиг чигтээ амьдрах ёс байдаг. Иймээс хэдүүлээ салахаасаа өмнө нэг нэг хүрд

хийж, адуу малын хөл хүрэхгүй газарт аваачиж тавья. Хожим бид эргэж үзэхэд амар мэнд, сайн сайхан явж байвал хүрд нь зогсолтгүй эргэж байх ёстой. Хэрэв бидний хэн нэгэнд нь муу зүйл тохиовол түүний хүрд буруу эргэж, унаад өгөршсөн байх болно гэж тангараг тавиад өөр өөрийн хүрдээ аваачиж хатгаж тавьчихаад цааш цуварч явжээ.

Нэлээд явж байтал ах дүү зургаагийн замд нь оосор бүчгүй орд цагаан монгол гэр таарч гэнэ. Зургуулаа цувраад орж гэнэ. Гэрт гэгээнд нь адуу малламаар, гэрэлд нь зүү сүвэлмээр тийм нэг хөөрхөн хүүхэн сууж байж гэнэ. Ах дүү зургаа хүүхний царайг харж мэлэрч суутал, өнөө хүүхэн тэр хэдийг ойшоосонгүй, цай чанадаг гуулин тогоогоо гаргаж, нар зөв гурав эргүүлж угаагаад, нар буруу гурав эргүүлж угаагаад, угаадсаа асгачихаад нар зөв гурав эргүүлж арчаад, нар буруу гурав эргүүлж арчаад, усаа хийж сүүгээ сүлж, улаан шаргал цай чанаж, өрөм ээзгий таваглаж, боов боорцгоо тавьж өгчээ. Ах дүү зургаа өлсөж, цангаж явсан болохоор өнөө сайхан цай, идээнээс нь хөлс усаа гартал ууж идэж аваад жаахан амарч суув. Хөхөлдэй мэргэн баатар:

- За, дүү нар минь, нар сүүдэр оройтох нь. Бид эртхэн хөдөлцгөөх үү? гэсэнд, таван дүү нь айлын хүүхний царайнд нь дурлаад, харцаа салгаж чадахгүй:

- Ах аа, бид хол газар яваад их ядарч байна. Өнөөдөр ямар ч байсан энэ айлд хоноод явья. Ах та тун явья гээд байвал өөрөө мэд гэж хэлцгээв. Хөхөлдэй мэргэн дүү нарынхаа санааг ухаж ойлгоод:

- За, тэгвэл та нар өөрсдөө мэд. Би ч явья гэж хэлээд ганцаараа гараад явчихжээ.

Хөхөлдэй мэргэн баатар өнөө айлаас гараад хоёр өдөр явж байтал зам дээр нь оосор бүчгүй орд цагаан гэр таарч гэнэ. Гэрт орж очвол бас нэг хөөрхөн бүсгүй үс гэзгээ самнаад сууж байв гэнэ. Тэр хөөрхөн бүсгүй Хөхөлдэй мэргэн баатрын амар мэндийг асуугаад, гуулин улаан тогоогоо тавьж, нар зөв гурав эргүүлж угаагаад, нар буруу гурав эргүүлж угаагаад, угаадсаа асгачихаад нар зөв гурав эргүүлж арчаад, нар буруу гурав эргүүлж арчаад, усаа хийж сүүгээ сүлж, улаан шаргал цай чанаж, өрөм ээзгий боов боорцог таваглаж өгөв. Хөхөлдэй мэргэн баатар айлын цай хоолноос амтархан идэж уучихаад, айлд хонож өнжөөд явах гэсэнд, айлын бүсгүй мэдээд:

- За, явуулын хүн та хоол ундаа сайн идэж уусан бол сурсан дуугаа дуулаад, явдаг замаараа явсан нь дээр байх. Манайх бол арван таван толгойтой атгар хар мангасынх байна. Одоо манай өвгөн харьж ирэх юм бол таныг барьж иднэ гэж хэлэв. Хөхөлдэй мэргэн баатар түүнийг сонсоод дотроо “Муу мангас намайг явал гэж. Би түүнийг дарахаар хайж явахад өөрөө таарлаа” гэж бодоод:

- Би өнөөдөр туйлын их ядарч байна, явахгүй гэж хэлсэнд, айлын бүсгүй:

- Хүүе, та тэгж болохгүй. Манай өвгөн хүн амьтныг барьж иддэг юм. Та хурдхан явсан дээр гэж хэлэв. Хөхөлдэй мэргэн баатар “Энэ хүүхэн мангасын эхнэр байж яасан сайхан зантай хүн бэ? Энэ лав мангасын төрөл биш байх” гэж бодоод учрыг асуусанд, өнөө хөөрхөн хүүхэн:

- Би бол тэнгэрийн дагина. Гурван жилийн өмнө баруун мөрөнд умбаж байсан чинь мангас

намайг булааж авгайгаа болгосон юм. Одоо би нутагтаа харьж чадахгүй болжээ гэж яриад уйлж суув. Хөхөлдэй мэргэн баатар бүсгүйн үнэн учрыг олж мэдээд, өрөвдөж:

- Мангас хаашаа явсан бэ? гэж асуув. Бүсгүй:

- Мангас өнөөдөр урагшаа явсан. Өдрийн ажлаа хийж дуусгавал орой ирэхдээ явсан замаараа буцаж ирдэг юм. Ирэхдээ их сүртэй ирнэ. Хамгийн түрүүнд зуун алд биетэй, зураг улаан авын нохой нь явдаг, түүний араас тэнгэрийн нарыг бүрхмээр том авын шувуу нь явдаг, түүний араас арван таван толгойтой атгар хар мангас өөрөө ирдэг юм гэж зааж өгөв. Хөхөлдэй мэргэн баатар “Өнөөдөр муу хар мангасын үхэх цаг нь болсон” гэж шүд зуугаад эрдэнийн хүлэг морио унаж, мангасын өмнөөс угтаж явав. Хэсэг явж байгаад мангасын ирэх цагийг дөхүүлээд мориноосоо бууж, эрдэнийн хүлэг морио шагайн чинээ болгож, хормойдоо хийж нуучихаад мангасын ирэхийг хүлээж суужээ. Хэсэг хүлээсэнд, гэнэт тэнгэрт тулсан тоос босгосон сүртэй юм ирлээ гэнэ. Хөхөлдэй мэргэн баатар ухасхийн босч харвал зуун алд биетэй зураг улаан авын нохой гараад ирэв гэнэ. Хөхөлдэй мэргэн баатар далан тэхийн эврээр давтаж хийсэн дархи хар нумаа гаргаж өмнөөс нь эвшээлгэж бариад өвчүүрүү нь нэг сайн харвасанд авын нохой газар унаж үхэв. Тэр нохойны цус гэдэг нь үерийн ус шиг урсаж ирэв гэнэ. Нохойны хажууд хүрч үзсэнд араа шүднээс нь олон арван үнэг, чонын арьс өлгөөтэй байв гэнэ. Мангасын авын нохойг дарчихаад байж байтал гэнэт тэнгэр харанхуйлах шиг болж, мангасын авын хар шувуу тэнгэр бүрхэн нисээд ирж байна гэнэ. Хөхөлдэй мэргэн баатар далан тахийн эврээр давтаж хийсэн дархи нумаа эвшээлгэж байгаад тавьтал өрөөсөн жигүүрийг нь хуга оноод авын хар шувуу газар бүрхэн унажээ. Хөхөлдэй мэргэн баатар мангасын хоёр сүрхий амьтныг дарчихаад хүлээж байтал, төдий удалгүй уулын цаанаас атгар хар мангасын арван таван толгой арзганаад гараад ирэв. Хөхөлдэй мэргэн баатар далан тэхийн эврээр давтаж хийсэн дархи хар нумаа угт нь тултал эвшээлгээд тавьтал арван гурван толгойг нь унагаж, мангас хоёр толгойтой үлдэв гэнэ. Хөхөлдэй мэргэн баатар мангасыг дарчихаад өврөөсөө шагайн чинээ морио гаргаж, эрдэнийн хүлэг морь болгож хувиргаад, буцаж авын хар нохойны дэргэд хүрч, араа шүднээс нь үнэг, чонын арьсыг авч мориныхоо зөв буруу ганзаганд нь дүүрэн ганзагалчихаад өнөө хөөрхөн хүүхэн дээрээ хүрч ирэв. Бүсгүй өөдөөс нь гарч ирээд:

- Дайснаа дарав уу? Дархан цолоо мандуулав уу? Өшөөтнөө дарав уу? Өргөн цолоо мандуулав уу? гэж асуужээ. Хөхөлдэй мэргэн баатар баяр хөөртэй “Дарлаа, дарлаа” гэж хариулаад мангасыг дарсан тухайгаа нэгд нэгэнгүй ярьж өгчээ. Бүсгүй түүнийг сонсоод “Энэ хүн чинь жинхэнэ баатар мөн байна” гэж бодож суутал; Хөхөлдэй мэргэн баатар:

- Би хамаг амьтны дайсныг дарлаа. Одоо харин чамайг эхнэрээ болгож, айл гэрээ босгож, жаргаж суумаар байна гэж хэлсэнд, бүсгүй дуртай зөвшөөрч гэнэ. Хөхөлдэй мэргэн баатар, эхнэртэйгээ хоёулаа баруун мөрний хөвөөнд гэр орноо барьж суув. Эхнэр нь өглөө бүр мөрний усанд нүүр гараа угааж, үс гэзгээ самнадаг бөгөөд үснийхээ сэвийг мөрний усруу хаядаг байжээ. Нэг өдөр тэднийд самуун гуйранч иржээ. Тэр гуйранч Хөхөлдэй мэргэн баатар болон хатан хоёрт:

- Би бол хажуудаа түших ханьгүй, уйлж дуулах үргүй, орох гэр, оочих аягагүй хөгшин хүн байна. Хэрэв та хоёр намайг алтан суундаа хавчуулж хажуудаа байлгавал би та хоёрын ажил төрөлд тус дэм болж сууя гэж гуйжээ. Хөхөлдэй мэргэн баатар, хатантайгаа хоёул өнөө

гуйранчийг өрөвдөж, хажуудаа байхыг зөвшөөрчээ. Үүнээс хойш нэлээд хэдэн жилийн дараа Хөхөлдэй мэргэн баатрын хатан нэгэн хүү төрүүлжээ. Гуйранч эмгэн, Хөхөлдэй мэргэн баатарт:

- Чи их буянтай хүн байна. Чамд ийм сайхан хүү төрлөө. Харин би буянгүй болохоор хүү заяахгүй юм. Би танай хажууд олон жил боллоо. Одоо нэг нутаг усандаа очоод ирье гэж хэлээд мөрний хөвөөг дагаад явчихжээ. Эмгэн хэсэг удсаны дараа буцаж ирээд:

- Би одоо та нарын хажууд суугаад олон жил боллоо. Өөрийн гэсэн гэр оронтой болж сууя. Харин та хоёр надад мөрний хөвөөндөх модноос нэгийг буулгаад өгчих. Би тэр модны голыг хөндийлж байгаад дотор нь орж сууя гэж гуйсаар байгаад Хөхөлдэй мэргэн баатраар нэг мод буулгуулж аваад шөнө болгон хөндийд нь орж унтдаг болов. Хөхөлдэй мэргэн баатар, хатан хоёр түүнийг хараад дургүй байдаг ч “Хөгшин хүн тааллаараа болог” гэж бодоод өнгөрчээ. Нэг удаа Хөхөлдэй мэргэн баатрыг ан гөрөө хийгээд гадагшаа явсан хойгуур өнөө эмгэн, хатнаас нь:

- Хатантаан? Танай нөхрийн чинь сүр сүлд, амь нас нь хаанаа байдаг юм бэ? гэж асуув. Хатан “Энэ настан ямар сонин юм асуудаг юм” гэж бодсон боловч олон жил хамт амьдарч, төрсөн ээж шиг нь болсон болохоор төдийлөн юм санасангүй:

- Мэдэхгүй гэж хариулав. Эмгэн түүнийг сонсоод:

- Хань нөхрийнхөө сүр сүлд, амь насыг хаанаа байдгийг мэдэж байх ёстой юм. Чи дараа заавал асууж мэдэх хэрэгтэй гэж хэлжээ. Хатан “Настны ярьж байгаа нээрээ үнэн үг байна. Хайрт нөхөр минь байнга ан гөрөөнд явдаг болохоор түүний араас залбирч мөргөх ёстой. Гэтэл сүр сүлд, амь нас нь хаанаа байдгийг мэдэхгүй болохоор яаж залбирах билээ” гэж нөхрөө хүлээж суужээ. Хөхөлдэй мэргэн баатрыг ан гөрөөнөөсөө буцаж ирэхэд нь хатан нь.

- Таны амь нас, сүр сүлд хаана чинь байдаг юм бэ? гэж асуужээ. Хөхөлдэй мэргэн баатар түүнийг сонсоод, ихэд гайхаж:

- Түүнийг чинь хамаагүй хүнд хэлж болдоггүй юм гэхэд, хатан нь эмгэний хэлсэн аргаар:

- Та чинь хань ижилдээ итгэхгүй байгаа юм уу? гэж гомдоллоход, нөхөр нь сандарч, аргагүйн эрхэнд:

- Миний баруун талын суганд жижигхэн хүрэн мах байдаг юм. Тэр бол миний амь нас, сүр сүлд. Түүнийг эм хүн аваад дээр нь гурав гишгэж, газарт булвал би тэр дороо үхнэ гэж хэлж өгчээ. Тэгвэл таны эрдэнийн хүлэг морины чинь сүр сүлд хаанаа байдаг юм бэ? гэж асуусанд, Хөхөлдэй мэргэн баатар:

- Морины баруун талын суганд жижигхэн шувууны ангаахай шиг нялцгай мах байдаг юм. Түүнийг эм хүн аваад дээр нь гурав гишгэж, газарт булвал би тэр дороо үхнэ гэж хэлж өгчээ. Хөхөлдэй мэргэн баатар өөрийн нууцаа болон хүлэг мориныхоо нууцыг хатандаа хэлж өгч байх хоохонд өнөө самуун гуйранч эмгэн гэрийн гадна ирээд сэм чагнаж байжээ. Тэгээд Хөхөлдэй мэргэн баатар нууцаа хэлчихээд унтсаны дараа самуун эмгэн хар нойрон дундуур

нь гүйж очоод баруун сугаруу нь гараа шургуулж үзсэнд үнэхээр нэг хөрөө шиг мах байв. Самуун эмгэн хурдан гэгч түүнийг тас татаж аваад дээгүүр нь гурав алхаж, шороонд булж хаяжээ. Гэтэл Хөхөлдэй мэргэн баатар ч унтаагаараа үхэж гэнэ. Самуун эмгэн Хөхөлдэй мэргэн баатрыг алчихаад бас эрдэнийн хүлэг мориных нь дэргэд гүйж очоод баруун сугаруу нь гараа хийж үзсэнд мөн жижигхэн нялцгай мах байжээ. Эмгэн түүнийг нь хурдан гэгч тасдаж аваад дээгүүр нь гурав алхаж, газарт булж орхисонд морь нь тэр дороо үхэж гэнэ. Самуун эмгэн баярлаж “За, би ч нэгдэх үүргээ гүйцээлээ” гээд модон дотроо орж унтжээ. Маргааш өглөө нь Хөхөлдэй мэргэн баатрын хатан эртлэн босч цайгаа чаначихаад хүлээгээд байтал нөхөр нь босч ирдэггүй гэнэ. Хатан нь “Нөхөр маань олон хоног ан гөрөө хийгээд аяншиж ядраа байлгүй” гэж бодоод дуудсангүй. Үдийн нар хөөрч байх үед ер босохгүй болохоор нь дэргэд нь очоод дуудах гэсэн чинь Хөхөлдэй мэргэн баатар аль эрт үхээд хөшчихсөн байж гэнэ. Хөхөлдэй мэргэн баатрын хатан нь ихэд сандарч, гэрээсээ гүйж гараад эмгэнд хэлэх гэсэнд эрдэнийн хүлэг морь нь бас үхчихсэн тэрийж хэвтэнэ гэнэ. Хатан нь энэ бүгдийг үзээд туйлын их гашуудан уйлж бархирч байхыг самуун эмгэн хараад, өрөвдөж хайрласан хүн болж:

- Хатантаан, Чи одоо ийм сайхан хүн байж, гашуудаж гуниад яахав. Ядаж хүүгээ бод. Би үүнээс хойш та хоёрын дэргэдээс салахгүй, түшиг болж явья гээд “Хайран залуу хүн, ямар амьтан хорлочихдог байна аа” хэмээн худал уйлан орилж, чарлажээ.

Хөхөлдэй мэргэн баатар үгүй болоод гурван жил болжээ. Хүү нь өсч томроод гурван нас хүрч, гадаа гэрт гүйдэг болж гэнэ. Нэг өдөр хүү нь гэрийнхээ гадаа ганцаараа тоглож байхыг самуун эмгэн хараад, дуудаж модон гэртээ хуурч оруулав. Хатан хэсэг хугацааны дараа хүүгээ хайгаад ирэхэд нь:

- Өө, хүү чинь манайд байна. Та гэрт ор! гэж хэлэхэд хатан санамсаргүй гэрт нь орчихжээ. Хорон санаат эмгэн эх хүү хоёрыг гэртээ мэхэлж оруулаад, модон гэрийнхээ тагийг тас хийтэл хаагаад, чийгтэй сураар дангинатал нь хүлээд мөрний усанд тавьж явуулаад өөрөө хөвөөг даган алхаж гэнэ. Учир нь мөрний адагт шулмын хаан суудаг бөгөөд, мөрний усанд урсаж ирсэн хатны алтан үсийг олж үзээд “Энэ ямар сайхан үс вэ? Лав сайхан хүүхний л үс биз. Би энэ хүүхнийг заавал хатнаа болгож авна” гэж шийдээд нэг шулмаа хорон санаат эмгэний дүрд хувилгаж явуулсан нь тэр байжээ.

Хатан хүүтэйгээ модон гэрт хоригдон мөрний адагт хүрсэнд, шулмын хаан тосч аваад ээжээр нь хатнаа хийгээд, хүүг зарцаа болгож гэнэ. Олон жилийн дараа, Хөхөлдэй мэргэн баатартай ах дүүгийн барилдлага тогтоосон таван дүү нь ахыгаа санаж, өнөө хатгасан хүрдэн дээрээ очиж үзтэл, Хөхөлдэй мэргэний хүрд аль эрт унаад өгөршсөн байжээ. Ах дүү тав түүнийг үзээд:

- Бидний том ахад ямар нэг юм болсон байна. Одоо хурдан хайж олъё гэцгээгээд хайж явцаажээ. Ийнхүү хайж явсаар мөрний эхэнд хүрч ирсэнд, аль эрт үхчихсэн байж гэнэ. Ах дүү тавуулаа том ахыгаа үхсэн байхыг хараад гайхаж, Мөрдөгч дүү гэрийг нь тойрч үзсэнд шулмын мөр байжээ. Тэгэхээр нь ах дүү тав шулмын мөрийг мөшгиж явтал нэг газарт юм булаад орхисон байв. Ухаад үзсэн чинь ахынх нь амь нас байжээ. Түүнийг нь авч ахынхаа суунд хийсэнд, Хөхөлдэй мэргэн баатар:

- Хүүе, Би яагаад ингэтлээ унтдаг юм? гэж хэлээд босч иржээ. Дүү нар нь баярлаж:

- Та унтсан юм биш ээ. Шулам таныг хорлочихжээ гэж учрыг хэлэж өгөв. Хөхөлдэй мэргэн баатар гэрээсээ гарч ирсэнд морь нь аль эрт үхэж, хатан хүү хоёр нь ор сураггүй алга болсон байлаа. Мөрдөгч үүнийг мэдээд мөн шулмын мөрөөр явж, мориных нь амь насыг авчирч суганд нь хийсэнд морь нь амь ороод босоод ирж гэнэ. Хөхөлдэй мэргэн баатар эрдэнийн морио амь оруулчихаад, дүү нараа дагуулж, мөрдөгч дүүгээрээ мөрдүүлж явсаар мөрний адагт хүрч ирсэнд шулмын хааны гэрийн гадаа хүрээд иржээ. Хөхөлдэй мэргэн баатар гэрийн ойролцоо очоод “Яаж хатан, хүү хоёроо авч явах вэ?” гэж гайхан зогсож байтал хэдэн хүүхэд нум сум харваж тоглож байгаа харагдав. Тэгтэл нэг хүүгийн сум Хөхөлдэй мэргэн баатрын өвдгөнд ирж туссанд авч үзвэл өөрийнх нь сум байв. Хөхөлдэй мэргэн баатар “Энэ миний сум байхыг бодоход, тэр хүүхэд миний хүү байх” гэж бодоод:

- Хөөе, миний хүү ээ? Ирж сумаа ав! гэж дуудсанд өнөө хүү гүйж ирээд сумаа авчээ. Хөхөлдэй мэргэн баатар хүүдээ сумыг нь өгөхдөө, өврийн товчоо мулт татаж аваад:

- За, чи үүнийг аваачиж ээждээ өг. Тэгээд гадаа аав, таван авга ахтай хамт ирсэн байна гэж хэл гэв. Хүү товчийг аваачиж ээждээ өгсөнд шулмын хаан түүнийг мэдээд, ээж хүү хоёрыг хол аваачиж, төмөр гэрт хийгээд таглаж тавив. Хөхөлдэй мэргэн баатар хүүдээ товч өгч явуулаад “Одоо хатан товчийг танивал нэг аргаар гарч ирэх байх” гээд хүлээгээд байсанд хатан нь гарч ирэх байтугай хүү нь ч тоглож наадахаа байчихав гэнэ. Хөхөлдэй мэргэн баатар ямар нэг учир гарсан гэдгийг мэдээд Чагнаач дүүдээ:

- За дүү минь, чи нэг сайн чагнаатах бэргэн чинь хаана байна. Шулмын хаан юу гэж хэлэлцэж байна гэж хэлэв. Чагнаач газар хэвтэж хэсэг чагнаад :

- Ах аа, бэргэнийг хүүтэй нь хамт хол газар аваачаад гурван давхар төмөр гэрт хийж хорьжээ. Шуламнууд:

- Энэ ах дүү зургаа нийлвэл барагтай хүн амьганд дийлдэхгүй. Энэ зургааг хурдан аргалж байгаад хортой хоолоор хорлож алья. Тэгээд дийлэхгүй бол төмөр гэрт оруулж галаар түлж алья. Үгүй бол удахгүй биднийг устгана гэж хэлэлцэж байна гэж хэлэв. Хөхөлдэй мэргэн баатар шуламнуудын санааг мэдэж аваад яаж хатан хүү хоёроо аврах билээ? Чичээч дүүдээ:

- Дүү минь чамд ямар арга байна? гэж асуусанд Чичээч дүү нь:

- Бэргэнийг хүүтэй нь чичиж гаргаж авах арга надад байна. Гэвч тэр хол газарт би очиж ирж чадахгүй гэв. Гүйгч дүү нь сонсоод:

- Тэр амархан бэргэнийг хүүтэй нь чичээд гаргачих л юм бол би тэднийг тэр дор нь аваад ирнэ гэж хэлэв. Хөхөлдэй мэргэн баатар хоёр дүүгийнхээ үгийг сонсоод тэр дор нь томилж явуулав. Тэгээд гүйцэгч нь Чичэгчээ үүрч хатан хүү хоёрыг хорьсон газарт хүрч Чичэгч нь гурван давхар төмөр хайсыг цоо чичиж, хатан хүү хоёрыг гаргаж авав. Гүйцэгч хатан хүү, Чичигч гурвыг үүрээд буцаж ирэв. Хөхөлдэй мэргэн хааныг хүү, хатан хоёроо булааж авсныг шулмын хаан мэдээд уур нь хүрч, санд мэнд үй түмэн цэргээ хөдөлгөж хатан хүү хоёрыг булаахаар ирсэнд Хөхөлдэй мэргэн баатрын Балгагч дүү нь мөрний усыг цөмийг нь балгаж

аваад шулмын хааны цэрэг рүү тургисанд, өнөө шулмын хааныг цэрэгтэй нь урсгаж гэнэ. Ингээд хөхөлдэй мэргэн баатар хатан, хүү хоёроо аваад таван дүүгээ дагуулаад нутагтаа харьж ирээд:

- За би одоо ерөөлөөр учирсан таван дүүгийнхээ ачаар хатан, хүү хоёроо олж авлаа. Хортон дайснаа дарлаа, хойшдын амьдрал лавтай сайн сайхан болно. Иймээс бид хойшдын амьдралаа хуваалцах уу гэж хэлсэнд Мөрдөгч дүү нь:

- Хн, юун тийм амар хэрэг байдаг юм. Хэрвээ би анх мөрдөөгүй бол ах таны амийг яаж аврах юм бэргэн хүү хоёрыг яаж тийм амархан олох юм. Иймээс би бэргэнтэй амьдарна гэж хэлжээ Чагнаач түүнийг сонсоод :

- Юу гэсэн үг вэ? Хэрвээ би бэргэн хүү хоёрын нуусан газрыг чагнаж олоогүй бол ах та хатан, хүү хоёроо хаанаас олж авах юм. Иймээс би бэргэнтэй хамт амьдарна гэж хэлжээ. Энэ үгийг Чичээч дүү нь сонсоод уурлаж:




- Дуу! Юун тийм амархан хэрэг байдаг юм. Хэрвээ би тэр үед би гурван давхар төмөр хайсыг цөм чичиж гаргаагүй бол ах та хаанаас хатан хүү хоёртой болох юм. Иймээс би бэргэнтэй амьдарна гэж хэлжээ. Үүнийг Гүйгч сонсоод :

- Улам уур нь хүрч та нарын тэр хэрэг чинь юу юм, юу ч биш. Хэрэв тэр үед би бэргэн хүү хоёрыг булааж аваагүй бол тэр хоёр дахиад шулмын хааны гарт орох байсан. Тэгвэл ах танд юун хатан хүү хоёр байдаг юм. Иймээс би бэргэнтэй амьдрах ёстой гэж хэлжээ. Балгаач түүнийг сонсоод дэлбэртлээ уурлаж :



- Та нар бүгдээрээ чимээгүй бай. Хэрвээ тэр үед шулмын хаан үй түмэн цэргээ дагуулаад ирэхэд би мөрний усыг балгаж тэднийг устгаагүй бол хатан хүү хоёр байтугай та нар ч үгүй болсон. Иймээс би бэргэнтэй амьдарна гэжээ. Шулмыг дараад энх тайван болсон боловч Хөхөлдэй мэргэн баатрын хэдэн дүү нь хоорондоо эвдрэлцээд болохгүй болохоор хатан нь:

- За та нар маргах хэрэггүй. Та нарын хэлж байгаа бүхэн үнэн боловч Хөхөлдэй мэргэн баатар бол атаатан дайсан арван таван толгойтой атгар хар мангасыг дарж намайг аварч хатнаа болгосон хүн. Мөн манай нар саранд мөргөж, үс толгойгоо холбож, ариун цусаа нийлүүлсэн хань нөхөр. Энэ хүү ч бид хоёрын цус махны тасархай. Тэгвэл ерөөлөөр ирсэн таван дүү нь та нар мөн. Та нарын ач тусаар бид аврагдсан нь ч үнэн. Тэгэхээр ах дүү зургуул миний төлөө эвдрэлцэхийн хэрэггүй. Нэг эм хүн зургаан эртэй амьдрах ёс энэ орчлонд байхгүй. Иймээс та ах дүү зургуул миний хүүтэй долуул болж миний нутаг тэнгэрийн дунд алтан гадсын орчим очиж долоон бурхан болж амьдар. Би үүрийн цолмон болж өнө үүрд та нарыг гэрэлтүүлж амьдарья гэж тангараглаж гэнэ.

Ийнхүү Хөхөлдэй мэргэн баатар хүү болон таван дүүгийнхээ хамт долоон бурхан болж хатан нь үүрийн цолмон болж мөнх тэнгэрт мөнхөрсөн гэнэ. Түүнээс хойш тэнгэрт долоон бурхан болон цолмон од буй болсон ажээ.



ГАЗАР УСНЫ
ДОМООГ ҮЛГЭР





Алтан малгайтын даваа

Эрт урьд цагт Алтан малгайтын даваа гэдэг газарт хоёр хүүтэй дээрэмчин эмгэн суудаг байжээ. Тэр айл хэзээд бадарчин ламыг мэхэлж эд зүйлийг нь тонодог байж гэнэ.

Нэг удаа, дээдийн гэгээний хоёр шавь бадар хийж яваад тэр айлд хүрч очив. Айлын эмгэн сайхан зантай байна гэдэг их. Мах шөл чанаж хоол унд бэлдэн, хоёр хүү нь унаа малыг нь бэлчээрт тавьж, хөл алдахад хоёр лам дотроо энэ айл яасан сайхан, ямар сайн улс вэ? гэж бодоод хоёр өнжөөд явахдаа:

- Бид буцахдаа танайхаар дайрч ирнэ гэж хэлээд явав.

Хоёр лам бадарчилж явсаар нэлээд тэмээ мал, эд хөрөнгө цуглуулж, олоод буцаж нөгөө айлдаа ирэхэд хоёр залуу үүдэндээ хүлээж байв.

- За, залуучууд сайн сууж байна уу? гэхэд тэд царайгаа барайлган сайн гэж хэгжүүн дуугаар хариу мэндлэв.

Хоёр лам ч ачаа хошоо буулгаж эхлэхэд хоёр залуу хар цагаан дуугүй хүрч ирэн богц, савыг нь уудлан эд зүйлийг нь булааж авав. Хоёр лам энэ хоёр биднээр тоглож байгаа байлгүй гэж бодоод гэрт нь ортол ээж нь бас ихэд ууртай сууж байв. Лам нар учрыг сайн ойлгосонгүй:

- За, хөгшин ээж сайн сууж байв уу? гэж мэндэлсэнд нөгөө сайхан зантай эмгэн чинь дуу шуу ч үгүй нэлээд сууж байснаа:

- Сайн гэж хүйтэн хөндий дуугарав.

Хоёр лам сая л хэрэг биш болж гэдгийг мэдээд яах учраа олохгүй сууж байтал гэрийн үүдээр хоёр бууны ам ороод ирэв гэнэ. Хоёр лам “Ээ, гэгээн минь, одоо алуулах юм байна, ийм амархан дээдийн гэгээнээсээ салах юм гэж үү” хэмээн учир утгагүй залбирч эхлэхэд, эмгэн:

- Дээдийн гэгээний лам байтугай, далай ламын шавь нар олон сүйдсэн юм гэж хүйтэн дуугаар хэлэв. Хоёр лам ихэд айн сандарч:

- Бид хоёрт байгаа бүх юмыг ав. Ганцхан амийг минь л өршөө гэж гуйхад хоёр залуу:

Энэ муу хоёр ламыг буудахад сум хайран юм гэж басамжлан хэлээд тонон чинээ чулуугаар бага ламыг цохиж алаад их ламыг нь мөнөөх чулуугаар дарж орхив.

Дээдийн гэгээн хоёр шавьдаа аюул ирснийг сэрж мэдээд олон лам нараа дуудаж, ном уншиж, бурхандаа даатгал хийж, тав, зургаан ламаар зүүн хойд зүгт сайн гэгч нь догжир* хаяулжээ.

Их лам том чулууны доороос гарч чадахгүй зовж хэвтгэл, цагаан зүрхтэй, том хар нохой гүйж ирээд, дарсан чулууг нь зайлуулж, амийг нь аврав гэнэ. Үнэндээ тэр зүрх цагаан хар нохой бол дээдийн гэгээний гаргасан арга байв.

Арайхийн амь мултарсан их ламтан тэр газраас хурдан зугтааж, болсон хэргийг яаманд

мэдэгдэв. Хэсэг хуяг энгийн хувцас сольж өмсөөд их ламтай хамт дээрэмчдийг барихаар ирэхэд өнөөх хоёр залуу буугаа үүрчихсэн ламын мөрөөр явж байхтай таарав. Хуягууд мэдээгүй дүр эсгэн:

- Хаа хүрэхээр явна? гэж асуухад, хоёр залуу:

- Сая манайхаар хулгайч ирж, байдаг юмыг маань аваад явчихаж, тэгээд хулгайчийг барихаар мөшгиж явна гэхэд, хуяг замын хажуу талын айлыг зааж:

- Тун сая тэр айлд нэг доголлон хүн орж яваа харагдсан. Хөл нь юмуу, нуруу нь хугарсан янзтай гэж хэлсэнд хоёр залуу лавтай өнөө лам мөн гэж тэр айлруу хүрч, буугаа гадаа нь тавиад орж очиход дагаж явсан хуяг яах ийхийн зуургүй бууг нь хурааж аван хоёр залууг барьж хүлэн гэрт нь дагуулж хүрээд эмгэнийг бас барив. Их лам эмгэнээс:

- Хөгшин ээж намайг таньж байна уу? гэж асуухад:

- Өө, чи байсан юм уу? Чи ч бас ус уух хувьтай амьтан байж дээ хөөрхий гэв.

Хуягууд дээрэмчдийн гэрийг нэгжин алт мөнгө, магнаг торго зэрэг элдэв зүйлийн эдлэлийг суйлж хураав. Хуягууд дээрэмчдээс:

- Та нар лам нарыг хуурч алаад хаана нуудаг юм? гэж асуухад, нэг өндөр уулыг зааж өгөв.

Тэнд хүрсэнд ламын алтан малгай, даваа дүүрэн хийсч байв.

Түүнээс хойш хүмүүс энэ газрыг Алтан малгайтын даваа гэж нэрлэх болсон гэнэ.

Баянхотыг барьсан нь

Алша ноён хааны догшин гүнжийг хатнаа болгон авч, Алша хошуунд ирсний дараа суух олигтой сайн ордон байсангүй тул хатнаа дагуулан хаан аавдаа хүрээд:

- Бид Алшад нэг ордон барьж сууя гэж гуйсанд хаан:

- Монгол хүн ордноор юу хийх юм гээд зөвшөөрөхгүй болохоор нь хатан нь нэг арга бодож олоод:

- Бид ордон барихгүй, агтын хүрээ барья гэж хэлсэнд хаан зөвшөөрч гэнэ. Алша ноён хатантайгаа нутагтаа ирээд ордноо хаана барих талаар нэгэн мэргэн хүнээс асуусанд мэргэн хүн мэргэ буулгаад олигтой сайн газар буусангүй тул:

- Би нэг удаа цай уугаад явсан нэг газар бий. Өмнө талаараа устай, урагшаа харсан дэвш хэлбэртэй, их эвтэйхэн газар байсан. Тэнд ордноо баривал тохирно гэж хэлжээ.

Тэгээд тэр газарт ноёны ордныг барихаар тогтож, хэн хүн хаанд заалдахаас сэргийлэн:

- Бид агтын хүрээ барьж байна гэдэг байжээ.

Хожим энд олон ордон сүндэрлэн босч Баянхот гэж нэрийдсэн гэдэг.

Агт аргалах газар авсан нь

Алша ноён, хааны догшин гүнжийг хатнаа болгон авсны дараа, нутаг бэлчээр нь хүрэлцэхгүй болов. Ноён хатантайгаа зөвшиж яриад хаан эзнээс нутаг, бэлчээр авахаар явав. Хаан эзнийд хүрч очоод:

- Хаан аав аа, бид айл гэр болоод нэлээд удлаа. Агт хүлгээ хариулах газар нутаг хүрэлцэхгүй боллоо. Манай тэнд үхрийн арьсан чинээ тээрэм эргүүлэх газар байна. Тэр газрыг бидэнд хайрлаж, агт хорих газар болгож болох уу? гэж гуйв. Хаан дотроо “Үхрийн арьсан чинээхэн тээрэм эргүүлэх газар юу шалих билээ” гэж бодоод:

- Тэг тэг, ав гэж зөвшөөрчээ.

Алша ноён хатантайгаа харьж ирээд бүдүүн үхрийн арьсыг дэвтээж, нарийхан зүсээд, түүгээрээ газраа хэмжиж, одоогийн Алша нутгийг хувааж авсан гэдэг.

Бууран хад

Ловончимбоос баруун тийшээ даамай холгүй газарт Бууран уул гэдэг уул байдаг. Тэр уулын зүүн хойд хажууд нэгэн хөх өнгөтэй гялгар, хээ шиг хад байдаг. Түүний хажууд бас нэг тас хар буур шиг дүртэй хад харагдана. Буур хад нь яг ороо нь орсон буур баруун тийшээ хараад шавж байгаа янзтай харагддаг бөгөөд сайн ажиглавал бурантаг дээс нь салхинд хийсч үзэгддэг гэнэ.

Тэр буур жилийн дөрвөн улиралд адилгүй харагддаг ба өвөл орсон буур шиг үзэгдэж, цагаан хөөс нь бутарч байдаг. Хавар зогдор үс нь унаж, энд тэндээс нь атга ноос бутарч харагддаг. Зун ноосгүй цэлдэн хөх болж, намар ноос үс нь ургаж, хомтой тэмээ шиг үзэгддэг гэнэ.

Зарим хүний хэлэх нь: Тэр буур нэг цагаан ингийг гишгэхээр хөөж байх шиг харагддаг гэж ярьцгаадаг. Сайн харвал Хан уулын зүүн хөтөл дээр яг цагаан ингэ шиг дүрс үзэгддэг гэнэ.

Энэ газар ийм буурын хадтай тул эндхийн тэмээ сайн өсдөг бөгөөд зарим хүн ингээ ботголуулахдаа зориуд энэ уулын хөндийд авчирч ботголуулдаг байсан нь энд төрсөн ботгоны амь, бие бөх байдагтай холбоотой байжээ.

Эрт цагт нэг хүн Буур хадны талаарх олны яриа үнэн эсэхийг туршиж үзье гэж бодоод олон жил ботголоогүй хоёр ингэ авчирч тавьсанд үнэхээр хээлтэж, дараа жил нь ботголсон гэдэг.

Ловончимбо

Алша нутагт Ловончимбо гэдэг бурхан номын газар байдаг. Энэ газар яагаад ийм нэртэй болсон бэ гэвэл бас түүхтэй юм.

Эрт урьд цагт Алша нутагт чөтгөр, шулам самуурч, ард олныг түйвээн амьдрах аргагүй болж гэнэ. Энэ хэргийг дээд тэнгэр мэдээд Ловончимбо бурханыг томилж, чөтгөрийг дарахаар явуулжээ.

Ловончимбо бурхан Алша нутагт бууж ирээд чөтгөр шулмуудыг нэг нэгээр нь уулын агуйд хөөж оруулаад өөрийн биеэрээ агуйн амсрыг таглаж зогсжээ.

Ловончимбо бурханы таглаж зогссон агуйн амнаас урагшаа нэг хад буй. Тэр хадны хажууд шулам хөөсөн Ловончимбо бурханы мөр байдаг бөгөөд хадыг няц няц гишгэсэн ором байдаг гэнэ. Тэр том мөрний хажууд шулмын мөр гэж сая төрсөн нялх хүүхдийн мөр шиг жижигхэн нүцгэн хөлийн ором байдаг гэнэ.

Бас агуйн доторх баруун талын хадан дээр Ловончимбо бурхан чөтгөрийг барих гэж байгаад нэг нялцгар шавар шиг хадыг хуга татсан гарын ором үлдсэн байдаг.

Агуйн амнаас дотогшоо нэг бүдүүн багана шиг хад байдаг. Түүнийг шорон тулгуур гэж нэрлэдэг. Тэр шорон тулгуур багана бол Ловончимбо бурханы чөтгөрийг дарсан Очир нь юм гэнэ.

Хуучны хүмүүсийн хэлэлцдэгээр энэ агуйн нэг ам зуутай* нийлж байдаг бөгөөд чөтгөр шулам буцаж гарч ирээд ард олныг зовоох тул Ловончимбо бурхан одоо ч өдөр шөнөгүй агуйн амыг сахиж суудаг гэсэн домог яриа байдаг.

Сүүлд нь Ловончимбо бурханы ач буяныг дурсан санаж байхын тулд энд сүм барьж, жилийн турш тоо томшгүй хүн зорин ирж, бурханыг хүндэтгэн мөргөж хадаг өргөдөг болжээ.

Ээжийн агуй

Ловончимбо сүмээс урагш гурван зуун алхмын зайтай нэгэн уулын зүүн хажууд том агуй байдаг. Түүнийг ээжийн агуй гэдэг.

Тэр агуйн хэлбэр нь эхийн хэвлий шиг байдаг бөгөөд дунд нь багана шиг чулуу байдаг. Хүн тэр агуйд заавал хувцсаа тайлж зөв эргэж ордог.

Ээжийн агуйд ганц л хүн багтах зайтай, дотор нь орохдоо мөлхөж яваад доод амаар нь гардаг. Гарч ирэхдээ хүний бие улаан сэндэр¹ болчихсон байдаг бөгөөд тэр нь ээжээсээ сая төрж буйн тэмдэг гэж ярьдаг. Улаан сэндэр зөөлхөн торго шиг байдаг ба түүнийг гөвж болдоггүй учиртай.

Ээжийн агуйд зөөлхөн мөлхөж явах ёстой ба хэрвээ хүчтэй явбал ээжийн хэвлий өвдөж, догширдог гэнэ.

Ээжийн агуйд орохдоо голдуу өөрийн төрсөн ээжийнхээ сайн сайхны төлөө залбирч дуудах юм уу, эсвэл өөд болсон ээжийгээ дараа төрөлдөө сайн заяанд төрөх болтугай гэж залбирч гуйдаг.

Хүн хэрвээ энэ яваа насандаа эхдээ муу хандаж, гомдоосон бол ээжийн агуйнаас хурдан гарч чаддаггүй.

Доод амаар нь гарахад хүний биед цав цагаан гурил шиг сэндэр наалддаг. Түүнийг ч мөн гүвж болдоггүй.

Сүмд мөргөл хийсэн хүн тэр хоёр янзын сэндрээс гуйж авдаг. Сэндэр нь хүний халуун, сэрүүн өвчинг эдгээдэг бөгөөд их авбал зунд нь мөндөрт цохиулж, өвөлд нь зуданд даруулдаг гэнэ.

Ээжийн агуйн хажууханд хүүхэн агуй гэж бас байдаг. Хүүхэн агуйд мөргөсөн хүн ээжийн агуйд мөргөж болно. Харин ээжийн агуйд мөргөсөн хүн хүүхэн агуйд мөргөж болдоггүй юм гэнэ.

Алтан дэвш

Алша баруун хошууны Алтанцог сумын өмнө бие дэх ууланд Алтандэвш гэдэг нэртэй уртаараа гурван метр гаруй, өргөнөөрөө хоёр метр орчим дөрвөлжин чулуу байдаг.

Тэр чулууг яагаад Алтандэвш гэж нэрлэсэн тухай домгийг үгүүлье.

Эрт урьд цагт Чингис хаан Тангудыг дарахаар одоогийн Алтандэвш уулаар гаталж явахдаа энэ газрыг их өлзийтэй газар байна гэж тоогоод цэрэг морио амрааж, цай хоол ууж идэн, нэг гунан үнээ муулж, дэвш шиг дөрвөлжин чулуун дээр хөх тэнгэрийг тахьсан гэнэ. Тэгээд цааш явж их ялалт олсон тул хожим нь Алшачууд тэр дэвш шиг чулууг алтан эрдэнэтэй зүйрлэж “Алтандэвш” гэж хүндэтгэн нэрлэдэг болсон гэнэ.

Алтандэвш гэж чулууны баруун хойд талд дундаа нэг нүхтэй дугуй чулуу байдаг бөгөөд түүний хажууд нь тойруулж тавьсан гурван метр өндөр, жингийн туухайтай адил босоо чулуу байдаг. Мөн цаахантай нь хоорондох зай нь жигд хэмжээтэй адилхан гурван чулуу бий.

Эндхийн улс эдгээр чулууг Чингис хааны тээрэм, Чингис хааны морины шон, Чингис хааны тулга гэж тус тусад нь домоглон ярьдаг.

Хожим нь Алшачууд Алша ноёноор зөвшөөрүүлэн Алтандэвшийн уулыг өлзийтэй газар хэмээн сүм барьж мөргөл хийдэг болсон гэнэ.

Буухын голын мөнгөний агуй

Алша нутагт Яваарай уул гэж нэг том уул байдаг. Тэр уулын дунд Буухын гол гэж нэг гол урсаж байдаг бөгөөд голын нэг хөвөөндөх уулын асга хадан дээр урагшаа харсан агуйтай, түүнийг холоос харвал дотор нь гангийн ам цухуйж байх шиг үзэгддэг. Түүнийг хуучны хүмүүс “Мөнгөний агуй” гэж хэлдэг. Тэр агуйг яагаад мөнгөний агуй гэж нэрлэдэг нь бас түүхтэй юм гэнэ.

Эрт урьд цагт Баатар хар жанжин Яваарай ууланд сууж байгаад буухын голын агуйд арван гурван хасаг тэрэгтэй мөнгөө хийж булаад охин хүү хоёроо харж бай гэж хэлээд хаяад явсан гэнэ.

Охин, хүү хоёр нь эцгийгээ хүлээж суусаар хоёр могой болон хувираад жилийн дөрвөн улиралд агуйн аман дээр нааш, цааш зөрөлдөж байдаг гэнэ.

Тэр үеэс хойш олон хүн мөнгөнд шунаж авах гэсэн боловч тун өндөр болохоор давж гарч чаддаггүй байж. Тэгээд уулан дээрээс хүнийг дээсээр уяд доош тавихад агуйн аманд ойртохтой зэрэг дээс нь тасрах юмуу эсвэл ам хамраас нь цус гарч үхдэг гэнэ.

Одоо болтол уулын оройд олон дээсний тасархай байдаг бөгөөд хэн ч тэр мөнгийг авч чадаагүй гэнэ.

Баатар хар жанжин яаж мөнгөө тэр агуйд аваачиж нуусан бэ гэхээр өвлийн хүйтнийг ашиглаж, чулуун дээр ус асгаж хаданд хүргэж байгаад давж гарсан бөгөөд хүмүүс тэр аргаар давах гээд ч чадаагүй гэдэг.

Тэр мөнгийг хэзээ хэн авч чадах вэ? гэхээр Бадайн жарны элс Яваарай уулыг дараад, агуйн амтай чацуурахад зүүн хойт зүгээс хөх бух унасан хүн авах ёстой юм гэнэ.

Баадайн жарны элс

Угтаа Баадайн жаран элс шороогүй туйлын сайхан уул устай тал газар байсан гэнэ. Яагаад ийм их элстэй болсон гэдэг нь түүхтэй юм.

Эрт урьд цагт Баадайн жаранд Улаан хот гэдэг том хот байжээ. Тэнд Бүндэрьеэ хаан гэдэг хувилгаан хаан байв. Тэр хаан жилдээ зууд нэг удаа явж, ном уншиж, буян хийдэг байв гэнэ.

Бүндэрьеэ хаан зууд явах болгондоо Сээр гэдэг газар очиж, тэнгэр газрыг тахиад явдаг, ирэхдээ мөн Сээр гэдэг газраа ирж, тэнгэр газраа тахиад Жарандаа ордог байсан бөгөөд зууд явахдаа зуун хүнээр хүргүүлж, ирэхдээ мөн зуун хүнээр хүргүүлдэг байжээ.

Нэг жил хаан эрх тушаалаа хүүдээ өгөөд явсны дараа нэгэн муу санаат түшмэл хүүд нь:

- Чи бод. Хаан суух хэчнээн сайхан байна? Хийе гэсэн бүхнээ өөрийн дураар хийчихнэ. Аав чинь зуугаас буцаж ирээд чамд дахин эрх мэдлээ өгөхгүй. Харин ч чамд эрх мэдлээ алдахаас айж чамд муу юм хийлгэхээр явсан юм гэж хатгаж хэлэв. Хааны хүү гайхаж:

- Тэгээд одоо ямар арга байна? гэж асуухад:

- Ганц л арга бий. Чи аавыгаа алчихвал өнө үүрд хаан сууж чадна гэв. Хүү нь муу санаат түшмэлийн үгэнд орж, аавыгаа алж, хаан ширээнд суухаар болов.

Бүндэрьеэ хаан зууд мөргөөд буцаж ирэхэд хүү нь олон цэрэг түшмэлээ дагуулан аавыгаа алахаар хүрч ирэв. Аав нь учрыг олсонгүй яагаад өөрийг нь алах болсон тухай асуухад хүү нь:

- Та зууд явахдаа надад хараал хийлгэхээр явсан биз дээ? гэж хэлэв. Аав нь учрыг тайлбарлах гэж оролдсон боловч муу санаат түшмэлийн үгэнд итгэсэн хүү нь аавынхаа үгэнд үл итгэв. Ингээд аав нь хүүдээ:

- За, хүү минь чи намайг алвал ал, дураараа бол. Хэрвээ би чамд муу зүйл хийлгэсэн бол миний хүзүүг цавчихад цус гарна. Харин сайн зүйл хийсэн бол сүү гарна гэж хэлэв. Хүү хэлсэндээ хүрч аавынхаа хүзүүг цавчиж алах тушаал өглөө. Түүний доор захирагддаг нэгэн түшмэл Бүндэрьеэ хааны хүзүүг цавчихад үнэхээр цус биш сүү гоожиж байсан гэнэ.

Энэ цагаас хойш тун удалгүй тэнгэр бурхан хилэгнэж, Улаан хотын дээрээс их хэмжээний элс буулгаж, хот тэр чигээрээ элсэнд дарагджээ.

Одоо болтол Баадайн жарны элсний зүүн хойд үзүүрт Улаан хотын орой цухуйж байдаг гэнэ.

Өндөр цохио

Эрт урьд цагт Баадайн жаранд өндөр цохиотой газар байсан гэнэ. Нэгэн хүн тэр хавиар явж байгаад Өндөр цохионы хажууд байдаг айлд ирж хонов.

Өглөө айлын бүсгүй эрт босч өрхөө татан цайгаа чанаж байтал тооноор нь тэмээний хоргол өнхрөн орж ирээд, тогоотой цайнд нь уначихав. Бүсгүй өнөө тэмээний хорголыг галынхаа хайчаар авч галруугаа хийснээ:

- Өө, харла! Өнөөдөр бас манайд гийчин ирэх нь гэж хэлэв.

Өнөөх гийчин “Тэмээний хоргол, гийчинтэй ямар холбоотой юм бол?” гэж сонирхон бодоод, дахин нэг өнжихөөр болов.

Тэгж байтал орой болж, нар шингэхэд үнэхээр нэг хүн ирэв.

Учир нь тэр цохио туйлын өндөр болохоор тэмээтэй хүн явж, орой дээр нь гарч очоод тэмээгээ амраахад тэмээний хоргол цохионы уруу өнхөрч, бэлд нь буусан айлын тооноор унадаг бөгөөд цохионоос буцаж буухад нар шингэж байдаг нь тэр юм гэнэ.

Богдын овоо

Алша баруун хошууны Эрвээхэй сумын ууланд гурван том овоо байдаг. Хамгийн өмнө талын овоог Гэсэндомбын овоо, дундах овоог Богдын овоо, хамгийн хойд талын овоог Алтангадастын овоо хэмээдэг.

Эрвээхий уулын баруун бэлд Өлгэн хошууны Гашуун гэдэг нэг задгай устай шалбааг байдаг. Түүнийг улс Гэсэр богд энд Гэсэндомбо болон Алтангадаст хоёрын дунд адуугаа холбож уяад хариулж байхад адуу морь нь шээж шалбааг тогтоосон гэцгээдэг.

Мөн Алтангадастын овооноос урагш Богдын өндөр хүртэл уулын хөтөл болгонд хөх, хөх чулуу байдаг ба түүнийг Гэсэр богд Алтангашуутын овооноос агтаа уясанд агт нь уяагаа алдуурч суран цулбуураа чирч явсан ором гэж хэлдэг.

Гурван овооны дундах Богдын овоог одоо болтол улс ихээр хүндэтгэн тахьдаг бөгөөд яагаад тахиж шүтдэг болсон нь бас нэгэн домогтой юм гэнэ.

Эрт урьд цагт Гэсэр Богд Эрвээхэйд морио идэшлүүлж байгаад Алтангадастын овооноос уяж орхиод унтаад өгч. Сэрээд харсан чинь морь нь уяагаа алдуураад өмнө зүгрүү явж байна гэнэ. Гэсэр богд араас нь мөгшиж яваад одоогийн Богдын өндөрт хүрсэнд морь нь Өндөрийн хадруу орчихов. Богд “Энэ ямар учиртай юм бол?” гэж гайхаад хадны хажууд иртэл өөрөө ч мөн мөнөөх хаданд шингээд орчихжээ.

Тэгээд хожмын улс Богдын овоог Гэсэр богд өөрөө биеэрээ зогсож байгаа нь тэр хэмээн ихээр сүжиглэж тахидаг болсон юм гэнэ.

Улаан суварга

Одоогийн Алша зүүн хошууны Улаанбулаг балгаст байгаа Буур уулын зүүн хойд түшээд Улаан уулын энгэрт Байгалийн хувирлаар аяндаа буй болсон 40м өндөр, 21м өргөн, эр хүний бэлэг эрхтэний хэлбэртэй нэгэн улаан хад байдаг.

Үүнийг Улаан суварга гэж нэрлэдэг бөгөөд хэзээнээс нааш хүмүүс шүтэж ирсэн уламжлалтай. Сүүлийн үед суваргын хажууд сүм барьж, билгийн улирлын зуны эхэн сарын 25-нд тахилгын ёслол хийдэг болжээ.

Ингэж шүтдэг болсны учир нь, хүүхэд гардаггүй эмэгтэй хүн тэр хадны доор очоод мөргөж, хадганд чулуу боож, хад өөд шидэж, үр гуйдаг.

Хэрвээ хадаг нь хаданд наалдвал тэр хүн үр хүүхэдтэй болдог. Эс наалдвал насаараа үр хүүхэдгүй явдаг юм гэнэ.

Гурван гэр толгой

Баадайн жарны элсэнд “Гурван гэр толгой” гэдэг нэртэй, холоос харвал гэр шиг хэлбэртэй гурван бондгор улаан толгой байдаг бөгөөд тулгын чулуу шиг байрлаж тогтсон, өмнөх нь бүдүүн, хоёр талых нь багавтар, өндрөөрөө бараг хориод метр.

Тийм их элсэн дунд яагаад ийм гурван толгой гараад ирсэн тухай бас нэг домог үгүүлье.

Эрт урьд цагт Баатар хар жанжин Хархорум хотоос гарч, Баадайн жарныг туулж яваад энэ газарт ирж хоножээ.

Тэгээд энэ нутгийг их аятайхан газар байна гээд нэг шөнийн дотор цэргээ хөдөлгөж, шороо зөөлгөж алт мөнгө, буу зэвсэг болон үхсэн цэргүүдээ гурав хувааж булаад явчихжээ.

Одоо болтол Баатар хар жанжны цэргүүдийн шороо зөөсөн мөр болох гурван гэр толгойн зүүн тийш том улаан эрэг байдаг ба түүнээс хойш тэр газарт гурван гэр толгой буй болсон юм гэнэ.

Агтын хүрээ

Одоогийн Алша баруун хошууны Алтанцог сумын өмнө уулын энгэрт том шавар хүрээ байдаг бөгөөд үүнийг Алша монголчууд адууны хүрээ гэж нэрлэдэг. Энэ тухай хүмүүсийн хэлэлцэх нь:

Эрт урьд цагт Эрвээхий уул, Алтанцогийн уул хоёр амьд уул байжээ. Эрвээхий уул нь хойшоо явдаг, Алтанцогийн уул нь урагшаа явдаг бөгөөд эцэстээ нийлэх ёстой байжээ.

Тэр үед одоогийн Агтын хүрээ гэдэг газар нь их сайхан нутаг байсан тул нэг хаан энэ газарт хот байгуулж суухаар болж, агтын хүрээ бариулж адуу малаа хүрээлсэн юм гэнэ.

Нэг өдөр хааны бие хүндтэй хатан гэрээсээ гарч явахдаа хоёр уулын явж байхыг харчихжээ. Тэгээд хатан:

- Хаантаан? Тэр хоёр уул явж байна. Одоо удахгүй нийлэх нь гэж хашгирсан чинь тэр дорхноо хатан дутуу төрж, хүүхэдтэйгээ хоёулаа амиа алджээ.

Учир нь хоёр уул тангаргаар бүтсэн уул байсан бөгөөд хааны хатан хоёр уулыг нийлэх болоогүй байхад нь хашгирснаас болж хоёр уул цочиж тэр дороо зогсож, үхмэл уул болсон юм гэнэ.

Үүнээс болж хааны гэр бүлд хагацал зовлон тохиож, билиггүй үйл болсон тул хаан хот байгуулах санаагаа орхиж, агтын хүрээгээ орхиод нүүсэн юм гэдэг.

Шаазан даваа

Эрт урьд цагт нэг хэсэг аянчид хужир давсаа ачаад хотруу оруулж борлуулаад зээлээс баахан шаазан аяганууд худалдаж авчээ. Шаазан аягануудаа савласаар байтал уут сав нь ч дүүрч гэнэ. Аянчид “Гангар* шаазан хагардаггүй юм. Хагарсан ч эвэндээ ордог юм” гэж уутныхаа дээрээс дэвсээд л савлаад байж.

Тэгээд гангар шаазан аягануудаа тэмээндээ ачаад харьж явтал замд нь тэмээ нь туйлж бүх шаазангууд нь хагарчихаж гэнэ. Гангар шаазан эвэндээ ордог юм гээд эвэнд нь оруулах гэтэл нэг нь ч эвэндээ ороогүй юм гэдэг.

Аргаа барсан аянчид арван шуудай шаазангаа асгачихаад хоосон буцаж ирэв.

Түүнээс хойш Монголд Шаазангийн даваа гэдэг нэртэй газар буй болсон гэнэ.

Алтан овоо

Алша баруун хошуунд Алтан овоо гэдэг сум байдаг. Энэ сумын нутагт эрт урьд цагт нутгийн ард түмэн шүтэж тахидаг нэгэн овоо байдаг байжээ.

Тэр овоог их алттай гэдгийг нутгийн хаан мэдээд олон хүн томилж алт ухуулж гэнэ.

Алт малтагчид алт ухаж байтал нэг алтан унаганы чих цухуйж байв гэнэ. Хаандаа хэлтэл, хаан их олз олох нь хэмээн баярлаад заавал бүтнээр нь гаргаж ирэхийг зарлиг болгов. Тэгээд олон улс өглөө нар битүү босч өнөө алтан унагыг малтаад нар шингэж харуй бүрий болоход арай гэж туурайд нь хүрчээ. Хүмүүс маргааш өглөө үргэлжлүүлж малтахаар болоод явцгаав. Өглөө нь мөн л нар битүү босоод алтан унагаа малтаж гаргахаар ирцгээхэд доошоо шигдэж ороод дөнгөж чих нь цухуйж байв гэнэ. Алт ухагчид үүнийг хараад ихэд гайхацгааж, дахиад л үдшийн харанхуй болтол ухаад туурайд нь хүрчээ. Маргааш өглөө нь ирэхэд бас л буцаад доошоо орчихсон байв. Энэ байдлаар олон хоног ухсан боловч алтан унагыг гаргаж чадсангүй. Нэг өдөр алт ухагчдын нэг нь:

- Бид энэ алтан унагыг гаргаж авч чадахгүй юм байна. Юу ч гэсэн хөдөлгөөд үзье гээд хөдөлгөөд үзсэн чинь хөдөлж байв.

Тэгэхээр нь бүгдээрээ нийлж байгаад татсанд алтан унага гэнэт амь орж, нүхнээсээ үсрэн гарч ирсэнд нүх нь нурж, нүхэн дотор байсан алт ухагчдыг дарж алжээ.

Тэр алтан унага зүүн хойшоогоо давхисаар яваад одоогийн Дааган шанд гэдэг газар ирээд алга болсон бөгөөд одоо болтол Дааган шандын өмнө орой дээр алтан унагыг малтсан нүх байдаг юм гэнэ. Үүнээс хойш тэр газрын алтыг дахиж ухахаа больсон гэдэг.

Хүрэмтийн гол

Алша баруун хошууны Яваарай ууланд Хүрэмтийн гол гэдэг нэртэй нэгэн гол урсдаг. Хуучны хүмүүсийн ярьдгаар: Эрт цагт Баатар хар жанжин дайснаас зугтан Яваарай ууланд бүслэгдэж олон хоног суугаад баригдаагүй гарч чадсан тул энэ ууланд их хайртай болсон бөгөөд уулын арлуу зам гаргаж дайснаас зугтаж гарахдаа малгай, хүрэм хоёроо тайлж тавиад:

- Энэ ууланд хүний удам бүү тасраг, малын мөр бүү тасраг гэж хэлээд явжээ.

Түүнээс хойш Яваарай ууланд хүн зон, адуу малын хөл тасардаггүй баян сайхан хангай болсон бөгөөд уулын нэгэн сугаар урсдаг голыг Хүрэмтийн гол гэж Баатар хар жанжны хүрэмний нэрээр нэрлэсэн юм гэдэг.

Жарантайн домог

Эрт цагт одоогийн Жарантайн давсан нуур гэж байгаагүй. Тэр газар Жарантай нэртэй өвгөн, эмгэн охин хоёртойгоо жаран цагаан ямаагаа хариулан жаргалтай сайхан амьдардаг байжээ.

Нэг өдөр нутгийн ноён нь ан гөрөө хийж яваад Жарантай өвгөнийд оржээ. Жарантай өвгөний цэцэг шиг хөөрхөн охиныг хараад сэтгэл нь хөдөлсөн ноён охиныг гэргийгээ болгон авья гэж аав, ээжид нь хэлэхэд, өвгөн эмгэн хоёр аянгад ниргүүлэх шиг болж юу ч хэлж чадалгүй сууж байв. Өвгөнийг дуугарахгүй болохоор хаан баярлаж:

- За, Жарантай өвгөн минь, та бэлтгэлээ хийж бай, би маргааш ирж охиныг чинь төрийн ёсоор мордуулж авна гэж хэлээд яваад өгөв. Ноёныг явсны дараа ганц охиноосоо салах болсон өвгөн, эмгэн хоёр хоол унд идэхгүй, сэтгэлээр унан уйлан хайлж байхыг охин нь үзээд:

- Та хоёр минь бүү санаа зов. Би нэг арга бодъё гэж хэлээд унтаад өгөв.

Маргааш нь ноён олон түшмэл, зарцаа дагуулан Жарантай өвгөний охиныг буулгаж авахаар ирсэнд, Жарантай өвгөний гэр байсан газар айл амьтан юу ч үгүй, цав цагаан давсан нуур цайрч байжээ. Ноён түүнийг үзээд ихэд гайхаж, сайн харах гэтэл цагаан давсанд нүд нь гялбаад юу ч харж чадсангүй. Ингээд ноён Жарантай өвгөний охиныг авч чадалгүй буцаж гэнэ.

Учир нь Жарантай өвгөний гэр давсан нуур болж, жаран цагаан ямаа нь жаран булаг болж хувирсан нь тэр гэнэ. Ингэж Жарантайн давсан нуур буй болсон түүхтэй аж.

Яваарай

Эрт цагт Баатар хар жанжин Яваарай ууланд сууж байжээ. Дараа нь явахдаа Яваарай уулын өндөр оргил Алтансүмбэрийн орой дээр гарч:

- Энэ газар устай, модтой сайхан газар байна. Энд хүний үр бүү тасраг гэж хэлээд өөрийн хүрмээ тайлж тавиад явжээ. Тэгээд нутгийн ард тэр оройг Хүрэмтийн орой гэж нэрлэсэн гэнэ.

Баатар хар жанжин бас цаашаа явж байгаад нэг уулан дээр гарч:

- Энэ газарт адуу малын үр бүү тасраг гэж хэлээд өмсч байсан алтан малгайгаа тайлж орхиод явжээ. Түүнээс хойш тэр оройг Алтанмалгайтын орой гэж нэрлэсэн гэнэ.

Баатар хар жанжны энэ билигдлээс хойш Яваарай ууланд хэчнээн ган, зуд болсон ч одоо болтол хүн, малын үр тасраагүй гэнэ.

Мөн Баатар хар жанжин Яваарай ч Буухын голын агуйгаас гарахдаа бүх алт мөнгөө агуйд хийж, дээрээс нь хүү, охин хоёроо хийж булчихаад алс хол гарч, их дуугаар:

- Одоо, би явлаа гэж эргэж хашгираад явсан гэнэ.

Дараа нь хүмүүс Баатар хар жанжны явахдаа “Явлаа” гэж хашгирсан үгээр нь “Явлаа” гэж хэлсээр байгаад сүүлдээ “Явлаа” нь “Яваарай” болж хувирчээ. Ийнхүү тэр газрыг Яваарай гэж нэрлэсэн гэдэг.

Өлгий шанд

Одоогийн Алша зүүн хошууны Өлзий суманд задгай устай “Өлгий шанд” гэдэг нэртэй газар байдаг. Урьд цагт Алшад их дээрэм болж, Алшагийн ард түмнийг дээрэмдэн тонож явсаар зүүн Сэржийн сүмд хүрч гэнэ. Тэд сүмийн ганжрыг алт гэж андууран дээсээр цаламдаж татсанд ганжир нурж, олон дээрэмчид дарагдаж гэнэ.

Тэдний дундаас нэг нь шархтай биеэ чирж сүмээс гарч, мөлхөж явсаар Өлгий шандын усанд орж үхжээ.

Түүнээс хойш задгай усанд хүн, мал ойртохын аргагүй үмхий ханхалж нутгийн ард Үмхийшанд гэж нэрлэж байгаад хожим Өлгийшанд нэртэй болсон гэнэ.

Баадайн жаран

Дэлхийд дөрөвдүгээрт ордог Баадайн жарны элс нь манай улсад гуравдугаарт ордог их элс юм. Энд дэлхийн хамгийн их элс, хамгийн олон нуур байдаг ба эртнээс алдартай рашаан булагтай. Алша нутагт дэлхийд цорын ганц элсэн доторх сүм байдаг тул даян дэлхийд алдаршсан байна.

Эрт цагт нэгэн Баадай гэдэг нэртэй хүн одоогийн Баадайн нууранд нутаглан суудаг байжээ. Тэр хүн Баадайн элсэнд жаран нуур байхыг олж мэдэв. Тэгээд устай элс хонхор болгон нь жаран нуур болж хувирчээ. Хожим Баадай гэдэг хүн жаран нуур олсноос үүдэн тэр газрыг Баадайн жарны элс гэж нэрлэх болжээ.

Бууран хүрэн уул

Алша зүүн хошууны Өлзий суманд нэг хүрэн уул байдаг. Түүнийг өмнө нь Бууран хүрэн уул гэдэг байгаад догшроод болохгүй болохоор нь Хайрхан гэж нэрлэх болжээ.

Ямар ч хүн тэр уулыг хараад Буур гэж хэлж болдоггүй юм гэнэ.

Хэрэв ам алдаж, Буур гэж хэлвэл тэр дороо салхи шороо босч, тэнгэр газар нийлж, хүн амьтан тогтохын аргагүй болдог байжээ.

Хүрэн уулыг сайн шинжиж харвал урагшаа явж байгаа Буур шиг дүртэй. Түүний өмнө нь бас хэд хэдэн уул цуварч тогтсон байдаг. Тэдгээрийг Ингэн уул гэж нэрлэдэг. Хүмүүсийн хэлдгээр ингэнүүд нь өмнө нь цуварч, араас нь буур нь тууж яваа нь тэр гэнэ.

Тэр уулс урагшаа цуварч Ордосын хошуу хүрдэг бөгөөд Ордосын хошуунд тэмээ сайн өсдөг нь тийм учиртай гэнэ.

Морин хайрхан

Алша баруун хошууны Энгэр-Ус гэдэг газар Морин хайрхан гэдэг нэртэй уул байдаг. Тэр уулыг сайн ажиглавал азарган адуу зүүн тийшээ бөхийгээд орж байх шиг харагддаг. Тиймээс Морин хайрхан гэж нэрлэсэн бөгөөд нэрийг нь хэлж болдоггүй. Хэлвэл догширдог гэж ярьдаг.

Тэр Морин хайрхан зүүн тийшээ явж байгаа дүртэй тул одоо зүүн Монголд адуу их өсдөг нь тийм учиртай гэнэ.

Дэргийн уул

Одоогийн Алша зүүн хошууны Хонгорнөөлөг суманд Дэргийн уул гэж бий. Тэр уулыг яагаад Дэргийн уул гэж нэрлэх болсон нь дараах түүхтэй ажээ.

Эрт урьд цагт Орос нутгаас гаралтай Ёлдоруу хэмээх алдарт дархан хүн байжээ. Ёлдоруу дархан Чингис хааны зарлигаар Халхаас цэргийн зэвсэг хийх дөш авахаар явжээ. Тэрээр цэргийн зэвсгээ аваад буцаж явахдаа замдаа нэгэн уулын бэлд буудаллажээ. Ёлдоруу дархан их том биетэй, өндөр хүн байсан тул унтахаар хэвтэхэд нь толгой нь одоогийн Дэргийн уулыг дэрлэж байхад хөл нь Уран дөшийн ууланд хүрч байсан гэдэг. Тэгээд шөнө дунд болсон хойно хөл нь загнаад унтуулахгүй болохоор нь зарцаа босгож:

- Миний хөл загнаад нойр сэргээчихлээ. Чи яваад үзээд ир. Юу болов? гэж явуулжээ. Зарц нь явсаар Ёлдоруу дархны хөл байгаа ууланд хүрч үзсэн чинь нэг чоно ирчихсэн хөлийг нь долоогоод зогсож байсан гэдэг.

Маргааш нь явсаар Ёлдоруу дархан хөлөө тавьж унтсан ууланд ирж Чингис хааны зарлиг ёсоор тэр газар байрлаж, зэвсгээ дөшин дээрээ улайтгаж цохин, ар талын Хатан голын усанд дүрж хөргөж байсан гэдэг.

Тэгээд Ёлдоруу дархны дэрлэж хоносон уулыг Дэргийн уул, дөшөө тавьж цэргийн зэвсэг урласан уулыг Уран дөшийн уул хэмээн нэрлэх болсон юм гэнэ.

Чулуун ой

Эрт цагт Чингис хаан төр гүрний улсыг хөдөлгөж урт цагаан хэрмийг бариулж гэнэ. Урт цагаан хэрмийг барьж байсан хүмүүсийн толгойлогч нь их хэрцгий ширүүн хүн байжээ. Хэрвээ хэн нэг хүн ядарч зүдрээд жаахан л амсхийх гэвэл тэр дор нь барьж, Урт цагаан хэрмийн дотор хаяж, хэрмээ үргэлжлүүлэн барьдаг байв.

Нэг удаа энэ хэргийг хурмаст тэнгэр олж мэдээд энэ янзаараа ядарч туйлдсан ард олныг алаад байвал, Урт цагаан хэрмийг барьж дуусахад орчлон дээр нэг ч хүн үлдэхгүй юм байна гээд Бодисадва бурханыг орчлонд илгээж:

- Чи Урт цагаан хэрэм барьж байгаа газарт очоод ядарч туйлдсан улсыг авар! гэж захиж явуулав.

Бодисадва бурхан орчлонд бууж ирээд нэгэн хувилгаан хутагтын дэргэд хүрч:

- Би хурмаст тэнгэрийн зарлигаар хүний ертөнцөд бууж, Цагаан хэрэм барьж байгаа хүмүүст туслахаар ирлээ. Та надад тус болооч? гэж гуйв. Хувилгаан хутагт Бодисадва бурханд нэг бургасны мөчир өгч, хэдэн тахиа, галуу, нугас туулгаад:

- За та үүнийг туугаад цагаан хэрэм барьж байгаа газарлуу яв. Замдаа огт зогсож болохгүй. Хүн амьтан таарвал дуугарч болохгүй. Замд таарсан юмыг идэж ууж болохгүй шүү гэж захив.

Бодисадва бурхан бургасан шилбүүрээ бариад тахиа, галуу, нугаснуудаа туугаад цагаан хэрэм барьж байгаа газарлуу явж байв.

Замдаа ам нь цангаж харангадахын даваан дээр тулж явтал тунгалаг сайхан устай нуур тааралджээ. Бодисадва бурхан баярлан гүйж очоод, хувилгаан хутагтын захиасыг ч мартаж бургасан шилбүүрээ нуурын эрэг дээг хатгаж орхиод цангаагаа тайлтал ус ууж, нүүр гараа угааж аваад, тууж явсан шувуунуудаа ч нуурлуу оруулж умбуулав.

Гэтэл нуурын мандал дээр нэгэн цагаан толгойтой өвгөн гарч ирээд:

- Чи хаанаас ирсэн юун хүн бэ? Яагаад миний нуурын уснаас ууж, нүүр гараа угааж, тахиа шувуугаа оруулдаг билээ? гэж чанга дуугаар зандрахад, сая хэрэг буруудсаныг ойлгож, санд мэнд нуурын уснаас гарч, бургасан шилбүүрээ авах гэтэл уул болоод ургачихсан байв.

Бодисадва бурхан нууранд буцаж ороод шувуунуудаа гаргах гэтэл тахиа нь тахиа шиг уул болоод, галуу нь галуу шиг уул болоод, нугас нь нугас шиг хэлбэртэй уул болоод хувирчихсан байв гэнэ. Үүнийг үзээд Бодисадва бурхан мэл гайхан зогсож байтал өөрөө ч уул болоод ургачихаж гэнэ.

Ингээд Бодисадва бурхан хувилгаан хутагтын үгэнд ороогүйгээс болж Цагаан хэрэм барьж ядарч туйлдсан хүн ардад тусалж чадалгүй, өөрөө хад болон хувирчээ.

Үүнээс хойш тэр газарт босоо, босоо цагаан уул чулуу бий болсон бөгөөд тэр газрыг одоо ч Ши Лин буюу Чулуун ой гэж нэрлэдэг юм гэнэ.

Хатан голын ус яагаад булингартай болсон бэ?

Эрт урьд ганц охинтой эмгэн өвгөн хоёр амьдардаг байжээ. Охиноо харийн нутагт хадамд гаргаад гурван жил болсон хойно махчин болсон гэж сонсов. Энэ үгийг сонсоод ээж нь итгэж чадахгүй, өөрийн нүдээр очиж үзэхээр шийдээд өвгөндөө хэлсэнд:

- Явж болохгүй, чамайг ч бас иднэ гээд явуулсангүй.

Гэвч эмгэн өдөр бүр уйлж унжин:

- Охин минь махчин болсон байлаа ч арай ч эхийгээ барьж идэхгүй байлгүй гэж гуйсаар байж зөвшөөрүүлж гэнэ.

Тэгээд өвгөн нь цаашаа харж уйлж, наашаа харж инээн байж эмгэндээ сувай ингэ унуулаад явуулжээ.

Учир нь махчин хүн их хурдан болдог ч сувай ингийг гүйцэж чаддаггүй юм гэнэ.

Ингээд эмгэн сувай ингээ унаад охиноо үзэхээр явжээ. Охин нь хатан голын цаад эрэгт суудаг байв. Эмгэнийг хүрч очиход Хатан гол үерлээд эргээ халин урсаж байв. Эмгэн голын эргээр явж явж арай гэж нэг гарам олоод гаталж гарав. Ээж нь яваад очсонд хүүхэн гэрээсээ гарч ирээд:

- Хүүе, ээж минь ирлээ, Яасан сайн юм бэ? гэсээр тосон ирж, гэртээ оруулав. Гэрт нь хэн ч байсангүй, охин нь ганцаараа суудаг бололтой байв гэнэ. Хүүхэн аяга цай хийж өгөөд ээжийнхээ эрүүг илж үзсэнээ:

- Манай ээж нэлээд мярайтай болсон байх чинь гэж хэлээд тас тас инээв. Ээж нь дотроо “Миний охин үнэхээр махчин болчихсон юм биш биз? Яагаад эрүү илж үзээд байгаа юм бол?” гэж сэжиг авч цайгаа ууж суув. Хүүхэн нь:

- Ээж цайгаа уугаад сууж бай! Би хурдхан ус аваад ирье гэж хэлээд гараад явчихав.

Охиноо гарсны дараа эмгэн “Миний охины авдарт юу байдаг юм бол?” гэж бодоод баруун талын авдрыг нь сөхөөд харсан чинь хүний гавлын яс дүүрэн байв. Зүүн талын авдрыг нь нээгээд харсан чинь хүний хаа гуя дүүрэн байв.

Эмгэн үүнийг үзээд айн балмагдаж, хүний хэлдэг үнэн юм байна. Миний охин махчин болжээ.

Одоо усаа авчраад намайг ч бас идэх юм байна гэж бодоод гэрээс гарч тэмээгээ аваад явах гэтэл тэмээний шонгийн цаах нь талд нэг хуурай худаг байв. Хажуугаар нь гарах гэтэл охин нь худаг дотор хутгаа билүүдээд сууж байв. Хүүхэн ээжийгээ үзээд:

- Ээж та хаашаа явах гэж байгаа юм? гэж асуусанд ээж нь айж байсан ч арга гаргаж:

- Би чамайг усаа даахгүй байгаа болов уу гээд тэмээгээр ачихаар ирлээ гэв. Хүүхэн сонсоод:

- Ээж та намайг хүлээж байгаарай гэж хэлээд худаг дотроос мацан гарч ирэв. Энэ хооронд эмгэн ингээ унан зугтаж явав. Хүүхэн ээжийгээ зугтаасныг мэдээд:

- Бөөн, бөөн өөх минь, бөгтөр буурал ээж минь, сэмж сэмж өөх минь сэгсгэр буурал ээж минь та зогсож бай гэж хэлээд хөөж гэнэ. Ээж нь сувай ингээрээ нисэх мэт тэшүүлсээр Хатан голын эрэг дээр ирэн:

- Хатан ээж минь ээ! Одоо би ачлалгүй үрдээ идүүлэх нь. Та надад зам тавьж хайрла! гэж хашгираад мээмээ Хатан голын тунгалаг усанд саасанд Хатан голын ус тэр дороо цагаан зураас татуулж, нарийхан цагаан зам гаргаж өгч гэнэ. Эмгэн тэмээгээ ташуурдаж тэр замаар зугтааж гарахад араас нь хөөж ирсэн хүүхэн:

- Ээж гаталж болсон юм чинь би яагаад гаталж чаддаггүй юм гээд хутгаа барьсаар өнөө замаар ортол зам нь хаагдаж, махчин хүүхэн усанд унаж, барьсан хутга нь биеийг нь сүлбэж алжээ.

Түүнээс хойш Хатан голын ус ээжийн сүү, хүүхний цус хоёртой холилдож, булингартай болсон юм гэдэг.

Ээж нуур хатан гол болсон нь

Эрт урьд цагт эмгэн өвгөн хоёр ганц хүү, долоон улаан ямаатай байж гэнэ.

Хүү нь өдөр бүр ээж нуурын хөвөөгөөр долоон улаан ямаагаа хариулдаг байв. Нэг өдөр олон загасчин ирж, ээж нуурын загасыг шүүрдэж нэг ув улаан загас гохдож гаргахыг хүү харав. Хүү их өрөвч зөөлөн сэтгэлтэй тул загасыг өрөвдөж:

- Та нар наад улаан загасаа надад өгчих гэж гуйсанд, загасчид:

- Чи тэгвэл нэг улаан ямаагаа бидэнд өг. Тэгвэл загасаа чамд өгье гэв. Хүү зөвшөөрч, нэг ямаагаа барьж өгөөд загасыг авч ээж нууранд нь буцааж тавьжээ. Улаан загасыг усанд нь тавьсанд загас уснаасаа гарч ирээд хүүг баахан харж байснаа буцаад усандаа орж алга болов.

Хүү зургаан улаан ямаагаа туугаад харьж ирэхэд, аав ээж хоёр нь:

- Нэг улаан ямаагаа яасан бэ? гэж асуув. Хүү:

- Нэг улаан загасаар сольчихлоо гэж хариулав. Аав ээж хоёр нь:

- Нэг улаан загасаа яасан бэ? гэж асуув. Хүү:

- Та хоёр минь дандаа “Амьд амьтны амийг аварч байвал буян болно” гэж захидаг болохоор усанд нь буцаагаад тавьчихлаа гэж үнэнээ хэлэв. Аав ээж нь уурлаж хүүдээ нэг уут өгөөд хөөж явуулжээ.

Хүү гэрээсээ хөөгдөөд орох орон, оочих аягагүй, өлсөж ундаасаад нэгэн толгойн энгэрт муу хар уут дэрлээд “Одоо нэг сайхан мах байсан бол” гэж бодож хэвтгээд унтчихав. Унтаж, унтаж сэрсэн чинь өмнө нь тавагтай чанасан мах байж байв. Өлссөн хүү юм бодож санасангүй өнөө махыг идчихээд цааш явав. Явж явж бас нэг толгойн энгэрт суугаад “Одоо нэг сайхан бууз байсан бол” гэж бодож байгаад унтчихав. Нойрон дунд нь жигнэсэн буузны үнэр ханхийхэд сэрээд харсан чинь үнэхээр дөнгөж жигнэсэн тавагтай бууз байж байв. Хүү бас л идчихээд цааш явав.

Ийнхүү хүү унтах бүртгээ “Тийм хоол идэх юмсан, ийм хоол идэх юмсан” гэж бодоод санасан бүгд нь бүтдэг байлаа.

Нэг өдөр “Нэг сайхан байшин байсан бол” гэж бодоод унттал гурван давхар байшинтай болчихсон сэрж гэнэ. Дараагийн өдөр унтахдаа “Байшиндаа эд хөрөнгөтэй болох юмсан” гэж бодоод унттал бас л дутах юмгүй эд хөрөнгөтэй болсон байлаа. Харин түлэх түлээтэй болох юмсан гэж хэчнээн бодоод түлээтэй болохгүй байв.

Тэгээд хүү өдөр бүр түлээ түүдэг болов. Нэг өдөр түлээгээ түүж яваад ядраад болохгүй болохоор нь “Түлээ намайг үүрдэг байсан бол” гэж бодоод түлээн дээрээ гараад унтчихав. Нэг сэрсэн чинь үнэхээр түлээ нь өөрийг нь үүрээд гэрийнхээ үүдэнд ирж байв.

Хүү нэг удаа “Хэн надад хоол, цай хийж авчирч өгдөг юм бол? Мэдэх юмсан гэж бодоод”

түлээ түүж яваад хурдан гэгч буцаж ирээд харсан чинь нэг үзэсгэлэнтэй хөөрхөн охин хоол хийгээд зогсож байв. Хүү охиныг хараад магнайгаа хагартал баярлаж гэртээ гүйж ороод:

- Чамайг хэн гэдэг вэ? Чи хаанаас ирсэн юм бэ? гэж асуухад, охин:

- Би бол чиний усанд нь буцааж тавьсан улаан загас байна. Би чиний ачийг хариулж, эхнэр чинь болохоор ирсэн юм. Харин чи намайг харах ёстой өдрөөсөө гурав хоногийн өмнө харчихлаа. Тийм болохоор чи бид хоёрын амьдралд нэг гай учирна гэж хэлжээ.

Ингээд хүү, охин хоёр жаргалтай сайхан амьдарч байтал хаан энд үзэсгэлэнтэй хөөрхөн бүсгүй байгааг олж мэдээд эхнэрээ болгон буулгаж авахаар олон цэргээ дагуулан иржээ. Загас бүсгүй:

- За одоо бид хоёрт аюул ирлээ. Чи хааны цэрэгтэй тулалд. Тулалдаад үхэхийн өмнө “Хаан нь үнээ бол, цэргүүд нь бух бол” гэж хэлээрэй гэж захив.

Хүү эхнэрээ өгөхгүй гэж хааны цэргүүдтэй тулалдав. Тулалдаж, тулалдаж үхэхийн даваан дээр:

- Хаан нь үнээ бол, цэргүүд нь бух бол гэж хэлсэнд үнэхээр хаан нь үнээ болж, цэргүүд нь бух болж хувираад олон бух ганц үнээгээ булаалдаж, хоорондоо мөргөлдсөөр хүч тамираа барж ирэв. Хүү:

- Одоо юу хийх ёстой вэ? гэж асуухад, эхнэр нь:

- Одоо хаан нь хаан болж, цэргүүд нь цэрэг болж буцацгаа гэж хэл гэв. Хүү эхнэрийнхээ хэлсэн ёсоор “Хаан нь хаан болж, цэргүүд нь цэрэг болж буцаж явцгаа” гэж хэлэв. Үнэхээр хаан нь хаан болж, цэргүүд нь цэрэг болж буцаж явцгаав. Бүсгүй: :

- Одоо бид хоёрын гай өнгөрсөн. Харин хоёулаа гурван жил л сайхан амьдарна. Харин түүний дараа чи үхрийн эвэрт үхэж би чиний хойноос гашуудахдаа буцаж загас болоод ээж нуурандаа орж хатан гол болон урсаж явна гэж хэлжээ.

Залуу хос аз жаргалтай сайхан амьдарсаар гурван жил харвасан сум шиг өнгөрч, бүсгүйн хэлсэн хугацаа ч ирэв. Хүү ихэд сэтгэлээр унаж:

- Би үхэхгүй, би чамаасаа салахгүй, байшингийн дээвэр дээр гараад суучихвал үхэр хаанаас ирж намайг мөргөх билээ гэж хэлээд байшин дээрээ гараад өдөржин суудаг болжээ.

Нэг өдөр байшин дээрээ гараад хийх юм олдохгүй уйдагдаа хөөрөгнийхөө халбагаар чихээ ухаж суутал, гэнэт байшингийн дэргэд үхэр мөөрөх сонсдов. Үхэр бодож суусан хүү цочихдоо хөөрөгнийхөө халбагаар чихрүүгээ хатгаад үхчихэж гэнэ. Учир нь тэр хөөрөгний халбагыг үхрийн эврээр хийсэн юм байж.

Нөхрөө үхсэний дараа үзэсгэлэнт хөөрхөн лусын дагина бүсгүй гашуудан шаналж, хүний амьдралаас уйдагдаа ээж нуурандаа очиж загас болон хувирчээ. Удалгүй Ээж нуурын ус загас бүсгүйн гашуудлыг даалгүй Хатан гол болон урссан домогтой юм гэнэ.

* Газар нутгийн нэр

* Эмээлийн хүндэтгэлийн утга

1. Жижиг биетэй

2,3. Унах, ойчих

* Муу үйлийг буцааж хариулах, гүрмийн зан үйл; гурилаар шовх гурвалжин хэлбэр гаргаж хийсэн балин

* Буддын шашны ёсны бурханы нэр

* Сайн чанарын шаазан